

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# “ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



## ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Нийгэм
- Эрх зүй, төрийн байгуулал

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ, 2020

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXXI боть)-ийг  
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хурээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Т.Баярмаа  
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Баатар



## ГАРЧИГ

### I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тодорхойлолт, загварууд, олон улсын туршлага  
*Г.Билгээ, О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*
- 1.2 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд болон Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн шинжилгээ  
*H.Тогтох*

### II БҮЛЭГ. НИЙГЭМ

- 2.1 Дэлхийн улс орнуудын коронавирус ба нийгэм эдийн засгийн бодлогын тойм  
*Д.Амаржаргал (Ph.D), И.Жаргалзаяабямба*
- 2.2 Хямралын үеийн манлайлал: коронавирусийн тахалд хариу үзүүлэх ба ирээдүйн сорилт  
*Г.Алтан-Оч (Ph.D)*

### III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- 3.1 Төрийн хамгаалалтын байгууллагын статус, эрх зүйн орчны талаарх харьцуулсан судалгаа  
*Д.Бадамдаш, Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ  
Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл  
Р.Оргилмаа, Д.Халиун, Э.Энхтувшин*
- 3.2 Парламентын боловсрол олгож буй гадаадын зарим орны туршлага  
*Г.Алтан-Оч (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D),  
О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл,  
Р.Оргилмаа, О.Нарантуяа, Б.Туул*
- 3.3 Бусад орны парламентын шинэ гишүүдэд зориулсан сургалт, түүний зохион байгуулалтын талаарх туршлага  
*Э.Энхтувшин, О.Билгүүтэй, Г.Уянга*
- 3.4 Монгол Улсын Их Хурлын даргын зарим албан тушаалтныг томилохтой холбоотой бүрэн эрхийн талаарх мэдээлэл  
*О.Нарантуяа*
- 3.5 Австрали, БНСУ-ын Парламентын ажлын албаны цалин хөлс, нэмэгдлийн талаарх лавлагaa, мэдээлэл  
*О.Нарантуяа, Р.Нургүл*
- 3.6 Тагнуулын байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын чиг үүрэг, тэдгээрийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэргийн харьяалал болон мөрдөн байцаах албаны орон тоо, албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээний талаарх лавлагaa  
*Д.Халиун, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*
- 3.7 БНСУ-ын Үндэсний ассамблейн төсвийн албаны талаарх мэдээлэл  
*Д.Жигваагүнсэл, О.Билгүүтэй*
- 3.8 Виртуал орчин дахь парламентын үйл ажиллагаа, анхаарах асуудлууд  
*Д.Халиун, Р.Нургүл*

- 3.9** Парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт: зарим орны туршлага

*Д.Халиун, Д.Амаржаргал (Ph.D),  
Г.Билгээ, П.Уранчимэг*

- 3.10** Парламентын чуулганы хуралдааны цаглаврын талаарх харьцуулсан судалгаа

*Г.Алтан-Оч (Ph.D)  
Р.Оргилмаа, Б.Туул*

- 3.11** ОХУ-ын Төрийн Думын Регламентад Тамгын газрын хуулийн хэлтсээс гаргах эрх зүйн дүгнэлтийн талаарх зохицуулалт

*Г.Билгээ*

- 3.12** Парламентын ажлын албаны даргын чиг үүрэг

*Г.Билгээ*

- 3.13** Парламентын нэрэмжит шагналын талаарх харьцуулсан судалгаа

*Г.Алтан-Оч, (Ph.D) О.Нарантуяа*

- 3.14** Ковид-19-ийн тойм: Сонгуульд үзүүлэх нөлөө (2020.10.01-ний байдлаар)

*Г.Билгээ*

- 3.15** Гадаадын зарим орны парламентын Ёс зүйн хороодын талаарх судалгаа

*Г.Билгээ, Э.Энхтувшин  
Ц.Ариунаа, О.Билгүүтэй, Б.Туул*



# 1

## БҮЛЭГ

---

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ,  
ЗАГВАРУУД, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Билгээ, О.Билгүүтэй,  
Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

**ГАРЧИГ**

**Судалгааны хураангуй**

**Судалгааны хэсэг**

- 1. “Хөгжил”-ийн талаарх зарим тодорхойлолтууд**
- 2. Хөгжлийн загварууд**
- 3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн олон улсын туршлага**

- 3.1.OХУ
- 3.2.Их Британи
- 3.3.Япон
- 3.4.Казахстан
- 3.5.Герман
- 3.6.Малайз
- 3.7.Латви
- 3.8.Сингапур



## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хөгжил гэдэг нь хүн өөрийнхөө хэрэгцээг экосистемийн даацад тохируулан хангах зарчмыг хэлнэ.

Хөгжлийн бодлогыг улс орон бүр өөрийн нөхцөл байдал, нөөц бололцоо, нягт тооцоонд үндэслэсэн тодорхой хөгжлийн загвараа боловсруулж, шат дараалсан төлөвлөлтийн үндсэн дээр хэрэгжүүлдэг байна.

Төлөвлөлт нь тухайн байгууллага, эсхүл салбар, бүс нутаг, үндэсний хэмжээнд хөгжлийн дотоод давуу байдал, сул тал, нөөц боломжууд, эдийн засгийн болон бусад орчны өөрчлөлтийн нөлөөгөөр үүсэж болох хүндрэл бэрхшээл, эрсдлийг шинжлэн үнэлсний үндсэн дээр стратегийн зорилтуудаа тодорхойлж, түүнд хүрэх үйл ажиллагааг тусгасан өргөн цар хүрээтэй бичиг баримт юм. Мөн энэхүү баримт бичигт хөгжлийн талаар баримтлах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэглэгч, харилцагчдад хэрхэн оновчтой хүргэх арга замуудыг тодорхойлсон байдаг.

Төлөвлөлтийн салшгүй бүрдэлд 4 хүчин зүйлсийг зайлшгүй анхаарна. Үүнд:

- Цаг хугацаа
- Үйл ажиллагаа
- Санхүүжилт
- Хүний нөөц болон бусад нөөц боломж, хүчин зүйлс (Тухайн улс орны газарзүйн байрлал, уур амьсгал, хүн амын тоо, улс төрийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчин, эдийн засгийн багтаамж, байгалийн баялаг, институцийн бүтэц, зохион байгуулалт зэрэг олон хүчин зүйлс орно.)

Өнөөг хүртэл хөгжлийн талаарх тодорхой “жор” бий болоогүй байна.<sup>1</sup> Энэ талаар олон эрдэмтэд тухайлбал, Монгол Улсад хөгжлийн философиин талаар судалж байгаа эрдэмтэн Б.Даш-Ёндөн “Ганц онолд тулгуурласан нийтэд хамаатай ганцхан загвар гэж байж таарахгүй, харин тухайн **улс орон өөртөө тохирсон хөгжлийн онолоо бий болгоод, түүнээ хэрэгжүүлэх өөрийн “загвар”-ыг гаргаж мөрдөхийг оролдоно гэвэл энэ нь жич хэрэг”<sup>2</sup> хэмээн өгүүлсэн байна.**

Аливаа улсын үндэсний хөгжлийн бодлого нь сүүлийн хэдэн арван жилийн түүхээс сургамж авч, өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудыг оновчтой тогтоон, улмаар ойрын ирээдүй буюу 10-20 жилийн хугацаанд ард иргэдийн сайн сайхан амьдралыг бий болгон баталгаажуулахад чиглэгдэж байна.

Ингэхдээ хөгжлийн алтан гурвалжин болох нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлуудыг ямагт анхаарлынхаа төвд, тэнцвэртэй байлгаж байна.

Богино хугацаанд буурай хөгжлөөс хөгжингүй улс болж чадсан орнууд улсаа хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд урт, дунд, богино хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган зохион байгуулах, хянах тогтолцоог бий болгон гол удирдлагаа болгож ирсэн.

Онолын хувьд урт хугацааны хөгжлийн бодлогод дунд хугацааны, дунд хугацааны хөгжлийн бодлогод богино хугацааны бодлого үндэслэж төлөвлөгдөх бөгөөд бодлого төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүд нь өөр хоорондоо дэвшүүлсэн

<sup>1</sup> Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, туршлага. УИХ-ын Тамын Газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2013 он.

<sup>2</sup> Б.Даш-Ёндөн. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Монголын хөгжлийн философи – Цуврал 1. Нэмж, засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2017 он. 88-89 дэх талууд.

зорилго, зорилт, хамрах түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээ буюу агуулга, бүтцийн хувьд харилцан уялдсан байх ёстой байдаг.

Хувь хүний ажиллах, амьдрах орчин төдийгүй тухайн улс орныг бүхэлд нь өөрчилж чадахуйц хэрэгсэл бол бодлого, төлөвлөлт юм. Зөв төлөвлөлтийн систем өөрөө зөв хөгжилд хүрэх, зөв цагт, зөв газарт байх баталгаа нь болж өгдөг байна.

Төлөвлөлтийн амин цөм нь **тогтвортой хөгжил** байдаг байна<sup>3</sup>. Тогтвортой хөгжил нь өнөө болон хойч үеийн хүн бүрт илүү сайн сайхан амьдралыг бий болгох суурь юм.

Төлөвлөлтийг хийхдээ үндэсний, салбарын, бус нутгийн төлөвлөлтийн зорилгыг тодорхойлж, ач холбогдоор нь эрэмбэлэх, тэдгээр зорилго, зорилтыг биелүүлэхэд дэмжлэг болж өгөх хөтөлбөрийг боловсруулах, нөөцийг хуваарилах замаар төлөвлөх ба дор дурдсан тэргүүн туршлагын зарчмуудыг чухалчилдаг. Үүнд:

- *Нэг ижил нэр томьёо хэрэглэх:* Төлөвлөлтийн үйл явцад нэг ижил, товч тодорхой нэр томьёо хэрэглэж, тэдгээрийн талаар нэгдсэн ойлголттой байх явдал чухал бөгөөд энэ нь мөн хяналт үнэлгээ хийх үйл явцыг хөнгөвчилнө.
- *Төлөвлөлтийн үе шатууд хоорондоо уялдаатай байх:* Урт, дунд, богино төлөвлөлтийг бэлтгэхдээ үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг суурь болгож, уялдуулна.
- *Төлөвлөлт, гүйцэтгэл хоёрыг тэнцвэртэй байлгах:* Төлөвлөлтийн баримт бичгүүд хоорондоо давхардаагүй байх бөгөөд төлөвлөлтийн үйл явц бүрт гүйцэтгэлийг байнга дүгнэж байх хэрэгтэй.

Амжилтад хүрсэн улсуудын хувьд:

- бизнесийн тэргүүлэх салбарыг сонгох;
- тэргүүлэх чиглэл, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх;
- техник, технологийн дэвшил, ололт амжилт;
- эрчим хүч, дэд бүтцийн бодлого, нөөц баялгийг бий болгох;
- экспортын боломж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зэрэгт анхаарч төлөвлөгөө боловсруулан эдийн засгийн суурийг бэхжүүлдэг байна.



<sup>3</sup> Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 1. “ХӨГЖИЛ”-ИЙН ТАЛААРХ ЗАРИМ ТОДОРХОЙЛОЛТУУД

Нэн түрүүнд “хөгжил” гэдгийг “энгийнээр авч үзвэл бидний одоо оршин тогтнож байгаа аж байдлыг (ахуйн, материаллаг, оюун санааны гэх мэт) илүү сайжруулах үйл явц” хэмээн Г.Ганзориг нар “Ногоон эдийн засаг ба загварчлал” номондоо<sup>4</sup>, “нийгмийн ямар нэгэн шалгуур бүхий төрх байдал, шинж чанар” хэмээн эрдэмтэн Б.Даш-Ёндон “Монголын хөгжлийн философи” номондоо<sup>5</sup> тус тус тодорхойлжээ.

Харин Нобелийн эдийн засгийн шагналт Амартяя Сен “Хөгжил бол эрх чөлөө” номондоо “хөгжил” бол хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн эрх чөлөөнүүдийн хэлхээсэн дээр тогтдог гэсэн байна. Үүнд: улс төрийн буюу хүмүүсийн боломжийг эдлэх эрх чөлөө, эдийн засгийн буюу ядуурлаас гарахад дэмжлэг авах эрх чөлөө багтдаг байна.<sup>6</sup>

Орчин үед эдийн засгийн шинжлэх ухаанд “**Эдийн засгийн хөгжил**” гэдгийг эдийн засгийн болон хүний хөгжлийн цогц үр дүн гэж үздэг төдийгүй мөн байгаль орчны асуудлыг ч хамтад нь авч үзэх болсон байна.<sup>7</sup>

Мөн “тогтвортой хөгжил” хэмээх нэр томьёог 1987 оноос дэлхий нийтээр хэрэглэж эхэлжээ. “Тогтвортой хөгжил” гэдгийг Хүрээлэн буй орчны болон хөгжлийн асуудлаарх олон улсын комиссын НҮБ-д зориулж бэлтгэсэн “Бид нийтийн ирээдүй” илтгэлд: “эдүгээ цагийн хэрэгцээг хангаж буй боловч ирээдүй үеийнхэн хэрэгцээгээ хангах чадварыг нь сүйрэлд оруулахгүй тийм хөгжил юм” гэсэн бол, Оросын судлаач А.Д.Урсул, А.Л.Романович нар “Тогтвортой хөгжил нь нийгмийн амьдрал оршихуйн болон тасралтгүй дэвшилийг хангадаг бөгөөд хүрээлэн буй орчин, ялангуяа биосферийг эвдлэн сүйтгэдэггүй, нийгэм-байгальч хөгжлийн стратеги юм” гэж, ОХУ тогтвортой хөгжилд шилжих үзэл баримтлалдаа: “тогтвортой хөгжил гэдэг бол байгалийн үндсийг үл эвдсэн нийгэм-эдийн засгийн жигд хөгжил юм” гэж тус тус тодорхойлжээ.

Харин Монголын судлаачид “**тогтвортой хөгжил**” гэдгийг “хойч үе өөрсдийн хэрэгцээ, шаардлагаа хангах боломжийг хязгаарлахгүйгээр өнөө үеийнхэн өөрсдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн хөгжил” юм. Байгаль, эдийн засаг, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, алс хэтийг харсан цогц хөгжлөөр тогтвортой хөгжлийн үндсэн агуулгыг нь бүрдүүлдэг гэж тодорхойлсон байна.<sup>8</sup>

Үүний зэрэгцээ “**бодлого**” гэсэн үгийн тайлбарыг авч үзвэл энэ нь Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан улс төрийн шийдэл, үйл ажиллагааны чиглэлийг хэлнэ.<sup>9</sup>

“Хөгжүүлэх”, “хөгжлийн” бодлогын талаар эрдэмтдийн тодорхойлолтуудыг авч үзвэл: Б.Даш-Ёндон - “**хөгжүүлэх бодлого**” гэдэг нь хөгжлийг цэгцтэй өрнүүлэх талаарх төр засгаас дэвшиүүлдэг тодорхой зорилт, Г.Ганзориг нар - “**хөгжлийн бодлого**” гэдэг нь тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, зорилго, зорилтой, хэрэгжих хугацаатай, аливаа нэг хүн амын бүлэг, эсхүл зорилтот бүлэгт зориулагдсан, хүрэх үр дагавар, үр нөлөө нь хэмжигдэх боломжтой, эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг, эдийн засагч Tejvan Pettinger - “**хөгжлийн бодлого**” гэдэг нь эдийн засаг, нийгмийн бодлогыг сайжруулах замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зэрэг улс орны өмнө тулгамдсан

<sup>4</sup> Г.Ганзориг ба бусад. Ногоон эдийн засаг ба загварчлал. УБ., 2018. 60 дахь тал.

<sup>5</sup> Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Монголын хөгжлийн философи – Цуврал 1. Нэмж, засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2017 он. 95 дахь тал.

<sup>6</sup> Амартяя Сен. “Хөгжил бол эрх чөлөө”. УБ.

<sup>7</sup> Ц.Сүхбаатар. Хөгжлийн эдийн засаг. УБ., 2018 он. 22 дахь тал.

<sup>8</sup> Г.Ганзориг ба бусад. Ногоон эдийн засаг ба загварчлал. УБ., 2018. 11 дэх тал.

<sup>9</sup> Г.Ганзориг ба бусад. Ногоон эдийн засаг ба загварчлал. УБ., 2018. 60 дахь тал.

асуудлуудыг шийдвэрлэх үйл ажиллагааг төрөөс нарийн зохион байгуулалттай төлөвлөн хэрэгжүүлэх үйл явц<sup>10</sup> гэж тус тус тодорхойлсон байна.

Харин Б.Даш-Ёндон “хөгжүүлэх загвар” гэж хөгжлийн ямар нэгэн хэв маягийг өөрсдөө зохиох, “хөгжлийн загвар” гэдэг нь гадаад орнуудын аль нэгэн байдлыг хэв болгон хэрэглэх гэж салгаж тодорхойлсон байна.

“Хөгжлийн бодлогын төлөвлөлт” буюу бодлогыг боловруулах үйл явц нь тухайн бодлогыг боловруулах эрх бүхий этгээд буюу парламент, засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага нь нийгэмд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдэхэд чиглэсэн бодлогын төслийг боловсруулахаас эхлээд холбогдох шатны байгууллагаар баттуулах хүртэлх бүх шат дамжлагаас бүрдэнэ.<sup>11</sup>

## 2. ХӨГЖЛИЙН ЗАГВАРУУД

Хөгжлийн гурван гол тулгуур бол эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн хөгжил гэдгийг бүх улс орнууд хүлээн зөвшөөрсөн байdag.

Эдийн засгийн онолын чиглэлийн нэрт эрдэмтэд хөгжлийн асуудлыг зөвхөн эдийн засагтай холбож судалдаг хүрээнээс хальж улс төр, хүн амын сэтгэл зүйг сэтгэлгээ, уламжлал, ахуй заншилтай нягт уялдуулан авч үздэг болж байна.

Сүүлийн жилүүдэд улс орнууд социалист, капиталист системийн аль нэгийг шууд сонгохоос татгалзаж, харин энэ хоёр системийн давуу талуудыг оновчтой хослуулан, эдийн засгийн хөгжлийн загвараа улс орон бүр өөрийн орны өвөрмөц, дахин давтагдашгүй чанарыг агуулсан газар нутаг, түүх, соёл, ёс онцлогтой бөгөөд тэдгээртэй уялдсан төрийн байгуулалт, эдийн засаг, нийгмийн бүтэц, онцлог шинжид тулгуурлан боловсруулдаг байна.

Дэлхийн улс орнуудын хөгжлийн загварын нийтлэг хандлагыг авч үзвэл дараах байдалтай байна.<sup>12</sup> Үүнд:

- 1) Америкийн хөгжлийн загвар
- 2) Европын хөгжлийн загвар
- 3) Азийн хөгжлийн загвар

Эдгээр загваруудыг дэлгэрүүлэн авч үзвэл:

**1) Америкийн хөгжлийн загвар** нь амьдралын америк загварыг хувь хүний үнэлгэмж, үнэт зүйлсийг дээдэлсэн шинж чанартай, хөгжил хөдөлгөөнтэй, хүмүүнлэг, урагшаа харсан, тэмүүлсэн өөдрөг үзэл гэж үздэг. Гэвч АНУ-д хувь хүний өөрийн болон бусдын өмнө хүлээх хариуцлагыг дээд зэргээр мэдрүүлсэн ч төрөөс хүн амын талаар авах зарим бодлогыг хязгаарласан нь хөгжлийн бусад загвараас ялгаатай гэж эрдэмтэд үздэг. Эдийн засгийн орчин үеийн судлаачид олон үндэстнээс бүрдсэн ардчилал, эрх чөлөө, зах зээлийн нийгэм нь хөгжлийн ерөнхий чиг хандлага болохоос биш улс орон бүрийн хөгжлийн загвар биш гэж үзэх болжээ.

**2) Европын хөгжлийн загварт** Англи, Эх газрын, Газар дундын тэнгисийн болон Умардын (буюу Нордикийн) гэсэн 4 загвар байдаг. Дэлхийн 2-р дайны дараа хямд эрчим хүч үйлдвэрлэх, АНУ-ыг үйлдвэрлэлийн зарим чиглэлээр гүйцэх гэсэн хоёр эрмэлзлэлд тулгуурласан тодорхой зорилтууд дэвшигүүлэн хэрэгжүүлсэн байдаг.

<sup>10</sup> <https://www.economicshelp.org/blog/4998/development/policies-for-economic-development/>

<sup>11</sup> Г.Ганзориг ба бусад. Ногоон эдийн засаг ба загварчлал. УБ., 2018. 62 дахь тал.

<sup>12</sup> Ц.Сүхбаатар “Хөгжлийн эдийн засаг” УБ, 2018 он.

- **Английн хөгжлийн загвар** - Зах зээлийн эдийн засгийн уламжлал сонгодог чиглэлийг баримталдаг, ядуурал орлогын тэгш бус байдал, нийгмийн хамгаалал зэрэгт харьцангуй бага анхаардаг барууны үзэл баримтлал бүхий загвар юм.
- **Эх газрын загвар** - Эдийн засгийн идэвхтэй хүн амын ажлын байрыг найдвартай хадгалах, нэмэгдүүлэхэд түлхүү чиглэгдсэн, аж үйлдвэр, үйлчилгээг орчин үеийн стандарт шаардлагын дагуу оновчтой зохион байгуулахад илүү анхаардаг онцлогтой. Гэвч хөдөлмөрийн зах зээл нь уян хатан биш, даатгалд тулгуурласан ажилгүйдлийн тэтгэмж үйлчилдэг загвар юм. Үүнийг Австри, Франц, ХБНГУ, Бельги, Люксембург зэрэг орнуудад хэрэгжүүлсэн.
- **Газар дундын тэнгисийн загвар** - Улсын тэтгэвэрт тулгуурласан нийгмийн хамгааллын тогтолцоотой. Хөдөлмөрийн зах зээл нь ажлын байрны хамгаалалтайгаа тэр бүр зохицдоггүй. Үүнийг Итали, Испани, Грек, Португали, зэрэг орнууд хэрэгжүүлсэн.
- **Нордик буюу Умардын загвар** - Үүнийг хөгжиж байгаа улс орнууд ихээхэн сонирхдог, харьцангуй үр дүнтэй социал-демократ үзэл баримтлал бүхий хөгжлийн загварт тооцогддог. Энэ нь эдийн засгийн өндөр хөгжилтэй, төрийн санхүүжилт бүхий нийгмийн хамгааллын боловсронгуй, олон жил мөрдөгдөж ирсэн тогтолцоотой, хүн амын олонх нь орлогын хувьд нийгмийн дундаж давхаргад хамрагдсан зэрэг давуу талтай. Гол онцлог нь нийгмийн үр дүнтэй, тогтвортой байдлыг хангах зорилтыг зах зээлийн холимог эдийн засгийн тогтолцоотой хослуулж чадсанд оршино. Эдгээр улс орнуудад нийгмийн хамгаалал, эмнэлгийн үйлчилгээ, үнэ төлбөргүй боловсрол гэсэн нийгмийн гурван гол бодлого хэрэгжүүлдэг. Гэвч сүүлийн жилүүдэд тэтгэмжээр дагнан амьдардаг давхарга бий болох, хөренгө гадагш урсах зэрэг сөрөг зүйлс бий болсон. Энд Дани, Финланд, Швед, Норвеги, Исланд зэрэг орнууд хамрагддаг.

**3) Азийн хөгжлийн загвар** - Азийн улс орнуудын хөгжлийн түвшин хэдийгээр өөр хоорондоо ихээхэн ялгаатай боловч эрчимтэй хөгжиж байгаа улс орнуудын хувьд нийтлэг зүйлс цөөнгүй байдаг. Тухайлбал,

1. төр засаг хүчирхэг, чанга, зарчимч, авилгагүй байж эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлсэн;
2. экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарсан;
3. төрийн захиргааны зардлыг хамгийн бага байлгаж, хэмнэж ажилласан;
4. төрийн зарим үүргийг орлон гүйцэтгэдэг зардал багатай төр, хувийн хэвшлийн хосолсон хэлбэр болох PPP (Public-private-partnership)-ийн үр дүнтэй тогтолцоог хэрэглэсэн;
5. нийгэм-эдийн засгийн гол зангилаа асуудлыг боловсруулахдаа хэрэглэдэг хүлээцтэй хандлага (жишээлбэл, БНХАУ-ын төрийн бодлогод Күнзийн сургаалд тулгуурласан эдийн засаг, сэтгэлгээний ерөнхий зарчмуудыг баримталдаг);
6. дотоодын хөрөнгийн бүх нөөц, нийгмийн даатгалын хөрөнгийг бүрэн дайчилж, ашиглалтыг сайжруулснаар эдийн засгийн өсөлт, хөгжлийг бий болгоход хуримтлалын эх үүсвэр болгон ашигласан;
7. Сингапурын баялгийн төвлөрсөн сан, орон сууцны хөтөлбөр, БНСУ-ын тэтгэврийн сан, Тайваний эрүүл мэндийн тогтолцоо, Японы ахуйн үйлчилгээ, БНХАУ-ын нийгмийн хамгааллын тогтолцоо, ядуурал, ажилгүйдлийг даван туулж байгаа арга зам зэрэг хөгжилд эерэгээр нөлөөлсөн үр дүнтэй бодлогуудыг нэрлэж болно.

- **Японы хөгжлийн загвар** - тус улс дэлхийн 2-р дайны дараа эдийн засгаа сэргээх 10 жилийн төлөвлөгөө боловсруулан, ард түмэндээ ойлгомжтой цөн зорилт дэвшүүлж, хүч нөөц боломжоо дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд бүрэн дайчилсан байдаг. Энэ үеийн Японы макро эдийн засгийн хамгийн чухал төлөвлөсөн зорилт бол үндэсний орлогыг 2 дахин өсгөх явдал байсан бөгөөд энэ шахуу зорилтыг амжилттай хэрэгжүүлж чадсан байна. Эдийн засгийн макро зорилтуудыг дотор нь тодорхой бүлэг зорилтуудад багцлан уялдуулан хэрэгжүүлсэн нь ихээхэн сургамжтай гэж судлаачид үздэг.

Азийн улс орнууд хөгжлийнхөө загвараа боловсруулж хэрэгжүүлэхдээ Япон улсын эдийн засгийн өсөлтийн загвар, түүний онцлог сургамжийг заавал судалж харгалzan үзэж иржээ.

- **БНСУ-ын хөгжлийн загвар** - тус улсыг хөгжлийн хамаарлын загварууд үр дүнтэй хөгжсөн улс гэж эрдэмтэд үздэг. 1945 он хүртэл эдийн засаг нь Япон улсаас ихээхэн хамааралтай байгаад 1950-аад оноос АНУ-ын тусlamж дэмжлэгээс ихээхэн хамаарах болсон байдаг.

БНСУ экспорт, импортын бодлого хэрэгжүүлэхдээ АНУ, Японтой хорших хэлбэрт шилжиж, эдгээр орнуудын туслалцаатайгаар хөгжиж байгаа бусад улс орнуудын зах зээлд гарах бодлого хэрэгжүүлсэн. Тэд хөгжлийн эхэн үедээ гадаадын тусlamж дэмжлэгийг их хэмжээгээр авч бүтээлчээр ашигласан нь хөгжлийн хамаарлын загвар үр дүнтэй хэрэгжиж болохыг олон улсад харуулсан юм. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг шууд утгаар нь хэрэгжүүлээгүй, харин зээллэг хэлбэрээр хэрэгжүүлсэн онцлогтой. Чөлөөт зах зээлд тулгуурласан сонгодог загварыг хөгжиж байгаа улс орнууд нэлээд хэрэглэсэн байхад БНСУ-д төрийн төвлөрсөн зохицуулах бодлогыг түлхүү баримталсан байдаг. Тухайлбал, үйлдвэрийн газар бүрт улсаас даалгавар өгч, татварыг зохицуулах механизмыг өргөн хэрэглэж, төлөвлөлтийн арга замыг ихээхэн ашигласан. Ялангуяа эдийн засгийн салбар бүрт үйлдвэрлэл, үйлчилгээний технологийг сайжруулах, түүнтэй холбоотой лиценз олгох, хянах, зохих хэмжээгээр урамшуулан дэмжих төрийн бодлого тууштай хэрэгжүүлсэн байна.

- **Сингапурын хөгжлийн загвар** - тус улсын хөгжлийн загварын гол нууц нь Хонконг, Швейцар, Израил улсын туршлагыг судалж, хэрэгтэй зүйлсүүдийг тусгаж авсан социалист, капиталист хувилбарын оновчтой хослолыг хэрэгжүүлсэн гэж үздэг. Тус улс капиталист зах зээлд төрийн оролцооны оновчтой хүрээг тодорхойлж, Засгийн газрын дунд болон урт хугацааны бодлогыг дагаж мөрдөж чадсан байна. Сингапур улсын хурдацтай өсөлт дараах хэд хэдэн хүчин зүйлсээс шалтгаалсан гэж В.Ж.Хафф тодорхойлжээ. Үүнд: Засгийн газрын зүгээс хөдөлмөрийн зах зээлд хийсэн зохицуулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг болон иргэдээ мөнгөн хуримтлалтай болохыг дэмжсэн бодлогууд, мөн төрийн өмчит компаниудын оновчтой менежментийг тодорхойлох, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зэрэг бодлогуудыг дурдсан байна. Түүнчлэн эдийн засаг, улс төрийн шийдвэрүүдийг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролтой “элит бүлэг” (elite group) гаргаж байсан. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хөгжилд эдийн засаг, улс төрийн “институц”-ээс гадна боловсролтой, манлайлагч (leader), элит бүлгийн үүрэг оролцоо чухал байсан.

- **Хятадын хөгжлийн загвар** - Хятадын эдийн засгийн хөгжил нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн түүхэн дэх өвөрмөц загвар гэж тэмдэглэгддэг байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийн загварыг баримталж байсан Хятад улс нь

1979 оноос хөдөө аж ахуй, аж үйлдвэр, санхүү, банк, үнэ, хөдөлмөрийн зах зээлийг хамарсан эдийн засгийн томоохон өөрчлөлтийг эхлүүлсэн байна.

- тариалангийн газрыг иргэдэд эзэмшигж, газар тариалангийн үйлдвэрлэлээ тариаланчид өөрсдөө эрхлэх, чөлөөт зах зээлд бараа бүтээгдэхүүнээ чөлөөтэй борлуулах саад хязгаарлалтыг арилгаснаар хөдөө аж ахуйн салбарт улсын ба хувийн аж ахуй зэрэгцэн орших болсон байна.
- аж үйлдвэрийн салбарт хувийн үйлдвэрлэл, өмчийг зөвшөөрч, хөрөнгө оруулалтыг гол төлөв хөнгөн ба өндөр технологи бүхий үйлдвэрлэл рүү чиглүүлснээр аж үйлдвэрт өрсөлдөөн үүсэж, гадаад зах зээл рүү тэмүүлэх болжээ. Түүнчлэн 1997 онд Хятадын Коммунист намын Их Хурлаас улсын өмчит томоохон үйлдвэрүүдийг худалдах, нэгтгэх, хаах зэргээр өөрчлөх зорилт дэвшүүлсэн нь томоохон дэвшил болжээ.
- эдийн засгийн тусгай бүс /special economic zones/, нээлттэй бүс /open areas/ хэд хэдийг байгуулж, эдгээр бүсэд татварын таатай орчин бий болгосноор гадаадын капитал чөлөөтэй орж ирэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 1993 он гэхэд Хятадад 200 гаруй эдийн засгийн тусгай бүс байгуулагдсан байна.
- төвлөрсөн төлөвлөлтийг багасгаж, зах зээлийн механизмыг өргөн нэвтрүүлж, төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг чөлөөт зах зээлд борлуулах эрх олгосноор дан ганц хатуу тогтоосон үнэ үйлчлэх бодлого өөрчлөгджэй, энэ нь эдийн засгийн идэвхийг сэргээн, хөгжлийг хурдасгахад чухал түлхэц болжээ.

Хөгжлийн алсын хараагаа зөв томьёолох, түүндээ чиглэсэн бодлогын уялдаатай, цэгцтэй арга замуудаа гаргахад маш нарийн, өргөн хүрээтэй төлөвлөлтийн үйл явцыг баримтлах нь чухал юм. Төлөвлөлтийг хийх дараах зарчмууд байдаг<sup>13</sup>. Үүнд:

- дээрээс доош (top down)
- доороос дээш (bottom up)

Дээрээс доош төлөвлөх хэсэгт макро түвшний зорилтуудыг хөгжлийн алсын хараатай уялдуулж тооцох, томьёолох үйл явцыг авч үздэг. Ингэхдээ тодорхой загварчлалыг ашиглан (тухайлбал CGE загвар, салбарын хоорондын тэнцлийн загвар) дунд хугацааны зорилтуудаа буцаан хөөж тооцох (backcasting) боломжтой юм. Өөрөөр хэлбэл, урт хугацааны хөгжлийн зорилтуудад нийцүүлэн дунд хугацааны зорилтод хүрэх үр дүнгээ тооцож гаргах үйл явц юм. Үүний дараа доороос дээш төлөвлөх буюу салбаруудын, салбар дундын болон орон нутгийн хөгжлийн тэргүүлэх зорилтуудтай уялдуулан томьёолж, эдгээр зорилтуудыг хангах үйл ажиллагаа, бодлогын хөшүүргүүд, төсөл хөтөлбөрүүдийг нарийвчлан тодорхойлно. Төлөвлөлтийн энэ үе шатуудад үр дунд сууринсан зарчмыг тогтмол хангах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, доороос дээш төлөвлөх буюу салбаруудын, салбар дундын болон орон нутгийн хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хангаснаар дээрээс доош төлөвлөлтөөр томьёологдсон макро түвшний зорилтууд түүний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байхаар төлөвлөнө гэж ойлгож болно. Ингэж дээрээс доош болон доороос дээш төлөвлөх явцад дараах хэдэн зарчмуудыг хэрэглэнэ. Үүнд:

- өнгөрсөн болон өнөөгийн нөхцөл байдалд бодитой цогц үнэлэлт дүгнэлт өгч цаашид авах бодлого арга хэмжээнд сургамж авдаг байх;
- урт, дунд, богино хугацааны, салбар хоорондын (horizontal) болон үндэсний, бүс, орон нутгийн (vertical) бодлогын уялдааг хангах;

<sup>13</sup> Ж.Должинсүрэн. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим асуудал. “Олон улс судлал” дугаар 1(109) 2019 он.

- бодлого боловсруулахдаа нотолгоонд суурилсан байх, шинжлэх ухааны үндэстэй, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулдаг байх;
- бодлогын тэргүүлэх зорилтуудыг оролцооны аргаар томьёолох (тулгамдаж буй асуудлууд болон авах арга хэмжээний шийдлийг эрх ашиг нь хөндөглөх талуудтай хэлэлцэж хамтран тодорхойлдог байх);
- үр дүнд суурилсан төлөвлөлтийг хийх;
- хэрэгжүүлэх, хяналтын, хариуцлагын механизмыг тодорхойлох гэх мэт.

Хөгжлийн бодлогыг боловсруулахдаа юуны өмнө өнөөгийн нөхцөл байдал, дотоод болон гадаад орчны шинжилгээ, нөлөөлж буй эерэг ба сөрөг хүчин зүйлсийг илрүүлж, сүл ба давуу талууд болон боломжууд, эрсдлийг тодорхойлж, үйлдвэрлэлийн нөөц, чадамж, түүний хэрэглээнд үнэлгээ өгч, мэргэжлийн хүмүүс болон ашиг сонирхол нь хөндөгдэх талуудыг өргөнөөр оролцуулж, хөгжлийн таамаглалыг 2-3 хувилбараар дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх соёл, зан төлвийг бий болгох, тулгамдаж буй асуудлуудыг эрэмбэлсэний дараа тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, салбаруудын бүтцийг оновчтой болгож, бодлогын арга хэрэгсэл, механизмууд, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, хэрэгжүүлэгч институциудын бодлого, үйл ажиллагааны уялдааг хангахад шаардлагатай нөөцийн байршилтыг оновчтой тодорхойлох чухал ач холбогдолтой. Уг бодлогыг хэрэгжүүлэх явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан алдааг засах, шалгуур үзүүлэлтүүдээс хазайсан шалтгааныг тогтоож, запруулга хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй болно. Мөн түүнчлэн дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, туршлага дээр үндэслэн хүртээмжтэй өсөлт, тогтвортой хөгжилд чиглэсэн төлөвлөгөөний зорилтолт түвшин, хүрэх ёстой үр дүнг биелүүлэхэд шаардлагатай бодлогын зорилт үйл ажиллагааг тодорхойлж ач холбогдолоор нь эрэмбэлэх, хэрэгжүүлэх төлөвлөгөөнд давхардал, өөр хоорондын зөрчил гаргахгүй байхын тулд баримтлах зарчмыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд гарч болох саад бэрхшээлүүдийг (олон улсын нөхцөл байдал болон хөрөнгө нөөцийн бололцоо) урьдчилан тооцож, хариу авах арга хэмжээ мэдээллийг судалдаг байх нь чухал юм. Үүнийг олон улсад хувилбарт төлөвлөлт (scenario planning)-ийн арга гэж үздэг.

### **3. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

Улс орон бүр өөрийн өвөрмөц, дахин давтагдашгүй чанарыг агуулсан газар нутаг, түүх, соёл, ёс заншилтай бөгөөд тэдгээртэй уялдсан төрийн байгуулалт, эдийн засаг, нийгмийн бүтэцтэй. Хөгжлийн бодлогоо төлөвлөхдөө ч өөрийн орны онцлог шинжид тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлдэг. Иймд энэхүү ялгаатай байдлыг харгалзан үзэлгүйгээр улс орнуудын хөгжлийн бодлого төлөвлөх механизмыг шууд харьцуулан авч үзэх нь учир дутагдалтай. Хөгжлийн хувьд амжилттай хөгжсөн болон хөгжиж байгаа орнуудын хувьд хөгжлийн бодлогын баримт бичгүүдээ боловсруулахдаа урт хугацаанд 20 жил, дунд хугацаанд 5 жил, богино хугацаанд буюу жил бүрийн төлөвлөгөө, төсөв боловсруулж байна.

Урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь ихэнх оронд тунхаг хэлбэрээр бичигдэж, түүнд дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг тодорхой үе шат бүхий дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусган, жил бүрийн төлөвлөгөө болон төсвийн хүрээнд хэрэгжүүлж байна. Бодлого төлөвлөлтийг нэлээд урт хугацаагаар хийдэг улс нь Казахстан бөгөөд урт хугацаанд 40 жил, дунд хугацаанд 20 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөдөг байна. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах, тэдгээрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг байна. Түүнчлэн аж үйлдвэржсэн, хөгжингүй орнуудын туршлагаас харахад хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал тэдгээр орнуудын хөгжлийн

үйл явцын чухал хэсэг болж байна.<sup>14</sup>

Судалгаанд хамрагдсан улс орнуудын төлөвлөлтийн (урт, дунд богино) хугацааг харьцуулан хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

	<b>Үрт хугацааны төлөвлөгөө</b>	<b>Дунд хугацааны төлөвлөгөө</b>	<b>Богино хугацааны төлөвлөгөө</b>
1. ОХУ	10-20 жил	5-10 жил	3-5 жил
2. Их Британи	10 жил	5 жил	1-3 жил
3. Япон Улс	10 жил	5 жил	1-3 жил
4. Казахстан Улс	5 жилээс дээш	1-5 жил	1 жил
5. Герман Улс	10 жил	1-5 жил	1-3 жил
6. Малайз Улс	10 жил	5 жил	1 жил
7. Латви Улс	10 жил	5 жил	1-3 жил
8. Сингапур Улс	40-50 жил	5 -10 жил	1-3 жил

### 3.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

2006 онд “ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг боловсруулж, 2008 онд баталжээ. 2012 оны 1 дүгээр сарын 24-нд ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин “ОХУ-ын нүүрсний аж үйлдвэрийг 2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр”-ийг баталж, үүний санхүүжилтэд 3,7 триллион рубль гаргахаар шийдвэрлэсэн байна.

2009 онд “ОХУ-ын Стратеги төлөвлөлт”-ийг баталсан<sup>15</sup> ба түүний зорилго нь үндэсний нөөц, иргэний нийгмийн чадварыг үр ашигтай ашигласнаар Үндсэн хуулийн эрх, эрх чөлөө, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, түвшинг хангах, ОХУ-ыг тогтвортой хөгжүүлэх, улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд институциональ зохион байгуулалтын болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

Стратеги төлөвлөлтийн үндсэн зарчмууд:

1. ОХУ-ын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээ нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай харилцан уялдаатай байх;
2. Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд ОХУ-ын төрийн байгууллагуудын бүрэн эрх болон тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулалтыг зааглах;
3. Тогтвортой хөгжилтэй холбоотой урт хугацааны шийдвэрүүд нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдтэй нийцсэн байх;
4. Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх болон эдийн засаг, соёл, оюуны хөгжлийг эрчимжүүлэх арга хэмжээг цаг үеэ олж хэрэгжүүлэх;
5. Хувь хүн, нийгэм, улс орноо зохистой хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад үндэсний стратеги чиглэлүүдэд цаг үеэ олж тодотгол хийх;

<sup>14</sup> Ж.Должинсүрэн. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим асуудал. “Олон улс судлал” дугаар 1(109) 2019 он.

<sup>15</sup> Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.

6. Тогтвортой хөгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангахад материаллаг, санхүү, боловсон хүчин, шинжлэх ухаан-технологи, мэдээлэл болон бусад нөөцийг төвлөрүүлэх.

Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг хугацааны хувьд урт /10-20 жил/, дунд /5-10 жил/ болон богино хугацаагаар /3-5 жил/ боловсруулна.

### 3.2. ИХ БРИТАНИ

Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа төлөвлөлтийн бодлого (planning policy statements), эрдэс баялгийн бодлого (minerals policy statements) болон Үндэсний бодлого (National Policy Statements) гэдэг баримт бичгүүд байна. Мөн Засгийн газар, салбарын яамдаас гаргасан төлөвлөлтийн асуудлыг шийдэхэд бодлого болон бусад хүчин зүйлүүдэд ач холбогдол өгөх тайлан, удирдамжууд эзэнтэй.

Их Британи Улсын Засгийн газрын Тогтвортой хөгжлийн стратеги буюу Ирээдүйг баталгаажуулах (Securing the Future) баримт бичгийг 2005 онд батлан гаргаж хөгжлийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл;
- уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүч;
- байгалийн баялгийг хамгаалах;
- тогтвортой нийгмийг цогцлуулах.

1999 оноос хойш 6 жилийн турш боловсруулагдаж гарсан уг бодлогын баримт бичиг нь хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах урт хугацааны стратеги юм.

### 3.3. ЯПОН

Япон Улсын хэрэгжүүлсэн урт, дунд, богино хугацааны ("Comprehensive National Development Plan (CNDP) -1,2,3,4", "Comprehensive National Development Plan-5 and Grand Design for the 21st Century", "Japan's Future Development Strategy and Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy", 2007 оноос хойш хэрэгжүүлж буй "Japan's Innovation-25 strategy", "Japan Revitalization Strategy, Japan is back) төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг судалж үзлээ.

Япон Улсын төлөвлөлтийн тогтолцоо нь хууль, эрх зүйн хяналт, төлөвлөлт хийх, газар төлөвлөлт, бүсчлэх, хүн амын нягтаршилыг хянах зэрэг олон бүрэлдэхүүнийг хамарсан нарийн тогтолцоо юм. Японы төлөвлөлт нь үндэсний, бүсийн, орон нутгийн гэсэн 3 түвшинд явагддаг байна.<sup>16</sup>

Япон Улс хугацааны хувьд 5-25 жилийн урт хугацааны төлөвлөгөө, дунд хугацааны буюу 5 жилийн төлөвлөгөө, мөн богино хугацааны буюу жилийн төлөвлөгөө /төсвийн төлөвлөлт/ гэсэн 3 янзын төлөвлөгөөг боловсруулж баталдаг.

Урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрт Японы ирээдүйн хөгжлийн бодлого, чиглэлийг хэтийн зорилго болгон боловсруулж баталдаг бол таван жилийн төлөвлөгөөгөөр эдийн засаг, нийгмийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тогтоож, түүнд хүрэх тоон үзүүлэлт, түвшинг тогтоодог.

Япон улсын төлөвлөлтийн баримт бичгүүдээс дурдвал:

- Урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
  - "Japan's Innovation-25 strategy" 2025 он

<sup>16</sup> <http://www.gdrc.org/uem/observatory/jp-overview.html>-Global Development Research Centre, 2010

- Comprehensive National Development Plan-1 /1962-1970 он/
  - Comprehensive National Development Plan-2 /1969-1985 он/
    - Comprehensive National Development Plan-3 /1977-1987 он/
      - Comprehensive National Development Plan-4 /1987-2010 он/
        - Growth Initiative towards Doubling the Size of Asia's Economy
        - Comprehensive National Development Plan-5 or Grand Design for the 21st Century /1998-2015 он/
        - Japan is back, Japan Revitalization Strategy
        - Strategic Market Creation Plan
  - Дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
    - 5 year economic plan
    - Japan's 5-Year Science Plan
  - Богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг:
    - Annual report
    - budget report
    - other

Японы эдийн засгийг хөгжүүлэх талаар боловсруулсан хамгийн чухал төлөвлөгөө бол “Үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлэх” төлөвлөгөө байсан. Энэ төлөвлөгөөг 1960 онд баталсан ба уг төлөвлөгөөгөөр эдийн засгийг жилд 7.2 хувиар өсгөж, 10 жилийн дотор Японы үндэсний орлогыг 2 дахин өсгөж, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх зорилго тавьсан юм. Уг төлөвлөгөө нь дотроо нийтийн аж ахуйг хөгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, экспортыг хөгжүүлэх, хөгжиж байгаа орнуудтай гадаад худалдаагаа өргөжүүлэх, шинжлэх ухааныг хөгжүүлэх, мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй болох, эдийн засгийн давхардсан бүтцийг арилгах, нийгмийн тогтвортой байдлыг хангах гэсэн үндсэн бодлогуудаас бүрдэж байжээ.

Япон Улсын хөгжил дэвшилд хүрэх, эдийн засгаа сэргээн хөгжүүлэх оновчтой зөв бодлогын гол цөм нь дотоод, гадаад зах зээлд нийцүүлэн хөгжүүлэх салбараа зөв сонгож авсан, аж үйлдвэрийн зохистой бүтцийг бүрэлдүүлсэн явдал юм.

### 3.4. КАЗАХСТАН<sup>17</sup>

Казахстаны Ерөнхийлөгчийн 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Бүгд Найрамдах Казахстан Улсын төлөвлөлтийн тогтолцооны тухай” зарлигийн дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын төлөвлөлтийн тогтолцоо батлагджээ.

Казахстан Улсын төлөвлөлтийн тогтолцоо гэдэг нь улс орны хөгжлийг урт (5 жилээс дээш), дунд (1-5 жил), богино (1 жилийн) хугацаанд хангах улсын хөгжлийн төлөвлөлтийн зарчим, үйл явц, баримт бичиг, оролцогчдоос бүрдсэн харилцан хамаарал бүхий харилцааны цогц юм.<sup>18</sup>

Тус улсын төлөвлөлтийн тогтолцоо нь дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Казахстаны 2050 он хүртэлх хөгжлийн Стратеги;
- БНКазУлсын 10 жилийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө, Улс орны газар нутаг-орон зайн хөгжлийн прогнозын схем;
- БНКазУлсын Үндэсний аюулгүй байдлын стратеги;
- Нийгэм-эдийн засгийн 5 жилийн прогноз;

<sup>17</sup> Гадаадын зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хангах тогтолцоо  
Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл

<sup>18</sup> О Системе государственного планирования в Республике Казахстан. <http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>

- Улсын хөтөлбөрүүд (5 жил хүртэл);
- Засгийн газрын хөтөлбөрүүд (5 жил хүртэл);
- Төрийн байгууллагуудын 5 жилийн стратегийн төлөвлөгөө;
- Бүс нутгийн хөгжлийн 5 жилийн хөтөлбөр;
- Үндэсний компаниудын 10 жилийн хөгжлийн стратеги зэрэг болно.

Казахстаны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “Казахстан -2050” Стратеги: Улсын шинэ улс төрийн чиг шугам” илгээлтийн<sup>19</sup> дагуу түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Ерөнхийлөгчийн №449 Зарлиг гарсан. Уг Зарлигаар дээрх илгээлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний Үндэсний төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцах, тайлбарлан-таниулах ажлыг нийгэм, олон нийтэд системтэйгээр явуулах, жил бүрийн 1 дүгээр сарын 25, 7 дугаар сарын 25-ны өдөр бүтэн жил болон хагас жилийн үр дүнгээр Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын мэдээллийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт танилцуулах үүргийг Засгийн газарт, “Казахстан-2050” Стратегийн хэрэгжилтийн талаарх Ерөнхийлөгчийн Зарлигийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус өгчээ.

Казахстан Улсын Хөгжлийн стратеги төлөвлөгөөний үнэлгээг улсын төлөвлөлтийг хариуцсан эрх бүхий байгууллагаас Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэнээс хойш 5 жилийн дараа нийт тайлант хугацааны хэрэгжилтийн тайлан, статистик мэдээлэл, хяналт шалгалтын материал, төрийн аудит, гадаад, дотоодын шинжээчдийн дүн шинжилгээ, ТББ, шинжлэх ухааны хүрээлэнгийн үнэлгээнд үндэслэн хийж, үнэлгээний дүгнэлтийн төсөл бэлтгэх хэлбэрээр гаргана.

### **3.5. ГЕРМАН**

Герман улс 2002 онд Холбооны Засгийн газраас дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийг 10 гаруй жил хэрэгжүүлж байна.

Тогтвортой хөгжлийн удирдлагын зарчим нь Удирдлагын дүрэм болон тогтвортой хөгжлийн зорилтууд, үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдээр тодорхойлогдох бөгөөд эдгээр нь тасралтгүй хяналт үнэлгээний суурийг бүрдүүлнэ. Удирдлагын үндсэн 10 дүрэм нь удирдлагын зарчмаас гадна тогтвортой хөгжлийн шаардлагуудыг илэрхийлнэ. 21 салбарын үндсэн индикатор, 38 тоон зорилт нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлохоос гадна үр дүнг хянахад чухал үүрэгтэй.

Тасралтгүй мониторингийн хүрээнд хэрэгжилтийн явцын тайлан тогтмол гарна. Хоёр жил тутамд Холбооны статистикийн байгууллага тогтвортой хөгжлийн индикаторуудын байдлын тайланг нийтэлдэг.

Дөрвөн жил тутам хэрэгжилтийн явцын тайлан хэлбэрээр Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийн тайланг гаргана. Уг тайланда Стратегийн хэрэгжилтийн явцыг үнэлэхээс гадна тавигдсан зорилтод хүрэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж, Стратегийг боловсронгуй болгоно.

Холбооны Засгийн газрын кабинет тогтвортой хөгжлийн стратегитэй холбоотой аливаа шийдвэрийг гаргана. Шаардагдах бэлтгэл ажлыг **Тогтвортой хөгжлийн асуудлаарх төрийн нарийн бичгийн дарга нарын хороо** гүйцэтгэнэ. Уг хороог Холбооны канцлерийн албаны дарга тэргүүлнэ. Хороо Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийн агуулгыг цаашид боловсронгуй болгох асуудлыг хариуцахаас гадна индикаторуудын тухайн үеийн байдлыг тогтмол хянана.

<sup>19</sup> Послания Главны государства народу Казахстана от 14 декабря 2012 года «Стратегия «Казахстан-2050»: новый политический курс состоявшегося государства». [online.zakon.kz](http://online.zakon.kz)>online.zakon.kz/

Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийн асуудлыг Холбооны канцлерийн алба хариуцна. Стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх яамдын албан тушаалтнууд оролцно.

**Тогтвортой хөгжлийн зөвлөл** нь Холбооны Засгийн газарт тогтвортой хөгжлийн бүх асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй байгууллага юм. Зөвлөлийн 15 гишүүнийг холбооны канцлер 3 жилийн хугацаагаар томилдог. Зөвлөл мэргэжлийн хувьд хараат бус байгууллага бөгөөд Стратегийн хэрэгжилтийн талаарх өөрийн дүгнэлтээ нийтлэхээс гадна цаашдын хөгжлийн талаарх саналаа зөвлөмж хэлбэрээр гаргана. Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцсан Парламентын зөвлөлдөх зөвлөл нь бундестагт Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийг дэмжин ажилладаг.

### 3.6. МАЛАЙЗ

Малайз Улс 1950-иад оноос хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Малайзын Засгийн газар улсын Нэгдүгээр таван жилийн хөгжлийн төлөвлөгөөг (*First Malaya Plan 1956-1960*) хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн хөгжлийг төлөвлөх, салбар хоорондын төлөвлөлт, хяналтын механизмыг бий болгох чиг үүрэг бүхий Эдийн засгийн төлөвлөлтийн товчоог (*Economic Planning Unit EPU*) Ерөнхий сайдын дэргэд байгуулсан.

Малайз Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн үндсэн баримт бичгүүд нь:

- Урт хугацааны төлөвлөлт
  - Малайзын хөгжлийн үзэл баримтлал 2020
  - Нэгдүгээр Хэтийн төлөвлөгөө, 1971-1990
  - Хоёрдугаар Хэтийн төлөвлөгөө, 1911-2000
  - Гуравдугаар Хэтийн төлөвлөгөө, 2001-2010
- Дунд хугацааны төлөвлөлт
  - Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө
- Богино хугацааны төлөвлөлт
  - Жилийн төсөөв зэргээс бүрдэж байна.

Урт хугацааны төлөвлөлт - 1991 онд Малайзын Засгийн газраас батлан гаргасан “Малайзын хөгжлийн үзэл баримтлал 2020”-д: 2020 он гэхэд хөгжингүй орон болон хөгжсөн байх нь нийт үндэстний зорилго мөн гэж тунхагласан байна. Үзэл баримтлалд эдийн засаг, түүний дотор аж үйлдвэрт бүтцийн өөрчлөлт хийж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг ханган, жилийн дундаж өсөлтийг 7 хувьтай байлгаснаар Малайз Улс аж үйлдвэржсэн, бүх талаар хөгжингүй улс болно гэж тусгажээ.

Дунд хугацааны төлөвлөлт - урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх алхам болгон 5 жилийн хугацаатай дунд хугацааны төлөвлөлтийг хийнэ. Энэ төлөвлөлтөөр макро эдийн засгийн зорилтууд, салбарын хөгжлийн чиглэл, хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлно. Тухайн 5 жилийн хугацааны дундуур төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг явуулж, шаардлагатай бол макро эдийн засаг болон хөрөнгө оруулалтын бодлого, салбарын хөгжлийн зорилтуудад засвар хийдэг.

Богино хугацааны төлөвлөлт - жилийн төсвийг Сангийн яам боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, Төв банк санхүү, мөнгөний бодлогыг тодорхойлоход тус тус оролцно.

### 3.7. ЛАТВИ

Тус улсын “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” нь 2009 оны 1 дгээр сарын 1-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба Латви улсын Сейм “Латвия-2030” тогтвортой хөгжлийн стратегийг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр баталжээ. “Латвия-2030” тогтвортой

хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хяналтыг нийгмийн удирдлага буюу Сайд нарын танхим, шууд удирдлагын байгууллагууд, нутгийн өөрөө удирдлагын байгууллагууд нь нийгмийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ.

Засгийн газар нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хариуцан гүйцэтгэдэг ба үүний дотор улс орны төлөвлөлт хариуцсан Яам нь тогтвортой хөгжлийн урт болон дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналтыг шууд хариуцан ажилладаг.

Латви Улсын парламентын сонгуулийн дараах эхний ба гурав дахь жилүүдэд 2 жилд нэг удаа Сайд нарын танхимаас “Латвия-2030” тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх илтгэлийг Сеймд хэлэлцүүлэхээр оруулна. Мэдээллийн үндсэн дээр Сейм стратегийн зорилтуудад зарим өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргаж болно.

Сейм шинээр Тогтвортой хөгжлийн байнгын хороог байгуулсан бөгөөд тус хорооны гишүүд улс орны хөгжлийн төлөвлөлтийн тулгамдсан асуудлууд, “Латвия-2030” стратегийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн талаарх мэдээллийг тогтмол авдаг байна.

Үүний зэрэгцээ “Латвия-2030” тогтвортой хөгжлийн институтийг байгуулсан ба энэхүү институтийн үндсэн зорилт нь Сайд нарын танхим, Сеймд танилцуулах улс орны тогтвортой хөгжил, “Латвия-2030” стратегийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн талаарх илтгэлийг бэлтгэх явдал юм. Түүнээс гадна тус институт нь улс төрийн хариуцлагатай шийдвэр гаргахад шаардлагатай төрийн стратегийн чухал асуудлуудыг судалж, үндэслэлтэй зөвлөмж гаргах судалгааны найдвартай баазыг бий болгох, төрийн мөнгөний бодлого нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх, нийтийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгэм, эрдэмтэд, судлаачдын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг зорилготой ажээ.

Мөн Сайд нарын танхимиын дэргэд Хөгжлийн үндэсний зөвлөл ажилладаг ба түүнийг улс орны төлөвлөлт хариуцсан яамны сайд тэргүүлдэг байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сейм, Сайд нарын танхим, төлөвлөлтийн бүс, нутгийн өөрөө удирдах байгууллага, “Латвия-2030” тогтвортой хөгжлийн институт, ТББ-ын төлөөлөл байдаг.

### 3.8. СИНГАПУР

Үндэсний хөгжлийн яам нь (The Ministry of National Development) Сингапур Улсын газар ашиглалтын төлөвлөлт, дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Сингапурын үндэсний хөгжлийн үндсэн зорилтуудад:

- Эдийн засгийн өсөлтийг дэмжих;
- Амьдрах орчныг сайжруулах;
- Хүрээлэн буй орчин, ногоон хөгжлийг дэмжих;
- Байгалийн баялгийг зохистой ашиглах (газар ашиглалт) гэсэн үндсэн тэргүүлэх чиглэлүүдэд тусгагдсан байдаг ба салбар бүрийн алсын хараатай цогц нэгдсэн төлөвлөгөө боловсруулдаг байна.

Сингапур Улсын Газар ашиглалт, зам тээврийн стратеги төлөвлөгөөг 40-50 жилээр төлөвлөсөн байдаг ба 10 жил тутамд үр дүнг судлан сайжруулдаг. Урт хугацааны төлөвлөгөөнд газар ашиглалт болон хүн амын өсөлтийг урьдчилан тооцож бодлого боловсруулдаг байна. Харин дунд хугацааны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд хуулийн дагуу газар ашиглалтын төлөвлөгөөг 10-15 жилээр төлөвлөж, 5 жил тутамд хяналт хийж сайжруулдаг.

Сингапур Улсын хөгжлийн онцлог талууд нь Засгийн газрын зүгээс хөдөлмөрийн зах зээлд



хийсэн зохицуулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг болон иргэдээ мөнгөн хуримтлалтай болохыг дэмжсэн бодлогууд, мөн төрийн өмчит компаниудын оновчтой менежментийг тодорхойлох, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зэрэг бодлогууд юм гэж эрдэмтэд үздэг. Хэдийгээр сайн институцыг сонгосон ч тухайн институц тогтвортгүй байвал эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрч чадахгүй. Иймд тухайн улсын хөгжил нь эдийн засгийн институцын тогтвортой байдал, түүний тогтолцооноос ихээхэн хамаардаг байна.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Г.Ганзориг ба бусад. Ногоон эдийн засаг ба загварчлал. УБ., 2018.
- Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Монголын хөгжлийн философи – Цуврал 1. Нэмж, засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2017 он. 95 дахь тал.
- Амартия Сен. “Хөгжил бол эрх чөлөө”. УБ.
- Ц.Сүхбаатар “Хөгжлийн эдийн засаг” УБ, 2018 он.
- Ж.Должинсүрэн. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим асуудал. “Олон улс судлал” дугаар 1(109) 2019 он.
- Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.
- <http://www.gdrc.org/uem/observatory/jp-overview.html>-Global Development Research Centre, 2010
- Гадаадын зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хангах тогтолцоо Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл
- О Системе государственного планирования в Республике Казахстан.  
<http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>
- Послания Главны государства народу Казахстана от 14 декабря 2012 года «Стратегия «Казахстан»
- Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.
- <https://www.economicshelp.org/blog/4998/development/policies-for-economic-development/>
- 2050»: новый политический курс состоявшегося государства». [online.zakon.kz>online.zakon.kz/](http://online.zakon.kz)



**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛД  
БОЛОН МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

H.Тогтох

Төсөлд тусгагдсан байдал	Шинжилгээ	Үндэслэл	Хүрэх үр дүн
<b>1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ</b>			
<b>Дөрөв.Засаглалын бодлого.</b> 8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. <b>Иргэдийн аюулгүй, амар тайван, байдлыг хангана.</b> 11. Гамшигаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник тоноог төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж гамшигийн үеийн харилцаа холбоог сайжруулна.	11-д үргэлжлүүлээд “Цаг агаарын аюул гамшигийн үед үзэгдэл суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг сумын төвөөс малчдад хүргэн түгээж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор Орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй Говь-хээрийн бүсэд байгуулна” гэж нэмж тусгах.	<b>- “Алсын хараа 2050”</b> 8.1.10-д Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг 18 аймаг, аюулын эрсдэл өндөртэй 13 суманд үе шаттайгаар байгуулна. <b>- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийн Зорилт 8.1-ийн 5 дахь хэсэгт:</b> “Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулсан байна.” гэж тус тус заасан мөртлөө энэ хөтөлбөрийн төсөлд тусгагдаагүй байна.	1. Цаг агаарын аюул (жилд 20 орчим хоног)-ын үед Аюулаас урьтаж амжиж анхааруулах мэдээлэл, түүнийг малчдад дамжуулдаг техник, технологийн цогцолбор (цаашид Цогцолбор гэх)-той болсноор Монголын хөдөөд аюулаас урьтаж амжиж анхааруулах гамшигийн менежментийн тогтолцоотой болж аюулын эрсдэл эрс буурах нөхцөл бүрдэнэ. 2. Цаг агаар ердийн үе (жилд 340 орчим хоног)-ийн Цогцолбор нь Сумын тэр, захиргаа, олон нийтийн байгууллагууд цаг үеийн асуудлаар иргэд малчдад өдөр тутам тогтмол ил тод мэдээллэж, хэлэлцүүлэг явуулдаг эргэх холбоо бүхий орон нутгийн мэдээллийн хэрэгсэл болно.
“...Баруун бүсийн босоо чиглэлийн төмөр зам”-ын ТЭЗҮ-ийг хийж дуусгана.	“Баруун босоо чиглэлийн төмөр зам”-ын ТЭЗҮ-ийг хийж дуусгана” гэж өөрчлөн найруулах.	<b>- “Алсын хараа 2050”-ийн найм. Бүс орон нутгийн хөгжил I үе шат 2021-2030</b> 3. Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцлийг бүрдүүлсэн байна. <b>II үе шат 2031-2040</b> 3. УБ-Шинэ нийслэлийн чиглэлийн төмөр зам, “Босоо чиглэлийн төмөр зам”-ыг барьж нэгдсэн сүлжээг бүрдүүлсэн байна. <b>- УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор</b> батлагдсан “Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлогын 3.2.6.1 ба 3.2.6.2 заалт	“Баруун босоо чиглэлийн төмөр зам” нь зөвхөн баруун бүсийн аймгуудаар хязгаарлагдахгүй ОХУ-ын Тувагийн “Улук-Хем”-ийн, Монголын Баянхонгорын “Шинэ жинст” ба Өмнөговийн “Нарийн сухайт”-ын коксжих нүүрсний ордуудыг дамжин холбож Арц суурь-Шивээ хүрэнгийн

		<p>болон Монгол улс, ОХУ, БНХАУ-ын хооронд 2016 онд байгуулсан Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт “Монгол улсыг дайруулсан төмөр замын баруун коридор” гэж тусгагдсан.</p>	<p>боомтуудаар нүүрс экспортлох, дамжуулан экспортлооор тавигдах 1091 км төмөр зам болно. Улаанбаатар төмөр зам(УБТЗ) 1954 онд ашиглалтад орсноор Монгол орны нутаг дэвсгэрийн зүүн хагаст хөгжлийн суурь болсонтой адил Монгол орны баруун хэсэгт мөн хөгжлийн суурь болж алслалтаас шалгаалсан хүн амын шилжилт хөдөлгөөн саарна.</p>
“Барилга, хот байгуулалт”-ын хэсэгт (нэмж тусгах)	“Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөөг боловсруулна” гэсэн заалт шинээр нэмж тусгах.	<p>- “Алсын хараа 2050”-ийн I үе шат (2021-2030)-д</p> <p>Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөөг боловсруулж бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.</p> <p>- <b>УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7.5Д-д</b> Монгол Улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртлэх хугацаанд шийдвэрлэх.</p> <p>- Барилга хот байгуулалтын яам 2009 онд Шинжлэх ухаан технологийн төслийг “Хангайн бүсийн тулгуур төв шинэ Хархорин хотын ирээдүйн төлөв, архитектур, хот төлөвлөлт” зарлаж Барилгын салбарын эрдэм шинжилгээний байгууллага болох Барилга архитектур корпорац шалгарч 2010-2012 онд гүйцэтгэжээ. Орхон голын хөндийд нийслэлийн баримжаатай хөгжүүлэх 1.5 сая хүн амтай, 10 дүүрэгтэй ирээдүйн нийслэл хотын ерөнхий төлөв, архитектур хот төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж 600 гаруй хуудастай баримт бичгийг тус яамны ШУТ-ийн зөвлөлөөр хэлэлэлцэн дэмжиж ШУТ-ийн сангаас санхүүжүүлжээ.</p>	<p>УБ хотын, байгаль орчны даацаас хэтэрсэн хэт төвлөрлийг сааруулах асуудлыг шийдвэрлэх нь зөвхөн хотын асуудал бус Улсын хөгжлийн асуудалтай нягт уялдаатай шийдвэрлэгдэнэ. Богд уул тойруулан тараан байршуулах замаар шийдвэрлэх хувилбар нь Үндэсний аюулгүй байдалд сөрөг үр дагавартай байж болзошгүй. Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэг болох Орхоны хөндийд шинэ нийслэл байгуулах тухай Төрийн уламжлалт бодлогын залгамж чанарыг үргэлжлүүлэн хангах нь илүү зохимжтой.</p>
<b>2. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ</b>			
XIV.1.1.23 Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их	XIV.1.1.23 Мянганы замын хөндлөн гол тэнхлэгийн	- “Алсын хараа 2050”-ийн 8.1.1 Олон улс, бус болон орон нутгийн чанартай дараах чиглэлийн авто замуудыг	Хануйн гүүрээс баруун тийш байршилтай нутгийн иргэд болон Увс, Завханы хүн ам УБ хот

<p>чиглэлийн гүүр авто замын ажлын эхлэл 63 км (Архангай) 2019-2021 төсөв 69.000.0 санхүүжих 12.000.0”</p>	<p>Орхон гол-Батцэнгэл-Хануйн гүүр чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл 63 км (Архангай) 2019-2021 төсөв 69.000.0 санхүүжих 12.000.0” гэж өөрчлөн найруулах</p>	<p>барина: 3 дахь мөрөнд “Батцэнгэл”-“Хануйн гүүр”  <b>- УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор</b> батлагдсан Мянганы замын чиглэлд Батцэнгэл-Хануйн гүүр” гэж тусгагдсан бөгөөд “Улаанбаатар-Батцэнгэл-Хануйн гүүр” хооронд мянганы замаар 490 км зйтай.  <b>- УИХ-ын 2011 оны 12 дугаар тогтоолоор</b> батлагдсан өөрчлөлтөөр “Улаанбаатар-Батцэнгэл-Их тамир-Хануйн гүүр”-ийн хооронд 519 км. Мянганы замаас 29 км илүү.  <b>- Одоогийн</b> Улаанбаатар-Цэцэрлэг-Хануйн гүүр хүртэл хатуу хучилттай замаар 548 км. Мянганы замаас 58 км илүү явж байгаа.</p>	<p>руу мянганы замаар ирж очиход 116 км одоогийнхоос татуу явах тул иргэдээс гарах зайлшгүй зардал хэмнэгдэж амьжирааны өртөг мөн хэмжээгээр хямдрах болно.      Энэ нь Төрөөс тэдгээр иргэдийн цалин тэтгэврийг нэмсэнтэй ижил ач холбогдолтой.</p>
--	---	---	--

# **2**

## **БҮЛЭГ**

---

**НИЙГЭМ**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН КОРОНАВИРУС БА НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТОЙМ

(Харьцуулсан судалгаа)

*Д.Амаржаргал (Ph.D), И.Жаргалзаяабямба*

### АГУУЛГА

#### НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТОЙМ

- Монгол
- Тайвань
- Θmnөd Солонгос
- Шинэ Зеланд
- Словак
- Вьетнам
- Руанда
- АНУ
- Англи
- Герман
- ОХУ
- Хятад
- Цаашид авах арга хэмжээний санал

#### ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТОЙМ

- 2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал
- 2.2. Зарим улс орны засгийн газраас эдийн засгийн эрсдлийг бууруулахад авч буй арга хэмжээнүүд
- 2.3. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал
- 2.4. Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн эрсдлийг бууруулахад авч буй арга хэмжээнүүд
- 2.5. Дэвшүүлэх санал


#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ




## Нэг. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТОЙМ

Дэлхий дахинаа 21 сая хүн өвчилж, 774 мянган хүн нас бараад буй (2020.08.17-ны байдлаар) КОВИД-19 цар тахал нь өмнө нь тохиолдож байсан Испани ханиад (500 сая хүн өвчилж, 50 сая хүн нас барсан)<sup>20</sup>, SARS (8098 хүн өвчилж, 774 хүн нас барсан) гэх мэт тахлуудыг бодвол халдвартархах байдал, нас барагтын түвшингийн муруйгаар эрс ялгаатай байгаа нь өмнөх түүхээс суралцаж, арга хэмжээ авахад нэн төвөтгэй болгож байгаа юм<sup>21</sup>.

**Зураг 1. Испани ханиад (1000 хүнд ногдох нэг өдөрт нас барагсад)**<sup>22</sup>



**Зураг 2. Ковид-19(1 сая хүнд ногдох нэг өдөрт нас барагсад)**



Тиймээс КОВИД-19 цар тахлын эсрэг авч буй арга хэмжээнд цаг тухайд нь үнэлгээ өгч, шуурхай шийдвэр гаргахын тулд их өгөгдөл дээр суурилсан боловсруулалтыг дэлхийн өнцөг булан бүрд хийж байна<sup>23</sup>. Үүнд:

- LSHTM төсөл – London school of hygiene and tropical medicine сургуулиас дэлхий даяар байрлах 1200 сайн дурынхны тусламжтайгаар аливаа орны авч буй арга хэмжээний талаарх мэдээллийн баазыг үсгэж байна.
- University of Oxford, UK - КОВИД-19 цар тахлын үед засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний харьцуулалт хийж байна.
- Complexity Science Hub Vienna (CSH Vienna)- Цар тахлын үед эмийн бус хариу арга хэмжээнүүд халдвартархах хурданд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэх дата анализ хийж байна.
- ACAPS гэх мэт нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд- Эрүүл мэндийн үйлчилгээ, өдөр тутмын бараа үйлчилгээ, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд тахлаас үүдэн гарах дунд ба урт хугацааны үр нөлөөг тооцоолж байна.

Эдгээрээс Оксфордын их сургуулийн гаргасан “КОВИД-19 засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний харьцуулалт” хамгийн өргөн цар хүрээтэй, аргачлалын хувьд бодитой тул эрдэмтдийн дүгнэлтэд өргөнөөр ашиглагдаж байна<sup>24</sup>. Энэ харьцуулалтыг дэлхийн 160 орны их өгөгдөл дээр суурилан, 17 үзүүлэлтийг<sup>25</sup> нэгтгэн гаргаснаар хариу арга хэмжээний цар хүрээ, цаашид хийх алхмыг нотолгоонд суурилан тодорхойлоход дөхөм болж байна.

<sup>20</sup> <https://www.cdc.gov/flu/pandemic-resources/1918-pandemic-h1n1.html>

<sup>21</sup> <https://development.asia/explainer/covid-19-and-sars-epidemiological-and-economic-comparison>

<sup>22</sup> <https://theconversation.com/compare-the-flu-pandemic-of-1918-and-covid-19-with-caution-the-past-is-not-a-prediction-138895>

<sup>23</sup> <https://www.nature.com/articles/d41586-020-01248-1>.

<sup>24</sup> <https://www.bsg.ox.ac.uk/research/research-projects/coronavirus-government-response-tracker>

<sup>25</sup> <https://www.bsg.ox.ac.uk/sites/default/files/2020-05/BSG-WP-2020-032-v6.0.pdf>

**Хүснэгт 1. “КОВИД-19 засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний харьцуулалт”-д орсон үзүүлэлтүүд<sup>26</sup>**

Тусгаарлалтын арга хэмжээ	Эрүүл мэндийн арга хэмжээ	Эдийн засгийн арга хэмжээ
1. Сургууль хаах	1. Олон нийтийг мэдээллээр хангах систем	1. Орлого дэмжих
2. Ажлын байр хаах	2. Оношлуурын арга хэмжээ	2. Өрхийн өр зээл хөнгөвчлөх
3. Олон нийтийн арга хэмжээг цуцлах	3. Ойрын хавьтлын хүмүүсийг тодорхойлох	3. Санхүүгийн арга хэмжээнүүд
4. Бөөгнөрөлийн хэмжээг хязгаарлах	4. Эрүүл мэндийн яаралтай хөрөнгө оруулалт	4. Олон улсад дэмжлэг үзүүлэх
5. Нийтийн тээврийг хязгаарлах	5. Вакцин гарган авахад хөрөнгө оруулах	
6. Гэрээс гарахгүй байх шаардлага		
7. Орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарлах		
8. Олон улсын хөдөлгөөнийг хязгаарлах		

Цар тахлын үеэр улс орнуудыг хэр үр дүнтэй ажилласныг нийт нас баралтын тоогоор харьцуулах нь хамгийн оновчтой гэж үзэж байна<sup>27</sup>. 2020 оны 8 сарын 17-ы байдлаар Монгол Улсыг оруулаад нийт 21 оронд уг тахлаас үүдэлтэй нас баралт бүртгэгдээгүй байна<sup>28</sup>. Мөн ДЭМБ-с гаргасан COVID-19 цар тахлын үеийн хорио цээрийг сулруулах үндсэн шалгуурууд дээр үндэслэн Оксфордын их сургуулиас хорио цээр сулруулах бэлэн байдлын индексийг тооцоолсон<sup>29</sup>.

**ДЭМБ-аас гаргасан COVID-19 цар тахлын үеийн хорио цээрийг сулруулах үндсэн шалгуурууд<sup>30</sup>:**

1. Халдварын тархалт хяналтанд байгаа;
2. Оношлох, тусгаарлах, ойрын хавьтал илрүүлэх эрүүл мэндийн системийн чадавхтай;
3. Хүн ам төвлөрсөн хороолол, хөгшчүүлийн асрах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв гэсэн өндөр эрсдэлтэй байршилуудад дэгдэлтийн эрсдлийг бууруулж чадсан;
4. Ажлын газруудад зайд барих, гар угаах ба найтаах үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авагдсан;
5. Гадаад улсаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдлийг хянасан;
6. Олон нийт ойлголт сайтай, саналаа хэлэх боломжтой, анхаарал болгоомжтой байгаа.

<sup>26</sup> [https://github.com/OxCGRD/covid-policy-tracker/blob/master/documentation/index\\_methodology.md](https://github.com/OxCGRD/covid-policy-tracker/blob/master/documentation/index_methodology.md)

<sup>27</sup> <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1201971220303738>

<sup>28</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?tab=table&zoomToSelection=true&time=2020-03-15..&deathsMetric=true&totalFreq=true&smoothing=0&country=USA~GBR~CAN~BRA~AUS~IND~DEU~FRA&pickerMetric=location&pickerSort=asc>

<sup>29</sup> <https://www.bsg.ox.ac.uk/research/publications/lockdown-rollback-checklist>

<sup>30</sup> <https://www.euro.who.int/en/health-topics/health-emergencies/coronavirus-covid-19/news/news/2020/4/whoeurope-publishes-considerations-for-gradual-easing-of-covid-19-measures>

#	Улсын нэр	Халдвартын тоо	Нас барсан тоо	Тохиолдол- нас баралтын харьцаа (CFR)	Хорио цээр супруулах бэлэн байдлын индекс (1.0 сайн→0.2 муюу)
1	Монгол	298	0	0.0%	0.7
2	Тайвань	484	7	1.4%	0.9
3	Өмнөд Солонгос	15,318	305	2.0%	0.6
4	Шинэ Зеланд	1271	22	1.7%	1.0
5	Словак БНУ	2855	31	1.1%	0.9
6	Вьетнам	934	22	2.4%	0.9
7	Руанда	2352	8	0.3%	0.9
8	АНУ	5.36 сая	169,481	3.2%	0.5
9	Англи	316,367	41,358	13.1%	0.3
10	Герман	223,453	9,231	4.1%	0.5
11	Орос	917,884	15,617	1.7%	0.6
12	Хятад	89,279	4,703	5.3%	0.7

Хорио цээр супруулах бэлэн байдлын индексээр улс орнууд өөр хоорондоо ялгаатай байгаа нь авсан арга хэмжээнүүдийн дараах онцлогоос шалтгаалж байна.

### Монгол (хүн ам 3,278,290; нягтаршил 1 км<sup>2</sup>-2 )

Хорио цээр супруулах бэлэн байдлын индексийн задаргаа: Тархалтыг хянасан – 0.9, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт- 0.3, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан- 1.0 олон нийтийн ойлголт -0.5

Уг цар тахлаар өвчлөх эрсдэлтэй бүлэгт өндөр настан, зүрх судасны өвчтэй хүмүүс, тарган хүмүүс орж байгаа ба Монголд зүрх судасны өвчтэй хүмүүс нийт нас баралтын 30%-ийг эзэлдэг, 2 хүн тутмын нэг нь таргалалт ба илүүдэл жинтэй байгаа нь аюул ойр байгааг сануулж байна<sup>32</sup>.

Аливаа орны эрүүл мэндийн системийн чадавхыг эмч, сувилагчийн тоо, тэдний ур чадвар, эрчимт эмчилгээний орны тоо, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлаар дүгнэдэг. Монголд тус бүр 12 мянган эмч, сувилагч байгаа нь нэг эмчид 283 өвчтөн ногдохоор өндөр үзүүлэлттэй байгаа ч эрчимт эмчилгээний орны тоо 100 мянган хүнд 11 ор ногдохоор байгаа нь уг цар тахалд хүндээр нэрвэгдсэн Итали, Испанитай ойролцоо байна.

Энэ тахлын үеэр сургуулийг эрт хааснаас хүүхдүүд хараа хяналтгүй үлдэж, гэмтэл бэртэл энэ оны эхний хагаст л гэхэд 5 хүртэлх насанд өмнөх жилийнхээс 3%-аар өсөж, 10320<sup>33</sup> хүрсэн байна.

Монгол, Хятад, Палестин иргэд эх орондоо орж чадахгүй, гадаадад гацсан хүнд байдалтай байна гэж олон улсад онцлогдож байна<sup>34</sup>. Энэ нь бэлэн байдлын индекс 0.7 байгаагийн нэг шалтгаанаас гадна оношууруын бэлэн байдал хангалттай бус байгааг илэрхийлнэ.

### Тайвань ( 23,816,775; 649 )

Тархалтыг хянасан – 1.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт- 0.9, зөөвөрлөгдөх эрсдлийг

<sup>31</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?tab=table&zoomToSelection=true&time=2020-03-15..&deathsMetric=true&totalFreq=true&smoothing=0&country=USA~GBR~CAN~BRA~AUS~IND~DEU~FRA&pickerMetric=location&pickerSort=asc>

<sup>32</sup> [https://www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X\(20\)30295-3/fulltext](https://www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X(20)30295-3/fulltext)

<sup>33</sup> <http://gemtel.mn/uploads/Осол%20гэмтлийн%20тандалтын%202020%20оны%20эхний%20хагас%20жилийн%20зэргэн%20мэдээлэл.pdf>

<sup>34</sup> [https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share\\_btn\\_fb](https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share_btn_fb)

хянасан- 1.0 олон нийтийн ойлголт -0.7

Тахлын эсрэг арга хэмжээг их өгөгдлийн анализад суурилан доорх байдлаар авч байна. Сэжигтэй тохиолдол илэрмэгц даатгал болон гаалийн мэдээллийг нэгтгэн тухайн өвчтөний эрүүл мэнд ба аяллын түүхийг харсанаар эрсдэлт бүлгээ тодорхойлон, авч байгаа арга хэмжээнийхээ чиглэлийг тодорхойлж байна.

Тайваний засгийн газар 60 үйлдвэрт амны хаалт үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлж, хариуд нь тогтсон үнээр амны хаалт нийлүүлэх гэрээ байгуулсанаар амны хаалтны дутагдлыг 1 сард 20 саяыг үйлдвэрлэх хүчин чадалтай байхаар нөхсөн. Мөн амны хаалт зарж буй цэгүүдийн нөөцийн мэдээллийг харуулсан гар утасны апликашн эрэлт ихтэй байна<sup>35, 36</sup>.

Тайваньд албан ёсоор сургуулийг огт хаагаагүй ба сургуулийн ариутгал хийж, шаардлагатай эмнэлгийн бүтээгдэхүүнээр хангасны дээр сурагчдын биеийн халууныг хэмжиж, ширээний хуванцар тусгаарлалт ашиглаж байна<sup>37</sup>.

### **Өмнөд Солонгос ( 51,269,185; 527 )**

Тархалтыг хянасан – 0.2, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт- 0.9, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан- 0.8 олон нийтийн ойлголт -0.6

Супер халдаагчид (нэг дор олон хүнд зэрэг халдаах чадвартай хүн) шашны цуглаан, банк гэх мэт газруудад удаа дараа гарч байсан ба байгууллагуудад орсон гарсан мэдээлэл, гар утасны байршил тодорхойлох мэдээлэл, кредит картны тооцоо хийсэн газруудын мэдээлэл, камержуулалтын мэдээллийг ашиглан ойрын хавьтагчдыг илрүүлж байна. Зөвхөн эмнэлгээс гадна өдөрт 20000 тест хийх хүчин чадалтай 600 оношлуурын цэг байгуулсан. Эхний тохиолдол гармагц 7 хоногийн дотор хувийн компаниудад оношлуур бүтээх хүсэлт гарган 118 институц оношлуур үйлдвэрлэж байна<sup>38</sup>.

Цар тахал эхэлснээс хойш 5 удаа сургууль эхлэхийг хойшлуулсан ч 7 сарын сүүлээр гэхэд бүх сургууль нээгдэн амны хаалт, гар ариутгачийг сурагчдад үнэгүй тараасан байна. Сургууль руу орох үед биеийн халуун хэмжиж, тогтмол гарыг нь угаалгаж байна. Зарим сургууль зайд барих үүднээс сурагчдийг өнжөөд сургуульд нь ирүүлж, цахим сургалтыг хослуулж байна<sup>39</sup>.

### **Шинэ Зеланд ( 4,822,233; 18 )**

Тархалтыг хянасан – 1.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.9, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан - 1.0, олон нийтийн ойлголт -0.9

4.8 сая хүнтэй Шинэ Зеланд бусад улсын иргэдээс хилээ эрт хааж, аюулаас хамгаалж чадсан ч 20 мянга гаруй иргэн гадаадад гацсан байдалтай байна<sup>40</sup>. Тэд 4-7 сарын хооронд өөрсдийн агаарын компани болон тухайн улсын агаарын компаниудтай хамтран тусгай үүргийн нислэг үйлдэж иргэдээ татсаар байна<sup>41</sup>. Нутагтаа ирсэн иргэд тусгаарлалтад орж, тэднийг зөөсөн жолооч, буудалласан зочид буудлын ажилчид гэх мэт шууд бусаар

<sup>35</sup> <https://theconversation.com/what-coronavirus-success-of-taiwan-and-iceland-has-in-common-140455>

<sup>36</sup> <https://theconversation.com/what-coronavirus-success-of-taiwan-and-iceland-has-in-common-140455>

<sup>37</sup> <https://www.smh.com.au/world/europe/global-rollbacks-coronavirus-lockdowns-eased-as-pandemic-continues-20200507-p54qx5.html>

<sup>38</sup> <https://ourworldindata.org/covid-exemplar-south-korea>

<sup>39</sup> <https://time.com/5868098/schools-reopening-coronavirus-denmark-south-korea-israel/>

<sup>40</sup> <https://www.rnz.co.nz/news/national/416188/covid-19-mercy-flights-for-new-zealanders-could-cost-up-to-14m>

<sup>41</sup> <https://www.mfat.govt.nz/en/countries-and-regions/south-asia/india/new-zealand-high-commission/faqs-potential-air-india-flights-information-for-new-zealanders/>

хавьтад орсон бүх хүн вирусийн оношилгоонд орж байна<sup>42</sup>.

### **Словак ( 5,459,642; 114 )**

Тархалтыг хянасан – 1.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.7, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан - 1.0, олон нийтийн ойлголт -0.8

Словакийн эрүүл мэндийн системийн чадавх сайн биш ч халдвартын тохиолдол нас барагтын харьцаагаар хамгийн бага Европын орноор тодорсон байна. Тахлын эхэн үеэс ерөнхийлөгч Zuzana Čaputová маск зүүж, олны өмнө гарч байсан нь амны хаалтын чухлыг олон нийтэд ойлгуулахад том нөлөө үзүүлсэн. Хорио цээр тогтооход хүн ард нь ямар нэг эсэргүүцэлгүйгээр сайтар даган мөрдж байсан нь бусад Европын орноос ялгаатай байна. Зөвхөн үндсэн мэдээний сувгаар л коронагийн талаар мэдээлж, олон нийтийн дундах ташаа мэдээлэл үймээнээс зайлсхийсэн байна. Ресторанууд нь зөвхөн гадна орчинд үйлчилдэг бол үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрчээ<sup>43, 44</sup>.

### **Вьетнам (97,338,579; 314 )**

Тархалтыг хянасан – 1.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.8, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан - 1.0, олон нийтийн ойлголт -0.7

Вьетнам улс оношлуурын нөхцөл байдал дээр илүү сайн үзүүлэлттэй байна. Хувийн хэвшил болон улсын 4 байгууллага оношлуур бүтээсэн байна. Хэдийгээр дотооддоо алдаагүй ч тест хийх 63 цэг байгуулсан нь нэг тохиолдолд ногдох хамгийн их тест (142) хийсэн орны нэгээр тодорч байна.

2009 оноос эхэлсэн эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг тухай бүр цахимжуулан оруулдаг систем бий болж, 2016 оноос анхаарал татахуйц өвчлөлийн мэдээллийг 24 цагийн дотор төв мэдээллийн системдээ байршуулдаг болсон нь адил шинж тэмдэгтэй олон тохиолдол илэрсэн үед бүх шатанд тахлын анхааруулгыг өгөх зорилготой. NCOVI гар утасны аппликеийшн гаргасан нь илэрсэн тохиолдлын газрын зураг дээрх байршил, супер халдвартархсан газрууд, халдвартын сэжиг бүхий тохиолдлыг мэдээлэх зэрэг давуу талтай ч хувь хүний нууцад халдаж байна гэдэг шүүмжлэл дагуулдаг. “Тахлын эсрэг тэмцэх нь дайсантайгаа тэмцэж буйтай адил” гэсэн уриа гарган коронагийн эсрэг авч буй засгийн газрын арга хэмжээнд олон нийтийн саналыг нэгтгэхэд зорьсон нь үр дүнтэй байна. 2000-2016 оны хооронд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлаа жил бүр 9.0 хувиар нэмж эрүүл мэндийн системийн хөрөнгө оруулалтаа ихэсгэсэн үзүүлэлттэй байгаа нь уг тахалтай тэмцэхэд дөхөм болсон<sup>45</sup>.

### **Руанда (12,952,218; 525 )**

Тархалтыг хянасан – 0.9, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт- 1.0, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан- 1.0, олон нийтийн ойлголт -0.8

Өдөр тутам хамгаалалтын хувцастай ажилчид гудамжинд явж байгаа хүмүүсээс нармайн арчдас авч, олон нийтийн дунд үнэгүй тест хийдэг. Зургаан өөр хотод шинжилгээний лаборатори ажиллаж байна. ХДХВ илрүүлдэг лабораторийн багаж тоног төхөөрөмж энэ тахлын үеэр ашиглагдаж байгаа нь дөхөм болж байна. 2012 оноос Эрүүл мэндийн яамнаас сүрьеэгийн тархалтыг хянахын тулд DHIS2 мэдээлэл боловсруулалтын системийг ашиглаж эхэлсэн ба энэ нь коронагийн тохиолдлыг хянахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнд

<sup>42</sup> <https://www.bbc.com/news/world-asia-53274085>

<sup>43</sup> <https://spectator.sme.sk/c/22404507/slovakia-earns-reputation-as-a-success-story-in-the-coronavirus-pandemic.html>

<sup>44</sup> <https://foreignpolicy.com/2020/05/06/slovakia-coronavirus-pandemic-public-trust-media/>

<sup>45</sup> <https://ourworldindata.org/covid-exemplar-vietnam>

бүх эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл цуглардаг ба 300 андройд таблет ашиглан, тест хийсэн мэдээлэл, хөл хорио тогтоосон газрын мэдээллийг нэгтгэн хариу арга хэмжээ авах хурдыг нэмэгдүүлсэн<sup>46, 47</sup>.

Гар утасны байршлын хөдөлгөөнөөр хүн хоорондын зайд барилтыг хянаж байна. Хүний хэмжээтэй робот температур хэмжиж, уг вирусээр халдварласан хүнд бараа зөөж, бэлэн бус мөнгөний гүйлгээ зонхицж байна.

#### **АНУ (331,002,651; 36)**

Тархалтыг хянасан – 0.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.6, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан -0.8, олон нийтийн ойлголт -0.6

Шинэ тохиолдлын тоо 14 хоногийн турш буурч, нийт тестийн 5%-аас дооших нь эерэг гарсан тохиолдолд хорио цээрийг супруулж болно гэж өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төвөөс мэдэгдсэн ч мужууд уг зааврыг мөрдөлгүй хорио цээрээ супруулсанаас байдал дахин дордож байна. АНУ-д коронавирусээр өвчлөгсөдийн 20% нь амьсгалын дутагдлын хүнд хэлбэрт орж байгаа ч Ерөнхийлөгч Доналд Трампийн 99% нь хөнгөн явцтай байна гэдэг ташаа мэдээлэл болон түүний амны хаалт зүүхээс татгалзсан зэрэг нь дэмжигчдийнх нь дунд амны хаалт зүүхгүй байх, зайд барих дүрмийг баримтлахгүй байх тохиолдлыг нэмэгдүүлж байна.

АНУ-д 162 мянга гаруй хүн нас барж (8 сарын 10-ы байдлаар), уг цар тахалд хамгийн их нэрвэгдсэн орон болсон ч анагаах ухааны судалгаа, вирусийн үеийн эмчилгээ, вакциныг гарган авах шинжлэх ухаан энэ үеэр хурдацтай хөгжиж байгаа нь онцлогдож байна<sup>48</sup>.

#### **Англи (67,886,011; 281)**

Тархалтыг хянасан – 0.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.3, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан -0.0, олон нийтийн ойлголт -0.9

Англи хилээ энэ тахлын үеэр огт хаагаагүй ба 6 сараас эхлэн орж ирсэн хүмүүс өөрсдийгөө тусгаарлалтад оруулахыг албан үүрэг болгосон. Одоогоор халдварлуулах хурд (1-ээс их байвал экспоненциалаар өснө) 1-ээс доош орж чадахгүй байгаа тул олон нийтийн бөөгнөрлийг хязгаарласан хэвээр байна. Нийт 41 мянга гаруй хүн нас барсан нь АНУ, Бразил, Мексикийн дараа дэлхийд 4-т орохоор байна. Генийн инженерчлэл хийсэн ба идэвхгүйжүүлсэн коронавирус гэх мэт өөр өөр механизмаар үйлчилдэг 190 сая дозын вакциныг Оксфордын их сургууль болон бусад эмийн компаниудад хөрөнгө оруулалт хийсэн ба бэлэн болмогц тухайн төрлийн вакцин тохиорох бүлэгт хэрэглэж, 67 сая хүнээ вакцинуулахаар бэлтгэлээ хангаад байна<sup>49, 50</sup>.

#### **Герман (83,783,942; 240)**

Тархалтыг хянасан – 0.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.7, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан -0.8, олон нийтийн ойлголт -0.6

Герман Улс нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал \$5,119, 1000 хүнд ногдох эмч 4.2, сувилагч 13.2, эрчимт эмчилгээний орны тоогоор (100 мянган хүнд 29.2<sup>51</sup>) дээгүүр ордог

<sup>46</sup> <https://www.npr.org/sections/goatsandsoda/2020/07/15/889802561/a-covid-19-success-story-in-rwanda-free-testing-robot-caregivers>

<sup>47</sup> <https://www.dhis2.org/rwanda-covid-testing>

<sup>48</sup> <https://www.bbc.com/news/world-us-canada-53337483>

<sup>49</sup> <https://time.com/5874222/uk-halts-easing-covid19-lockdown/>

<sup>50</sup> <https://www.bbc.com/news/uk-53469839>

<sup>51</sup> <https://www.forbes.com/sites/niallmccarthy/2020/03/12/the-countries-with-the-most-critical-care-beds-per-capita-infographic/#ad11c047f864>

тул эрүүл мэндийн системийн чадавх өндөр үзүүлэлттэй байдаг. Дэлхийд хамгийн анхны оношлуур бүтээсэн орны нэг ба ДЭМБ энэ аргачлалыг загвар болгосон.

Эрүүл мэндийн яамнаас анагаахын оюутнуудыг цагаар ажиллуулж, халдварт авагчдаас нэг бүрчлэн хавьтал илрүүлэх ажилд дайчилсан. Хэдийгээр Герман 2 сарын 1 гэхэд Уханиас ирж байгаа өөрийн иргэдэд оношлуур тавьж эхэлсэн ч вирус илрэх нууц үеийг тооцоолоогүйн улмаас дотоодын халдвартархсан тул халдвартын хяналт дээр бага оноо авсан байна. Гэсэн ч тохиолдол нас барагтын харьцааг бага хэмжээнд барьж чадсан нь өндөр настануудад чиглэсэн тусгаарлалтын арга хэмжээг сайн авсантай холбоотой. Вирусийн халдвартын улмаас эрчимт эмчилгээнд орсон өвчтөний явц, эрчимт эмчилгээний тасагт тулгарч байгаа асуудлыг өдөр бүр тайлагнаж, цаашид эрчимт эмчилгээний чадавхыг хэрхэн сайжруулах вэ гэдэгт онцгой анхаарч байна<sup>52</sup>.

### **ОХУ (145,934,462; 9)**

Тархалтыг хянасан – 0.0, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.8, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан -1.0, олон нийтийн ойлголт -0.6

Хувийн мэдээлэлд халтай хэмээн олны эсэргүүцэл төрүүлж байсан нүүр таних систем тахлын үеэр ашиглагдаж, гудамжинд 170 мянган камер байрлуулснаар тусгаарлалт, бөөгнөрлийн журмыг зөрчсөн иргэдийг торгосон байна<sup>53</sup>. ОХУ дэлхийн хамгийн анхны вакцин бүтээсэн орон болохыг зорьж, 8 сарын 15 гэхэд иргэдээ вакцинжуулж эхэлнэ хэмээн зарласан байна. Эхний шатны туршилт нь 7 сарын дунд гэхэд дууссан ба хангалттай дархлаа үүсгэж чадаж байна хэмээн дүгнэсний үндсэн дээр 2, 3-р шатны туршилтыг богино хугацаанд дуусгаж, эмийн бүртгэлд оруулна гэв<sup>54</sup>. Харин Англи, АНУ, Канад зэрэг орнууд ОХУ-ын хакериийн бүлэг коронагийн вакцин бүтээж байгаа тус улсуудын хэд хэдэн байгууллагын мэдээллийг хулгайллах оролдлого хийсэн хэмээн буруушааж байгаа юм<sup>55</sup>.

Сургуулийг 9 сарын 1-с хэвийн ажиллуулж эхлэх ба сургуулийн байрны бүх гадаргууг системтэйгээр ариутган, коронавирусийн оношлуурыг сурагчдад хийж, хичээлийг эхлүүлнэ. Өглөө бүр биеийн халууныг хэмжиж, аль болох цөөн хүүхэдтэй байхаар бүлгүүдэд хуваана. Хичээл эхэлмэгц өнгөрсөн хаврын цахим хичээлийн үр дүнг үнэлэх зорилгоор бүх сурагчдаас шалгалт авах ба үүний үр дүнд үндэслэн хичээлийн хоцрогдлыг нөхнө<sup>56</sup>.

### **Хятад (1,439,323,776; 153)**

Тархалтыг хянасан – 0.9, оношлолт, илрүүлэлт, тусгаарлалт - 0.5, зөөвөрлөгдөх эрсдлийг хянасан -0.8

Олон улсад суугаа хятадын оюутнууд гадаадад гацсан байдалтай байна. Одоогоор нислэгийн тоо нэмэгдсэн ч өртгийн хувьд хэд дахин ихэссэний улмаас гомдол ихтэй байна<sup>57</sup>. Коронавирусээс үүдэлтэй Хятадын эсрэг үзэл олон улсад газар авч, Казакстан гэх мэт Хятад гаралтай үндэстэн агуулсан улс орны иргэдийн дунд мөргөлдөөн үүсэж байгаагаас гадна Төв Азид Хятадын хөрөнгө оруулалттай зарим төсөл хөтөлбөрүүд

<sup>52</sup> <https://ourworldindata.org/covid-exemplar-germany>

<sup>53</sup> <https://edition.cnn.com/2020/03/29/europe/russia-coronavirus-authoritarian-tech-intl/index.html>

<sup>54</sup> <https://www.themoscowtimes.com/2020/08/03/coronavirus-in-russia-the-latest-news-aug-3-a69117>

<sup>55</sup> <https://www.bbc.com/news/world-europe-53621708>

<sup>56</sup> <https://www.gazeta.ru/social/2020/07/27/13167487.shtml>

<sup>57</sup> [https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share\\_btn\\_fb](https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share_btn_fb)

удаашрах хандлагатай байна<sup>58</sup>.

Сургууль 5 сар гэхэд нээгдсэн ба сурагчдыг хичээлдээ ирэхэд нь халуун хэмжихээс гадна зарим сургууль үнэгүй халууны шил тарааж, өдөрт 2 удаа халууныг нь хэмжүүлж байна.

Гар утасны апликеийшн дээр халдвартын эрсдлийг тодорхойлох асуумж бөглүүлэн, зөвхөн бөглөсөн хүүхдийг л сургуулийн байранд оруулж байна<sup>59</sup>. Хүүхдүүд амны хаалтаа зөвхөн хоол идэх үедээ л авах эрхтэй<sup>60</sup>.

### Дээрх туршлагад суурилсан цаашид авах арга хэмжээний санал

- Бага ба дунд хөгжилтэй 72 орныг хамарсан DHIS2 системд нэгдэх ажил манай улсад 2016 оноос ДЭМБ-ын тусламжтайгаар “Эрүүл мэндийн анхан шатны болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь” нэрээр хийгдэж эхэлсэн ба Сонгинохайрхан дүүрэг, Өмнөговь аймагт туршилтаар хэрэгжиж байна<sup>61</sup>. Руанда энэ системийг ашиглаж, тахлын эсрэг арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа билээ. Харин манай улсад уг төсөл зогсонги байдалтай байна. Энэ төслийн явцыг үнэлж, цаашид өргөжүүлэн их өгөгдөл суурилсан боловсруулалтыг тухай бүрд нь хийж, нотолгоонд суурилсан цар тахлын хурдтай арга хэмжээ авах нөхцөлийг хангах;
- Анагаах ухааны судалгааг дэмжих, ялангуяа эрчимт эмчилгээний тасгуудад ямар асуудал гарч, юу дутагдаж байгааг тогтмол судалж, хянах нь тахлын бэлэн байдалд онцгой ач холбогдолтой;
- Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 2013 оноос хойш жил бүр тогтмол буурч байгааг<sup>62</sup> анхаарч, эрүүл мэндийн системийн чадавхыг тахлын үед бүрэн хүрэлцэхүйц байлгахын тулд эрчимт эмчилгээний орны тоо, шаардлагатай тоног төхөөрөмжийг (амьсгалын ба унтуулгын аппарат, уушги орлуулах ЭСМО аппарат, цус цэвэршүүлэгч PMX-DHP аппарат) нэмэгдүүлэх;
- Тахлын үеэр оношлуурыг хурдан шуурхай, өөрсдийн оронд хүрэлцэхүйц хэмжээгээр үйлдвэрлэх нь тархалтыг хянах, хорио цээрийг чангатгах болон сулруулах (шинэ тохиолдлын тоо 14 хоногийн турш буурч, нийт тестийн 5%-аас дооших нь эзэрэг гарсан тохиолдолд сулруулах зэрэг ) нэн чухал ач холбогдолтой тул энэ тал дээр боловсон хүчин, лабораторийн баазыг бүрдүүлэх (нэг оношлуур бүтээх үнэ ойролцоогоор \$6-\$10<sup>63</sup>,<sup>64</sup>; Монгол эрдэмтдийн гарган авсан оношлуурын<sup>65</sup> олон улсын баталгаат байдлыг шалгуулан, цаг алдалгүй хэрэглээнд нэвтрүүлэх, оношлох цэгийн тоог нэмэгдүүлэх;
- Тахлын үеэр хил хаасан тохиолдолд гадаадад гацсан Монголчуудаа татан авах нөхцөл боломжийг сайжруулах бэлтгэл ажлыг хангах;
- Манай оронд зонхилон тохиолдох таргалалт, зүрх судасны өвчлөлийн хяналтыг сайжруулж, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах нь шинэ коронавируст халдвартын эрсдлийг бууруулахаас гадна нийгмийн эрүүл мэндийн бодлого, нийгмийн маркетингийг энэ чиглэлд хандуулж, хүн амын эрүүл мэндэд тулгамдсан дээрх нөхцөл байдлыг сайжруулах.

<sup>58</sup> <https://thediplomat.com/2020/07/post-covid-china-set-to-gain-in-central-asia/>

<sup>59</sup> <https://thediplomat.com/2020/07/post-covid-china-set-to-gain-in-central-asia/>

<sup>60</sup> <https://www.sciencemag.org/news/2020/07/school-openings-across-globe-suggest-ways-keep-coronavirus-away-despite-outbreaks>

<sup>61</sup> <https://www.who.int/mongolia/news/feature-stories/detail/country-programme-on-subnational-health-system-strengthening-in-mongolia>

<sup>62</sup> <https://data.worldbank.org/indicator/SH.XPD.CHEX.PC.CD?locations=MN>

<sup>63</sup> <https://www.aa.com.tr/en/asia-pacific/indonesia-produces-50-000-testing-kits-for-covid-19/1844999>

<sup>64</sup> <https://www.medicaldevice-network.com/news/genestore-low-cost-covid-19-rt-pcr-test-kit/>

<sup>65</sup> <http://www.mnb.mn/i/211477>

## Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТОЙМ

### 2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал

Коронавирусийн халдварт дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна.

Дэлхийн банк 6 дугаар сарын 8-ны өдөр нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа дэлхийн эдийн засаг 2020 онд 5.2 %-аар агших, 2021 онд 4.2 %-аар өсөх төсөөллийг мэдээлжээ.

Коронавирусийн тархалтын улмаас хөгжиж буй орнуудын 70-100 орчим сая хүн нэн ядууралд өртөж, дэлхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ 3.6%-аар буурна гэж тооцоолжээ. Дэлхийн улс орнуудын 90% орчимд нэг хүнд ногдох ДНБ буурах төсөөлөлтэй байна.

Эдийн засгийн сөрөг нөлөөллөөс дэлхийн эдийн засаг 2020 онд 8%-аар, хөгжиж буй орнуудын эдийн засаг 5.2%-аар агшиж муудаж болзошгүйг анхааруулжээ<sup>66</sup>.

*Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүдийг харуулбал:*

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт	2020 оны II хагаст			
				БНХАУ	АНУ	Евро бүс	ОХУ
1.	Дэлхийн банк	2020.6.08	-5.2%	1.0%	-6.1%	-9.1%	-6.0%
2.	OECD	2020.6.10	-6.0%	-2.6%	-7.3%	-9.1%	-8.0%
3.	RaboResearch	2020.6.09	-4.1%	1.2%	-5.7%	-9.1%	
4.	Bloomberg	2020.5.18		2.0%	-5.4%	-7.5%	-5%
5.	Fitch	2020.5.18	-3.2%.	1.1%	-4.9%	-6.7%	
6.	Oxford Economic	2020.7cap	-4.5%	2.0%	4.2%	7.9%	

Эх сурвалж: [www.mongolbank.com](http://www.mongolbank.com)

Дэлхийн банкнаас 2020 онд дэлхийн эдийн засаг 5.2%-аар агшина хэмээн төсөөлж байгаа тул тус байгууллагаас ядуу буурай орнуудад нийт 160 тэрбум ам.долларын буцалтгүй тусламж болон бага хүйтэй зээл олгохоор төлөвлөсөн байна.

ОУВС дэлхийн эдийн засгийн төлвийг ОУВС-ийн 4 дүгээр сард хийсэн төсөөллөөсөө бууруулах эрсдэл өндөр байгааг онцлов. Хэдийгээр Азийн зарим орнуудад гүйцэтгэл хүлээлтээс өндөр байгаа ч гол эдийн засгуудад хүчтэй хөл хороо хэрэгжиж, эдийн засгийн үзүүлэлтүүд хурдтай муудсан тул өсөлтийн төсөөллийг бууруулах эрсдэл нь давамгайлж байна.

**Герман.** Герман Улсын хөрөнгө оруулагчдын дунд явуулсан “The Zew”-ийн санал асуулгаар тус улсын эдийн засаг хөл хороогоо супруулж, их хэмжээний төсвийн багц арга хэмжээ (ДНБ-ий 30%-тай тэнцэхүйц) авсны нөлөөгөөр 2020 оны II хагасаас эхлэн сэргэхээр байна. Бодит эдийн засгийн идэвхжилийг хэмжих үзүүлэлтүүд болох хурдны зам

<sup>66</sup> Дэлхийн банк: Дэлхийн эдийн засаг 2020 онд 5.2%аар агшина. Эх сурвалж: Монголбанк 2020.06.17 <https://news.mn/r/2314835/>

ашиглалтын төлбөр, цахилгааны хэрэглээ, олон нийтийн тээвэр хэрэглэгчдийн тоо, дэлгүүр, худалдааны төвүүдээр үйлчлүүлэгчдийн тоо зэргээс харахад хөл хориог супруулсны дараагаас Германы эдийн засаг хурдтай сэргэх төлөв ажиглагдаж байна. "The Zew"-ийн эдийн засгийн хандлагын үзүүлэлт 5 дугаар сард өмнөх сараас 22.8 % буюу сүүлийн таван жилийн дээд хэмжээгээр өсөж 51% болжээ.

**Хоёр улсын хэлэлцээр.** ХБНГУ, БНФУ хоёр улсын Засгийн газар Европыг "Хөл хорио цээрийн их хямрал"-аас аврахын тулд 500 тэрбум еврогийн төсвийн дэмжлэг үзүүлэхээ мэдэгдлээ. Тус төсвийг цар тахалд хамгийн ихээр нэрвэгдсэн орнуудын эмзэг салбаруудыг дэмжихэд зарцуулахаар төлөвлөжээ. Төсвийн дэмжлэгийг бүсийн орнуудын нөхцөл байдлаас хамааран буцалтгүй тусламж хэлбэрээр олгохоор заасан байгаа ч Европын Холбооны 27 гишүүн орны зарим удирдагчид санал зөрөлдөж, эргэн төлөгдөх зээлийн нөхцөлөөр олгох хэрэгтэй гэж үзэж байгаа аж.

**АНУ.** Тус улсын Конгрессийн төсвийн алба (*Congressional budget office*)-аас 5 дугаар сарын 19-ний өдөр Америкийн эдийн засаг II улиралд 38% агших төсөөллийг мэдээлсэн. Төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ийг 11%-д хүрнэ гэсэн байна. Эдийн засаг оны II хагаст сэргэж эхэлнэ гэсэн таамаглалыг дэвшүүлжээ.

АНУ болон БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн ширүүсэх төлөвтэй боллоо. "Ковид-19" вирусийн анхны тархалттай холбоотой хоёр талын маргаанаас гадна АНУ-ын Засгийн газар 2020 оны 5 дугаар сарын сүүлийн 7 хоног Хятадын технологийн компаниуд болох Huawei, ZTE-д экспортын хориг тогтоож, Huawei компанийг АНУ-ын программ хангамжийг ашиглахыг хориглох шийдвэрийг гаргасан зэрэг нь нөхцөл байдал хурцахад хүргээд байна.

**Хятад.** Тус улсын ДНБ нь оны II улиралд 3.2%-аар өссөн үзүүлэлттэй гарсан нь дэлхий эдийн засагт зэрэг өсөлттэй үзүүлсэн орон болсон. Энэ оны I улиралд, цар тахал тус улсад оргил үедээ хүрч байхад түүхэнд байгаагүйгээр 6.8%-аар буурсан юм. Эдийн засагчдийн дунд явуулсан санал асуулгаар Хятадын эдийн засаг 2020 оны II улиралд ойролцоогоор 2.6 %-аар өснө гэж таамаглаж байна. БНХАУ-ын хувьд хөдөлмөрийн зах зээлийг тогтворжуулж, илүү олон ажлын байрыг хамгаалж үлдсний үр дүнд хот суурин, бус нутагт ажилгүйдлийн түвшин өнгөрсөн 5 дугаар сард 5.9 % байсан бол 6 дугаар сард 5.7 % болж буурсан байна<sup>67</sup>.

**Улс хоорондын зөрчилдөөн.** АНУ болон БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн ширүүсэх төлөвтэй боллоо. "Ковид-19" вирусийн анхны тархалттай холбоотой хоёр талын маргаанаас гадна АНУ-ын Засгийн газар 5 дугаар сарын сүүлийн долоо хоногт Хятадын технологийн компаниуд болох Huawei, ZTE-д экспортын хориг тогтоож, Huawei компанийг АНУ-ын программ хангамжийг ашиглахыг хориглох шийдвэрийг гаргасан зэрэг нь нөхцөл байдал хурцахад хүргээд байна. Түүнчлэн "Ковид-19"-ийн гарал үүсэлтэй холбоотой маргаанд хариу үйлдэл болгон БНХАУ нь Австрали улсаас авах арвай зэрэг хүнсний бүтээгдэхүүний импортод татвар ногдуулсанаар хоёр улсын хоорондын харилцаа таагүй болоод байна.

**ОХУ.** Тус улсын Засгийн газар 5 дугаар сарын 20-нд төсвийг тэлэх багц бодлогоо санхүүжүүлэх зорилгоор 112 тэрбум рублийн Засгийн газрын бондыг арилжаалжээ. Энэ нь тус улсын хувьд нэг удаагийн арилжаагаар авсан хамгийн их хэмжээний өрийн түвшин юм. ОХУ-ын дөрөвдүгээр сарын төсвийн үзүүлэлтүүдэд суурилан тус эдийн засаг дөрөвдүгээр сард 25 %-аар агшсан, II улиралд 16 %-аар агших төлөвтэй гэж Блуумбергийн эдийн

<sup>67</sup> Хятадын эдийн засаг цар тахлын дараа анх удаа өссөн үзүүлэлтэй гарчээ. Эх сурвалж:CNN 2020.07.16 <https://news.mn/r/2327444/>

засагчид тооцож байна.

**Итали.** Засгийн газраас эдийн засгийг дэмжих 55 тэрбум еврогийн төсвийг өнгөрсөн долоо хоногт баталлаа. Тус төсөвт хөл хорионы улмаас дампуурлын ирмэгт тулсан бизнесүүдийг эргэлтийн хөрөнгөөр хангах (үүнд компаниудад олгох дэмжлэг 15 тэрбум евро), иргэдэд амьжирааны мөнгөн тусlamж үзүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж (25.6 тэрбум евро), эрүүл мэндийн салбарт нэмэлт тусlamж (3.2 тэрбум евро) зэргийг хуваарилахаар тусгажээ. Италийн эдийн засгийн өсөлт 2020 онд 8 %-аар агшиж, төсвийн алдагдал ДНБ-ий 10.4 %, улсын өр ДНБ-ий 156 %-тай тэнцүү байхаар төсөөлж байна.

**Япон.** ДНБ I улиралд 3.4 %-аар агшилаа. Үүнд "Ковид-19" цар тахлаас сэргийлж хөл хорио тогтоосноос үүдэн хэрэглээ буурч, гадаад эрэлт саарсанаар экспорт багассан нь голлон нөлөөлжээ<sup>68</sup>. Япон Улсын эдийн засаг II улиралд сэргэж, 4.7%-аар агшиж, 2021 онд 3.3%-аар өсөхөөр төсөөлж байгааг мэдэгдлээ. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляц энэ онд 0.5%-аар буурах бол ирэх жил 0.3%-аар өсөхөөр байгаа аж. Тус улсын Төв банк хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдэд хөнгөлттэй зээл олгох зэрэг бодлогын хэрэгслүүдийг голчлон хэрэгжүүлж байна<sup>69</sup>

**Их Британи.** Тус улсын эдийн засагт коронавирусийн дэгдэлт нөлөөлж урд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрчээ. ДНБ нь 2 дугаар сараас 4 дүгээр сар хүртэл хугацааг харьцуулбал 26%-аар бага байв. Энэ тохиолдолд эдийн засгаа сэргээхэд хэрэглэгч болон бизнес эрхлэгчид чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Гол хүчин зүйл бол ажилгүйдлийн түвшин өссөнтэй холбоотой<sup>70</sup> гэжээ. Их Британий Төсвийн хариуцлагын алба (*Office for Budget Responsibility*) эдийн засгийн төсөөллийг гаргасан. Энэ нь 2020 онд ДНБ-ний 12.4% нь ажилгүйдлийн түвшин байсан бол 2020 оны эцсээр 12% болгон бууруулахаар таамаглаж байна<sup>71</sup>.

## 2.2. Зарим улс орны засгийн газраас эдийн засгийн эрсдлийг бууруулахад ауч буй арга хэмжээнүүд

Коронавирусийн халдварын улмаас үүдэх эрсдлийг бууруулах чиглэлээр улс орон бүр өөр өөрсдийн эдийн засгийн чадавх, санхүүгийн нөөцөнд тааруулан арга хэмжээг хэрэгжүүлж байна. Доорх хүснэгтээс харна уу.

**Хүснэгт 2. Коронавирусийн халдварын эсрэг олон улсад ауч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг тоймловол:**

	Ауч буй арга хэмжээ	Хэрэгжүүлсэн орнууд
1.	Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, вирусийн оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж авах	Аргентин, Австрали, Бразил, Канад, БНХАУ, Франц, Герман, Энэтхэг, Индонез, Итали, АНУ, Өмнөд Африк, Испани, Итали, Япон, ОХУ, Саудын Араб, Өмнөд Солонгос, Мексик
2.	Зорилтот бүлэгт олгох мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх (Ядуу өрхүүдэд олгох тэтгэмж,	Аргентин, Герман, Энэтхэг, Индонез, Канад, Франц, АНУ, Их Британи, Турк, Япон, Өмнөд Солонгос, Испани, ОХУ, Мексик

<sup>68</sup> Дэлхийн эдийн засаг оны II хагаст сэргэх үү. Эх сурвалж: Монголбанк Б.Жаргал 2020.06.01  
<https://news.mn/r/2306939/>

<sup>69</sup> Bank of Japan on Hold, Expects Moderate Recovery in H2. 2020.07.15  
<https://continuumeconomics.com/2020/07/15/thought/bank-of-japan-on-hold-expecting-moderate-reco>

<sup>70</sup> House of Common library  
<https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8866/>

<sup>71</sup> House of Commons library “Coronavirus: Economic impact” 31 July 2020  
<https://commonslibrary.parliament.uk/>

	ажилгүйдлийн тэтгэмж, цалингийн татаас)	
3.	Жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд зээл, тусlamж олгосон	Герман, АНУ, Их Британи, Өмнөд Африк, Испани, Итали, ОХУ, Өмнөд Солонгос, Япон
4.	Зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (аж ахуйн нэгжүүдийн банкнаас авах зээлийн батлан даалт)	Аргентин, Австари, Бразил, Франц, Герман, Итали, ОХУ, Өмнөд Солонгос, Өмнөд Африк, Турк
5.	Иргэн, аж ахуйн нэгжүүдийг татвараас чөлөөлөх (бизнесийг дэмжих, ажлын байрыг хадгалах)	Бразил, Канад, БНХАУ, Индонези, Өмнөд Солонгос, ОХУ
6.	Иргэн, аж ахуйн нэгжүүдэд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх (бизнесийг дэмжих, ажлын байрыг хадгалах)	Аргентин, БНХАУ, Франц, Герман, Энэтхэг, Индонез, Итали, АНУ, Испани, Итали, ОХУ
7.	Татвар төлөх, тайлагнах хугацааг хойшлуулах	Франц, Герман, Энэтхэг, Индонез, Итали, АНУ, Турк, Япон, ОХУ, Өмнөд Солонгос
8.	Төсвийн гүйцэтгэлийг сайжруулах үүднээс тендерийг эрчимжүүлэх	Аргентин, Мексик
9.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний хомсдол, зохиомол үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх (Экспортын квот, импортын татвараас чөлөөлөлт, дотоодын нийлүүлэлтийг дэмжих)	Аргентин, ОХУ

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

Дэлхийн улс орнууд коронавирусийн халдвартын үед татварын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: татвараас чөлөөлөх, татварын хувь хэмжээг бууруулах, татвар төлөх, тайлагнах хугацааг хойшлуулах, торгууль алдангиас чөлөөлөх, алдагдал шилжүүлэх хугацааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ багтаж байна.

Нийт дэлхийн 59 улс аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 74 улс хувь хүний орлогын албан татварын чөлөөлөлт, 41 улс нь нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлжээ.

Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн нөлөөгөөр нэмэгдэж байгаа төсвийн зарлага, өсөлтөөс гадна эдийн засгийн хямрал, хөл хорионы улмаас хумигдаж буй татварын орлогын бууралтаас шалтгаалан улс орнуудын төсвийн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэж байна.

Дэлгэрэнгүй байдлаар 2 улсын жишээгээр харуулав.

#### Австрали<sup>72</sup> (2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шинэчлэгдсэн)

2020 оны эхний улиралд ДНБ-ий бодит хэмжээ өмнөх улирлаас 0.3 %-аар буурч, өндөр давтамжийн үзүүлэлтүүд 2 дугаар улиралд огцом буурч байгааг харуулж байна. Үндэсний Засгийн газар эдийн засгаа сэргээхийн тулд 5-р сарын 8-ны өдөр Ковид-19 хорио цээрийн хязгаарлалтыг бууруулах үе шаттай төлөвлөгөөг боловсруулжээ.

Муж ба нутаг дэвсгэр, бүс нутгийн хорио цээрийн хязгаарлалтыг бууруулж байна. Сургууль, ресторан, зугаа цэнгэлийн газар, жижиглэнгийн худалдааны газрууд цагийн

<sup>72</sup> International monetary fund;Polive responses to Covid-19. 2020.07.31  
<https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>  
<https://www.imf.org/en/About/FAQ/imf-response-to-covid-19>

хязгаарлалттайгаар нээгдсэн байна. Олон нийтийн цугларалт, дотоод аялал жуулчлалын хязгаарлалтыг мөн аажмаар бууруулж байна. Мельбурн хотын “Ковид 19” дэгдэлт нь 2020 оны 7-р сарын 9-ний өдрөөс зургаан долоо хоногийн хугацаатай гэрийн хорионд байх гэсэн хязгаарлалтыг хэвээр хадгалжээ.

8-р сарын 3-ны өдрөөс Виктория мужид маскийг заавал зүүлгэх шаардлагатай гэж үзсэн байна. Хэрэв маск зүүгээгүй, хууль зөрчсөн иргэдийг AUD \$ 200 австрали доллараар торгох, харин 12 наснаас доош насны хүүхдэд маск зүүлгэх хэрэггүй гэжээ. Гэрийн хорио тусгаарлалтыг зөрчсөн тохиолдолд AUD \$ 1652 доллар торгох ба шүүхээр (*Magistrates' Court*) давтан үйлдсэн гэмт хэргийг дээд хэмжээг AUD \$ 10,000 австрали доллараар торгоно. Коронавирусийн шинжилгээг хийлгэсний дараа 2 болон түүнээс дээш удаа гэрийн хорио тусгаарлалтыг зөрчсөн бол AUD \$ 4957 австрали доллар бөгөөд шүүхээр (*Magistrates' Court*) давтан гэмт хэрэг үлдтэх тохиолдолд AUD \$ 20,000 австрали доллараар торгоно гэжээ<sup>73</sup>.

Австралийн төсвийг сэргээхэд нөлөө үзүүлэхэд орлого болон зарлагын зардал 164 тэрбум австрали доллар (ДНБ-ий 8.6 хувь)-аас бүрдэх төсвийн дэмжлэг бөгөөд 2023-2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх ба дийлэнх хэсгийг 2020-2021 онд хэрэгжүүлнэ.

Энэхүү арга хэмжээнд хөдөлмөрийн хөлсний тэтгэмжийн хэмжээ (ДНБ-ний 4%), өрхийн орлого болон бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын дэмжлэг, бус нутаг, аж үйлдвэрүүдэд чиглэсэн зорилтот арга хэмжээнд зориулагдана.

Тус улсын Засгийн газар нь ажлын байрыг бий болгохын тулд муж, нутаг дэвсгэрийн дэд бүтцийн төслүүдийг (AUD \$ 3.9 тэрбум австрали доллар), аж үйлдвэрүүдийг санхүүжүүлэх, өндөр настан, ахмадуудад (AUD \$ 0.3 тэрбум австрали доллар), нэг сая орчим гэр бүлд үнэ төлбөргүй асрамжийн (AUD \$ 0.3 тэрбум австрали доллар) үйлчилгээ үзүүлэхээр болов.

Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүжилтэд туслах зорилгоор орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхэд зориулж AUD\$ 15 тэрбум австрали доллар хүртэлх санхүүжилт олгох, Засгийн газар болон банкуудын хооронд байгуулсан зээлийн баталгааг яаралтай бэлэн мөнгөөр нөхөх, ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээнд (AUD\$ 20 тэрбум австрали доллар хүртэл) олгохоор болжээ. Зээлийн хэмжээг 2020 оны 7 дугаар сарын дунд үеэс 2021 оны 6 дугаар сар хүрэл сунгаж, зээлийн дээд хэмжээ нь AUD \$ 250,000-аас AUD \$ 1 сая австрали доллар хүртэл, хамгийн дээд хугацаа нь 5 жил хүртэл болгов.

Засгийн газар нь эрүүл мэндийн системийг бэхжүүлэх, эмзэг бүлгийн иргэд, өндөр настны асрамжид буй хүмүүсийг Ковид-19-ийн тархалтаас хамгаалахын тулд AUD \$ 9.4 тэрбум австрали доллар (ДНБ-ний 0.5%)-ийг зарцуулахаар болсон.

Муж болон нутаг дэвсгэр бус нутгийн Засгийн газрууд AUD \$ 32.9 тэрбум австрали доллар (ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэх) хэмжээний татварын хөнгөлөлтөд үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх, эмзэг бүлгийн иргэдэд тэтгэмж олгох, эрүүл мэндийн зардалд дэмжлэг үзүүлэх болсон байна. Мөн барилга, дэд бүтэц, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалт, сэргээгдэх эрчим хүч, технологийн татварын хөнгөлөлтөд хамруулжээ.

Австралийн Нөөцийн банк (*Reserve Bank of Australia-RBA*) Засгийн газрын бондыг худалдаж авснаар 3 жилийн хугацаатай, 0.25 орчим хувийн хүйтэй байхаар мэдэгдлээ.

<sup>73</sup> Coronavirus (COVID-19) restrictions Victoria. 2020.08.02  
<https://www.vic.gov.au/coronavirus-covid-19-restrictions-victoria>

## **БНХАУ<sup>74</sup> (2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)**

БНХАУ-ын төсвийн онцгой байдал 4.6 их наяд юанийн (ДНБ-ний 4.5 хувь) дэмжлэг үзүүлэхээ мэдэгдсэн. Голлон авч хэрэгжүүлэх арга хэмжээнд: (i) тахал өвчинеэс урьдчилан сэргийлэх, хянах зардал, (ii) эмнэлгийн хангамж үйлчилгээний хэрэгслийн үйлдвэрлэл, (iii) цагаач иргэдийн хугацааг сунгах, ажилгүйдлийн даатгалын төлбөрийг олгох, (iv) татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх; v) улсын хөрөнгө оруулалт зэрэг 5 арга хэмжээнүүдийг хамруулжээ.

Улсын хэмжээнд эрүүл мэндийн яаралтай тусlamжийн менежментийн системийг сайжруулах, төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, үр нөлөөтэй төсвийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

БНХАУ-ын Ардын банк (*People's Bank of China*) мөнгөний бодлого, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн гол арга хэмжээнд:

- (i) нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан банкны системд хөрвөх чадварыг сайжруулах;
- (ii) эмнэлгийн хангамж үйлчилгээний хэрэгслийн үйлдвэрлэл, өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээл болон хөнгөлөлттэй зээлийн хэмжээг 1.8 их наяд юаниар бичил, жижиг үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарыг өргөжүүлэх;
- (iii) нэг жилийн хугацаанд зээлийн хүүгийн түвшинг бууруулах;
- (iv) бичил болон жижиг үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн нөөцийг бүрдүүлэхэд шалгуур үзүүлэлтийг бууруулах боломжоор хангах;
- (v) банкны хувьцаа, жижиг дунд бизнес эрхлэгчдийг хүүгийн хэмжээг бууруулах;
- (vi) банкны бодлогоор хувийн хэвшил болон хөрөнгийн биржүүдийн (350 тэрбум юань) зээлийг өргөтгөх;
- (vii) хөрөнгийн биржийн зээлийг дэмжих шинэ хэрэгслийг нэвтрүүлэх, зээлийн хүүгийн 1%-ийн санхүүжилтийг (40 тэрбум юань) олгох, орон нутгийн банкуудын шинэ баталгаагүй зээлийн 40 хувийг санхүүжүүлэх, зээлийн хүүгийн төлбөрийн хугацааг уртасгахад чиглэсэн тэг хүйтэй "зээлийн санхүүжилт олгох" (400 тэрбум юань) арга хэмжээг хамруулжээ.

2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар БНХАУ-ын Засгийн газар санхүүгийн нөхцөл байдлыг чангатгасныг бууруулах арга хэмжээ авсан. Үүнд: зээлийг эргэн төлж чадахгүй байгаа бүс нутгуудын өрх гэр болон корпорациудыг хамруулсан байна. Үүнд:

- (i) жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээл олгохыг дэмжих, үүнд: орон нутгийн банкуудаас ЖДҮ-ийн зээлийг дэмжих, банкуудын хөрөнгийн биржид олгосон зээлийн өсөлтийг 30-40%-д хүргэх, зээлийн үнэлгээний тогтолцоог бий болгох;
- (ii) зээл төлөлтийг хойшлуулах, 2021 оны 3-р сарын эцэс хүртэл сунгах, онлайн зээлд хамрагдах зээлийн хэмжээ хязгаарлалтыг бууруулах, ЖДҮ, өрхүүдэд олгох зээлийн дэмжлэг үзүүлэх;
- (iii) чанаргүй зээлийн үлдэгдэл, хүлээгдэж буй зээлийн үлдэгдлийн шаардлагыг бууруулах;
- (iv) жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг санхүүжүүлэх, санхүүгийн байгууллагуудын бонд гаргахыг дэмжих;
- (v) бондын хөрөнгө оруулалтад даатгагч нь корпорациудын бондын хэмжээг нэмэгдүүлэх замаар нэмэлт санхүүжилт олгох;
- (vi) зээлийн баталгаа, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;
- (vii) хөрөнгийн менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, уян хатан байдал;

<sup>74</sup> International monetary fund;Polive responses to Covid-19. 2020.07.31  
<https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

(viii) орон нутгийн засаг захиргаанаас орон сууцны бодлогыг хөнгөвчлөх зэрэг санхүүгийн нөхцөл байдлыг бууруулах арга хэмжээ авсан.

### **2.3. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал**

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2020 оны эхний улиралд 7.4 их наяд төгрөгт хүрч, эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 10.7 %-аар буурсан байна.

Бууралтыг салбараар авч үзвэл тээвэр ба агуулахын үйл ажиллагаа хамгийн өндөр буюу - 30.6 %-аар, уул уурхай олборлолт -29.6 %-аар бөөний болон жижиглэн худалдаа -11.1 %-аар буурсан бол хөдөө аж ахуйн салбар 14.0 %-аар, барилга 11.9 %-аар боловсруулах үйлдвэр 5.1 %-аар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний 6 сарын байдлаар 5.3 тэрбум ам.долларт хүрч 2019 оны мөн үеэс 22.6 %-аар буурсан бол гадаад худалдааны тэнцэл 368.2 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 64.8 %-аар буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2020 оны эхний 6 сарын байдлаар 4,358.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1,212.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлаар мөнгөний бодлогын төлвийг хэлэлцэж байхдаа эдийн засгийн өсөлт II улиралд -7% орчим, жилийн дунгээрээ -1% байхаар төсөөлсөн байна.<sup>75</sup>

### **2.4. Монгол Улсын засгийн газраас эдийн засгийн эрсдлийг бууруулахад авч буй арга хэмжээнүүд**

Монгол Улсын коронавируст халдвартын цар тахлын улмаас ийнхүү эдийн засгийн өсөлт саарч, улмаар оны эцэст төсвийн орлого 3.4 их наяд төгрөгөөр буурах нөхцөл байдал үүсээд байгаа тул Засгийн газраас эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээнүүдийг он дуустал үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, мөн Улсын Их хурлын 2020 оны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Улсын Их Хурал, Тамгын газар, бүтэц, бүрэлдэхүүн, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийг тусган төсвийн тодотголын төслийг боловсруулж байна.

Төсвийн тодотголын төслийг боловсруулахдаа дараах **зарчмыг** баримталсан байна:

**а/Иргэд, аж ахуй нэгжийг үргэлжлүүлэн дэмжинэ.** Коронавируст халдвартын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн зарим арга хэмжээг үргэлжлүүлнэ.

**б/Коронавируст халдвартын эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангана.** Коронавируст халдварт цар тахлын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай санхүүжилтийг тэргүүн ээлжинд шийдвэрлэнэ.

**в/ Экспортыг нэмэгдүүлнэ.** Экспортыг далайцтай нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай хэрэгжүүлнэ.

**г/ Цахим шилжилтийг хурдасгана.** Иргэд, бизнес эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, бүх төрлийн тусгай зөвшөөрлийг цахим болгох замаар төрийн үйл ажиллагааг хүнд сурталгүй, шуурхай болгоно.

**д/ Хөрөнгө оруулалттын ажлыг гүйцэтгэлтэй уялдууллан санхүүжүүлнэ.** Гэрээ байгуулаагүй болон үр ашиггүй төслийг хасна. Дараа он руу шилжих болон ажлын гүйцэтгэл удаашралтай төслүүдийн санхүүжилтийг бууруулна.

<sup>75</sup> Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн. Эх сурвалж: Монголбанк <https://www.mongolbank.mn/news.aspx?id=2563&tid=2>

Төслийн тодотголоор дараах гол арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгаж байна. Үүнд:

**a/ Иргэд, аж ахуй нэгжийг үргэлжлүүлэн дэмжих чиглэлүүд:**

**Хүүхдийн мөнгө хөтөлбөр:** 2020 оныг дуустал 3 сарын хугацаанд хүүхдийн мөнгөн тэтгэмж **100.0** мянган төгрөгийг үргэлжлүүлэн олгоходо нийтдээ **300.0** тэрбум төгрөг зарцуулна.

**Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж:** 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр **288.0** мянган төгрөг олгож байгаа арга хэмжээг оны сүүлийн гурван сард үргэлжлүүлэн олгох ба нийтдээ **73.3** мянган хүн хамрагдаж **22.0** тэрбум төгрөг нэмж зарцуулахаар тооцсон байна.

**Нийгмийн даатгалын шимтгэл тэглэх арга хэмжээ:** 2020 оны 10-12 дугаар саруудад шимтгэлийн “хөнгөлөлт” байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр тооцов. Ингэхдээ шимтгэл “тэглэх” арга хэмжээнд хамрагдсан ААН, даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 5 %, даатгуулагч 5 % байхаар тооцсон бөгөөд нийт **144.4** тэрбум төгрөгийг чөлөөлнө.

**ААНОАТ-аас чөлөөлөх арга хэмжээ:** Уг татварын чөлөөлтөд **105** мянга гаруй аж ахуйн нэгжийг татвараас үргэлжлүүлэн чөлөөлөх ба үүний үр дүнд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд **15** тэрбум төгрөгийн дэмжлэг олгоно.

**Түрээсийн орлогын татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ:** Энэ арга хэмжээг он дуустал хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба ингэснээр **1000** орчим ААН, **25** мянган худалдаа эрхлэгчдийн түрээсийн төлбөр буурах боломжтой.

**b/ Коронавируст халдвартай /КОВИД-19-/ын эрдслээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангах чиглэлээр:**

Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зардлыг **109.3** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцлоо.

Коронавирусийн халдвартай эсрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр төсвийн орлого тодорхой хэмжээнд буурч байна. Цар тахлын улмаас хүндэрсэн иргэд, аж ахуйн нэгжийн зарим арга хэмжээг энэ оныг дуустал хэрэгжүүлж, ирээдүйд үүсэх эрсдлийг саармагжуулахаар төлөвлөж байна. Үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд нийт **642.2** тэрбум төгрөг зарцуулагдах ба арга хэмжээнүүдийг багцлан авч үзвэл:

**Хүснэгт 3. Коронавирусийн халдвартай холбоотой 2020 он дуустал үргэлжлүүлэх арга хэмжээний төсөө (тэрбум төгрөгөөр)**

	<b>Авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Төсөө</b>
1.	НДШ-ийн хувь хэмжээг бууруулах	144.4
2.	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөг, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн арга хэмжээг он дуустал үргэлжлүүлэн олгох	322.0
3.	Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах	109.3
4.	Эрсдлийн бэлэн байдлыг хангах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх	40.0
5.	Оношуур, эм эмнэлгийн хэрэгслийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх	4.0
6.	Жилийн 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-ийг ААНОАТ-аас үргэлжлүүлэн чөлөөлөх	15.0
7.	Түрээсийн төлбөрөө бууруулсан ААН-ийн түрээсийн орлогод ногдуулах татварыг үргэлжлүүлэн хөнгөлөх	7.5
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>642.2</b>

Эх сурвалж: Сангийн яам

**в/ Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр:**

Төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд нийт **1.2** их наяд төгрөгийн нэмэлт орлого төвлөрүүлнэ. Үүнд: Нүүрсний экспортыг нэмэгдүүлж, 2000 хүртэл машин нүүрс экспортолж **300** тэрбум төгрөг, уул уурхай газрын тосны экспортыг нэмэгдүүлэх **50** тэрбум төгрөг, алт-2 хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн алт тушаалтыг 5 тонноор нэмэгдүүлснээр **40** тэрбум төгрөг, татвар, гаалийн шинэчлэлийн хүрээнд е-баримт, татварын удирдагын нэгдсэн системийг хөгжүүлэх, бүртгэл хамрагдалтыг **90** тэрбум төгрөг, шүүхийн шийдвэртэй, хурумтлагдсан татварын өрийг ХЗДХЯ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран барагдуулах ажлыг эрчимжүүлэх **110** тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, “Эрдэнэс Таван толгой” ХК-аас татварын урьдчилгаа авах замаар нийт 600 тэрбум төгрөг төсвийн нэмэлт орлого бүрдүүлэх арга хэмжээнүүдийг авна.

**г/ Цахим шилжилтийг хурдасгах, урсгал зардлыг хэмнэх чиглэлээр:**

Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулж, төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор төрийн үйлчилгээний цахим шилжилтийг түргэтгэх зорилт тавьж байна. Төрийн үйлчилгээг цахимжуулснаар төрийн үйлчилгээний байгууллагад хүн олноор цуглуулахгүй байх, төрийн үйлчилгээний хүнд суртал, авлигыг арилгах, иргэнд хүргэх үйлчилгээний хурд нэмэгдэх эерэг үр дагавартай юм.

**д/ Хөрөнгө оруулалтыг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлэх чиглэлээр:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тодотголыг дараах хоёр зарчмыг баримтлан боловсруулсан байна. Үүнд: Гэрээ байгуулаагүй төслүүд, мөн тэвчиж болох төслүүдийн санхүүжилтийг хасах. Дараа он руу үргэлжлэх төслүүд болон ажлын гүйцэтгэлтэй уялдуулан, удаашралтай төслүүдийн санхүүжилтийг бууруулж 2021 он руу хойшшуулах шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн ДНБ-ний 5 ба түүнээс дээш хувь бол гэсэн нөхцөлүүд зэрэг үүссэнээр нэгдсэн төсвийн 2020 оны тодотголд төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх хууль, эрх зүйн нөхцөл бүрдсэн болно<sup>76</sup>.



<sup>76</sup>Эх сурвалж: Сангийн яам [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn)

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.cdc.gov/flu/pandemic-resources/1918-pandemic-h1n1.html>.
- <https://development.asia/explainer/covid-19-and-sars-epidemiological-and-economic-comparison>.
- <https://theconversation.com/compare-the-flu-pandemic-of-1918-and-covid-19-with-caution-the-past-is-not-a-prediction-138895>.
- <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&deathsMetric=true&dailyFreq=true&perCapita=true&smoothing=7&country=USA~GBR~CAN~BRA~AUS~IND~DEU~FRA&pickerMetric=location&pickerSort=asc>.
- <https://www.nature.com/articles/d41586-020-01248-1>.
- <https://www.bsg.ox.ac.uk/research/research-projects/coronavirus-government-response-tracker>.
- <https://www.bsg.ox.ac.uk/sites/default/files/2020-05/BSG-WP-2020-032-v6.0.pdf>.
- [https://github.com/OxCGR/T/covid-policy-tracker/blob/master/documentation/index\\_methodology.md](https://github.com/OxCGR/T/covid-policy-tracker/blob/master/documentation/index_methodology.md).
- <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1201971220303738>.
- <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?tab=table&zoomToSelection=true&time=2020-03-15..&deathsMetric=true&totalFreq=true&smoothing=0&country=USA~GBR~CAN~BRA~AUS~IND~DEU~FRA&pickerMetric=location&pickerSort=asc>.
- <https://www.bsg.ox.ac.uk/research/publications/lockdown-rollback-checklist>.
- <https://www.euro.who.int/en/health-topics/health-emergencies/coronavirus-covid-19/news/news/2020/4/who-europe-publishes-considerations-for-gradual-easing-of-covid-19-measures>.
- Available: <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?tab=table&zoomToSelection=true&time=2020-03-15..&deathsMetric=true&totalFreq=true&smoothing=0&country=USA~GBR~CAN~BRA~AUS~IND~DEU~FRA&pickerMetric=location&pickerSort=asc>.
- [https://www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X\(20\)30295-3/fulltext](https://www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X(20)30295-3/fulltext).
- <http://gemtel.mn/uploads/Oсол%20гэмтлийн%20тандалтын%202020%20оны%20эхний%20xarac%20жилийн%20эргэн%20мэдээлэл.pdf>.
- [https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share\\_btn\\_fb](https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share_btn_fb).
- <https://theconversation.com/what-coronavirus-success-of-taiwan-and-iceland-has-in-common-140455>.
- <https://theconversation.com/what-coronavirus-success-of-taiwan-and-iceland-has-in-common-140455>.
- <https://www.smh.com.au/world/europe/global-rollback-coronavirus-lockdowns-eased-as-pandemic-continues-20200507-p54qx5.html>.
- <https://ourworldindata.org/covid-exemplar-south-korea>.
- <https://time.com/5868098/schools-reopening-coronavirus-denmark-south-korea-israel/>.
- <https://www.rnz.co.nz/news/national/416188/covid-19-mercy-flights-for-new-zealanders-could-cost-up-to-14m>.
- <https://www.mfat.govt.nz/en/countries-and-regions/south-asia/india/new-zealand-high-commission/faqs-potential-air-india-flights-information-for-new-zealanders/>.
- <https://www.bbc.com/news/world-asia-53274085>.
- <https://spectator.sme.sk/c/22404507/slovakia-earns-reputation-as-a-success-story-in-the-coronavirus-pandemic.html>.
- <https://foreignpolicy.com/2020/05/06/slovakia-coronavirus-pandemic-public-trust-media/>.
- <https://ourworldindata.org/covid-exemplar-vietnam>.
- <https://www.npr.org/sections/goatsandsoda/2020/07/15/889802561/a-covid-19-success-story-in-rwanda-free-testing-robot-caregivers>.
- <https://www.dhis2.org/rwanda-covid-testing>.
- <https://www.bbc.com/news/world-us-canada-53337483>.
- <https://time.com/5874222/uk-halts-easing-covid19-lockdown/>.
- <https://www.bbc.com/news/uk-53469839>.
- <https://www.forbes.com/sites/niallmcCarthy/2020/03/12/the-countries-with-the-most-critical-care-beds-per-capita-infographic/#ad11c047f864>.

- <https://ourworldindata.org/covid-exemplar-germany>.
- <https://edition.cnn.com/2020/03/29/europe/russia-coronavirus-authoritarian-tech-intl/index.html>.
- <https://www.themoscowtimes.com/2020/08/03/coronavirus-in-russia-the-latest-news-aug-3-a69117>.
- <https://www.bbc.com/news/world-europe-53621708>.
- <https://www.gazeta.ru/social/2020/07/27/13167487.shtml>.
- [https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share\\_btn\\_fb](https://www.theguardian.com/world/2020/aug/03/the-people-that-covid-19-has-cut-off-from-home?CMP=share_btn_fb).
- [<https://thediplomat.com/2020/07/post-covid-china-set-to-gain-in-central-asia/>].
- <https://www.insider.com/how-china-denmark-japan-reopening-schools-2020-4#some-schools-have-rooms-to-isolate-students-who-have-fever-7>.
- <https://www.sciencemag.org/news/2020/07/school-openings-across-globe-suggest-ways-keep-coronavirus-away-despite-outbreaks>.
- <https://www.who.int/mongolia/news/feature-stories/detail/country-programme-on-subnational-health-system-strengthening-in-mongolia>.
- <https://data.worldbank.org/indicator/SH.XPD.CHEX.PC.CD?locations=MN>.
- <https://www.aa.com.tr/en/asia-pacific/indonesia-produces-50-000-testing-kits-for-covid-19/1844999>.
- <https://www.medicaldevice-network.com/news/genestore-low-cost-covid-19-rt-pcr-test-kit/>.
- <http://www.mnb.mn/i/211477>.
- Дэлхийн банк: Дэлхийн эдийн засаг 2020 онд 5.2%-аар агшина. Эх сурвалж: Монголбанк 2020.06.17. <https://news.mn/r/2314835>
- Хятадын эдийн засаг цар тахлын дараа анх удаа өссөн үзүүлэлтэй гарчээ. Эх сурвалж: CNN 2020.07.16 <https://news.mn/r/2327444>
- Дэлхийн эдийн засаг оны II хагаст сэргэх үү. Эх сурвалж: Монголбанк Б.Жаргал 2020.06.01 <https://news.mn/r/2306939>
- Bank of Japan on Hold, Expects Moderate Recovery in H2. 2020.07.15 <https://continuumeconomics.com/2020/07/15/thought/bank-of-japan-on-hold-expecting-moderate-reco>
- House of Common library
- <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8866/>
- House of Commons library "Coronavirus: Economic impact" 31 July 2020
- <https://commonslibrary.parliament.uk/>
- International monetary fund; Polive responses to Covid-19. 2020.07.31
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>
- <https://www.imf.org/en/About/FAQ/imf-response-to-covid-19>
- Coronavirus (COVID-19) restrictions Victoria. 2020.08.02
- <https://www.vic.gov.au/coronavirus-covid-19-restrictions-victoria>
- International monetary fund; Polive responses to Covid-19. 2020.07.31
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>
- Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасурэн. <https://www.mongolbank.mn/news.aspx?id=2563&tid=2>

## **ХЯМРАЛЫН ҮЕИЙН МАНЛАЙЛАЛ: КОРОНАВИРУСИЙН ТАХАЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ БА ИРЭЭДҮЙН СОРИЛТ**

*Г.Алтан-Оч (Ph.D)*

### **АГУУЛГА**

**ХЯМРАЛЫН ҮЕИЙН МАНЛАЙЛАЛ: КОРОНАВИРУСИЙН ТАХАЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ БА  
ИРЭЭДҮЙН СОРИЛТ**

**ХЯМРАЛТАЙ НҮҮР ТУЛААД ТҮҮНИЙГ СӨРӨН ТУЛАЛДАХ УУ ЭСВЭЛ БУУЖ ӨГӨХ ҮҮ?**

**ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ТУСТАЙ МАНЛАЙЛАГЧИЙН 4 АРГА БАРИЛ**

**ХЯМРАЛЫН ҮЕД ЖИНХЭНЭ МАНЛАЙЛАГЧИД ХАТААГДДАГ**

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## **ХЯМРАЛЫН ҮЕИЙН МАНЛАЙЛАЛ: КОРОНАВИРУСИЙН ТАХАЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ БА ИРЭЭДҮЙН СОРИЛТ**

Хямралын үед манлайлагчдын хийх ёстай ажил бол урьдчилан тодорхойлсон хариу арга хэмжээний төлөвлөгөө бус харин өчигдрийн (өнгөрсөн) байдалд хэт реакцилахаас зайлсхийх зан байдал<sup>77</sup>, сэтгэлгээ<sup>78</sup>, ирээдүйг харах нь илүү чухал юм.

### **Хямралын үеийн зохион байгуулалт: Багуудын сүлжээ**

Хямралын үед манлайлагчид тогтвортой байдал хангах дээрээс-доош (top-down) хариу арга хэмжээнээс татгалзах шаардлагатай. Ердийн гамшгийн үед удирдлагын комманд-хяналт гэсэн бүтцээр тодорхой журамлагдсан хариу арга хэмжээ авч ажиллах нь үр дүнтэй байдаг аж. Гэтэл хямралын үед юуг ч урьдчилан таамаглах боломжгүй байдаг учир манлайлагчид үл таних нөхцөл байдалтай нүүр тулж, улмаар ойлгоц муутай байдаг аж. Зохион байгуулалтын бүтцийн удирдлагад байгаа гүйцэтгэх эрх мэдлийн багавтар бүлэг нь мэдээллийг бүрэн авах болон хариу арга хэмжээний шийдвэрийг түргэн гаргах боломжгүй байдаг. Тиймээс манлайлагчид эрх мэдлийн маш ойлгомжтой шатлал бүхий уян хатан зохион байгуулалтын бүтэц бий болгож, улмаар олгогдсон эрх мэдлийн хүрээнд асуудлыг илрүүлэх, бие даан зохих арга хэмжээ авах эрхийг бусдад олгох шаардлагатай.

Их стресс, хаос нөхцөл байдалтай үед асуудлыг түргэн шийдэж, гүйцэтгэхийн (хэрэгжүүлэхийн) тулд манлайлагчид багуудын сүлжээ зохион байгуулах нь зүйтэй.

Энэхүү багуудын сүлжээнд дараах 4 чиг үүргийг хэрэгжүүлэх мэдрэлийн төв<sup>79</sup> ажиллах ёстай: ажиллах хүчийг хамгаалах, хангамжийн гинжин хэлхээг<sup>80</sup> тогтворжуулах, харилцагчтай уулзах<sup>81</sup> болон санхүүгийн стресс шалгах<sup>82</sup>.

Манлайлагч нь багуудын сүлжээний хүрээнд хамтын ажиллагаа, ил тод байдлыг дэмжих хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга нь эрх мэдлийг төлөөлүүлэх болон мэдээллийг хуваалцах юм.

Манлайлагчийн бас нэг үүрэг бол хямралын үед сэтгэл хөдлөл, түгшүүрт байдлын түвшин өндөр байдаг учир сэтгэл санааны аюулгүй байдал тогтоох нь чухал: хүмүүст айдас хүйдэсгүй нээлттэй мэтгэлцэх (маргалдах), асуулт асуух боломж олгох.

### **Хямралын үе дэх сэтгэл сэргээдэг манлайлагч: “тайван амгалан”, “хязгаартай дэврүүн үзэл”-ийн үнэ цэнэ**

Байгууллагын ахлах гүйцэтгэх ажилтнууд комманд-хяналтын бүтцийн зарим эрх үүргээ багуудын сүлжээнд шилжүүлэхэд бэлтгэлтэй байх учиртай. Бусдад хямралын хариу арга хэмжээ авах эрх мэдлийг шууд олгох шаардлагатай. Ингэхдээ тэд зөвшөөрөл авалгүй гаргасан шийдвэрээ нэвтрүүлэх эрх мэдэлтэй байна.

### **Мэдэхгүй зүйлүүдийн хооронд шийдвэр гаргалт: Завсарлага авч үнэлээд, таамагласны дараа хийх**

Завсарлах-Үнэлэх-Таамаглах-Хийх гэсэн циклээр ажиллавал манлайлагчид тайван амгалан байдлаа хадгалж, шинэ мэдээлэл гарч ирмэгц хэт реакцилахаас зайлсхийхэд тустай байх болно. Заримдаа хямралын үед үнэлэх, таамаглах цаг байхгүйгээс шууд хийх шаардлага тулгарсан бол манлайлагч зогсоод, ойлгоод, урагш харж бодоод шийдвэрээ гаргах хэрэгтэй.

<sup>77</sup> behavior

<sup>78</sup> mindset

<sup>79</sup> Nerve center

<sup>80</sup> Supply-chain

<sup>81</sup> Customer engagement

<sup>82</sup> Financial stress testing

Үнэлэх, таамаглах тохиолдолд манлайлагчид 2 арга тус болно. Эхний нь, шинэчлэх<sup>83</sup> гэдэг, багуудын олсон шинэ мэдээлэл, тэдгээрийн мэдлэгт тулгуурлан гаргасан санааг хянан шалгах явдал юм. Удаах нь, эргэлзэх<sup>84</sup> гэдэг, авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнд шүүмжлэлтэй хандаж, тэдгээрийг өөрчлөх<sup>85</sup>, сайжруулах<sup>86</sup>, эсвэл таслан зогсоох<sup>87</sup> эсэх шийдвэр гаргахад манлайлагчид боломж олгох арга юм.

### **Хамт санаа зовж<sup>88</sup> байгаагаа үзүүлэх: Хүний зовлонд анхдагч ач холбогдол өгөх**

Даяар хямралын үед хүмүүс хамгийн эхэнд зөвхөн өөрөө амьд гарах, бусад суурь хэрэгцээгээ хангахад л анхаардаг. Харин хямралын үед манлайлагчийн хамгийн чухал үүрэг бол хүмүүсийн амьдралд эерэг ялгаа бий болгох явдал юм.

Эцэст нь хэлэхэд, манлайлагч өөрөө хамт санаа зовж байгаагаа харуулахаас гадна өөрийгөө бусдын санаа зовж байгааг тосож авахаар нээлттэй байж, мөн өөрийн эрүүл энх, сайн сайханд санаа тавих хэрэгтэй. Хямралын үеийн стресс нь манлайлагчийн мэдээлэл боловсруулах болон шүүн тунгаах чадварт муугаар нөлөөлөх нь зайлшгүй.

### **Үр дүнтэй харилцаа: Ил тод байдлыг хангаж, байнга шинэчлэх**

Манлайлагчид хямралын үед ихэвчлэн буруу харилцдаг<sup>89</sup>. Хямралын эхний үед тэд өөртөө хэт итгэлтэй, дуугаа өндөрсгөж мэдэгдэл хийх, мөн манлайлагч хямралыг хэр мэдэж байгаа болон яж сайн ажиллаж байгаа талаараа оролцогч талуудыг хардах нь нэмэгддэг. Бас цаг хугацаатай уралдан онцгой байдлын мэдээ баримт, шийдвэр гаргах асуудал хүлээгдэж байгаа боловч удирдах ажилтнууд мэдээлэл өгөхдөө сунжуулах тал руугаа хэлбийдэг.

Ами Эдмондсон бичсэнчлэн, “Хямралын үед манлайлагчийн хийх ‘нэгдүгээр ажил бол ил тод байдал’. Чи юу мэдэж байгаагаа, юу мэдэхгүй байгаагаа, асуудалд суралцаж байгаа тухайгаа тодорхой хэл.” Бодоход, тогтмол харилцах нь манлайлагч асуудлыг ойлгож, суралцангaa хариу арга хэмжээг засан сайжруулж байгаа гэдгийг харуулна. Ингэснээр хямралтай нүүр тулсан оролцогч талуудын санаа амрах болно. Хямралын хариу арга хэмжээний багийн гишүүдийн хэрхэн хийх талаар эхлээд сонсох нь нэн үр дүнтэй байдаг аж.

Хямрал болоод өнгөрсний хойно ч гэсэн харилцааг зогсоож болохгүй. Өөдрөг үзэл, бодит ирээдүйг харуулах нь нөхөн сэргээн босгох үйл явцад ажилтан болон оролцогч талуудад хүчтэй нөлөө үзүүлдэг байна.[1]

## **ХЯМРАЛТАЙ НҮҮР ТУЛААД ТҮҮНИЙГ СӨРӨН ТУЛАЛДАХ УУ ЭСВЭЛ БУУЖ ӨГӨХ ҮҮ?**

Хямралын үед манлайлагчид л манлайлдаг. Хямрал болгонд ямар нэгэн боломжгүй мэт зүйлийг хийж, сайн үйл хийх боломж манлайлагчид олддог.

### **Манлайлагчдын сөрөн тулалдах 10 арга**

#### **1. Хүлээлтийг зэрэгцүүлэх**

Хямралын үед чамд бүх хариулт байхгүй байж болно, гэвч мэдэхгүй байгаагаа

<sup>83</sup> Updating

<sup>84</sup> Doubting

<sup>85</sup> modified

<sup>86</sup> adopted

<sup>87</sup> discarded

<sup>88</sup> Empathy

<sup>89</sup> Communications

**илэрхийлж, итгэлтэй ярих** хэрэгтэй. Хүмүүс танаас үйлдэл хүлээж байгаа. Хүлээлт болон бодит байдлыг зэрэгцүүлэх нь мэдлэг чадвар, саруул ухаан, тэвчээр, түүнчлэн бүх хариултыг мэдэхгүй байгаагаа хүлээн зөвшөөрөх чадвартай байхыг шаарддаг аж. Манлагчид нь харилцааны саад тогторыг даван туулж, эрт бөгөөд байнга харилцах шаардлагатай.

## **2. Бүх нүд чам дээр тусна**

Манлагчид ихэвчлэн бүх нүд чам дээр тусаж байгааг мартдаг. Ялангуяа асуудал улам түгшүүртэй болохын сацуу. Ийм үед хүмүүс манлагчдын үгийг сонсож, үйлдлийг харж, дохио зангааг ажиглаж байдаг.

Манлагч өөрийгөө сайн мэднэ. **Би чухам хэн бэ гэдгээ харуулж юу хийх** чинь чухал: чиний талаар хүмүүсийн өмнө нь мэддэг тийм шинж чанар, үнэ цэн, авьяас чадвар болон мэдлэг туршлага. Өөрийгөө танин мэдэх гэдэг бол манлагчийн хөгжүүлэх ёстой ур чадварын нэг юм.

## **3. Эерэг бай**

Жоон Максвэлл “Гутранг үзэлтэн салхинд гомдолдог. Өөдрөг үзэлтэн түүнээс өөрчлөхийг хүлээдэг. Манлагч дарвуулаа тохируулдаг” гэж хэлжээ.

Манлагч аль болох өөдрөг байх хэрэгтэй. Хямралын үе дэх түүний зан байдал шийдвэрлэх ач холбогдолтой аж. **Эерэг бодол, үйлдэл** нь хүч чадал, амжилт бүтээл, аятай тохиол (боломж), хамтын ажиллагаа руу чиглэж байдаг. Манлагч нь итгэл, найдвар, өөдрөг бодол цацуулж байдаг, энэ нь эерэг эрчим, итгэл найдвар, зорилго үр дүнд хөтөлдөг.

## **4. Үнэнийг хэл**

Харилцаа бол чиний гол зэвсэг. Хямралыг ихэвчлэн мэдээллийн дутмагшил дагалдагаас буруу ойлгох явдал элбэг. **Асуудлыг чин сэтгэлээсээ чиг урагшаа замаар тайлбарлаж,** түүнийг даван туулах эерэг алхмууд руу чиглүүлэх хэрэгтэй. Үгийг ухаалгаар сонгож, тууштай (дэс дараалалтай), ойлгомжтой бай. Харилц, Харилц, бас дахин харилц. Хэрэв чи ойлгомжгүй болбол (будилаан таривал) **хожигдох (ялагдах) болно.**

## **5. Юуны төлөө байгаагаа мэддэг бай**

Хэрэв хэн нэгэн чамаас юуны төлөө байдгийг чинь асуувал чи юу гэж хариулах вэ? Чиний зорилго үр дүн, амьдралын зорилго, үнэ цэн юу вэ? Үйлдэл бүр чинь үүнийг тусгаж байх ёстой. Энэ нь зөвхөн ямар нэгэн зүйлийн төлөө байгаа биш; харин энэ хорвоод чиний хийж чадах ондоошлыг илтгэж, улмаар шат ахин **юуны төлөө байгааг чинь олон түмэнд харуулж, бусдаар ижил зүйл хийлгэхээр уриалан дуудаж** буй хэрэг юм. Манлагч нь зорилго үр дүнгийн байрнаас ажлаа эхэлдэг. Илүү дээд түвшний амьдралын зорилго багуудыг үйлдэл хийхэд нь өдөөж, бадрааж өгдөг. Манлагч чи бол нэг брэнд юм. Манлаглах боломжийг бүү алд, хямралын үеийг ашиглаж өөрийн брэндийн үнэ цэнийг бий болго.

## **6. Хамт санаа зовж байгаагаа үзүүл**

Ойлгохын тулд сонсож сур. Хүмүүст тэдний ирээдүйн төлөө чин зүрхнээс санаа тавьж буйгаа харуул. Зан заншлыг хүлээн зөвшөөр, сэтгэл хөдлөлд хариу үзүүл. Санаж ав: Хамт санаа зовож байгаа нь чи юу хүсэж байгаа тухай биш-харин бусад хүнд юу хэрэгтэй байгаа тухай юм. Чиний үйлдэл тэдэнд ашиг тус өгөх ёстой.

## **7. Том зургаар хар**

Манлагчид нь том зургаар харж, бусдыг харахаас аль өмнө боломжит үр дагаврыг харж

чаддаг байх хэрэгтэй. Ухарч очоод асуудлыг ажиглаж, ухаарах гэдэг их хэцүү. Миний аав “Чи юуг үл мэдэхээ мэддэггүй” гэж хэлдэгсэн. Манлайллагч нь харахгүй байгаа юмныхаа талаар тайван амгалан байх хэрэгтэй. Хямралын үед хамгийн хэцүү хийдэг зүйлүүдийн нэг бол том зурагт төвлөрөхийн сацуу яаралтай асуудлыг удирдах ажлаасаа алхам ухрах явдал юм.

### **8. Хурдаа хасаад тайван амгалан бай**

Тайван амгалан байдлаа хадгал! Хүмүүст хамгаалагдсан, аюулгүй байгаа гэсэн мэдрэмж төрөх ёстой. Тодорхой бус байдлын нөлөөг аль болохоор багасгахын тулд манлайллагч нь намбалаг байхын сацуу овсгоотой, тэвчээртэй байх ёстой. **Өөрийн оюун санаа, биеийн эрүүл мэндийг сахь**, тэгснээр чи бүрэн оршино. Хүмүүс сэтгэл хөдлөл, өдөөгдсөн зан байдлаар хооллож байдаг. Хэрэв намбалаг байдал алдагдвал хямрал дүүрэн байх болно.

### **9. Төлөвлө**

Теодоре М. Хэсбург “Манлайллын хамгийн чухал зүйл бол чи алсын хараатай байх явдал юм. Бодит бус бүрээг чи үлээж чадахгүй шүү дээ” хэмээн хэлжээ.

Хэрэв чи хаашаа явж байгаагаа мэдэхгүй бол хэзээ ч тэнд хүрэхгүй. Төвлөрөх (чиглүүлэх), сахилга бат маш чухал. Амжилтыг зөгнөж, ойлгоход хялбар, үл мэдэх зүйлд хариу өгөхөд уян хатан төлөвлөгөө зохио.

### **10. Зүгээр л манлайл**

Манлайллагч зүгээр л манлайлдаг. Тэд өөрсдийн дотроос, зоригтой, сэтгэл хөдлөлтэй, ухаалаг, хямралын үед чиг баримжаагаа алдалгүй ажилладаг. Тэд бэлтгэлтэй; тэд балмагддаггүй. Тэд бусдыг халамжилдаг, бусадтай харьцдаг. Манлайллагчид бол ер бусын зүйлийг хийж буй ердийн хүмүүс. Тэд хямралыг өөрсдийгээ болон хүрээлэн буй ертөнцийг өөрчлөх боломж гэж харж буй.

Юу ч боломжгүй мэт харагдах хаос, хямралын дээр авиран гарч, манлайлах боломжийг бүү алд. Хорвоо чамаар дутаж байна.[2]

## **ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ТУСТАЙ МАНЛАЙЛАГЧИЙН 4 АРГА БАРИЛ**

Харвардын эрдэмтдийн олж тогтоосноор, хямралын үед урагшаа алхахын тулд манлайллагч нь өөртөө болон багийн хамт олондоо дөрвөн арга барилыг суулгах шаардлагатай аж.

### **1-р тактик: Онохоос илүүтэй хурдан шийдэх**

Нөхцөл байдал өдөр хоногоор, заримдаа бүр цагаар өөрчлөгдөж байна. Тэргүүний манлайллагч нь байгаа мэдээллийг шалавхан боловсруулж, хамгийн гол санааг түргэн тодорхойлж, итгэл үнэмшилтэйгээр шийдвэрээ гаргадаг байна. Хямралын үед сэтгэхүйн хэт ачаалал заналхийлж, мэдээлэл дутмаг байж, ашиг сонирхол, эрэмбэ дараа зөрчилдэж, сэтгэл хөдлөл, зовнил түгшүүр дээд цэгт хүрсэн байдалтай байдаг. Иймээс түргэн шийдвэр гаргах хүрээ энгийн, хэр хэмжээтэй байх нь чухал байдаг.

### **2-р тактик: Зоригтой дасан зохицох**

Хүчтэй манлайллагч нь өөрчлөгдөн буй нөхцөл байдлыг түүчээлдэг байна. Тэд янз бүрийн эх сурвалжаас оролт, мэдээлэл хайж, мэдэхгүй байгаагаасаа аиж, ичдэггүй, хэрэв шаардлагатай бол гадны туршлагыг ч нэвтрүүлдэг.

### **3-р тактик: Найдвартай гүйцэтгэх**

Шилдэг манлайлагч нь хямралын үед олон өрсөлдөөн<sup>90</sup>, хүчин зүйл<sup>91</sup> түүний хяналтаас гадуур байдаг хэдий ч өөртөө эзэн болдог байна. Тэрээр багийг чиглүүлж, амжилт бүтээлийг хянах шинэ хэмжээс байгуулж, хариуцлагын соёл бий болгодог аж.

### **4-р тактик: Нөлөөлөхийн төлөө зоригжуулах**

Хямралын туршид өөрийн багийг тордохоос илүү чухал ажил гэж үгүй аж. Үр бүтээлтэй манлайлагч нь өөрийн багийн нөхцөл байдал, самуурлыг бүрэн ойлгож, харин ч чухал шинэ зорилт, мэдээллийн талаар ойлгомжтой, нэвтэрхий харилцан тэднийг зоригжуулах, өдөөх арга замыг олдог байна. Ковид-19 цар тахал нь мэдээж эрүүл мэндийн хямрал хэдий ч санхүүгийн хямралын оч үсэrsэн байгаа тул энэ асуудалд онцгой анхаарах нь зүйтэй. Манлайлагчид нь тогтмол, стресс ихтэй явагдаж буй энэхүү өөрчлөлтийн үед зэрэгцэн оршихын тулд шинэ эрэмбэ дарааг байнга тогтоож байх шаардлагатай аж.

### **Хямралыг манлайлахын төлөө өөрийн багийн бэлтгэлийг базаах.**

Манлайлагчдын манлайлагчийн хувиар та хариу барих хязгаарлагдмал цаг хугацаатай уралдан байнга өөрчлөгдөн буй шинэ эрэмбэ дарааны далайд сэлүүрдэн замнаж буй. Дэмжлэг үзүүлэх, дасгал сургуулилтын чиглэлд хийсэн бағавтар хөрөнгө оруулалт нь хэтдээ манлайлагчийн үр бүтээлийг хөөрөгдөх нь дамжиггүй.

Нэгэнт гарсан галыг хяналтдаа авсан бол гүнзгий амьсгaa аваад хэн нь баярын мишээлтэй байна вэ, хэн нь нэрвэгдэв, яагаад гэдэг талаар бодох үе ирнэ. Хямралын дараах ертөнцөд үүрэг роль хэрхэн өөрчлөгдөх, таны түлхүүр (гол) гүйцэтгэх ажилтнууд амжилтын төлөө зөв байршсан эсэхийг тунгаан бодох цаг. Сүүлчийн бөгөөд хамгийн чухал нь одоо хямралын үед болон маргааш шинэ хэвийн байдал тогтох үед ширээний ард хэнтэй цуг суухаа өөрөөсөө асуух явдал юм.[3]

## **ХЯМРАЛЫН ҮЕД ЖИНХЭНЭ МАНЛАЙЛАГЧИД ХАТААГДДАГ**

Зохиолч Давид Фостэр Валласе хэлсэнчлэн, “бидний хувийн хязгаарлагдмал зан чанар болох залхуу байдал, хувиа хичээсэн зан, сул тал болон айдсыг даван туулж, бидний өөрсдөө хийж чаддагаас илүү хэцүү зүйлийг хийхэд дэмжин тусалдаг” хүмүүсийг “жинхэнэ манлайлагч” гэнэ. Сүүлийн хоёр аравны зоригтой манлайлагчдыг судалсны үндсэн дээр манлайлагч нь төрмөл<sup>92</sup> бус, харин олдмол<sup>93</sup> болохыг тогтоов. **Хямралын үед манлайлагчид хатаагддаг** ажгуу. Хүмүүсийг хүнд цаг үеийг даван туулуулж, мандан бадраахын тулд хэрэв цөөн хэдэн арга барилыг эзэмшиж чадвал манлайлагч “жинхэнэ” болдог.

### **Хүмүүсийн айдсыг таньж, улмаар шийдэхэд нь зоригжуул.**

Хямралын үед танай ажилтнуудын ихэнх нь эрүүл мэнд, санхүүдээ зарим нь ажлын байрандаа санаа зовж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Нөхцөл байдал хэрхэн базаахгүй байгааг ойлгож, хамтын хүчээр даван туулах боломжтой талаар ухуулан тайлбарлах нь зүйтэй. Хамт олноо Рэвэрэнд В.С.Коффины хэлсэнчлэн “Зориг маш чухал шинж чанар. Бид үхэхийн төлөө айгаад байна уу, эсвэл амьдрахын төлөө айгаад байна уу?” гэдэг үгээр зоригжуул.

<sup>90</sup> Challenge

<sup>91</sup> Factor

<sup>92</sup> born

<sup>93</sup> made

## ***Хүмүүст үүрэг роль, зорилго өг.***

Жинхэнэ манлайлагч нь хувь хүмүүст өргөн олон нийтийн төлөө үйлчлэх үүрэг даалгавар өгдөг. Тэд хүмүүст ажил өгдөг.

Ингэхдээ үйл ажиллагаанд оролцож буй хүн бүрийн гол үүрэг ролийг тодотгох (тодруулах) нь амин чухал юм.

## ***Сорилт туршилтыг тодорхой болгож, суралц.***

Зоригтой манлайлагч нь замын туршид алдаа хийж болзошгүй, хэрэв алдвал түргэн эргэлт хийнэ гэдгээ ойлгодог, **явж байхдаа суралцдаг** аж.

Энэхүү хямрал нь нийгмийн хүрээнд нэгнээсээ зай барих, өргөн хүрээнд эдийн засаг унаж байгаагаас гадна байгууллага, баг бүрийг давуу болон сул талаа сайн танъж мэдэх, хүмүүсийг жинхэнээс нь уулзуулж, өдөөж, тэдний оршихуйн учир шалтгааныг тодруулж өгч байна.

## ***Эрчим болон сэтгэл хөдлөлөөр ханд-өөртөө болон тэдэнд.***

Хямралын үед хүмүүс түгшин шаналж шатах дөхөөд байна. Хайртай хэн нэгнээ алдсан зарим нь эзгүйрэн хоосорсон байгаа. Тиймээс хүмүүсийн эрчим болон сэтгэл хөдлөлийн судсыг байнга барьж, тохирсон хариу үйлдэл хийх нь манлайлагчийн бас нэг чухал үүрэг хариуцлага юм.

Эрчим болон сэтгэл хөдлөлийн чиг хандлагыг өөрөөсөө эхлүүл. Манлайлагч нь туг юм. Туг намирвал бүгд намирна, үгүй бол байгууллагын зорилтоос авахуулаад бүх зүйл эмзэг болно. Иймээс оролдлого хийх туршид өөрийн бие, сэтгэл болон оюун санааг сайн тордох хэрэгтэй. Хэзээ төвлөрч ажиллах, үр бүтээлтэй байдгаа, хэзээ завсарлахаа мэддэг бай. Сайн хоолло, сайн унтаж амар, тогтмол дасгал хий, салхинд гар, гэр бүл, гэрийн тэжээмэл амьтантайгаа хамт бай, найз нөхөд, хамаатан садантайгаа виртуал холбогд, өдөрт наанадаж төхөөрөмжгүй хоёр үеийг төлөвлө (дор хаяхад тус бүрдээ 30 минут), таныг хөрсөн дээр буулгах бусад практик г.м.

Дараагийн нь алхам бол биеийн хэл, үг болон үйлдэл ашиглан итгэлтэйгээр, зоригтой урагшаа ахиж байгаа дохио өг. Ингэснээр багийн гишүүд нэг нэгнийгээ дууриан хийх болно. Та амрахад зориулан цаг гаргадгаа мэдэгд, ажилтнуудаа ингэхийг уриалж, тэдэнд даалгавар өг. Ёс суртахууныг хөөрөгдөх түргэн арга бол баярласан сэтгэлээ илэрхийлэх явдал юм.[4]



## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- Leadership in a crisis: Responding to the coronavirus outbreak and future challenges <https://www.mckinsey.com/business-functions/organization/our-insights/leadership-in-a-crisis-responding-to-the-coronavirus-outbreak-and-future-challenges>
- 10 Steps to Effective Coronavirus Crisis Leadership <https://www.inc.com/entrepreneurs-organization/10-steps-to-effective-coronavirus-crisis-leadership.html>
- 4 Behaviors That Help Leaders Manage a Crisis <https://hbr.org/2020/04/4-behaviors-that-help-leaders-manage-a-crisis>
- Real Leaders Are Forged in Crisis <https://hbr.org/2020/04/real-leaders-are-forged-in-crisis>



# **3**

## **БҮЛЭГ**

---

**ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## **ТӨРИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТУС, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Д.Бадамдаш, Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ  
Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Нургүл  
Р.Оргилмаа, Д.Халиун, Э.Энхтүвшин*

### **АГУУЛГА**

Товчилсон үгийн жагсаалт

УДИРТГАЛ

НЭГ. ТӨРИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТУСЫН ТАЛААР

- 1.1. Төрийн хамгаалалтын хөгжлийн загвар, нийтлэг шинж, ялгаатай талууд
- 1.2. Гадаадын зарим орны төрийн хамгаалалтын байгууллагын загварын тойм
- 1.3. Дүгнэлт

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ  
МЭДЭЭЛЭЛ

- 2.1. ОХУ
- 2.2. БНХАУ
- 2.3. Япон
- 2.4. БНСУ
- 2.5. БНКаз.У
- 2.6. БНТУ
- 2.7. АНУ
- 2.8. ХБНГУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



## **Товчилсон үгийн жагсаалт**

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
Бнказ.У	Бүгд Найрамдах Казахстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНУ	Бүгд Найрамдах Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХАТИХ	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал
ДЯЯ	Дотоод Явдлын Яам
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
НАХХЭЯ	Нийгмийн Аюулаас Хамгаалах Хэрэг Эрхлэх Яам
ОНАБҮК	Олон Нийтийн Аюулгүй Байдлын Үндэсний Комисс
ОХУ	Оросын Холбооны Улс
ТЕГ	Тагнуулын Ерөнхий Газар
ТТГ	Тагнуулын Төв Газар
ТТХГ	Төрийн Тусгай Хамгаалалтын Газар
УАБХГ	Улсын Аюулгүй Байдлыг Хангах Газар
УАБХЕГ	Улсын Аюулгүй Байдлыг Хангах Ерөнхий Газар
УАХЯ	Улсыг Аюулаас Хамгаалах Яам
ҮЦА	Үндэсний Цагдаагийн Агентлаг
ХАЧА	Хятадын Ардын Чөлөөлөх Арми
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХКН	Хятадын Коммунист Нам
ХХА	Холбооны Хамгаалалтын Алба
ЭХХТШ	Эзэн Хааны Харуулын Төв Штаб

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Энэхүү судалгааны Нэгдүгээр бүлэгт: Төрийн хамгаалалтын хөгжлийн загвар, нийтлэг шинж, ялгаатай талуудын талаар болон нийт 15 улсын төрийн хамгаалалтын байгууллагын загварыг тоймлон судалсан.

Хоёрдугаар бүлэгт: Захиалагчийн хүсэлтийн дагуу 8 улс (ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНКаз.У, БНТУ, АНУ, ХБНГУ)-ын төрийн хамгаалалтын:

- эрх зүйн үндэс;
- тухайн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын статус, бүрэн эрх;
- удирдлагын эрх хэмжээ;
- галт зэвсэг хэрэглэх зохицуулалт;
- ажилтнуудыг төрийн албаны ангилал, зэрэглэл (энгийн цэрэг, эсхүл цэрэг);
- төрийн хамгаалалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо;
- төрийн өндөр дээд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хамгаалалтын зохицуулалт, хугацаа зэрэг асуудлын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг тус тус судалсан болно.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### НЭГ. ТӨРИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТУСЫН ТАЛААР

Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газар (ТТХГ) нь 1938 онд тухайн үеийн Дотоод явдлын яам (ДЯЯ)-ны бүтцэд байгуулагдсан цагаасаа хойш ДЯЯ, Цэрэг ба Нийгмийн аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яам (ЦНАХХЭЯ), Нийгмийг аюулаас хамгаалах яам (НАХЯ), Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар (УАБХЕГ), Тагнуулын төв газар (ТТГ), Улсын аюулгүй байдлыг хангах газар (УАБХГ), Тагнуулын ерөнхий газар (ТЕГ)-ын дэргэд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн, 2015 оноос хойш тагнуулын нэгдмэл байгууллагын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байж ирсэн төрийн тусгай алба юм. ТТХГ-ын алба хаагчид нь тусгай албаны ажилтанд тавигдах ёс зүйн болон бие бялдрын шалгуур үзүүлэлтэд нийцсэн, цэргийн жинхэнэ алба хаагч байдаг. Тус газрын статусыг өөрчлөх, төрийн өөр институтэд харьяалуулах талаар гарч байгаа санал, санаачилга нь манай улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын тогтолцооны хөгжлийн өнөөгийн түвшинд тохиромжгүй, өөрчлөлтийн бодит зорилго, хүрэх үр дүн нь тодорхойгүй төдийгүй олон талын сөрөг үр дагавартай байна.

#### 1.1. Төрийн хамгаалалтын хөгжлийн загвар, нийтлэг шинж, ялгаатай талууд

Төрийн хамгаалалт бол дэлхийн аль ч улсын хувьд төрийн онцгой чиг үүрэг гүйцэтгэдэг тусгай алба бөгөөд тухайн улс орны онцлогоос хамааран харилцан адилгүй загвараар хөгжиж иржээ. Үүнд “тухайн улс орны онцлог” гэдэгт:

- Төр, эрх зүйн түүхэн уламжлал (тухайн улс хаант засагтай, эсхүл бүгд найрамдах засагтай эсэх, бүгд найрамдах засагтай бол парламентын, эсхүл ерөнхийлөгчийн засаглалтай эсэхээс хамаарсан онцлог);
- Эрх зүйн тогтолцоо (Ром-Германы болон Англи-Саксоны ай бүлгийн алинд багтдаг болох, түүнчлэн тухайн харилцааг уламжлалаар, хуулиар, захирамжлалын баримт бичгээр зохицуулж ирсэн зэрэг онцлог);
- Түүхийн тодорхой үйл явдлуудаас улбаатай сэтгэлгээний онцлог (улс төрийн дэглэм өөрчлөгдсөн байдал, тухайлбал, хүчирхийлэл бүхий хувьсгал, тайван хувьсгал, төрийн эргэлт, цэргийн эргэлт зэрэг үйл явдал гарсан эсэх, олон намын болон нэг намын тогтолцоотой зэрэг онцлогоос хамаарсан сэтгэлгээний хэлбэр) зэргийг ойлгоно.

- Харин “төрийн хамгаалалтын загвар” гэдэгт;
- Байгууллагын статус (төрийн байгууллагуудын тогтолцоонд эзлэх байр суурь, бие даасан байгууллага, эсхүл төрийн аль нэг байгууллагын бүтцэд болон түүний дэргэд хамаардаг эсэх);
- Харьялал, удирдлага (төрийн гүйцэтгэх болон зарим тохиолдолд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч аль субъектээс удирдлага нь томилогддог, шууд захирагддаг байдал);
- Бүтэц, зохион байгуулалт (дотоод бүтэц, бие бүрэлдэхүүний нөхөн хангалтын онцлог, тухайлбал: алба хаагчдын төрийн тусгай албаны аль бүтцэд хамаарах зэрэг онцлог) эдгээр болно.

Дээрх шалгуур үзүүлэлтээр дэлхийн улсуудын төрийн хамгаалалтын байгууллагууд өмнө дурдсан онцлогуудаас хамааран нэг хэв загвар байхгүй хэдий ч дараах нийтлэг шинж байна:

- Төрийн церемониал удирдлага, функционал удирдлага (гүйцэтгэх эрх мэдэл)-ыг хэрэгжүүлэгч субъектын биечилсэн аюулгүй байдлыг хамгаалах, үүгээрээ төрийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;
- Төрийн институционал удирдлагыг хэрэгжүүлэгч субъектууд байрлах онцгой болон зарим үед улс үндэстний оюун санааны үнэт объектуудын физик аюулгүй байдлыг хамгаалах, үүгээрээ төрийн залгамж чанарыг хангах;
- Хүч хэрэглэх, үүний дотор галт зэвсэг хэрэглэх эрх бүхий байгууллага, цэргийн эсхүл цэрэгжсэн байгууллагын статустай, цэргийн болон цэрэгжсэн зохион байгууллтай байдаг;
- Дээрхээс үүдэн алба хаагчид тавигдах бие бялдар, ёс зүйн болон бусад тусгай шалгуур үзүүлэлтийг өндөр түвшинд мөрдүүлдэг нийтлэг шинжтэй.

Харин өмнө дурдсанчлан, төрийн түүх, улс төрийн сэтгэлгээ болон эрх зүйн тогтолцооноос болон зарим субъектив хүчин зүйлсээс хамаарсан ялгаатай талууд байна.

*Үүнээс харьялал, удирдлагын хувьд:*

- Шууд төрийн тэргүүн, эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнд (зарим тохиолдолд парламентад) захирагдах бие даасан байгууллага;
- Тусгай алба (тагнуулын байгууллага)-ны бүрэлдэхүүнд буюу дэргэд ажиллах байгууллага;
- Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн дэх анги, нэгтгэл;
- Хууль сахиулах системийн бүтэц дэх (цагдаа, дотоодын цэрэг, жандармери, гварди) байгууллага;
- Дээр дурдсан байгууллагуудын дундын буюу холимог тогтолцоотой гэсэн ялгаа байна.

*Харин хамгаалалтын ажилтан (алба хаагч)-ы статусын хувьд:*

- Ихэнх оронд цэргийн (зэвсэгт хүчин болон түүнтэй адилтгах байгууллагын) алба хаагч;
- Мөн цөөнгүй тооны улсад хууль сахиулах алба, түүнтэй адилтгах байгууллагын цол, хэргэм бүхий төрийн тусгай алба хаагч;
- Маш цөөхөн тохиолдолд иргэний статустай төрийн тусгай алба хаагч гэсэн хэлбэрүүд ялгагдаж байна.

## **1.2.Гадаадын зарим орны төрийн хамгаалалтын байгууллагын загварын тойм**

Харьцуулсан судалгаанд түүвэрлэн авсан 15 улсын төрийн хамгаалалтын байгууллагын загварыг тоймлон авч үзэхэд дараах байдалтай байна.

**1. ОХУ-ЫН Холбооны хамгаалалтын алба** (Федеральная служба охраны). Хуулиндаа “төрийн цэрэгжсэн байгууллага” (“государственная военизированная организация”), “улсын аюулгүй байдлыг хангах үндсэн хүч хэрэгслүүдийн нэг” (“один из основная сил и средствий обесечения государственной безопасности”), “тусгай алба” (“спецслужба”) хэмээн тодорхойлж, дээрх гурван тодорхойлолтод Гадаад тагнуулын алба, Холбооны аюулгүй байдлын албаны нэгэн адил хамрагдана гэж заажээ. Харьяллын хувьд ОХУ-ЫН Ерөнхийлөгчид шууд захирагдаг, алба хаагч нь “цэргийн алба хаагч” (“военнослужащий”)—ийн статустай. Бүрэлдэхүүнд нь Кремлийн комендант, Ерөнхийлөгчийн хороо (торгон цэрэг), Ерөнхийлөгчийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим багтах ба эдгээр нь Зэвсэгт хүчний төрлийн хүндэт харуул, хөгжмийн албанаас болон Үндэсний гвардиас тусдаа байна. Мөн тусгай алба хэмээх тодорхойлолтод нийцэхүйц нэгэн эрхийг хуульчилсан нь тус байгууллага гүйцэтгэх, шуурхай эрэн сурвалжлах ажил эрхлэхээр заасан байдаг аж.<sup>i</sup> ОХУ-ЫН Холбооны хамгаалалтын алба нь ЗХУ-ЫН үеийн бүтэц, алба хаагчийн статус, эрх хэмжээг тодорхой хэмжээгээр уламжилсан нь 1991 оноос хойш ОХУ-Д хийгдсэн тусгай албадын шинэчлэлийн нөлөөг ч тусгасан онцлогтойгоор хөгжиж ирсэн байна.

**2. БНХАУ-ЫН төрийн хамгаалалтын байгууллагыг ХКН-ЫН Хамгаалалтын төв товчоо** (Жунгун жунъян барьгуунтын жинвэйжю) хэмээн нэрлэх ба чиг үүргийг нь “ХКН, БНХАУ-ЫН дээд удирдлагын улс төрийн болон биечилсэн хамгаалалтыг хариуцна” хэмээн заасан байдаг. ХКН-ЫН Төв Хорооны бүтцэд багтах уг байгууллага ХКН-ЫН Төв Хороо, БНХАУ-ЫН Нийгмийг аюулаас хамгаалах яам, Хятадын Ардын Чөлөөлөх Армийн Нэгдсэн штаб (хуучнаар Жанжин штаб) гэсэн гурвалсан удирдлагатайгаараа онцлогтой. Хамгаалалтын ажилтнууд нь ХАЧА-ийн цэргийн алба хаагчийн статустай төдийгүй уг байгууллага “ХАЧА-ийн 2 дугаар дивиз” гэсэн байлдааны дугаартай байдаг.<sup>ii</sup> Бүрэлдэхүүнд нь нам, төрийн дээд удирдлагын хамгаалалтыг шууд гардан хэрэгжүүлдэг “61889 дүгээр отряд” багтдаг байна. Энэхүү байгууллага нь биечилсэн хамгаалалтаас гадна улс төрийн (үзэл суртлын) ажил эрхлэх үүргийг давхар хүлээдэг.

**3. АНУ-ЫН Нууц алба** (United States Secret Service). Тус улсын төрийн байгууллагуудын тогтолцоонд “холбооны хууль сахиулах, мөрдөх байгууллага” (“federal law enforcement and investigation authority”) төдийгүй “ууган тусгай алба” гэж томьёологддог. Тус байгууллагын үндсэн чиг үүргийг “АНУ-ЫН ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэдгээрт нэр дэвшигчид болон хуучин ерөнхийлөгч, тэдгээрийн гэр бүл, ерөнхийлөгчийн албан тушаалын залгамжлалд ойр албан тушаалтнуудыг хамгаалах” гэж заажээ. Түүнчлэн мөнгөн тэмдэгт, үнэт цаас хуурамчаар үйлдэхтэй тэмцэх, илрүүлэх, санхүүгийн гэмт хэрэг, залиланг мөрдөн шалгах, илрүүлэх чиг үүргийг давхар хүлээдэг онцлогтой. Энэхүү өвөрмөц онцлог нь Нууц албаны үүсэл, түүхэн уламжлалтай холбоотой. Анх 1865 онд ерөнхийлөгч А.Линкольны шийдвэрээр байгуулагдсан тус алба 1901 он хүртэл зөвхөн мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэхтэй тэмцэх чиг үүрэгтэй, энэ зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй байв. Тийм ч учраас үүсэн байгуулагдсан цагаасаа хойш 2003 оныг хүртэл АНУ-ЫН Сангийн департамент (Department of Treasury)-д харьялагдаж байв. Өөрөөр хэлбэл, 1901-2003 оны хооронд 102 жилийн турш төрийн хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэж ирсэн атлаа Сангийн яамны бүтцэд ажиллаж ирсэн байна. Харин 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа АНУ-ЫН тусгай албадыг бүхэлд нь хамарсан бүтцийн өөрчлөлт хийсний үр дүнд Нууц албыг 2003 оноос Дотоод аюулгүй байдлын департамент (Department of Homeland Security)-ын бүтцэд харьялуулжээ. Хамгаалалтын ажилтнуудын нэг хэсэг нь иргэний тусгай алба хаагч, зарим нь Холбооны нийслэлийн Колумбия тойрог буюу Вашингтон хотын цагдаагийн газрын алба хаагчийн статустай байдаг. АНУ-ЫН Нууц алба тус улсын түүхийн уламжлал, түүхэн үйл явдлуудтай салшгүй холбоотойгоор хөгжиж ирсэн байна.

- 4. Польшийн Засгийн газрын хамгаалалтын товчоо** (Biuro Ochrony Rzadu) нь 2001 оноос өмнө Зэвсэгт хүчний 1004 дүгээр ангийн дугаартай байгаад 2001 оноос АНУ-ын Нууц албатай адил зохион байгуулалтад шилжсэн. Төрийн хамгаалалтаас гадна терроризмтой тэмцэх сөрөх тусгай ажиллагааг давхар гүйцэтгэдэг.
- 5. Францын БНУ-ын ерөнхийлөгчийн аюулгүй байдлыг хангах бүлэг** (Groupe de securite de la presidence de la Republique) нь тус улсын Дотоод хэргийн яаманд харьяалагдана. Засгийн газрын албан ёсны ил мэдээллээр цагдаагийн 45, жандармерийн 45, нийт 90 алба хаагчийн орон тоотой бөгөөд 2007 оноос орон тоог нь 60 байсныг 90 болгож нэмэгдүүлсэн байна.
- 6. Япон Улсын хувьд** Төрийн тусгай хамгаалалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага болох **Аюулгүй байдлын ажиллагааны газар** Цагдаагийн агентлагийн бүтцийн нэгж байна. Харин Японы цагдаагийн байгууллага нь Засгийн газрын Тамгын газрын холбогдох асуудал эрхэлсэн Комисст харьяалагдана.
- 7. Энэтхэгийн Тусгай хамгаалалтын бүлэг** (Special Protection Group) нь 1981 он хүртэл Дели хотын цагдаагийн газрын бүтцэд харьяалагдаж байгаад 1981-1985 онд Тагнуулын товчоо (Intelligence Bureau)-ны тусгай хэлтсийн статустай байсан бол 1985 оноос Засгийн газрын хэрэг нарийн бичгийн дарга нарын газар (Засгийн газрын хэрэг эрхлэх газар)-ын шууд удирдлагад ажиллаж байна. Тус бүлгийн дарга нь Засгийн газрын нарийн бичгийн даргын зэрэглэлтэй, цагдаагийн дээд офицерийн цолтой байх аж. Хамгаалалтын ажилтнууд нь цагдаагийн алба хаагчид байна.
- 8. Израил улсын Кнессетийн харуул** (Мишмар Ха-Кнессет)-ыг 1958 онд цагдаагийн байгууллагаас салгаж тусад нь гаргасан ба бие бүрэлдэхүүн нь Израилийн Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид байна.
- 9. БНСУ-ын Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын алба** (Дэтоннён кёнхочо) АНУ-ын Нууц албаны загвараар байгуулагдсан, улсын ерөнхийлөгчид шууд захирагдах, иргэний тусгай албаны статустай.
- 10. Украин улсын Төрийн хамгаалалтын газар** (Управління державної охорони) нь тус улсын Ерөнхийлөгч болон Дээд Рада (парламент)-ын хоёрдмол удирдлагад шууд захирагдах цэрэгжсэн байгууллага бөгөөд хамгаалалтын ажилтнууд нь цэргийн алба хаагч байна.
- 11. Австралийн Хамтын нөхөрлөлийн хамгаалалтын алба** (Commonwealth Protective Service)-ыг 1984 онд Холбооны цагдаагийн газраас салгаж байгуулсан ч 2004 онд буцааж бүрэлдэхүүнд нь оруулсан, цагдаагийн тусгай хэлтсийн статустай, ажилтнууд нь цагдаагийн албан хаагч байхаар хуульчилжээ.
- 12. Шведийн Вант Улсын Аюулгүй байдлын алба** (Sakerhetspolisen) нь тус улсын сөрөх тагнуул, үндсэн хуулийн хамгаалалт, терроризмтой тэмцэх, төрийн тусгай хамгаалалтын нэгдсэн байгууллага юм.
- 13. Латвийн Сейм ба Ерөнхийлөгчийн хамгаалалтын алба** (Saiemas un Valsts prezidenta drosibas diensts) нь 2009 он хүртэл тус улсын сөрөх тагнуулын байгууллагын удирдлагад ажиллаж байгаад 2009 оноос Латвийн Зэвсэгт хүчний Цэргийн цагдаагийн батальоны статустай болсон, өдгөө БХЯ-нд шууд харьяалагддаг.
- 14. Гүрж улсын Төрийн тусгай хамгаалалтын газар** (Сакартвелос сахелмципо дацвис специалури самсахури) 1996 оныг хүртэл Улсыг аюулаас хамгаалах яамны бүтцэд байсан ба одоо бие даасан агентлагийн статустай. Энэ улс 2012 онд үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарласнаар тус байгууллага ерөнхийлөгчид бус, парламентад шууд захирагдах болжээ. Харин улсын ерөнхийлөгч зөвхөн өөрийнхөө

хамгаалагчдыг сонгох эрхтэй хэвээр үлдсэн байна.

**15. БНАСАУ-ын Хамгаалалтын дээд командлал** (Хови сарёнбу) нь тус улсын удирдагчийн аюулгүй байдлыг шууд хариуцдаг хамгаалалтын алба бөгөөд онцлог нь БНАСАУ-ын Улсыг аюулаас хамгаалах яамны Улсыг аюулаас хамгаалах ерөнхий газарт харьялагддаг төрийн тусгай хамгаалалтын албанаас тусдаа бүтэктэй. УАХЯ-ны ТТГ нь БНАСАУ-ын дээд удирдагчаас бусад удирдах албан тушаалтнууд болон гадаадын өндөр түвшний зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хариуцдаг бол Хамгаалалтын дээд командлал нь БНАСАУ-ын Төрийн зөвлөлийн дарга, СХН-ын дарга буюу тус улсын дээд удирдагчийн хамгаалалтыг гардан хариуцдаг, Солонгосын Ардын Армийн хуурай замын цэргийн 963 дугаар нэгтгэлийн дугаартай, зарим ил эх сурвалжийн мэдээллээр дотроо зургаан газар, байлдааны гурван бригад, хамгаалалтын дивизүүд, барилгын цэргийн нэг батальон гэсэн бүтэктэй байж магадгүй.

### **1.3.Дүгнэлт (Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Д.Бадамдаш)**

Европ, Америк, Ази тивийн төлөөлөл, улс төрийн тогтолцоо, хүн ам зүйн нөхцөл байдал, төрт ёсны уламжлал харилцан адилгүй 15 улсын төрийн тусгай хамгаалалтын байгууллагуудын загварыг түүвэрлэн харьцуулан судлахад дараах дүр зураг ажиглагдаж байна:

- Төрийн хамгаалалт нь их төлөв төрийн гүйцэтгэх эрх мэдлийн (төрийн тэргүүний, эсхүл засгийн газрын) шууд удирдлагад харьялагдах төрийн тусгай алба байдаг дэлхийн ихэнх улсын нийтлэг жишиг байна. Сонгон авсан 15 улсаас ганцхан Гүрж улсын төрийн тусгай хамгаалалтын алба парламентаас байгуулагддаг бол Украины төрийн хамгаалалтын албыг ерөнхийлөгч, парламент хамтран удирддаг. Эдгээр жишээ нь тухайн улсуудад сүүлийн жилүүдэд өрнөсөн улс төрийн үйл явцын ул мөр гэж үзэж болно.
- Нэг нам бүхий улс төрийн тогтолцоотой БНХАУ, БНАСАУ-ын хамгаалалтын албад эрх баригч намын төв хорооны шууд удирдлагад, цэргийн ангийн дугаартай, зэвсэгт хүчний нэгтгэлийн зэрэглэлтэй байгаа нь улс төрийн тогтолцооноос үүдэлтэй онцлог мөн.
- Парламентын засаглалтай ихэнх улсад засгийн газар, эсхүл хууль зүй, дотоод хэргийн яамны харьялалд, хамгаалалтын ажилтнууд нь цагдаагийн алба хаагчийн статустайгаар үйл ажиллагаа явуулдаг бол АНУ-д түүхэн уламжлалаас үлдэж хоцорсон загварыг БНСҮ, Польш зэрэг тус улсын зарим цэрэг-улс төрийн холбоотон жишиг болгон авсан байна.
- Харин хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан, эсхүл ЗХУ-тай ойр харилцаатай байсан улсуудад тусгай албаны эрх хэмжээ бүхий цэрэгжсэн байгууллагын загвараар оршин тогтнож, хамгаалалтын ажилтнууд нь зэвсэгт хүчнийхтэй адилтгасан цэргийн алба хаагчийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Иймд төрийн хамгаалалтын байгууллага бол тухайн улс орны: (а) төр, эрх зүйн түүхэн уламжлал, улс төрийн тогтолцооны онцлог, засаглалын хэлбэр; (б) эрх зүйн тогтолцоо, төр, засгийн байгууллагуудын үүсэн бүрэлдсэн нөхцөл байдал; (в) түүхэнд өрнөсөн тодорхой үйл явдлуудаас улбаатай сэтгэлгээний онцлог гэсэн гурван бүлэг хүчин зүйлээр нөхцөлдсөн өөрийн өвөрмөц хэв загвараар хөгжиж ирсэн ба Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газар ч орчин цагийн түүхийнхээ 80 жилийн туулсан замнал, түүн, уламжлал, 1992 оны Үндсэн хуулиар тогтсон төрийн тогтолцооны хүрээнд жам ёсны замналаар хөгжиж байна гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Төрийн хамгаалалтын алба бол зөвхөн биечилсэн хамгаалалтын үүрэг гүйцэтгэхгүй, гүйцэтгэх ажлын эрхтэй байх зайлшгүй шаардлагатай тусгай алба юм. Иймээс нэгдмэл бүтцийн давуу талыг тодорхойлбол:

**Аюул заналын харилцан хамаарал бүхий олон төрөл, хэлбэртэй нэгдсэн хүчээр тэмцэх чадавхид нэгдмэл тогтолцоо илүү үр нөлөөтэй.** Ийм нөхцөлд тусгай албад салангид үйл ажиллагаа явуулах нь нөхцөл байдлыг харилцан адилгүй үнэлэх, зөрүүтэй мэдээллийг төр, засгийн удирдлагад танилцуулах зэргээр шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлж байсан түүх дэлхийн улс орнуудад байдаг.

**Жижиг улсын хувьд тагнуулын хүч, хэрэгсэл, зардлыг оновчтой, үр ашигтай төлөвлөх боломжийг нэгдмэл бүтэц олгоно.** Тагнуулын үйл ажиллагаа бол хүн хүч, техник, санхүүгийн нөөцийн зарцуулалт ихээр шаарддаг тул бие даасан байгууллагуудад хуваарилах нь үр ашгийг бууруулж, татвар төлөгчдийн хөрөнгийг үр дүн муутай зарцуулахад хүргэнэ гэж дэлхийн улс орнууд үзэх хандлага ХХI зуун гарсаар нэмэгдэж байна.

**Манайд үйлчилж буй нэгдмэл тогтолцоо нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад илүү баталгаа болдог.** Аль ч улсын хувьд тусгай алба нь үндэсний аюулгүй байдлыг хангах дээд эрх ашгийн үүднээс, шаардлагатай тохиолдолд, хууль хяналтын байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор хүний эрхийг тодорхой хүрээ, цаг хугацаанд хязгаарлах үүрэг гүйцэтгэдэг. Ийм эрх бүхий байгууллага, субъектийн тоо олон байх нь ардчилсан нийгмийн үнэт зүйлд нийцэхгүй. Энэ үндэслэлээр тагнуулын байгууллага нэгдмэл удирдлага, зохион байгуулалттай байх, түүний хүрээнд төрийн хамгаалалтын байгууллага үйл ажиллагаагаа явуулах нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа болно.

## **ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **2.1.OХУ**

ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба (Федеральная служба охраны)-ыг хуулиндаа “төрийн цэрэгжсэн байгууллага” (“государственная военизированная организация”), “улсын аюулгүй байдлыг хангах үндсэн хүч хэрэгслүүдийн нэг” (“один из основная сил и средствий обесечения государственной безопасности”), “тусгай алба” (“спецслужба”) хэмээн тодорхойлж, дээрх гурван тодорхойлолтод Гадаад тагнуулын алба, Холбооны аюулгүй байдлын албаны нэгэн адил хамрагдана гэж заажээ. Харьяаллын хувьд ОХУ-ын Ерөнхийлөгчид шууд захирагддаг, алба хаагч нь “цэргийн алба хаагч” (“военнослужащий”)-ийн статустай. Бүрэлдэхүүнд нь Тусгай харилцаа холбоо, мэдээллийн алба, Кремлийн Комендантын алба, Ерөнхийлөгчийн найрал хөгжим, Тусгай зориулалтын гараж, Ерөнхийлөгчийн хороо (торгон цэрэг), Спорт клуб, ХХА-ны Академи багтах ба эдгээр нь Зэвсэгт хүчний төрлийн хүндэт харуул, хөгжмийн албанаас болон Үндэсний гвардиас тусдаа байна. Мөн тусгай алба хэмээх тодорхойлолтод нийцэхүйц нэгэн эрхийг хуульчилсан нь тус байгууллага гүйцэтгэх, шуурхай эрэн сурвалжлах ажил эрхлэхээр заасан байдаг. ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба нь ЗХУ-ын үеийн бүтэц, алба хаагчийн статус, эрх хэмжээг тодорхой хэмжээгээр уламжилсан нь 1991 оноос хойш ОХУ-д хийгдсэн тусгай албадын шинэчлэлийн нөлөөг ч тусгасан онцлогтойгоор хөгжиж ирсэн байна.

Оросын Холбооны Улс	
1. Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс	-Төрийн хамгаалалтын тухай хууль (1996) <sup>94</sup> ; -«ОХУ-ын Холбооны хамгаалалтын албаны журам» ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2004.08.07-ны өдрийн 1013-р тогтоол <sup>95</sup> ; -бусад эрх зүйн акт.
2. Байгууллагын статус	ХХА нь холбооны гүйцэтгэх байгууллага бөгөөд түүний удирдлагыг ОХУ-ын Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. <sup>96</sup>
3. Байгууллагын бүрэн эрх	ОХУ-ын ХХА-ны дараах <b>үндсэн үргүүдийг</b> хэрэгжүүлнэ <sup>97</sup> : 1) байнгын болон түр оршин суугаа газруудад, автотээврийн хэрэгслээр зорчих үед төрийн хамгаалалтын объектуудын аюулгүй байдлыг хангах; Төрийн хамгаалалтад авах объектуудад ОХУ-ын Ерөнхийлөгч, энэхүү Холбооны хуулиар тогтоосон хүмүүс, төрийн албан тушаалтнууд, албан хаагчид болон гадаад улсын төрийн болон засгийн газрын тэргүүнүүд, гадаад улсын бусад хүмүүс ОХУ-д оршин суух хугацаандаа хамаарна. <sup>98</sup> 2) төрийн хамгаалалтын объектын аюулыг урьдчилан таамаглах, тодорхойлох, энэхүү аюулаас урьдчилан сэргийлэх багц арга хэмжээг хэрэгжүүлэх; 3) холбооны төрийн байгууллага барилга байгууламж, улсын хамгаалалтад байгаа объектод хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох; 4) хамгаалалтын объект, улсын хамгаалалтын объектын байнгын болон түр хугацаагаар байх газрууд, тэдгээр рүү нэвтрэх замуудад гэмт хэрэг, бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох; 5) хамгаалалтын объектыг хамгаалах; 6) өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд терроризмтой тэмцэхэд оролцох; 7) төрийн байгууллагуудын тусгай харилцаа холбоо, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах, сайжруулах; 8) ОХУ-ын мэдээллийн аюулгүй байдал, техникийн тагнуултай тэмцэх, төрийн нууцыг бурдүүлж буй мэдээллийг хамгаалах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох; 9) ОХУ-ын хууль эрх зүйн мэдээллийн салбарт төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг уялдуулан зохион байгуулах; 10) мэдээллийн технологи, мэдээллийн шинжилгээгээр төрийн байгууллагуудыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны систем, нөхцөл байдлын төвүүдийн техник болон программ хангамж, мөн дайны болон онцгой байдлын үед төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн дэмжлэг үзүүлэх; 11) өөрийн аюулгүй байдлыг хангах.
4. Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн	ХХА нь холбооны гүйцэтгэх байгууллага бөгөөд түүний <b>удирдлагыг ОХУ-ын Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ</b> . <sup>99</sup> ОХУ-ын Ерөнхийлөгч тус албаны үйл ажиллагааны журам, холбооны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоог батална. <sup>100</sup>
5. Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт	Төрийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудын ажилтнууд зэвсэг, тусгай хэрэгслийг хадгалах, авч явахыг зөвшөөрөх, хуульд заасан журмын дагуу хэрэглэх <sup>101</sup> ба тэрээр албан тушаал, бүрэн эрх болон зэвсэг, тусгай хэрэгслийг хадгалах, авч явахыг баталгаажуулсан баримт

<sup>94</sup> ФЗ от 27.05.1996 N 57-ФЗ (ред. от 27.12.2019) "О государственной охране" - <http://www.consultant.ru/><sup>95</sup> Положение, утвержденное Указом Президента Российской Федерации от 7 августа 2004 г. № 1013 «Вопросы Федеральной службы охраны Российской Федерации».<sup>96</sup> ФЗ "О государственной охране", Статья 12 - <http://www.consultant.ru/><sup>97</sup> ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба (ХХА)-ны цахим хуудас - <http://www.fso.gov.ru/struktura/p8.html><sup>98</sup> ФЗ "О государственной охране", Статья 6-11 - <http://www.consultant.ru/><sup>99</sup> ФЗ "О государственной охране", Статья 12 - <http://www.consultant.ru/><sup>100</sup> ФЗ "О государственной охране", Статья 10, 12.4, 18.3 - <http://www.consultant.ru/><sup>101</sup> ФЗ "О государственной охране", Статья 15, 19.2, 24, 27 - <http://www.consultant.ru/>

бичигтэй байна.

Ажилтнууд дараахаас бусад тохиолдолд зэвсэг, тусгай хэрэгсэл, эсхүл бие махбодийн хүч хэрэглэхийн өмнө тухайн этгээдэд төрийн хамгаалалтын байгууллагын ажилтан гэдгээ мэдэгдэн **анхааруулах**, хууль ёсны шаардлагыг биелүүлэх боломж, цаг хугацаагаар хангах боломж олгоно.

- 1) зэвсэг, тусгай хэрэгсэл, эсхүл бие махбодийн хүч хэрэглэх хугацааг хойшлуулах нь төрийн хамгаалалтын объект, эсхүл төрийн хамгаалалтын байгууллагын ажилтан, төрийн хамгаалалттай арга хэмжээний оролцогчид, бусад иргэдийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учруулах, эсхүл төрийн хамгаалалтад байгаа байгууламж, тээврийн хэрэгсэлд бодит аюул занал учруулах бол;
- 2) ийм анхааруулга нь зохисгүй эсвэл боломжгүй бол.

Төрийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудын ажилтнууд дараах тохиолдолд өөр арга, хэрэгслээр хамгаалах боломжгүй бол **зэвсэг хэрэглэх эрхтэй**:

- 1) төрийн хамгаалалтын объектын амь нас, эрүүл мэндэд аюултай, халдлагын дайралтаас хамгаалах;
- 2) аюулгүй байдал арга хэмжээнд оролцсон төрийн аюулгүй байдлын болон бусад хамгаалалтын байгууллагын ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд аюул учрах, түүнчлэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, харилцаа холбоог хураах оролдлогыг таслан зогсоох;
- 3) хамгаалагдсан объект, тэдний тээврийн хэрэгсэл рүү дайрах, мөн дайрах аюулыг няцаах, барьцаалсны дараа суллах;
- 4) барьцаалагдсан хүмүүсийг суллах, террорист болон бусад гэмт хэргийн дайралтыг таслан зогсоох;
- 5) зэвсэгт эсэргүүцэл үзүүлсэн, зэвсгээ хүлээлгэн өгөх хуулийн шаардлагыг биелүүлэхээс татгалзах;
- 6) иргэдийг амь нас, эрүүл мэндэд нь заналхийлэх халдлагаас хамгаалах.

Мөн төрийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудын ажилтнууд дараах тохиолдолд **зэвсэг хэрэглэнэ**:

- 1) төрийн хамгаалалтын байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хамгаалагдсан объектуудыг нисгэгчгүй нисэх онгоцноос алсын удирдлагатай дохиоллыг дарах буюу хөрвүүлэх, тэдгээрийн хяналтын самбаруудад нөлөөлөх, түүнчлэн эдгээр хөлөг онгоцыг гэмтээх, устгах зорилгоор тээврийн хэрэгсэл, эсхүл бусад объектын хөдөлгөөнийг зогсоох (хэрэв өөр аргаар тэдгээрийн хөдөлгөөнийг зогсоох боломжгүй бол);
- 2) иргэдийн, эсхүл хамгаалалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудын ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлж байгаа амьтдыг устгах;
- 3) сэрэмжлүүлэх, дохио өгөх, дээшээ, эсхүл өөр аюулгүй чиглэлд тусламж дуудах зорилгоор буудах.

Хүмүүсийн амь насанд аюул заналхийлж буй зэвсэгт эсэргүүцэл, зэвсэгт бүлэглэлийн дайралт зэргээс бусад тохиолдолд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон насанд хүрээгүй хүмүүс гэдэг нь тодорхой, эсхүл ажилтанд мэдэгдсэн бол **зэвсэг хэрэглэхийг хориглоно**.

6. Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэрэг,

Төрийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудад **цэргийн албан хаагчид** ("военнослужащий"), **иргэний албан хаагчид** (холбооны улсын төрийн албан хаагчид, ажилчид) ажиллана.<sup>102</sup>

<sup>102</sup> ФЗ "О государственной охране", Статья 18.2 - <http://www.consultant.ru/>

### эсхүл цэрэг

7.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	<p>ХХА нь үйл ажиллагаагаа төв болон ОХУ-ын нутаг дэвсгэрийн салбар байгууллагуудаараа явуулна.</p> <p>1) <b>ХХА-ны Тусгай харилцаа холбоо, мэдээллийн алба</b> (Федеральная служба охраны, Спецсвязь ФСО)</p> <p>2) <b>Кремлийн Комендантын алба</b> (Служба коменданта Московского Кремля)</p> <p>-Ерөнхийлөгчийн хороо буюу торгон цэрэг (Президентский полк)</p> <p>-Ерөнхийлөгчийн найрал хөгжим (Президентский оркестр)</p> <p>3) <b>Тусгай зориулалтын гараж</b> (Гараж особого назначения) нь ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газрын тэргүүн, ОХУ-д болон гадаад улсад хийх айлчлалын үед дагалдан явах автотээврийн үйлчилгээ үзүүлнэ. Мөн төрийн хамгаалалтад байгаа бусад албан тушаалтан, гадаадын төлөөлөгчдөд болон албан ёсны томоохон арга хэмжээнд оролцно.</p> <p>-ХХА-ны автодром нь жолоочийн сургалт, дадлагын зориулалттай нийт 66 м<sup>2</sup> талбайтай, 1380 метр урт уралдааны замтай.</p> <p>-ХХА-ны музей</p> <p>-Хүндэт харуул (Почётный эскор特)</p> <p>4) <b>ХХА-ны Спорт клуб</b> (Спортивный клуб ФСО)</p> <p>5) <b>ХХА-ны Академи</b> (Академия ФСО) нь холбооны улсын төрийн өмчтэй цэргийн дээд боловсролын байгууллага бөгөөд дээд болон дунд мэргэжлийн боловсрол, мэргэжлийн үндсэн болон нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p> <p>-Түүний салбар сургууль нь Воронеж хот дахь Засгийн газрын харилцаа холбооны дээд сургууль бөгөөд харилцаа холбооны технологи болон системийн чиглэлээр дунд мэргэжлийн, давтан, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>
8.	Төрийн өндөр дээд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хамгаалалтын зохицуулалт, хугацаа	<p>Бүрэн эрхээ хэрэгжүүлэхээ больсон ОХУ-ын Ерөнхийлөгчийг <b>бүх насаар</b> нь "Төрийн хамгаалалтын тухай" хуульд заасан арга хэмжээ, түүний дотор тусгай харилцаа холбоо, тээврийн үйлчилгээнд хамруулж, түүний байнгын болон түр хугацаагаар оршин суудаг газруудад амь насыг хамгаалах үйл ажиллагааг төрийн хамгаалалттайгаар хангана.<sup>103</sup> Харин ОХУ-ын төрийн албан тушаалыг хашсан дараах хүмүүст төрийн хамгаалалтыг <b>бүрэн эрхийн хугацаанд</b> нь олгоно<sup>104</sup>:</p> <p>-ОХУ-ын Засгийн газрын тэргүүн;</p> <p>-ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн болон Төрийн Думын дарга нар;</p> <p>-ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тэргүүн;</p> <p>-ОХУ-ын Улсын дээд үзэхийн ерөнхий шүүгч;</p> <p>-ОХУ-ын Ерөнхий шүүгч;</p> <p>-ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны дарга.</p>

## 2.2.БНХАУ

ХКН-ын Ерөнхий Хорооны Аюулгүй байдлын товчоо нь ХКН-ын Төв Хорооны бүтцэд багтах бөгөөд ХКН-ын Төв Хороо, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам, Хятадын Ардын Чөлөөлөх Армийн Нэгдсэн штаб (хуучнаар Жанжин штаб) гэсэн турвалсан удирдлагатай. Төрийн өндөр дээд албан тушаалтуудын аюулгүй байдлыг турван түвшинд хамгаалдаг.

Хүснэгт 2

### Бүгд Найрамдах Хятад Ард Улс

- Байгууллагын статус Хятадын Коммунист Намын Ерөнхий Хорооны Аюулгүй байдлын товчоо нь Цэргийн төв зөвлөлийн хамтарсан штабт харьяалагддаг

<sup>103</sup> ФЗ от 12.02.2001 N 12-ФЗ (ред. от 21.07.2014) "О гарантиях Президенту Российской Федерации, прекратившему исполнение своих полномочий, и членам его семьи", Статья 2.1 –

<http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&firstDoc=1&lastDoc=1&nd=102063833>

<sup>104</sup> ФЗ "О государственной охране", Статья 8, 9 - <http://www.consultant.ru/>.

		бөгөөд энэ нь Хятадын Коммунист намын төв хорооны дэргэдэх цэргийн түвшний анги юм. Төрийн ерөнхийлөгчийн хувийн аюулгүй байдал, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга, Төрийн зөвлөлийн ерөнхий сайд, ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны байнгын хороо, ХКН-ын Төв хорооны улс төрийн товчооны аюулгүй байдлыг хариуцан ажилладаг. Товчоо нь Ардын чөлөөлөх армийн төв харуулын нэгжийг удирддаг.
2.	Байгууллагын бүрэн эрх	ХКН-ын Төв Хорооны бүтцэд багтах уг байгууллага ХКН-ын Төв Хороо, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам, Хятадын Ардын Чөлөөлөх Армийн Нэгдсэн штаб (хуучнаар Жанжин штаб) гэсэн гурвалсан удирдлагатайгаараа онцлог юм.
3.	Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн	Хятадын аюулгүй байдлын түвшинг дараах байдлаар зэрэглэнэ: Улс төрийн товчооны байнгын хороо нь нэгдүгээр түвшний хамгаалалтад, Улс төрийн товчооны гишүүн, орлогч гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга, ХКН-ын орлогч дарга, Төрийн зөвлөлийн дарга хоёрдугаар түвшний хамгаалалтад, Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн үндэсний хорооны орлогч дарга, Дээд ардын шүүхийн ерөнхийлөгч, Прокурор нь гуравдугаар түвшний хамгаалалтад тус тус байна. Төв засгийн газрын харьяа аймаг, автономит муж, засаг захиргааны байгууллагууд дахь нам, засгийн газрын удирдагчид мөн хамгаалалтад байдаг.
4.	Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт	Галт зэвсэг ашиглах эрхтэй.
5.	Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэрэг, эсхүл цэрэг)	Хамгаалалтын ажилтнууд нь ХАЧА-ийн цэргийн алба хаагчийн статустай төдийгүй уг байгууллага “ХАЧА-ийн 2 дугаар дивиз” гэсэн байлааны дугаартай. Бүрэлдэхүүнд нь нам, төрийн дээд удирдлагын хамгаалалтыг шууд гардан хэрэгжүүлдэг “61889 дүгээр отряд” багтдаг байна. Энэхүү байгууллага нь биечилсэн хамгаалалтаас гадна улс төрийн (үзэл суртлын) ажил эрхлэх үргийг давхар хүлээдэг.
6.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	Төв аюулгүй байдлын товчоо нь Ерөнхий алба, Улс төрийн хэлтэс, Бодлогын судалгааны газар, Үйл ажиллагааны алба, Тагнуулын газар, Технологийн газар, Харилцаа холбооны хэлтэс, Сургалтын алба, Аюулгүй байдлын газар, Барилгын тойм, алба, хэлтсээс бурддэг.
7.	Төрийн өндөр дээд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хамгаалалтын зохицуулалт, хугацаа	Төрийн зөвлөлийн 7 гишүүнийг бүх насаар нь хамгаална. Зарим албан тушаалтныг албан тушаалаа өгснөөс хойш 5-10 жил хамгаална.

### 2.3. ЯПОН

Япон Улсын хувьд Төрийн хамгаалалттай холбоотой асуудлыг Японы Цагдаагийн байгууллагын тухай, Цагдаагийн үүрэг гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоогоор зохицуулж байна.

Төрийн тусгай хамгаалалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага болох **Аюулгүй байдлын ажиллагааны газрын** статусын хувьд цагдаагийн агентлагийн бүтцийн нэгж байна. Харин Японы цагдаагийн байгууллага нь Засгийн газрын Тамгын газрын холбогдох асуудал эрхэлсэн Комисст харьяалагдана. Ингэхдээ ҮЦА-ийн улс төрөөс хараат бусаар ажиллах нөхцөлийг хангах асуудалд онцгой анхаарсан байна.<sup>105</sup>

<sup>105</sup> “Ерөнхий сайд Комисст шууд тушаал өгч, хяналт тавих эрхгүй ба энэ нь Комиссын улс төрийн төвийг сахисан байдлын баталгаа болдог. Комисс нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг удирдан явуулж, цагдаагийн алба хаагчдын сургалт, цагдаагийн холбоо, мэдээллийн арга технологид тулгуурлан мэдээллийг нарийвчлан задлан шинжлэх, гэмт хэргийн статистик, гэмт хэргийн криминалистик шинжилгээнд дүгнэлт

Хамгаалалтын товчоо Аюулгүй байдлын ажиллагааны газар нь тусгай хамгаалалтад байх албан тушаалтны аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцах болон томоохон хэмжээний осол, гамшиг, терроризмтой тэмцэх сөрөх тусгай ажиллагаа хариуцсан хоёр хэлтэстэй байна.

ҮЦА-ийн Ерөнхий комиссарыг Ерөнхий сайдын зөвшөөрснөөр ОНАБҮК томилно. Харин Ерөнхий комиссар Комиссын хяналтан дор агентлагийн ерөнхий үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлагаар хангаж, агентлагийн ажилтнуудыг томилно.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасны дагуу Эзэн хаан, түүний гэр бүлийн хамгаалалтыг ҮЦА-ийн харьяа Эзэн хааны харуулын төв штаб хариуцна.

Төрийн албаны ангиллын хувьд ҮЦА нь цагдаагийн ажилтан, эзэн хааны харуул хамгаалалтын ажилтан, бичиг хэргийн ажилтан, техникийн ажилтан болон шаардлагатай бусад ажилтнуудаас бүрдэнэ. ҮЦА-ийн удирдлага (Мэдээлэл, холбооны товчооны Ерөнхий захирлаас бусад) болон бусад албан тушаалтан цагдаагийн алба хаагч байна.

ҮЦА ны орон тооны хувьд: нийт ажиллагсдын тоо 7900 орчим байгаас цагдаагийн алба хаагч 2200, эзэн хааны харуул 900, инженер 4800, захирагааны ажилтнууд байна. (Нээлттэй эх сурвалжуудад нэгжүүдийн орон тоог нарийвчлан заагаагүй байна.)

### Хүснэгт 3

#### Япон

1. Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс	- Цагдаагийн байгууллагын тухай хууль, (1954 он) <sup>106</sup> - Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хууль, (1948 он) <sup>107</sup> - бусад эрх зүйн акт.
2. Байгууллагын статус (бие даасан агентлаг эсэх)	Япон Улсын төрийн тусгай хамгаалалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэх гол байгууллага, нэгж нь Үндэсний Цагдаагийн Агентлаг ( <i>National Police Agency</i> )-ийн <u>Хамгаалалтын товчоо</u> ( <i>Security Bureau</i> )-ны <u>Аюулгүй байдлын ажиллагааны газар</u> ( <i>Security operations department</i> ) юм. Харин <u>Үндэсний Цагдаагийн Агентлаг</u> (ҮЦА) нь Японы Засгийн газрын Тамгын газрын ( <i>Cabinet Office</i> ) Олон нийтийн аюулгүй байдлын үндэсний комисс ( <i>National Public Safety Commission</i> )-т харьяалагдана. Японы Үндэсний цагдаагийн байгууллага нь Олон нийтийн аюулгүй

хийх, цагдаагийн тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг нэгдсэн харьяалал доор байлгахын сацуу цагдаагийн байгууллагын захирагааг зохицуулснаар хүний эрх болон эрх чөлөөг хамгаалан, олон нийтийн амгалан тайван байдлыг болон хэв журмыг сахиулах үүрэгтэй ажилладаг.

Комисс нь ҮЦА-ийн Ерөнхий комиссар болон орон нутгийн цагдаагийн байгууллагын дарга нарыг томилдог. Комисс нь ҮЦА-аар дамжуулан орон нутгийн цагдаагийн байгууллагуудад шууд бус хяналт тавьдаг.

Комисс нь дарга, таван гишүүнээс бүрдэнэ. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ба Засгийн газрын бодлогын уялдааг хангахын тулд Комиссын дарга нь төрийн сайд байх ба тэрээр комиссын хурлыг даргална. Гишүүдийг Ерөнхий сайд Парламентын дээд, доод хоёр танхимтай зөвшилцэн 5 жилээр томилно.

Комиссын гишүүнээр сүүлийн таван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад болон прокурорын байгууллагад төрийн алба хашиж байсан хүмүүсийг томилохгүй. Улс төрийн төвийг сахих байдлыг хангах үүднээс нэг намаас хоёроос илүүгүй гишүүнийг томилохгүй.

Комисс нь долоо хоног бүр хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдана.”

Японы Цагдаагийн байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайлан, Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас.

[https://www.npa.go.jp/english/Police\\_of\\_Japan/2019/Police\\_of\\_Japan\\_2019\\_5.pdf](https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2019/Police_of_Japan_2019_5.pdf) хандсан 2020.04.03

<sup>106</sup> Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1954 он (2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр шинэчлэн найруулсан.) Японы албан ёсны мэдээллийн цахим сан. Японы дотоод хэрэг, харилцаа холбооны яам.

[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=329AC0000000162](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=329AC0000000162) хандсан 2020.04.03. япон хэл дээр

<sup>107</sup> Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хууль, 1948 он. Японы албан ёсны мэдээллийн цахим сан. Японы дотоод хэрэг, харилцаа холбооны яам.

[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=323AC0000000136](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=323AC0000000136), <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2229&vm=04&re=02> хандсан 2020.04.03.

	<p>байдлын үндэсний комисс болон Үндэсний Цагдаагийн Агентлагаас бүрдэнэ.<sup>108</sup> ҮЦА-ийн харьяанд Үндэсний цагдаагийн академи, Цагдаагийн шинжлэх ухааны Үндэсний судалгааны хүрээлэн, <u>Эзэн хааны харуулын төв штаб</u> (<i>The Imperial Guard Headquarters</i>) үйл ажиллагаа явуулна. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Эзэн хааны харуулын төв штаб нь Эзэн хаан, хатан, ханхүү болон эзэн хааны гэр булийн бусад гишүүдийг хамгаалахаас гадна Эзэн хааны ордон ба Эзэн хааны бусад байгууламжийн аюулгүй байдлыг хариуцна. ЭХХТШ нь Эзэн хааны Цагдаагийн газар (<i>Imperial Police Administration</i>), Эзэн хааны аюулгүй байдал (<i>Imperial Security</i>) болон Эзэн хааны хараа хяналт (<i>Imperial Escort</i>) хариуцсан хэлтсээс бүрдэнэ.<sup>109</sup> Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасны дагуу Эзэн хааны харуулын төв штабын байршил болон дотоод зохион байгуулалтыг Засгийн газрын Тамгын газрын захирамжаар тогтооно.</p>
3. Байгууллагын бүрэн эрх	<p>2019 он хүртэл Хамгаалалтын товчоо нь гадаадын иргэд болон гадаадад үйл ажиллагаа явуулдаг Японы иргэдтэй холбоотой асуудлыг хариуцдаг гадаад харилцаа болон тагнуулын гэсэн хоёр газартай үйл ажиллагаа явуулж ирсэн.</p> <p>2019 онд оруулсан өөрчлөлтөөр Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасны дагуу <u>Хамгаалалтын товчоо</u> (<i>Security Bureau</i>)-ны Гадаад харилцаа ба тагнуулын газруудыг нэгтгэж Гадаад харилцаа, тагнуулын газар (<i>Foreign affairs and intelligence department</i>) болгон өөрчилсөн, <u>Аюулгүй байдлын ажиллагааны газар</u> (<i>Security operations department</i>)-ыг шинээр байгуулсан.<sup>110</sup> Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасны дагуу Хамгаалалтын товчоо нь Үндэсний Цагдаагийн Агентлагийн дараах үндсэн асуудлыг хариуцна. Үүнд: Хамгаалалтын цагдаатай (<i>Security Police</i>) холбоотой асуудал; Эзэн хааны харуултай холбоотой асуудал; Төрийн хамгаалалтад байх хүмүүсийн хамгаалалттай холбоотой асуудал; Хамгаалалтын хэрэгжүүлэлттэй холбоотой асуудал; Хуулийн 71 дүгээр зүйлд заасан онц байдалд авах арга хэмжээний төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал.</p> <p>2016 оны Чухал объектын ойр орчимд алсын зайн удирдлагатай хөдөлгөөнт төхөөрөмж (дрон гм.) нисгэхийг хориглох тухай хуульд<sup>111</sup> заасны дагуу тусгай хамгаалалттай объектын (үүнд: Парламентын ордон, Ерөнхий сайдын өргөө, гадаад дипломат төлөөлөгчдийн газрын байр, батлан хамгаалахтай холбоотой байгууламж, цөмийн цахилгаан станц гм.)<sup>112</sup> ойр орчимд дрон нисгэхийг хориглосон. Дроныг хууль бусаар нисгэсэн тохиолдолд цагдаагийн алба хаагчид нислэгийг зогсоо болон дроныг устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авах эрхтэй.<sup>113</sup></p>
4. Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн байдал	<p>ҮЦА-ийн Ерөнхий комиссарыг Ерөнхий сайдын зөвшөөрснөөр Олон нийтийн аюулгүй байдлын үндэсний комисс (ОНАБҮК) томилно. Үндэсний цагдаагийн агентлагийн дарга нь Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн удирдлагад захирагдаж, Цагдаагийн газрын албыг нэгтгэн хариуцаж, ажилтнуудыг томилж, халах болон ажилтнуудын албан үүргийн гүйцэтгэлийг нэгтгэн хянахын сацуу Цагдаагийн агентлагийн</p>

<sup>108</sup> Мөн тэнд.

<sup>109</sup> Мөн тэнд.

<sup>110</sup> Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчилсэнтэй холбоотой орох өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл.

<https://www.npa.go.jp/hakusyo/r01/honbun/html/vf131000.html> > хандсан 2020.04.03. япон хэл дээр

<sup>111</sup> Чухал объектын ойр орчимд алсын зайн удирдлагатай хөдөлгөөнт төхөөрөмж (дрон гм.) нисгэхийг хориглох тухай хууль, 2016 он.

[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=428AC1000000009](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=428AC1000000009) > хандсан 2020.04.03

<sup>112</sup> Холбогдох хуулиар нарийвчлан зохицуулсан.

<sup>113</sup> Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. Хамгаалалтын товчооны талаарх мэдээлэл.

<https://www.npa.go.jp/english/bureau/security/index.html> > хандсан 2020.04.03

харьяалагдах албан үүргийн тухайд засаг захиргааны нэгжийн цагдаагийн байгууллагыг удирдан ажилладаг.<sup>114</sup>

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлд “Тамгын газар нь Ерөнхий захирал, Товчоо бүр нь Ерөнхий захиралтай байх ба тэдгээр нь өгсөн чиглэлийн дагуу өөрсдийн нэгжийн үйл ажиллагааг удирдана. Хэлтэс бүр даргатай байх ба өөрсдийн нэгжээ удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу удирдана.” гэж заасан.

5. Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэс

Цагдаагийн алба хаагчийн зэвсэг ашиглах нөхцөлийн талаарх ерөнхий зохицуулалтыг Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлээр зохицуулсан бол, мөн хуулийн 67 дугаар зүйлд Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхийн тулд жижиг хэмжээний зэвсэгтэй байж болно, 68 дугаар зүйлийн 68.1-т Засгийн газрын тогтоолд заасны дагуу төрөөс ҮЦА-ийн цагдаагийн алба хаагчдыг хувцас болон албан үүргээ гүйцэтгэх хугацаанд шаардлагатай хэрэгслээр хангана заасан байна.

Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасны дагуу цагдаагийн алба хаагч нь гэмт этгээдийг баривчлах, оргохоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах албан үүргээ гүйцэтгэж байхад эсэргүүцэл үзүүлсэн зэрэг тохиолдолд тухайн нөхцөлд байдалд шаардлагатай хүрээнд зэвсэг ашиглаж болно. Ингэхдээ цагдаагийн алба хаагч нь Эрүүгийн хууль (1907 он)-ийн 36 дугаар зүйл (бие хамгаалах), эсхүл мөн хуулийн 37 дугаар зүйл (аюултай довтолгооноос зайлсхийх) болон дор зааснаас бусад тохиолдолд бусдад гэмтэл учруулахыг хориглоно.

(i) цаазаар авах ял, бүх насаар хорих ял, эсхүл гурав ба түүнээс доошгүй жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлэх онц харгис, аюултай гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хангалттай үндэслэлээр дээрх хэрэгт сэжиглэгдсэн этгээд нь цагдаагийн алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэж байхад зугтаахыг оролдсон, эсхүл гуравдагч этгээд дээр дурдсан этгээдийг зугтаалгахаар саад учруулсан тохиолдолд цагдаагийн алба хаагч өөр арга хэмжээ авах боломжгүй гэж үзсэн бол;

(ii) Баривчлах захирамжийн дагуу баривчлах, шүүхэд зарлан дуудах, саатуулах шийдвэрийг үндэслэн цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад тухайн этгээд зугтаахыг оролдсон, эсхүл гуравдагч этгээд дээр дурдсан этгээдийг зугтаалгахаар саад учруулсан тохиолдолд цагдаагийн алба хаагч өөр арга хэмжээ авах боломжгүй гэж үзсэн бол; ОНАБҮК-ийн 2002 оны 16 дугаар тогтоолоор Цагдаагийн алба хаагчдын тусгай галт зэвсэг ашиглах, эзэмших журмыг<sup>115</sup> баталсан. Тус журамд заасан тусгай галт зэвсэг гэж Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан “жижиг хэмжээний зэвсэг” (*small-sized weapon*)-ийг хэлнэ. Журмаар цагдаагийн алба хаагч болон эзэн хааны харуул, хамгаалалт хариуцсан ажилтнуудад галт зэвсэг олгох журам (галт зэвсэг олгох ажилтанд тавигдах шаардлага гм.) эзэмших, ашиглах галт зэвсгийн төрөл, галт зэвсэг хадгалах, ашиглах нөхцөл зэргийг нарийвчлан тогтоосон.

СУДАЛГААНЫ САН

<sup>114</sup> Японы Цагдаагийн байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайлан, Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас.

[https://www.npa.go.jp/english/Police\\_of\\_Japan/2019/Police\\_of\\_Japan\\_2019\\_5.pdf](https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2019/Police_of_Japan_2019_5.pdf) хандсан 2020.04.03

<sup>115</sup> ОНАБҮК-ийн 2002 оны 16 дугаар тогтоолоор Цагдаагийн алба хаагчдын тусгай галт зэвсэг ашиглах, эзэмших журам

[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=414M60400000016](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=414M60400000016) хандсан 2020.04.03. япон хэл дээр

6. Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэргийн, эсхүл энгийн)	<p>Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу ҮЦА-т цагдаагийн ажилтан, эзэн хааны харуул хамгаалалтын ажилтан, бичиг хэргийн ажилтан, техникийн ажилтан болон шаардлагатай бусад ажилтнуудыг томилно.</p> <p>Ерөнхий Комиссар, Дэд Комиссар, Тамгын газрын Ерөнхий захирал, Товчооны Ерөнхий захирал (Мэдээлэл, холбооны товчооны Ерөнхий захирлаас бусад), орон нутгийн цагдаагийн товчооны Ерөнхий захирал болон Засгийн газрын тогтоолоор баталсан бусад албан тушаалтан цагдаагийн алба хаагч байна.</p> <p>Хамгаалалтын товчооны ажилтнуудыг ҮЦА-ийн харьяа Цагдаагийн академи бэлтгэнэ.</p>
7. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	<p>Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу ҮЦА нь Тамгын газар болон 5 дотоод товчоотой (Олон нийтийн аюулгүй байдлын товчоо, Эрүүгийн мөрдөн байцаах товчоо, Зам тээврийн товчоо, Хамгаалалтын товчоо, Мэдээлэл холбооны товчоо).</p> <p>Хамгаалалтын товчооны <i>Аюулгүй байдлын ажиллагааны газар</i> (<i>Security operations department</i>) нь төрийн тусгай хамгаалалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тус газар нь 2 хэлтэстэй бөгөөд Аюулгүй байдлын ажиллагааны <i>1 дүгээр хэлтэс</i> (<i>First Security Operations Division</i>) нь тусгай хамгаалалтад байх албан тушаалтны<sup>116</sup> аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцах бол Аюулгүй байдлын ажиллагааны 2 дугаар хэлтэс (<i>Second Security Operations Division</i>) томоохон хэмжээний осол, гамшиг болон терроризмийт тэмцэх ажиллагааг хариуцна.<sup>117</sup></p> <p>2018 оны байдлаар Цагдаагийн байгууллагын нийт ажилтны тоо ойролцоогоор 296700 байн гэж ҮЦА-ийн цахим хуудсанд мэдээлжээ. Үүний дотор ҮЦА-ийн нийт ажиллагсдын тоо 7900 орчим байгаас цагдаагийн алба хаагч 2200, эзэн хааны харуул 900, инженер 4800 болон захиргааны ажилтнууд байна. Харин орон нутгийн цагдаагийн алба хаагчдын нийт тоо 288000 байна. Үүнээс цагдаагийн алба хаагч 260400, инженер 28400 болон захиргааны ажилтнууд багтаж байна.<sup>118</sup></p> <p>(Нээлттэй эх сурвалжуудад нэгжүүдийн орон тоог нарийвчлан заагаагүй байна)</p>

<sup>116</sup> Тусгай хамгаалалтад байх албан тушаалтан нь Ерөнхий сайд, бусад сайд нар (Парламентын дээд, доод танхимиын спикер, Токио хотын дарга), гадаадын төрийн өндөр дээд, хэмжээний зочид болон холбогдох бусад этгээдийг хэлнэ.

Хамгаалалтын журам. ОНАБҮК-ийн 1975 оны 3 дугаар тогтоол.  
[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=340M50400000003](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=340M50400000003) > хандсан 2020.04.03 япон хэл дээр


[https://www.npa.go.jp/english/Police\\_of\\_Japan/2019/Police\\_of\\_Japan\\_2019\\_31.pdf](https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2019/Police_of_Japan_2019_31.pdf)>

<sup>117</sup> Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчилсэнтэй холбоотой орох өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл.

<https://www.npa.go.jp/hakusyo/r01/honbun/html/vf131000.html>> хандсан 2020.04.03. япон хэл дээр

<sup>118</sup> Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчилсэнтэй холбоотой орох өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл.

[https://www.npa.go.jp/english/Police\\_of\\_Japan/2019/Police\\_of\\_Japan\\_2019\\_6.pdf](https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2019/Police_of_Japan_2019_6.pdf)> хандсан 2020.04.03



## 2.4.БНСУ

Ерөнхийлөгчийн хамгаалалтын алба (PSS) нь анх 1963 онд Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хууль батлагдсанаар байгуулагдсан. Тус улсын Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тогтолцоо нь Хамгаалалтын албаны дарга, дэд дарга түүний удирдлага дор 6 хэлтэс үйл ажиллагаа явуулдаг. Хамгаалалтын алба нь үйл ажиллагаандaa Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг.

Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгчийн хамгаалалтын аюулгүй байдлын эсрэг арга хэмжээний хороо ажилладаг. Тус хороо нь Ерөнхийлөгчийн хамгаалалттай холбоотой байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр хамтран ажилладаг. Хороо нь дарга, дэд даргыг багтаасан 20 хүртэлх хүнээс бүрддэг.

Хороо нь дараах асуудлыг хариуцна. Үүнд:

1. Ерөнхийлөгчийн хамгаалалтад шаардлагатай аюулгүй байдлын эсрэг арга хэмжээний талаарх зөвлөгөөн;

<sup>119</sup> Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт. <https://www.npa.go.jp/english/index.html> > хандсан 2020.04.03

- Ерөнхийлөгчийн хамгаалалттай холбоотой тагнуулын мэдээлэл болон мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх;
- Аюулгүй байдлыг хангахад шаардлагатай гэж үзсэн бусад асуудлуудыг тус тус шийдвэрлэнэ.

Хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлэнэ.

Хорооны бүрэлдэхүүнд Үндэсний тагнуулын албаны ажилтан, Гадаад харилцааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Дээд прокурорын газар, Хууль зүйн яам, батлан хамгаалах яам, Дэд бүтэц, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Гаалийн газар, Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яам, Усан цэргийн анги болон Далайн цагдаагийн газар зэрэг 16 байгууллагын төлөөлөл ордог.

**Хүснэгт 4**

#### **Бүгд Найрамдах Солонгос Улс**

1	Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс	Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хууль Олон талт дээд хэмжээний уулзалтын аюулгүй байдал, аюулгүй байдлын менежментийн журам Ерөнхийлөгчийн харуул ба түүний харьяа байгууллагуудын алба Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, аюулгүй байдлын арга хэмжээний хорооны дүрэм Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай зарлиг
2	Байгууллагын статус (бие даасан агентлаг эсэх)	Бие даасан мэргэжлийн аюулгүй байдлын агентлаг
3	Байгууллагын бүрэн эрх	Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 3 дугаар зүйл. 1. Ерөнхийлөгч түүний гэр бүл 2. Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн ба түүний гэр бүл 3. Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд түүний гэр бүл, хүүхдийг тогтоосон хугацаанд 4. Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, түүний эхнэр, нөхөр 5. Гадаад орны төрийн тэргүүн эсвэл Засгийн газрын тэргүүн, түүний гэр бүлийн гишүүн 6. Солонгос улсад айлчилж байгаа бол 7. Хамгаалалтын албаны дарга хамгаалалт шаардлагатай гэж үзсэн гадаад, дотоод албан тушаалтан
4	Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн байдал	- Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу Хамгаалалтын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах - Эрх олгосон албан хаагчдийг томилох - Хамгаалалтын ажилтан шинээр авах асуудлыг шийдвэрлэх
5	Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэс	Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 19 зүйл. Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзвэл албан хаагч харьяалах даргын зөвшөөрлөөр зэвсэг хэрэглэж болно.
6	Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэргийн эсхүл энгийн)	Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 6 зүйл. Хамгаалалтын алба тусгай албаны төрийн албан хаагчийн 1-9 дүгээр түвшний хамгаалалтын алба хаагчид болон техникийн албаны төрийн албан хаагчдаас бүрдэнэ. Мөн шаардлагатай гэж үзвэл энгийн болон тусгай албадын төрийн албан хаагчид ажиллуулж болно. Хамгаалалтын алба хаагчдын ажил үүргийн хуваарийг Ерөнхийлөгч батална. 5-аас дээш түвшний хамгаалалтын ажилтан болон тусгай албадын төрийн албан хаагчийг Хамгаалалтын албаны даргын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Бусад хамгаалалтын болон тусгай

		албадын албан хаагчийг хамгаалалтын албаны дарга томилно. 1-3 дугаар түвшний хамгаалалтын ажилтан болон тусгай албадын ажилтнуудыг шинээр авах асуудлыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
7	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	<p>Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны даргын удирдлагад дэд дарга, Мөрдөн байцаах ерөнхий алба, PSS сургалтын төв байdag.</p> <p>Дэд даргын удирдлагад Төлөвлөлт, менежментын хэлтэс, Хамгаалалтын хэлтэс, Хамгаалалт, аюулгүй байдлын хэлтэс, Харилцаа холбоо, техник хангамжийн хэлтсүүд ажилладаг.</p> <p><b>Хэлтсүүдийн чиг үүрэг:</b></p> <p><b>Төлөвлөлт, менежментын хэлтэс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний ассамблей, төсөв зэрэг гадагшaa чиглэсэн ажил болон байгууллага, албан хаагчийн удирдлага, зохион байгуулалтын асуудлууд</li> <li>- Ирээдүйн хамгаалалтын эрсдлийн талаар анализ хийх болон бэлтгэх, урьдчилан сэргийлэх асуудал</li> </ul> <p><b>Хамгаалалтын хэлтэс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхийлөгчийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх болон сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой асуудал</li> <li>- Өмнөд Солонгос улсад айлчилж буй гадаадын төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн зэрэг гол хүмүүсийн хамгаалалтын асуудал</li> </ul> <p><b>Хамгаалалт, аюулгүй байдлын хэлтэс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхийлөгчийн ордон болон эргэн тойрны аюулгүйн бүсийн эрсдлийн хамгаалалтыг нэгтгэх удирдах асуудал</li> <li>- Ерөнхийлөгчийн ордон болон түүний дотоод, гадаад талын хамгаалалтыг удирдан зохион байгуулах асуудал</li> <li>- Ордны дотоод, гадаад хамгаалалттай холбоотой мэдээлэл цуглуулах болон аюулгүй байдлыг хангах асуудал</li> <li>- Арга хэмжээний талбарын аюулгүй байдлын эсрэг арга хэмжээ болон өмнөх ерөнхийлөгчийн хамгаалалт асуудал</li> </ul> <p><b>Харилцаа холбоо, техник хангамжийн хэлтэс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зохион байгуулалт, хамгаалалтын тээврийн хэрэгслийн үйлчилгээ зэрэг хамгаалалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх асуудал</li> <li>- Төрийн үйл ажиллагаанд холбооны сүлжээг зүй зохистой ашиглах болон шинжлэх ухаанч хамгаалалтын систем бий болгох, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг хөгжүүлэх асуудал</li> </ul> <p><b>Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны сургалтын төв</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хамгаалалтын аюулгүй байдлын менежментийн талаарх эрдэм шинжилгээний судалгаа хийх</li> <li>- Ажилчдыг сургах болон хамгаалалтын аюулгүй байдлын хүрээнд алба хашиж байгаа төрийн албан хаагчдад зориулсан сургалт</li> </ul>
8	Төрийн өндөр дээд албан тушаалаас буусны дараах хамгаалалтын зохицуулалт	<p>Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 3 дугаар зүйл. Өөрөө хүсэлт гаргаагүй бол Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн өдрөөс хойш 7 жилийн хугацаанд түүний гэр бүл, хүүхдүүдийг хамгаална, гэхдээ ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаанаас өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, албан тушаал хашиж байх хугацаандаа мөн чөлөөлөгдсөний дараа нас барвал хамгаалалтын хугацааг тухайн үйл явдлаас хойш 2 жил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нас барсан тохиолдолд хамгаалалтын хугацааг чөлөөлөгдсөн өдрөөс тооцно.</p>

## БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны бүтэц



### 2.5.БНКаз.У

Уг асуудлыг Төрийн хамгаалалтын албаны тухай хуулиар (О Службе государственной охраны Республики Казахстан) зохицуулж байна. Төрийн хамгаалалтын алба нь Казахстан Улсын Ерөнхийлөгчид шууд харьялагдаж тайлагнах бөгөөд хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд төрийн хамгаалалтад байх хүн болон объектын аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хүчинд хамааралтай төрийн тусгай байгууллага юм.

Төрийн хамгаалалтын албаны бүтэц, орон тоог албаны даргын санал болгосноор Казахстан улсын Ерөнхийлөгч тогтооно. Тус алба нь албан хаагч, цэргийн албан хаагч, энгийн ажилчдаас бүрдэнэ.

Хүснэгт 5.

#### Бүгд Найрамдах Казахстан Улс

- |  |  |
|--|--|
| 1. Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс | <u>Төрийн хамгаалалтын албаны тухай хуулиар</u> (О Службе государственной охраны Республики Казахстан) зохицуулж байна.  |
| 2. Байгууллагын статус                       | Төрийн хамгаалалтын алба нь Казахстан улсын Ерөнхийлөгчид шууд харьялагдаж тайлагнах бөгөөд хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд төрийн хамгаалалтад байх хүн болон объектын аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хүчинд хамааралтай төрийн тусгай байгууллага юм.  |
| 3. Байгууллагын бүрэн эрх                    | Төрийн хамгаалалтын алба нь дараах эрхтэй байна <sup>120</sup> .<br>1. Төрийн хамгаалалтад авсан объектод нэвтрэн орох болон гарахад (тээврийн хэрэгсэлтэй болон тээврийн хэрэгсэлгүй) нарийн шалгах, тухайн хүний биедээ авч яваа эд зүйлийг түүнчлэн, тээврийн хэрэгсэл болон тээврийн хэрэгслээр авчирсан эд зүйлийг техник хэрэгсэл ашиглан нарийн шалгана. Объектод эд зүйл болон бодис |

<sup>120</sup> Төрийн хамгаалалтын албаны тухай хууль (О Службе государственной охраны Республики Казахстан), 9 дүгээр зүйл <http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483>

- авч орохыг хориглох бөгөөд авч орохыг хориглох эд зүйл, бодисын жагсаалтыг Төрийн хамгаалалтын албаны тэргүүн тогтооно. Албан ажлын хэрэгцээнд баримт болон үйл явдлын зураг авах, дуу, дурсний бичлэг хийх, кино зураг авах эрхтэй.
2. Төрийн хамгаалалтад авсан хүний амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, нэр төр, эд хөрөнгөд халдах нөхцөл үүсэхээс хамгаалах төлөвлөгөө, заавар зөвлөмж гаргана. Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
    - Төрийн хамгаалалтад авсан хүн болон объектыг хамгаалах, тэдгээрт үйлчлэх хувь хүн болон хуулийн этгээдийг хянаж шалгана.
    - Терроризмын эсрэг үйл ажиллагаанд оролцох тохиолдолд Терроризмын эсрэг үйл ажиллагааны тухай хуульд заасан арга хэмжээ болон түр хугацааны хоригийг хэрэгжүүлнэ.
    - Хуульд заасны дагуу тодруулах байцаалт (дознания) авч болно.
    - Төрийн хамгаалалтад авсан хүн болон объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор Эрэн сурвалжлах ажиллагааны тухай болон Сөрөг тагнуулын ажиллагааны тухай хуулийн дагуу эрэн сурвалжлах болон сөрөг тагнуулын үйл ажиллагаа явуулна.
  3. Байгууллага, цэргийн анги бие бүрэлдэхүүний албан байр, иргэдийн орон сууц болон бусад төрлийн орон байр, тээврийн хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгсэл болон бусад эд хөрөнгийг харилцан тохирсны дагуу ашиглана.
  4. Албан үүргээ гүйцэтгэхдээ төрийн байгууллага, бусад байгууллага (өмчийн хэлбэр харгалзахгүйгээр), цэргийн анги бие бүрэлдэхүүнээс шаардлагатай мэдээллийг холбогдох журмын дагуу авна.
  5. Төрийн хамгаалалтад авсан хүний зочлох орон байр, байшин барилга, барилга байгууламж, тэдгээрийн ойр орчмын бүсийг, түүнчлэн хамгаалалтад авсан объектын ариун цэвэр-эрүүл ахуйд хяналт тавих, байгаль орчны, цацраг идэвхжилтийн, биологийн, химийн, болон халдварт өвчний нөлөөнөөс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Хамгаалалтад авсан хүний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтад авсан объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах, гүйцэтгэх, түүнчлэн, харуул хамгаалалтын ажилд оролцох бие бүрэлдэхүүн болон хамгаалалтын хэрэгслүүдийг төрийн байгууллагуудтай хэлэлцсэний дагуу тодорхойлно.
  6. Төрийн хамгаалалтын алба өөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
  7. Төрийн хамгаалалтын албаны тусгай бэлтгэлийг хангасан албан хаагчид албаны зэвсэг болон тусгай хамгаалалтын хэрэгслийг хадгалах, биедээ авч явах зөвшөөрөл өгнө.
  8. Хамгаалалтын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдыг бусад улс орон руу томилон ажиллуулна.
  9. Батлан хамгаалах яам, Дотоод хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын албаны харьяа боловсролын болон эрдэм шинжилгээний байгууллагатай, түүнчлэн гадаад орны холбогдох боловсролын байгууллагатай харилцан тохиролцсоны дагуу боловсон хүчиний бэлтгэнэ, мэргэшил дээшлүүлнэ. Төрийн хамгаалалтын алба, Зэвсэгт хүчин, бусад цэрэг болон цэргийн бие бүрэлдэхүүн, хууль сахиулах, төрийн тусгай байгууллагуудын, түүнчлэн олон улсын гэрээнд заасны дагуу гадаад орны тусгай албадын албан хаагч болон цэргийн албан хаагчдыг сургах, бэлтгэх, дахин бэлтгэх ажлыг хэрэгжүүлнэ.
  10. Бүртгэлд буй объектуудыг ашиглах, тэдгээрийн техник засвар үйлчилгээ, ариун цэвэр-эрүүл ахуйг хангах, байгаль орчин болон халдварт өвчний нөлөөнөөс хамгаалах ажлыг зохион байгуулна.

		Төрийн хамгаалалтын албаны байрлаж буй газраас өөр газарт тусгай нэгж байгуулах эрхтэй (эрх бүхий байгууллагын бүртгэлд бүртгүүлэхгүй).
		11. Ажил үүргээ амжилттай гүйцэтгэсэн албан хаагчийг урамшуулна, хуульд заасан журмын дагуу Казахстан улсын төрийн шагналд нэр дэвшүүлнэ.
		12. Казахстан улсын иргэдийг сайн дурын үндсэн дээр тус албаны орон тооны бус ажилтнаар ажиллуулна.
4. Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэс	Төрийн хамгаалалтын албаны албан хаагч болон цэргийн албан хаагчид зэвсэг, хамгаалалтын тусгай хэрэгслийг биедээ авч явах, хадгалах, хэрэглэх болон хүч хэрэглэх эрхтэй. Түүнчлэн тусгай бэлтгэл хангах, хүч хэрэглэх болон хамгаалалтын тусгай хэрэгсэл, зэвсэг шаардлага хангаж буй эсэхийг хуваарийн дагуу шалгаж байх үүрэгтэй байна. Тус албаны албан хаагч, цэргийн албан хаагч нь төрийн хамгаалалтад авсан хүн, объект болон өөрийгөө аюулаас хамгаалах зорилгоор хуульд заасан тохиолдлуудад хүч хэрэглэх, тусгай хамгаалалтын хэрэгсэл, зэвсэг, байлдааны техник хэрэгсэл хэрэглэсний улмаас бусдад учруулсан сэтгэл санааны, материаллаг, биед нь учруулсан хохирлын төлөө хариуцлага хүлээхгүй. Харин бүрэн эрхээ хэтрүүлэн тусгай хамгаалалтын хэрэгсэл, зэвсэг болон хүч хэрэглэвэл хуульд заасны дагуу хариуцлага хүлээн <sup>121</sup> .	
		<b>Зэвсэг хэрэглэх, байлдааны техник хэрэгсэл ашиглах</b> <sup>122</sup> . Энэ нь хамгийн эцсийн арга хэмжээ бөгөөд өөр арга байхгүй тохиолдолд хэрэглэнэ. Дараах нөхцөлд хэрэглэнэ:
		<ul style="list-style-type: none"> <li>– хамгаалалтад авсан хүнд халдах;</li> <li>– хамгаалалтад авсан байр, барилга байгууламж, орон байр, бусад объект, тээврийн хэрэгсэлд халдах;</li> <li>– Төрийн хамгаалалтын албаны албан хаагч болон цэргийн албан хаагч, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, тус албаны хамгаалалтын ажилд татан оролцуулсан бусад хүнд халдах;</li> <li>– иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, барьцаалагдсан хүний суллах, хамгаалалтад авсан объект, барилга байгууламж, тусгай ачаа бараа бусдад эзлэгдсэн тохиолдолд суллах;</li> <li>– гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг хэргийн газар дээр нь баривчлах, зэвсэглэн халдсан тохиолдолд зэвсгээ хураалгах хууль ёсны шаардлагыг хүлээж аваагүй этгээдийг баривчлах зэрэг болно.</li> </ul>
		Түүнээс гадна дараах тохиолдолд хэрэглэж болно.
		<ul style="list-style-type: none"> <li>– тээврийн хэрэгслийн жолооч тус албаны ажилтан, цэргийн албан хаагчийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд өөрөөр зохицуулах боломжгүй бол хамгаалалтад авсан хүний аюулгүй байдлыг хангахын тулд тээврийн хэрэгслийг зогсоохын тулд;</li> <li>– ан амьтны халдлагаас хамгаалах;</li> <li>– аюулын эсхүл, тусlamж хүссэн дохио өгөхийн тулд хэрэглэж болно.</li> </ul>
		Хамгаалалтад байгаа хүн, эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхэд зэвсэглэн халдах, мөн зэвсэглэн эсэргүүцэл үзүүлэх, хүн барьцаалах, агаарын хөлөг барьцаалахаас бусад тохиолдолд тэдний эсрэг зэвсэг

<sup>121</sup> Төрийн хамгаалалтын албаны тухай хууль (О Службе государственной охраны Республики Казахстан), 10 дугаар зүйл, [http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483_)

<sup>122</sup> Төрийн хамгаалалтын албаны тухай хууль (О Службе государственной охраны Республики Казахстан), 13 дугаар зүйл, [http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483_)

		хэрэглэхийг хориглоно. Зэвсэг хэрэглэх нь бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар бол хэрэглэхийг мөн хориглоно.
		Төрийн хамгаалалтын албаны албан хаагч болон цэргийн албан хаагч нь зэвсэг хэрэглэсэн ямар ч тохиолдолд эргэн тойрон дахь иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмтэл авсан тохиолдолд даруй эмнэлгийн тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах үүрэгтэй.
		Биеийн хүч, тусгай хамгаалалтын хэрэгсэл, зэвсэг, байлдааны техник хэрэгсэл хэрэглэсний улмаас хүний амь нас эрсдэх болон хүнд үр дагавар үүссэн аливаа тохиолдлын талаар 24 цагийн дотор прокурорт мэдэгдэнэ.
		Төрийн хамгаалалтын албаны хэрэглэх зэвсэг, байлдааны техник хэрэгслийн жагсаалтыг Засгийн газар тогтооно.
5. Төрийн албаны аngилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэргийн, энгийн)		Төрийн хамгаалалтын алба нь албан хаагч, цэргийн албан хаагч, энгийн ажилчдаас бүрдэнэ <sup>123</sup> .
6. Байгууллагын бүтэц, зохин байгуулалт, орон тоо		Төрийн хамгаалалтын албаны бүтэц, орон тоог албаны даргын санал болгосноор Казахстан улсын Ерөнхийлөгч тогтооно <sup>124</sup> .
7. Төрийн өндөр дээд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хамгаалалтын зохицуулалт, хугацаа		Казахстан улсын анхны Ерөнхийлөгч нь насан туршдаа төрийн хамгаалалтад байна <sup>125</sup> . Ерөнхийлөгч асан хүний хангамж, үйлчилгээ болон хамгаалалттай холбоотой зардлыг төр хариуцна. Насан туршдаа хувийн хамгаалалттай байна <sup>126</sup> .

## 2.6.БНТУ

Төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг Цагдаагийн Ерөнхий газар хариуцдаг бөгөөд тус газар нь Туркийн дотоод хэргийн яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг. Дотоод хэргийн дөрвөн дэд сайдын нэг нь ЦЕГ-ын үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

ЦЕГ-ын харьяанд төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулахдаа төрийн өндөр албан тушаалтнуудыг хамгаалах нэгжийг тус тусад нь байгуулах замаар хамгаалалтыг хэрэгжүүлэхээс гадна цагдаагийн сөрөг тусгай ажиллагааны нэгжийг тусад нь байгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл төрийн тусгай хамгаалалтын нэгж нь дараах бүтэцтэй. Үүнд:

- Ерөнхийлөгчийн хамгаалалтын газар;
- Ерөнхий сайдын хамгаалалтын газар;
- Үндэсний Их Хурлын хамгаалалтын газар;
- Цагдаагийн сөрөг тусгай хамгаалалтын газар /Police counter attack team/ гм.

Түүнчлэн төрийн ёслолын үйл ажиллагаанд оролцох болон төрийн ордонд, бусад байгууламжийг хамгаалах үүрэгтэй Ерөнхийлөгчийн хамгаалалтын хороо /Presidential guard regiment-2500 албан хаагчидтай/ байдаг. Гэвч 2016 онд гарсан төрийн

<sup>123</sup> Төрийн хамгаалалтын албаны тухай хууль (О Службе государственной охраны Республики Казахстан), 14 дүгээр зүйл, [http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483_)

<sup>124</sup> <https://www.sgork.gov.kz/ru/state-security-service/structure/>

<sup>125</sup> Казахстан Улсын Анхны ерөнхийлөгч-елбасы тухай хууль (О Первом Президенте Республики Казахстан - Елбасы), [http://adilet.zan.kz/kaz/docs/z000000083\\_#z6](http://adilet.zan.kz/kaz/docs/z000000083_#z6)

<sup>126</sup> Ерөнхийлөгчийн тухай хууль, 35 дугаар зүйл, [http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002733\\_#z38](http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002733_#z38)

эргэлтэд тус хамгаалалтын хорооны ажилтнууд оролцсон /албан бус мэдээгээр 300 гаруй албан хаагчийг баривчилсан/ тул татан буулгаж чиг үүргийг нь Дотоодын цэргийн Ерөнхий командлалын газарт /General command of Gendarmerie/ шилжүүлсэн.

## 2.7.АНУ

АНУ-ын төрийн тусгай хамгаалалтын албыг багтаасан Нууц алба (US Secret Service)-тай холбогдон гарах харилцааг Нэгдсэн Улсын Код 18-р зүйл, 203-р бүлэг, 3056-р хэсэг, Нэгдсэн Улсын Код 18-р зүйл, I хэсэг, 44-р бүлгийн 926B хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Нууц алба Дотоод аюулгүй байдлын департаментад харьяалагдах ба төрийн хамгаалалт болон мөрдөх гэсэн үндсэн 2 чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна.

Хүснэгт 6.

### Америкийн Нэгдсэн Улс

- |  |   |
|--|---|
| 1. Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс | Нэгдсэн Улсын Код 18-р зүйл, 203-р бүлэг, 3056-р хэсгээр (US Code Title 18, Part II, Chapter 203, Section 3056) <sup>127</sup> АНУ-ын Нууц албаны эрх, үүргийн талаар зохицуулна. |
| 2. Байгууллагын статус                       | Нууц алба нь 2003 оноос Дотоод аюулгүй байдлын департамент (Department of Homeland Security)-д харьяалагдаж эхэлсэн. <sup>128</sup>   |
| 3. Байгууллагын бүрэн эрх                    | Конгрессоос баталсны дагуу <i>төрийн тусгай хамгаалалт</i> болон мөрдөх, тагнах 2 чиг үүрэгтэйгээр ажилладаг.   |

#### Төрийн тусгай хамгаалалтын чиг үүрэг

А. Нууц алба нь дор дурдсан хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүрэгтэй:

1. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч;
2. Тэдгээрийн гэр бүлийн гишүүд;
3. Ерөнхийлөгч асан болон тэдгээрийн эхнэр/нөхөр-ийг насан туршид нь;
4. Өмнөх Ерөнхийлөгчдийн 16 нас хүрээгүй хүүхдүүд;
5. Гадаадын улс орнуудаас айлчилж буй төрийн болон засгийн газрын тэргүүнүүд;
6. АНУ-д айлчилж буй гадаад улс орны эрхэм дээд зочид болон Ерөнхийлөгч үүрэг болгосон тохиолдолд гадаад улс оронд тусгай үүрэг, даалгавар гүйцэтгэж буй албаны төлөөлөгчид зэрэг болно.

С. Дотоод аюулгүй байдлын департаментын Нарийн бичгийн даргаас олгосон эрхийн дагуу Нууц албаны ажилтнууд болон тусгай албан хаагчид нь:

1. АНУ-ын хууль хууль тогтоомжид заасан эрх, үүргийг биелүүлэх;
2. Галт зэвсэг хэрэглэх;
3. АНУ-ын эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа нь нотлогдсон этгээдийг болон гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж гэмт этгээдийг шууд баривчлах, бусад хуульд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

Е. Ерөнхийлөгчөөс өгсөн үүргийн дагуу, Дотоод аюулгүй байдлын департаментын Нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр Нууц алба нь үндэсний хэмжээний онцгой үйл явдлуудад аюулгүй байдлын үйл ажиллагааг төлөвлөх, бусад байгууллагуудтай хамтрах, гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

- |  |  |
|--|--|
| 4. Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалт | Нууц албаны удирдлага нь Захирал, Дэд захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирлаас бүрдэнэ.<br>Нууц албаны захирлыг Ерөнхийлөгч томилно. Захирал нь Дотоод аюулгүй байдлын департаментын шууд харьяанд ажиллаж Нарийн бичгийн даргад нь үйл ажиллагаагаа шууд тайлагнана. |
|--|--|

<sup>127</sup> <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>

<sup>128</sup> [https://www.dhs.gov/sites/default/files/publications/19\\_1205\\_dhs-organizational-chart.pdf](https://www.dhs.gov/sites/default/files/publications/19_1205_dhs-organizational-chart.pdf)

5.	Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Нэгдсэн Улсын Код 18-р зүйл, 203-р бүлэг, 3056-р хэсэг.           <ul style="list-style-type: none"> <li>Дотоодын аюулгүй байдлын департаментын Нарийн бичгийн даргаас олгосон эрхийн дагуу Нууц албаны ажилтнууд, тусгай албан хаагчид (agent) нь дараах эрхтэй:               <ul style="list-style-type: none"> <li>Галт зэвсэг хэрэглэх.</li> <li>Нэгдсэн Улсын Код 18-р зүйл, I хэсэг, 44-р бүлгийн 926B хэсэг. Хууль сахиулах албаны мэргэшсэн албан хаагчдын нууц галт зэвсэг эзэмших тухай:</li> <li>Агентлагаас зөвшөөрсний дагуу галт зэвсэг хэрэглэх эрхтэй.</li> <li>Хууль сахиулагч ажилтнуудын аюулгүй байдлын тухай хууль (Law Enforcement Officers Safety Act) болон холбогдох бусад хууль тогтоомжуудад заасны дагуу галт зэвсэг хэрэглэх эрхтэй байна.</li> </ul> </li> </ul> </li> </ul>
6.	Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэрэг, эсхүл цэрэг)	Холбооны албан хаагчдын Хууль сахиулах ажилтнуудын ангилал нь GL-3-aas GL-10 хүртэл зэрэгтэй байна. Нууц албаны ажилтнууд нь GL-7 болон түүнээс дээш ангилалд багтаж, <sup>129</sup> энэ ангиллаар цалинжина. <sup>130</sup>
7.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	<p>Нууц алба нь төв салбар, АНУ даяар болон хилийн чанадад нийт 150 салбартай.</p> <p>Нууц алба нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна:<sup>131</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн ерөнхий алба</li> <li>Мэдээллийн ерөнхий алба</li> <li>Хүний нөөцийн алба</li> <li>Стратеги төлөвлөгөө, бодлогын алба</li> <li>Төр, олон нийттэй харилцах алба</li> <li>Мөрдөх алба</li> <li>Мэргэжлийн хариуцлагын алба (Office of professional responsibility)</li> <li>Хамгаалалтын үйл ажиллагааны алба</li> <li>Стратегийн тагнуул ба мэдээллийн алба</li> <li>Техникийн хөгжил болон даалгавар гүйцэтгэхэд туслалцаа үзүүлэх алба</li> <li>Сургалтын алба</li> </ul> <p>Нууц алба нь Төрийн тусгай хамгаалалтын чиг үүргээ дараах салбаруудаараа хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>Агаарын орон зайн аюулгүй байдлын салбар</li> <li>Мэргэн буучдын баг</li> <li>Яаралтай арга хэмжээ авах баг</li> <li>Тагнуулын хэсэг</li> <li>Сөрөг довтолгооны баг</li> <li>Аюулыг бууруулах, эмнэлгийн яаралтай тусламжийн баг болон бусад мэргэшсэн багууд орно.</li> </ul> <p>Нууц алба нь 3200 тусгай ажилтан (Special agent), 1300 цэргийн албан хаагчид болон 2000 гаруй захиргааны, бусад мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлэх ажилтнуудаас бурдэнэ.</p>
8.	Төрийн өндөр дээд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хамгаалалтын зохицуулалт	Ерөнхийлөгч асан болон тэдгээрийн эхнэр/нөхрүүдийг насан туршид нь хамгаална. Хэрэв гэрлэлтээ цуцуулсан тохиолдолд эхнэр/нөхрүүдийн хамгаалалтыг зогсоно.

<sup>129</sup> <https://www.federallawenforcement.org/secret-service/>

<sup>130</sup> <https://www.federallawenforcement.org/salary/>

<sup>131</sup> <https://www.secretservice.gov/data/about/OrgChart.pdf>

## 2.8.ХБНГУ

Хүснэгт 7.

### Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

1. Төрийн тусгай хамгаалалтын эрх зүйн үндэс	<p>ХБНГУ-д төрийн хамгаалалтын чиг үүргийг Үндсэн хуулийг хамгаалах Холбооны Улс (ХҮ)-ын алба болон Муж Улсын яам (дотоод аюулгүй байдлын хүрээнд), Цэргийн сөрөх тагнуулын газар (БХЯ-ны харьяа), ХҮ-ын Радио өргөн нэвтрүүлгийн алба (гадаад аюулгүй байдлын хүрээнд) болон Эрүүгийн цагдаагийн орон нутгийн цагдаагийн хэлтэс, нэн ялангуяа улс төрийн сэдэлтэй эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий Цагдаагийн төрийн хамгаалалт гэсэн <u>байгууллагууд</u> хэрэгжүүлдэг.</p> <p>Эрүүгийн цагдаагийн төрийн хамгаалах асуудлыг хариуцсан хэлтсийн болон Прокурорын <u>чиг үүрэг</u>:</p> <ul style="list-style-type: none"><li>Гэмт хэргийг мөрдөн байцаан шийтгэх (гэмт хэрэгтэй репрессив тэмцэх)<ul style="list-style-type: none"><li>Улс төрийн гэмт хэргийн хүрээнд (“төрийн хамгаалалтын жинхэнэ гэмт хэрэг” гэж нэрлэдэг) жишээлбэл: Энхтайвнаас урвах, Эх орноос урвах, Ардчилсан эрх зүйт төрд заналхийлэх</li><li>Улс төрийн сэдэлтэй гэмт хэргийн хүрээнд (“төрийн хамгаалалтын жинхэнэ бус гэмт хэрэг” хэмээдэг) Зандалчлал, Хэт туйлшрал; жишээлбэл: арьс өнгө буюу улс төрийн сэдлээр биед гэм хор учруулах</li><li>Улс төрчийн эсрэг гутгэлэг, доромжлолтой холбоотой төрийн хамгаалалтын зарим тохиолдол</li></ul></li><li>Зандалчлал, хэт туйлшрал, улс төрийн сэдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (гэмт хэрэгтэй превентив тэмцэх)</li></ul> <p><u>Эрх зүйн үндэс</u></p> <p>Төрийн хамгаалалтын зохицуулалтад хамаарах хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"><li>Холбооны Улсын Үндсэн хуулийг хамгаалах тухай хууль (TX)</li><li>Цэргийн сөрөх тагнуулын TX</li><li>ХҮ-ын Радио өргөн нэвтрүүлгийн TX</li><li>Олон улсын терроризмтэй тэмцэх TX</li><li>Аюулгүй байдлыг шалгах TX</li><li>Хянан шалгах (парламентын) дээд зөвлөлийн TX</li><li>ХҮ-ын Эрүүгийн газрын TX</li></ul> <p>ХҮЭГ-ын тухай хууль нь Үндсэн хуулийн 73-р зүйлийн 10 дахь хэсэг, 87-р зүйлд тус тус үндэслэсэн байdag.</p>
2. Байгууллагын статус	<p>Байгууллагын нэр: ВКА-Холбооны Улсын Эрүүгийн газар (ХҮЭГ) Төрийн түвшин: Холбооны Улс Байрлал: Холбооны Улсын төрийн эрх барих дээд байгууллага Эрүүгийн мөрдөн шалгах дээд байгууллага Харьяалагдах дээд байгууллага: Холбооны Улсын Дотоод хэргийн Яам Үндсэн орших газар: Вийсададэн хот, Хессен Улс Албан хаагчид: ойролцоогоор 6 400 (2018) Төсөв: 729.18 сая евро (2019) Герман Улсын цагдаагийн 3 алба (ХҮ-ын Цагдаа, Бундестагийн дэргэдэх Цагдаа, ХҮ-ын Эрүүгийн газар)-ны нэг болох Эрүүгийн газрын бүтцийн нэгэн хэлтэс. Хэлтсийн нэр: Аюулгүй байдлын бүлэг (АББ).</p>
3. Байгууллагын бүрэн эрх	<p>Германы эрүүгийн цагдаагийн төв байгууллагын хувьд ХҮЭГ-ын үндсэн чиг үүрэг нь муж улсуудын эрүүгийн газартай нягт хамтран ажиллаж, үндэсний хэмжээнд эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг зохицуулахад оршдог. Энэ хүрээнд ХҮЭГ нь төвлөрсөн танин тодорхойлох албаны болон эрүүгийн техникийн тоног төхөөрөмж, сан хөмрөг (цуглуулга)-тэй байdag. ХҮЭГ нь эрүүгийн гэмт хэргийн талбарын шинжтэй ихэнх тодорхой хэрэг дээр өөрөө бие даан мөрдлөг явуулах бүрэн эрхтэй байdag.</p>

		<p>Хэрэв ХҮ-ын Ерөнхий Прокурорын газар даалгасан, Муж улсын төрийн байгууллага хүсэлт гаргасан, эсхүл ХҮ-ын Дотоод хэргийн яамнаас тушаасан бол ХҮЭГ нь түүнчлэн мөрдлөг явуулах боломжтой байдаг.</p> <p>Түүнээс гадна ХҮЭГ нь Үндсэн хуулийн байгууллагуудын гишүүдийг болон гэрчийг ХҮ-ын хэмжээнд хамгаалдаг.</p> <p>ХҮЭГ нь Үндэсний төв товчооны хувиар ХБНГУ-ыг Интерполд төлөөлдөг.</p>
4.	Удирдлагын эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалт	<p>ХҮЭГ-ын удирдлага нь Ерөнхийлөгч, З Дэд ерөнхийлөгч (2020 он хүртэл хоёр байсан) бүрдэнэ.</p> <p>Ерөнхийлөгч нь төрийн улс төрийн албан хаагч бөгөөд түүнийг ХҮ-ын Дотоод хэргийн сайдын санал болгосноор ХҮ-ын Ерөнхийлөгч бүх насаар нь томилдог. ХҮ-ын Дотоод хэргийн сайд ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх эрхтэй.</p>
5.	Галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт	<p>Германы цагдаа дахь галт зэвсгийг ихэвчлэн “дам бус албадлага”-ын зорилгоор ашигладаг. Дам бус албадлагын бүрэн эрхийг зөвхөн Германы ХҮ-ын цагдаагийн эрх зүй болон 16 муж улсын цагдаагийн хуулиар зохицуулсан байдаг. Дээрх бүрэн эрхийг амьдралд хэрэгжүүлэх нөхцөл байдлын хүрээ нь бараг бүгд ялгаатай. Гэхдээ хэрэгжүүлж буй арга хэмжээний зорилгоос хамаарна (аюулаас хамгаалах, эсвэл мөрдөн байцаах, эсвэл ял шийтгэх). Зорилго, заналхийллийн нөхцөл байдлаас (жишээлбэл: Аргагүй хамгаалалт) шалтгаалан ондоо бүрэн эрх хэрэгждэг.</p> <p>Германы цагдаад галт зэвсгийг хэрэглэхдээ заавал үнэлэх буюу сануулсаны дараа гэсэн үндсэн зарчмыг баримталдаг.</p>
6.	Төрийн албаны ангилал, зэрэглэл, албан хаагчийн эрх зүйн байдал (энгийн цэрэг, эсхүл цэрэг)	<p>ХҮЭГ-ын ерөнхийлөгч төрийн албан хаагчдын цалингийн сүлжээний В9, харин дэд ерөнхийлөгч В6 шатлалаар цалинжна. Цалингийн сүлжээ нь В1-B11 гэсэн 11 шатлалтай. (дашрамд дурдахад, В6-д бригадын генерал, В11-д дэслэгч генерал ордог байна)</p> <p>Төрийн албан хаагчид цалингийн сүлжээний А ангилалд багтана. А ангилал нь A1-A16 гэсэн 16 шатлалтай. Жишээлбэл, A9-A11 шатлалд эрүүгийн комиссар, цагдаагийн комиссар, дэслэгч; A12-д эрүүгийн ахлах комиссар, цагдаагийн ахлах комиссар, ахлах дэслэгч; A13-д эрүүгийн 1-р ахлах комиссар, цагдаагийн 1-р ахлах комиссар, ахмад; A14-д хошууч багтдаг байна.</p>
7.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо	<p>Аюулгүй байдлын бүлэг нь анх 1951 онд Бонн хотод байгуулагдсан. Эхэндээ бие хамгаалах чиг үүргийг 28 цагдаагийн албан хаагч гүйцэтгэдэг байсан. Тус хэлтэс нь 1999 онд Берлинд нүүж ирсэн.</p> <p>АББ-ийн албан хаагчдыг ХҮЭГ-аас ХҮ-ын Цагдаа болон Муж улсуудын Эрүүгийн цагдаагас шалгаруулан сонгож, бие хамгаалах чиглэлд нарийн мэргэшүүлэн сургаж авдаг.</p> <p>АББ нь 2 тасагтай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шуурхай ажиллагаа <ul style="list-style-type: none"> <li>◦ Бие хамгаалах баг (ХҮ-ын Ерөнхийлөгч, Канцлер, ХҮ-ын сайдууд г.м.)</li> <li>◦ Гадаадын төрийн зочид</li> <li>◦ Шуурхай дэмжлэг, мөрдлөг (гүйцэтгэх ажиллагаа)</li> <li>◦ Гадаад дахь болон тусгай үүргийн ажиллагаа зэрэг мэргэжлийн бие хамгаалах хүчин</li> </ul> </li> <li>• Удирдлагын болон байрлалын төв <ul style="list-style-type: none"> <li>◦ Байрлалын төв</li> <li>◦ Логистик (тээвэр), Мэдээллийн технологийн дэмжлэг</li> <li>◦ Бие хамгаалах сургууль болон мэргэжил дээшлүүлэх</li> </ul> </li> </ul> <p>АББ нь хэсэг хугацаанд төрийн албан хаагчдын гэмт хэрэг болон эх орноос урвалтын мөрдөн шалгах бүхий л ажиллагааг явуулдаг байсан. Түүнээс гадна зандалчлалыг мөн мөрддөг байв. Тэр үед АББ нь бие хамгаалалт ба мөрдлөгийн гэсэн 2 албад хуваагддаг байсан. Харин одоо штабын шугаман систем хэлбэрээр зохион байгуулагдсан. Бие хамгаалалтыг шуурхай ажиллагааны тасаг</p>

---

гүйцэтгэдэг бол зохион байгуулалтын туслах албыг удирдлага, байрлалын төвд байх штаб гүйцэтгэдэг.  
Объектын хамгаалалт буюу байшин барилгын гадаад аюулгүй байдлын хувьд АББ нь ХУ-ын Цагдаа, Германы Бундестагийн дэргэдэх Цагдаа болон Муж улсуудын цагдаагийн байгууллагатай хамтарч ажилладаг.

---

8. Төрийн өндөр  
дээд албан  
тушаалаас  
чөлөөлөгдсөний  
дараах  
хамгаалалтын  
зохицуулалт,  
хугацаа

ХУ-ын Ерөнхийлөгч, Канцлер нь албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа насан туршид ажлын байр, ажиллах хүчний хамт, хувийн хамгаалалт, мөн жолоочтой албан үүргийн автомашинаар хангагддаг.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Бүлэг. Нэг

- Федеральный закон РФ от 27 мая 1996 г. № 57 – ФЗ “О Государственной охране”, Гл. 1, ст.ст. 1-3.
- “People’s Liberation Army Order of Battle,” [www.china-defense.com/orbat/pla\\_orbat/pla\\_orbat\\_03.html](http://www.china-defense.com/orbat/pla_orbat/pla_orbat_03.html).
- Shawn Resse, “The U.S. Secret Service: An Examination and Analysis of Its Evolving Missions,” Congressional Research Service. April 18, 2012.
- “Europejski instytut bezpieczenstwa,” <https://mil.link/institut/formacie-i-sluzby/biuro-ochrony-rzadu/>.
- “Groupe de securite de la presidence de la Republique (GSPR),” Global Security. <https://www.globalsecurity.org/intell/world/fra/gspr.htm>.
- “The Special Protection Group Act,” The Gazette of India, 1988. [www.spg.nic.in/spgact.html](http://www.spg.nic.in/spgact.html).
- “Third Knesset,” The Knesset. The State of Isreal, 2003. December 27, 2004.
- “Presidential Security Service (PSS),” Global Security. <https://www.globalsecurity.org/intell/world/rok/pss.htm>.
- “Офіційний сайт Управління державної охорони України,” [www.do.gov.ua/udo/control/uj/publish/article?art\\_id=3784&cat\\_id=3738](http://www.do.gov.ua/udo/control/uj/publish/article?art_id=3784&cat_id=3738).
- “A History of the Australian Federal Police (incorporating the Australian protective Service).” May 9, 2016.
- “Swedish Security Service 2015,” Yearbook, p. 9.
- “Nacionalne brunotie speki,” [www.mil.lv/Vienibas/Militara\\_policija/Par\\_mums/Vesture.aspx](http://www.mil.lv/Vienibas/Militara_policija/Par_mums/Vesture.aspx).
- “Parliament Confirms Changes in SSPS,” Civil Georgia. January 18, 2013.
- “Guard Command,” North Korea Leadership Watch. February 14, 2017.

### Бүлэг. Хоёр

#### ОХУ

- ФЗ от 27.05.1996 N 57-ФЗ "О государственной охране" <<http://www.consultant.ru/>> хандсан 2020.04.03
- ФЗ от 12.02.2001 N 12-ФЗ "О гарантиях Президенту Российской Федерации, прекратившему исполнение своих полномочий, и членам его семьи".  
<http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&firstDoc=1&lastDoc=1&nd=102063833> хандсан 2020.04.03
- ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба (ХХА)-ны цахим хуудас  
<http://www.fso.gov.ru/struktura/p8.html> хандсан 2020.04.03

#### БНХАУ

- The State Council, The People's Republic Of China,
- [http://english.www.gov.cn/archive/lawsregulations/page\\_4.html](http://english.www.gov.cn/archive/lawsregulations/page_4.html) хандсан 2020.04.06

#### Япон

- Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1954 он (2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр шинэчлэн найруулсан.) (警察法) <<https://elaws.e-gov.go.jp/>> хандсан 2020.04.03
- Цагдаагийн үүргийг гүйцэтгэх тухай хууль, 1948 он. (警察官職務執行) <<https://elaws.e-gov.go.jp/>> хандсан 2020.04.03

- Чухал объектын ойр орчимд алсын зайн удирдлагатай хөдөлгөөнт төхөөрөмж (дрон гм.) нисгэхийг хориглох тухай хууль, 2016 он (重要施設の周辺地域の上空における小型無人機等の飛行の禁止に関する法) <<https://elaws.e-gov.go.jp/>> хандсан 2020.04.03
- ОНАБҮК-ийн 1975 оны 3 дугаар тогтоол. Хамгаалалтын журам (警護要則) <<https://elaws.e-gov.go.jp/>> хандсан 2020.04.03
- ОНАБҮК-ийн 2002 оны 16 дугаар тогтоол. Цагдаагийн алба хаагчдын тусгай галт зэвсэг ашиглах, эзэмших журам (警察官等特殊銃使用及び取扱い規範) <<https://elaws.e-gov.go.jp/>> хандсан 2020.04.03
- Японы Цагдаагийн байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайлан, Японы Үндэсний Цагдаагийн Агентлагийн цахим хуудас. <<https://www.npa.go.jp>> хандсан 2020.04.03

#### БНСУ

- Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны цахим хуудас (Англи хэл дээр) <<http://www.pss.go.kr/site/main/index002>>
- Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны албан ёсны цахим хуудас (Солонгос хэл дээр) <<http://www.pss.go.kr/site/main/index001>>
- Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хууль (Солонгосын хууль тогтоомжийн цахим хуудас, Солонгос хэл дээр) <<http://law.go.kr/lstInfoP.do?lslSeq=67018#0000->>

#### БНКаз.У

- Төрийн хамгаалалтын албаны тухай хууль (О Службе государственной охраны Республики Казахстан), <<http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002483>>
- Төрийн хамгаалалтын албаны цахим хуудас, <<https://www.sgork.gov.kz/ru/state-security-service/structure/>>
- Казахстан Улсын Ахнхы ерөнхийлөгч-елбасы тухай хууль (О Первом Президенте Республики Казахстан - Елбасы), <[http://adilet.zan.kz/kaz/docs/z000000083\\_z6](http://adilet.zan.kz/kaz/docs/z000000083_z6)>
- Ерөнхийлөгчийн тухай хууль, <[http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002733\\_z38](http://adilet.zan.kz/kaz/docs/Z950002733_z38)>

#### АНУ

- Legal Information Institute, Cornell Law School
- <<https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>> хандсан 2020.04.05
- U.S. Department of Homeland Security,
- <[https://www.dhs.gov/sites/default/files/publications/19\\_1205\\_dhs-organizational-chart.pdf](https://www.dhs.gov/sites/default/files/publications/19_1205_dhs-organizational-chart.pdf)> хандсан 2020.04.05
- <<https://www.federallawenforcement.org/salary/>> хандсан 2020.04.05
- U.S. Secret Service, <<https://www.secretservice.gov/data/about/OrgChart.pdf>> хандсан 2020.04.05

#### ХБНГУ

- Төрийн хамгаалалт-Staatsschutz-германаар <https://de.wikipedia.org/wiki/Staatsschutz>
- Холбооны Улсын Эрүүгийн газар-Bundeskriminalamt-германаар [https://de.wikipedia.org/wiki/Bundeskriminalamt\\_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Bundeskriminalamt_(Deutschland))
- Холбооны Улсын Эрүүгийн газар-BKA-Bundeskriminalamt-германаар [https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/Fachabteilungen/PolizeilicherStaatschutz/polizeilicherstaatsschutz\\_node.html](https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/Fachabteilungen/PolizeilicherStaatschutz/polizeilicherstaatsschutz_node.html)
- Албан хаагчдын цалингийн сүлжээний тухай хууль-Bundesbesoldungsgesetz-германаар <https://de.wikipedia.org/wiki/Bundesbesoldungsgesetz>

**ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БҮЙ  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Алтан-Оч (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D),  
О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл,  
Р.Оргилмаа, О.Нарантуяа, Б.Туул*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ**

- ИХ БРИТАНИ
- АВСТРАЛИ
- БНСУ
- СОЛОМОНЫ АРЛУУД
- ХБНГУ
- ШИНЭ ЗЕЛАНД

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## УДИРТГАЛ

Энэхүү судалгаанд Их Британи, Австрали, Өмнөд Солонгос, Соломоны Арлууд, Герман, Шинэ Зеланд зэрэг улсуудын хууль тогтоох дээд байгууллага болох парламентын зүгээс иргэдэд парламентын боловсролыг олгож буй арга хэлбэр, туршлагын талаар судалсан болно. Судалгаанд дээрх улс орнуудыг сонгож авахдаа парламентын боловсролын агуулгыг олон янз хэлбэрээр хүргэж байгаа байдал, парламентын боловсролын агуулга сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдал, сайн туршлага гэж хүлээн зөвхөөрөгдсөн байдал зэргийг шалгур болгон сонгосон болно.

## СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Сүүлийн жилүүдэд парламентын ажлын албадын зүгээс хууль тогтоох дээд байгууллагад дотоод хэрэглэгч буюу гишүүд, парламентад чиглэсэн үйлчилгээнээс гадна гадагшаа иргэдэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ буюу парламентын үйл ажиллагааг таниулан, сурталчлах, парламентын боловсрол олгох нь өсөн нэмэгдэж байна. Үүнийг судалгаанд хамрагдсан улс орнууд парламентын боловсрол олгох асуудлыг хариуцсан Парламентын ажлын албаны бүтцийн нэгж, эсхүл бие даасан нэгж ажиллуулах хэлбэрээр зохион байгуулсан байна.

Улс орнуудын туршлагаас үзэхэд иргэд, олон нийт рүү чиглэсэн сургалтын хөтөлбөр, арга хэмжээг өөр өөрийн онцлог, нөхцөл байдал, хөгжлийн түвшинд (техникийн дэвшлийг ашиглан гм.) нийцүүлсэн тогтмол, өргөн хүрээг хамруулахыг зорьдог байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан улс орнуудад парламентын боловсролыг сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрөөс нь эхлэн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн оюутнуудад, мөн насанд хүрэгчдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Дээрх орнуудын хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааны онцлогийг дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

**Их Британийн**<sup>132</sup> Нийтийн танхимын хувьд Стратеги төлөвлөгөөнд үндэслэн гардаг жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө парламентын боловсролын асуудлыг тусгадаг байна. Нийтийн танхимын ажлын албаны бүтцийн нэгж болох **Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба** (The Education and Engagement Service) нь бүх нийтэд парламентын боловсрол олгох, парламентын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Парламентын боловсрол олгох хөтөлбөрийг сургуулийн өмнөх наснаас эхлэн насанд хүрэгч, залуучууд, иргэний нийгмийн байгууллагаар төрөлжүүлэн Парламентын боловсролын төв, парламентын ажлын албаны цахим хуудас, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, орон нутаг дахь парламентын сургалт мэдээллийн төвүүд болон хэвлэл, мэдээллийн хэрэгслийдээр дамжуулан олгодог. Ерөнхий боловсролын сургуульд Иргэний боловсрол (Citizenship education) хичээлээр дамжуулан сурагчдад парламентын боловсролыг олгодог байна.

Сургалтын агуулгын хувьд:

- Британийн үнэт зүйлс;
- Парламент болон Засгийн газрын үйл ажиллагаа;

<sup>132</sup> <https://erskinemay.parliament.uk/section/6391/participation/> Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба

<https://www.parliament.uk/educationcentre> Парламентын боловсрол олгох төв

<https://www.byc.org.uk/ukyouthparliament> Британийн “Өсвөрийн парламент”

<https://www.gov.uk/government/publications/national-curriculum-in-england-citizenship-programmes-of-study>

Иргэний боловсрол хичээлийн товч танилцуулга

- хууль батлах үйл явц;
- ялгаатай байдал зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгуулдаг.

Эдгээр сэдвүүдийн хүрээнд мэдээллийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр олон нийтэд хүргэдэг.

Тус улс **Парламентын боловсролын төвтэй** бөгөөд тус төв нь парламентын ордны дэргэд байрладаг. Их Британийн төрийн тулгуур болох Нийтийн танхим, Лордууд, Эзэн хаан болон Парламент гэсэн сэдвээр 4 танхымыг тохижуулж, орчин үеийн техникийн дэвшлийг ашиглан бодитоор мэдрүүлэх (виртуал) боломжтой бүтээсэн байна. Тус төв нь бүтэн жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд виртуал танилцуулгыг цахим хуудаснаас үзэх боломжтой.

Парламентын боловсрол, иргэдийн оролцооны албанаас “Парламентын нэрэмжит 7 хоног” (UK Parliament week), “Таны парламент” шагнал, 11-18 настны гишүүдээс бүрдсэн “Өсвөрийн парламент”-ыг ажиллуулдаг.

### Зураг 1. Их Британийн парламентын цахим хуудас

The screenshot shows the official website of the UK Parliament ([www.parliament.uk](http://www.parliament.uk)). The top navigation bar includes links for Accessibility, Cookies, Email alerts, RSS feeds, and Contact us, along with a search bar. Below the header, there's a main menu with Home, Parliamentary business, MPs, Lords & offices, About Parliament, Get involved, Visit, Learning, and Shop. A secondary navigation bar features links for Contact an MP or Lord, Request a workshop, Join a learning programme, Research impact at the UK Parliament, Have your say: Laws and debates, Watch Parliament work, Vote in general elections and referendums, and Y Gornel Gymraeg. The page title is "Join a learning programme". On the left, a sidebar lists options like UK Parliament Week, Peers in schools, Parliamentary Studies module, Youth Select Committee, EqualiTees, and Your UK Parliament Awards 2020. The main content area features a large image of a person in academic regalia sitting at a desk with books, with the text "Learn or teach about Parliament and parliamentary processes for schools, universities and trainers". Below this, sections describe UK Parliament Week, Peers in schools, Parliamentary Studies module, and Youth Select Committee. To the right, a sidebar encourages users to "Sign up to our UK Parliament education newsletter" and provides a link to "Parliament's Education Service" with a photo of people in a meeting.

**Австралийн**<sup>133</sup> хувьд Сенатын танхимын Клеркийн газарт **Парламентын боловсролын газар** байдаг бөгөөд парламентын ардчиллын талаар боловсрол олгох чиг үүрэгтэй. Тус газраас парламентын ордны хөтөлбөр, хөтөлбөрт бэлтгэх, видео хурал хийх, мэргэжлийн

<sup>133</sup> Австралийн парламентын боловсролын газар  
[https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Parliamentary\\_Education\\_Office](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Education_Office)

сургалт зохион байгуулах хэлбэрээр 4 наснаас эхлэн парламентын боловсрол олгох ажлыг зохион байгуулдаг.

### Зураг 2. Австралийн Парламентын боловсролын газрын цахим хуудас

 PARLIAMENTARY  
EDUCATION  
OFFICE

I am looking for...

HOME UNDERSTAND TEACH BOOK CONNECT

How Parliament works System of government The Australian Constitution Three levels of government Parliament at work Bills and laws

HOME / UNDERSTAND / HOW PARLIAMENT WORKS / THREE LEVELS OF GOVERNMENT

## Three levels of government

The three levels of government is a key feature of the Australian system of government. Discover the roles and responsibilities of the federal Parliament, state and territory parliaments and local councils, and how they work together to deliver services to Australians.

### IN THIS SECTION



INTERACTIVE

Federal, state and local

Do you know what each level of government is responsible for? Test your knowledge of the three levels of government in Australia with this game.

INTERACTIVE

THREE LEVELS OF GOVERNMENT

YEAR 6 | YEAR 7



FACT SHEET

The roles and responsibilities of the three levels of government

This fact sheet introduces the three levels of government in Australia: the federal—Australian—Parliament, state and territory parliaments, and local councils.

FACT SHEET

THREE LEVELS OF GOVERNMENT

YEAR 6 | YEAR 7



VIDEO

Three levels of government

Get an introduction to the three levels of government with this short video.

VIDEO

THREE LEVELS OF GOVERNMENT

YEAR 6 | YEAR 7



VIDEO

Levels of government

In Australia 3 superheroes fight for the people. Discover their powers and those of the three levels of government with this video from the ABC's Behind the News.

VIDEO

THREE LEVELS OF GOVERNMENT

YEAR 6 | YEAR 7

Парламентын ордонтой танилцах хөтөлбөр нь 4-12 насны сурагчдад зориулсан хөтөлбөр бөгөөд хөтөлбөрийг илүү үр дүнтэй, сонирхолтой зохион байгуулах зорилгоор сурагчид өөрсдөө хөтөлбөрөө боловсруулах боломжтой байдаг.

Парламентын Боловсролын газар нь бага, дунд сургуулийн багш нарт зориулсан сургалтыг цахимаар зохион байгуулдаг.

**Өмнөд Солонгосын**<sup>134</sup> хувьд Үндэсний Ассамблейн Тамгын газарт **Үндэсний Ассамблейн сургалтын институт** байдаг. Тус институт нь Үндэсний Ассамблейн гишүүд, туслахууд, тамгын газрын ажилтнууд болон харьяа байгууллагууд, орон нутгийн зөвлөл, иргэдийн зөвлөл зэрэг бүх талуудад боловсрол олгох сургалт явуулдаг.

Сургалтын институт нь өөрийн бие даасан цахим хуудастай бөгөөд хөтөлбөрийн дагуу зохион байгууллагдах сургалтад цахимаар бүртгүүлэн хамрагдах боломжтой байдаг.

<sup>134</sup> Үндэсний Ассамблейн сургалтын институт  
<https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>  
<https://training.assembly.go.kr:448/napto/edu/retrieveEduList.do>

**Соломоны Арлуудын**<sup>135</sup> хувьд 2008 онд НҮБ-ын парламентыг бэхжүүлэх төслийн дэмжлэгтэйгээр Парламентын ерөнхий нарийн бичгийн даргын удирдлагад **Парламентын боловсролын албыг** байгуулсан. Тус албаны үндсэн зорилго нь тус улсын иргэдийг хууль тогтоох ардчилсан үйл ажиллагааг ойлгоход дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд олон нийтийг хамруулах долоо хоног, хичээлийн агуулгыг дэмжих хөтөлбөр, сурагчдад зориулсан хөтөлбөр, хүйсийн тэгш байдал зэрэг үндсэн 4 агуулгаар сургалт зохион байгуулдаг.

Олон нийтийг хамруулах долоо хоногт засгийн газрын ордон нь олон нийтэд нээлттэй ажилладаг.

Бага болон дунд ангийн сурагчдын хүсэлтийн дагуу багшийн хамт засгийн газрын ордонд зочлох аялал, ахлах ангийн сурагчдын хувьд парламентын чуулганд оролцож, тодорхой асуудлын хэлэлцүүлэгт үг хэлэх боломжоор хангадаг.

**ХБНГУ-ЫН**<sup>136</sup> хувьд Бундестагийн Тамгын газар нь хууль-эрх зүй, улс төр-эдийн засгийн чиглэлээр суралцдаг оюутнуудыг дадлага хийх боломжоор хангаж, ирээдүйд сайн улстөрч болоход нь тэднийг бэлтгэж, дэмжлэг үзүүлдэг. Германы Бундестагийн Парламентын семинарууд нь улстөрийн боловсрол олоход чиглэсэн байдаг бөгөөд хөтөлбөрийн бүрэлдэхүүнд Бундестагийн үйл ажиллагааны танилцуулга, Парламентын ордонтой буюу чуулганы хуралдаантай танилцах болон Бундестагийн урилгаар үдийн хоолонд орох багтдаг.

Мөн улстөр, газарзүй болон түүхийн багш нарт зориулсан семинар, сэтгүүлийн мэргэжлийн оюутан, сурагчдын семинар зохион байгуулдаг.

**Шинэ Зеландын**<sup>137</sup> хувьд парламентын үйл ажиллагааг ард иргэдэд хүртээмжтэй хүргэх зарчмаар парламентын боловсролын асуудлыг чухалчлан үзэж Парламентын ажлын албаны стратеги төлөвлөгөөндөө тусгасан байна. Парламентын боловсрол олгох хүрээнд парламентын үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх танилцуулга сургалт болон парламентын ордонтой танилцах аялал хийдэг. Мөн иргэдтэй уулзах хөтөлбөрөөр парламентын гишүүд Спикерийн хамт их, дээд сургууль болон дунд сургуулиудаар аялдаг 1 өдрийн хөтөлбөр юм.

Сургуулийн сурагчдад хэлэлцүүлгийн дүрд тоглох хөтөлбөрийг зохион байгуулдаг. Энэ хөтөлбөр нь Парламентын бүтэц, үйл ажиллагаатай танилцсан, сургалтын төвийн загвар танхимд хуулийн төсөл (загвар) дээр мэтгэлцэх боломжийг бүрдүүлнэ.

Парламентын албан ёсны цахим хуудсандaa багш, сурагчдад зориулсан тусгайлсан мэдээллийн хэсгийг /хуудас/ бий болгон ажиллуулсан нь оюутан сурагчдад тухайн цаг үеийн асуудлуудыг дэвшүүлэх, нягтлан үзэх, хүмүүс ямар шийдвэр гаргахыг ажиглах, улмаар өөрсдөө хэрхэн оролцоого ойлгох зэрэг боломжийг бүрдүүлсэн байна.

<sup>135</sup> Соломоны Арлуудын үндэсний парламентын иргэний боловсрол  
<http://www.parliament.gov.sb/index.php?q=node/783#1>

<sup>136</sup> Германы Бундестаг-Deutscher Bundestag <https://www.bundestag.de/besuche/seminar>

<sup>137</sup> Шинэ Зеландын парламент <https://www.parliament.nz/en/visit-and-learn/educators-and-students/education-programmes/how-parliament-works/>

### Зураг 3. Шинэ Зеландын Парламентын цахим хуудас

The screenshot shows the homepage of the New Zealand Parliament website. At the top, there's a banner with a video thumbnail of the House of Representatives, a calendar icon, a watch icon, a listen icon, and a text overlay: "The House next meets on Tuesday, 4 August 2020". To the right is the Parliament logo and the text "New Zealand Parliament Pāremata Aotearoa". Language options (English/Māori), a search bar, and an advanced search link are also at the top right. Below the banner, a large green header features the word "explore" in yellow and "PARLIAMENT" in white, with a small crown icon. The main content area is titled "Resources" and includes several cards:

- Social Actions and Parliament**: Shows a collage of images including the Parliament building and students in a classroom. Description: This resource has been created to link the requirements of the NZQA Achievement Standard 91599 (3.4) to parliamentary processes. [Read more](#)
- Parliament 360° Virtual Reality Tours: school resource**: Shows two students wearing VR headsets. Description: This new resource has been created to be used alongside the Parliament XR Headset. [Read more](#)
- Explore Parliament**: Shows a teacher and students in a classroom. Description: Resources, with teacher's guides for primary and secondary level students which introduce students to the work of Parliament and explore concepts of democracy, representation and leadership. Includes links to the New Zealand Curriculum. [Read more](#)
- Tō Tātou Whare**: Shows a classroom setting with a focus on Māori language resources. Description: A Māori language resource with bilingual teachers guide which introduces students to concepts of democracy, representation and leadership in Parliament with a focus on Māori participation. Includes links to TE MARAUTANGA o AOTEAROA. [Read more](#)
- Debating role play**: Shows students in a classroom setting. Description: An easy to follow teachers guide outlining how to run a debating role play in the classroom. [Read more](#)
- How Parliament Works - video**: Shows a video thumbnail with the title "How PARLIAMENT works". Description: Find out more about how New Zealand's Parliament works with this in-depth introduction! [Read more](#)
- Virtual reality at Parliament**: Shows students wearing VR headsets in a classroom. Description: Can't make it to Wellington? Want to carry Parliament in your pocket? [Read more](#)
- Interactive timeline**: Shows a screenshot of an interactive timeline interface. Description: An easy to use interactive timeline which explores 100 dates from the history of our Parliament through short text and visual images. Suitable for classroom use with links provided to related websites. [Read more](#)

## ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд парламентын боловсрол олгоход парламентаас онцгойлон анхаардаг бөгөөд энэ асуудлыг хариуцсан нэгжийг байгуулан ажилладаг байна. Судалгаанд хамрагдсан Их Британи, Австрали, Өмнөд Солонгос, Соломоны Арлууд, Шинэ Зеланд улсуудын хувьд парламентын боловсрол олгох асуудлыг хариуцсан нэгж Парламентын ажлын алба (Тамгын газар)-ны бүтцэд ажиллаж байна. Тус нэгж нь бүх нийтэд парламентын боловсрол олгох, парламентын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Холбогдох нэгжүүдийн үйл ажиллагаа явуулж буй хугацааны хувьд авч үзвэл БНСУ-ын сургалтын нэгж нь 45 жилийн өмнө, Соломоны Арлууд хувьд 12 жилийн өмнө тус тус байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Бүх нийтэд парламентын боловсрол олгох сургалт, хөтөлбөрийг ихэвчлэн насын байдлаар ангилж, тухайн насын онцлогт тохирсон хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Тухайлбал,

- Сургуулийн өмнөх насынханд зориулсан хөтөлбөр (Их Британи, Австрали)
- ЕБС-ийн сурагчдад зориулсан хөтөлбөр (Их Британи, Австрали, Соломоны Арлууд, Шинэ Зеланд)
- Их сургуулийн оюутнууд болон залуучуудад зориулсан хөтөлбөр (Герман, Их Британи)
- Насанд хүрэгчдэд зориулсан хөтөлбөр (Их Британи, Солонгос, Соломоны Арлууд, Шинэ Зеланд)
- Парламентын гишүүд, туслахууд болон Тамгын газрын ажилтнуудад зориулсан сургалт (БНСУ)
- Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан хөтөлбөр (Их Британи)
- Тусгайлсан сургалт (Их Британи, Австрали, Соломоны Арлууд, Герман, Шинэ Зеланд)

Үүнд тусгай багш бэлтгэдэг сургалт (Их Британи, Австрали, Герман) зохион байгуулдаг.

Дээр дурдсан бүлгүүдэд хийх сургалтын сэдвийн агуулга нь дараах хүрээнд хязгаарлагдаж байна. Үүнд:

- Парламент болон засгийн газрын тухай ойлголт, үйл ажиллагааны талаар (Их Британи, Австрали, Герман, Шинэ Зеланд)
- Парламентаас хууль батлах үйл ажиллагааны талаар (Их Британи, Австрали, Солонгос, Соломоны Арлууд, Герман, Шинэ Зеланд)
- Тухайн улсын үнэт зүйлийн талаар (Их Британи, Австрали)
- Сонгууль, сонгох эрхийн талаар (Их Британи)
- Тэгш болон ялгаатай байдлын талаар (Их Британи, Соломоны Арлууд)
- Мэргэшүүлэх сургалт (Солонгос)
- Парламентын гишүүдтэй уулзах (Соломоны Арлууд, Герман, Шинэ Зеланд)
- Парламентын үүссэн түүх

Парламентын боловсрол олгох арга хэлбэрийн хувьд иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хүргэх үүднээс дараах хэлбэрүүдтэй байна.

- Танилцуулга, ном товхимол, видео хичээл гаргах (Их Британи, Соломоны Арлууд, Шинэ Зеланд)
- Хичээлийн хэрэглэгдэхүүний багц (тоглоом гм.)
- Парламентын ордонтой танилцах аялал (Их Британи, Австрали, Соломоны Арлууд, Шинэ Зеланд)
- Тусгай бэлтгэгдсэн багш хичээл заах (Их Британи)
- Парламентын нэрэмжит 7 хоног буюу нээлттэй хаалганы өдөрлөг (Их Британи, Соломоны Арлууд, Шинэ Зеланд)
- Парламентын нэрэмжит шагнал (Их Британи)
- Θсвөрийн парламент (Их Британи, Шинэ Зеланд)
- Дадлага хийх (Герман)

Судалгаанд хамрагдсан улсууд парламентын боловсрол олгохтой холбоотой бэлтгэсэн танилцуулга, гарын авлага, ном товхимлыг сонирхсон хүмүүс үзэх, ашиглах боломжтойгоор цахим хуудаснаа байршуулдаг байна. Мөн зарим сургалтуудыг цахимаар (Австрали, Θмнөд Солонгос) зохион байгуулдаг.

Бага, дунд ангийн сурагчдад зориулсан хөтөлбөр нь ихэвчлэн өөрийн орныг танин мэдэх, парламент хэрхэн ажилладаг талаарх (Их Британи, Австрали, Шинэ Зеланд) мэдлэгийг энгийн ойлгомжтойгоор тайлбарлан таниулдаг байна.

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Судалгаанд хамрагдсан орнуудын парламентын боловсролыг олгож буй туршлагыг тоймлон харуулбал дараах байдалтай байна:

*Хүснэгт 1. Парламентын боловсрол олгох сургалт, хөтөлбөр хэнд чиглэгдэж байгааг ангилан үзвэл:*

	Их Британи	Австрали	БНСУ	Соломоны Арлууд	ХБНГУ	Шинэ Зеланд
Сургуулийн өмнөх насыханд зориулсан хөтөлбөр	✓	✓			✓	
ЕБС-ийн сурагчдад зориулсан хөтөлбөр	✓	✓	✓	✓	✓	✓
Их сургуулийн оюутнууд болон залуучуудад зориулсан хөтөлбөр	✓				✓	
Насанд хүрэгчдэд зориулсан хөтөлбөр	✓		✓	✓		✓
Парламентын гишүүд, туслахууд болон Тамгын газрын ажилтнуудад зориулсан сургалт			✓			
Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан хөтөлбөр	✓					
Тусгайсан сургалт	✓	✓	✓	✓	✓	✓

*Хүснэгт 2. Сургалт, хөтөлбөрийн сэдвийн агуулгыг тоймлон авч үзвэл:*

	Их Британи	Австрали	БНСУ	Соломоны Арлууд	ХБНГУ	Шинэ Зеланд
Парламент болон засгийн газрын тухай ойлголт, үйл ажиллагааны талаар	✓	✓		✓	✓	✓
Парламентаас хууль батлах үйл ажиллагааны талаар	✓	✓	✓	✓	✓	✓
Тухайн улсын үнэт зүйлийн талаар	✓	✓				
Сонгууль, сонгох эрхийн талаар	✓					
Тэгш болон ялгаатай байдлын талаар	✓		✓			
Мэргэшүүлэх сургалт			✓			
Парламентын гишүүдтэй уулзах				✓	✓	✓

*Хүснэгт 3. Парламентын боловсрол олгож буй арга хэлбэрийг тоймлон авч үзвэл:*

	Их Британи	Австрали	БНСУ	Соломоны Арлууд	ХБНГУ	Шинэ Зеланд

Сургалт зохион байгуулах	√	√	√	√	√
Танилцуулга, ном товхимол, видео хичээл гаргах	√	√	√	√	√
Парламентын ордонтой танилцах аялал	√	√	√	√	√
Тусгай бэлтгэгдсэн багш хичээл заах	√				
Парламентын нэрэмжит 7 хоног буюу нээлттэй хаалганы өдөрлөг		√		√	√
Парламентын нэрэмжит шагнал		√			
Өсвөрийн парламент		√			√
Дадлага хийх					√

## ИХ БРИТАНИ

Их Британи Улсын парламентын Нийтийн танхим нь стратеги төлөвлөгөөндөө үндэслэн жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө парламентын боловсролын асуудлыг багтаасаар ирсэн байна. Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба (Education and Engagement Service) нь Нийтийн танхимиын ажлын албаны бүтцэд харьялагдана.<sup>138</sup> Тус алба нь бүх нийтэд парламентын боловсрол олгох, парламентын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг. Парламентын боловсролыг Парламентын боловсролын төвөөр, парламентын ажлын албаны цахим хуудсаар, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр, орон нутаг дахь парламентын сургалт мэдээллийн төвүүдээр болон мэдээ, мэдээллийн хэрэгслийдээр дамжуулан олгодог байна.

Парламентын боловсролын хөтөлбөрийг насны ангиллаар:

- сургуулийн өмнөх нас;
- 5-7 нас;
- 7-11 нас;
- 11-14 нас;
- 14-16 нас;
- 16-аас дээш нас;
- Насанд хүрэгчид;
- Залуучуудын бүлэг болон иргэний нийгмийн байгууллагууд хэмээн ангилж байна.

Сургалтын хөтөлбөрийг дээрх насны ангиллуудад зориулан ойлгомжтой, хүртээмжтэй байх тал дээр түлхүү анхаарч тодорхой сэдвүүдийн хүрээнд янз бүрийн хэлбэрээр хүргэдэг байна. Үүнд: танилцуулга, ном товхимол, видео хичээл, зайн сургалт, парламентын байраар зочлон үйл ажиллагаатай нь танилцах болон тусгай бэлтгэгдсэн багш нараар сургуулийн анги танхимдаа хичээл заалгах зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой байна. Хүүхдүүдэд ойлгомжтой, сонирхолтой болгох үүднээс биет болон цахим тоглоом, хүүхэлдэйн кино зохион бүтээсэн байна. Сургалтын агуулгын цөм нь “чиний дуу хоолой, оролцоо парламентад зайлшгүй шаардлагатай” гэсэн ойлголтыг хүүхэд залуус, иргэдэд суулгахад оршдог байна.<sup>139</sup>

Дараах сэдвүүдээр иргэд олон нийт, хүүхэд багачуудад парламентын боловсролыг олгож, үйл ажиллагаатай нь танилцуулж байна:

- Иргэншил болон Британийн үнэт зүйлс;
- Сонгууль, сонгох эрх;
- Эмэгтэйчүүдийн сонгох эрх;
- Парламент болон Засгийн газар;

<sup>138</sup> <https://erskinemay.parliament.uk/section/6391/participation/>

<sup>139</sup> <https://learning.parliament.uk/resources/>

- Нийтийн танхим болон гишүүд;
- Лордуудын танхим;
- Хэлэлцүүлэг;
- Дүрэм журам болон хууль тогтоомж;
- Тэгш болон ялгаатай байдал зэрэг болно.

Эдгээр сэдвүүдийн хүрээнд мэдээллийн контентуудыг цахим болон хэвлэмэл хэлбэрээр бэлтгэн сургач, оюутнууд хийгээд сургагч багш нарт үнэ төлбөргүй түгээх боломжтой төдийгүй хөдөө, орон нутгийн багш, сурган хүмүүжүүлэгчид парламентын цахим хуудсаар дамжуулан эдгээр хичээлийн хэрэглэгдэхүүнийг татан авах буюу хэвлэмэл байдлаар захиалан авч, хичээлдээ хэрэглэх боломжтой юм.

Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид, боловсролын салбарын мэргэжилтнүүд нь парламентын боловсрол олгох тусгай багш нар бэлтгэх үнэ төлбөргүй сургалтанд хамрагдаж, өөрийн заадаг хичээлээ улам баяжуулан заах боломжтой. Түүнчлэн энэхүү сургалт нь насанд хүрэгчдэд мөн нээлттэй бөгөөд парламентын тухай мэдлэгээ нэмэгдүүлэх чухал эх сурвалж болдог байна. Сургалт нь бүтэн жилийн турш, танхимаар болон цахимаар явагддаг.

Парламентын боловсролын төв нь парламентын ордны дэргэд байрлах бөгөөд хүүхэд залуусын сурх идэвхийг нэмэгдүүлэхэд анхаарч, сонирхолтой орчныг бүрдүүлсэн байна. Тус төв нь Их Британийн төрийн 4 үндэс болох Нийтийн засаглал, Лордууд, Хаан болон Парламент гэсэн сэдвээр 4 танхимиг тохижуулан, тэдгээрийн тус тусын чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулах хийгээд хоорондын харилцан хамаарлыг орчин үеийн техникийн дэвшлийг ашиглан бодитоор мэдрүүлэх (виртуал) боломжтой бүтээсэн байна. Тус төв нь бүтэн жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд хүүхэд багачууд, оюутан сургчид, иргэд олон нийт хамт олноороо захиалга өгөн үйлчлүүлэх боломжтой.<sup>140</sup>

Парламентын ордноор тэр бүр зочлох боломжгүй алслагдсан бүс, орон нутгийн сургагч багачууд, ард иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан виртуал танилцуулгыг парламентын боловсролын цахим хуудсан дээр байршуулсан байна. Түүнчлэн тусгай бэлтгэгдсэн сургагч багш нар болон Нийтийн танхимын ажлын албаны ажилтнууд нь хөдөө орон нутагт томилогдон, сургуулийн танхимд нь биечлэн очиж парламент, түүний үйл ажиллагааны тухай мэдээллийг олгох боломжтой.

Парламентын орон нутаг дахь сургалтын төвүүд нь (Parliament's Outreach Officers) тус улсын бүс нутаг болгонд парламентын үйл ажиллагааг сурталчилж ажилладаг байна. Иргэд, олон нийт, нийгмийн бүлгүүдэд парламентын үйл ажиллагааны тухай мэдээллийг өгч, тэдэнд санал хүсэлт, тулгарч буй асуудлаа хэрхэн шийдвэрлүүлэх, хэрхэн өөрсдийн дуу хоолойг парламентад хүргэх талаар сургалт мэдээллийг хүргэдэг байна. Нийгмийн бүлгүүд, олон тооны байгууллагатай хамтран ажилладаг хэдий ч залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага, Ази, Африк гаралтай иргэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон урт хугацаанд ажилгүй байгаа иргэдийг түлхүү анхаарч үйл ажиллагаагаа тэдэнд чиглүүлэн ажилладаг байна.

Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба нь “Парламентын нэрэмжит 7 хоног” (UK Parliament week) хүүхэд залуус, олон нийтийг хамарсан, иргэдийн парламентын боловсролыг нэмэгдүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дээшлүүлэх, идэвхийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой олон төрлийн сонирхолтой уралдаан тэмцээнийг орон даяар 7 хоногийн турш зарлан, зохион байгуулдаг байна.

<sup>140</sup> <https://www.parliament.uk/educationcentre>

Тус албанаас мөн “Таны парламент” шагналыг тухайн жилдээ парламентын тухай мэдлэг мэдээллийг түгээн, өөрийнхөө хүрээлэл-анги танхим, сургууль, орон нутагтаа тодорхой хэмжээний өөрчлөлт хийсэн багш, сурган хүмүүжүүлэгчид, сурагч, оюутнууд, иргэд олон нийтийг шалгаруулан урамшуулдаг байна.

Британийн Залуучуудын Холбоо нь хүүхэд, залуучуудын улс төрийн боловсрол, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, ирээдүйд нийгмийн хариуцлагатай, оролцоотой иргэнийг бэлтгэх, шийдвэр гаргах түвшинд залуусын дуу хоолойг хүргэх зорилгоор 11-18 насныхнаас бүрдсэн “Өсвөрийн парламент”-ыг ажиллуулдаг.<sup>141</sup>

### **Парламентын боловсролыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгож буй туршлагын талаар**

Тус улсад Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн Иргэний боловсрол (Citizenship education) хичээлээр дамжуулан сурагчдад парламентын боловсролыг олгодог бөгөөд сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулж бага ангиас нь чи хэн бэ, чиний эргэн тойрон, хүрээлэн буй орчин чамаас ямар хамааралтай байдаг вэ гэсэн энгийн ойлголтыг өгч үүнийгээ дунд ангиудад лавшруулан нийгэмд өөрийн үзэл бодолтой, өөртөө итгэлтэй хувь хүн болон төлөвшихд түлхүү анхаарч, өөрийн амьдарч буй хүрээлэл, гадаад ертөнц хоёрын харилцан хамаарал, нийгмийн шударга байдал, ёс зүй гэж юу болох, чиний үзэл бодол, чиний сонголт зөвхөн орон нутгийн төдийгүй, цаашлаад өөрийн улсын, бүр энэ дэлхийн амьдралд ямар нөлөөтэй болох тухай мэдлэг мэдээлэл, ойлголтыг өгдөг байна.<sup>142</sup>

Ахлах ангид тус хичээлээр нийгэмд идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэхэд шаардагдах ойлголт, мэдлэг, ур чадварыг олгоход чиглэж, ардчилал, төр засаг, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх мэдлэгийг сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог байна. Улс төр, нийгмийн тулгамдсан асуудлуудыг судалж, хэлэлцүүлэг өрнүүлж, учир шалтгааныг нь дүгнэн цэгнэх мэдлэг чадвар суулгахыг мөн зорьдог байна. Ирээдүйд нийгэмд хариуцлагатай иргэн болж төлөвших, мөнгө төгрөгөө зөв зүйтэй зарцуулах, санхүүгийн зөв шийдвэр гаргаж байх зэрэг ойлголтыг энэхүү хичээлээр заадаг байна. Ахлах ангийн нийт сурагчдад Иргэний боловсрол хичээлээр дараах мэдлэг, чадварыг эзэмшигүүлэх зорилготой:

- Их Британийн төрийн тогтолцоо, ардчилсан засаглалд иргэд хэрхэн идэвхтэй оролцох талаар;
- Нийгэмд хууль тогтоомж, шүүхийн тогтолцооны гүйцэтгэх үүрэг болон хууль боловсруулах, батлах үйл явц, түүний хэрэгжилтийн талаар;
- Цаашид олон нийтийн болон бусад нийгэмд тустай, хариуцлагатай үйл ажиллагаанд оролцох идэвх, сонирхлыг төрүүлэх, хөгжүүлэх, хэвшүүлэх талаар;
- Асуудалд олон талаас нь нухацтай хандах, улс төрийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх, өдөр тутмын мөнгө санхүүгийн асуудлаа зөв зүйтэй зохицуулах зэрэг болно.<sup>143</sup>

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг сурагчдын нас, ангиар 4 үндсэн үе шат болгон заадаг байна.<sup>144</sup> Сурагчдад заавал олгох ёстой сургалтын цөм хөтөлбөрт улсын болон хувийн ерөнхий боловсролын сургуулиудын 1, 2-р шатанд, өөрөөр хэлбэл 1-6 ангид Иргэний боловсрол хичээлийг заавал оруулахаар хуульчлаагүй хэдий ч ерөнхий

<sup>141</sup> <https://www.byc.org.uk/uk-youth-parliament>

<sup>142</sup> [https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/402173/Programme\\_of\\_Study\\_KS1\\_and\\_2.pdf](https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/402173/Programme_of_Study_KS1_and_2.pdf)

<sup>143</sup> <https://www.gov.uk/government/publications/national-curriculum-in-england-citizenship-programmes-of-study>

<sup>144</sup> <https://www.gov.uk/national-curriculum>

боловсролын бүх сургуулийн 3, 4-р шат буюу 7-11 ангиудад энэ хичээлийг заавал оруулахаар хуульчилсан байдаг байна.

**Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн 4 үе шат  
сургуулийн анги, насны ангиллаар**

	Үе шат	Анги	Нас
Бага буюу анхан	1	1,2	5-7
Бага буюу анхан	2	3,4,5,6	7-11
Дунд	3	7,8,9	11-14
Ахлах	4	10,11	14-16

## **АВСТРАЛИ**

### ***Парламентын боловсролын газар***

Австрали Улсын Парламентын Боловсролын газар нь (*Parliamentary Education Office*) Сенатын танхимины Клеркийн удирдлагад харьяалагдах бөгөөд парламентын ардчиллын талаар австраличуудад мэдлэг олгодог байгууллага юм. Жилд 90,000 гаруй оюутнуудыг боловсролын хөтөлбөрт хамруулдаг. Тус газар нь бүх насны хүмүүст хүртээмжтэй, сонирхолтой хэлбэрээр хөтөлбөрүүдийг зохион байгуулдаг.

Тус хэлтсийг Сенатын танхим болон Төлөөлөгчдийн танхим хамтран санхүүжүүлж, парламентын бүх шатны боловсролд дэмжлэг үзүүлдэг.

Парламентын Боловсролын газар нь иргэдэд чиглэсэн дараах сургалтуудыг зохион байгуулдаг. Үүнд:

Бага, дундангийн сурагчдад зориулсан туршлага судлах хөтөлбөр нь Австрали орныг илүү сайн танин мэдэх, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд парламент хэрхэн ажилладаг талаар мэдлэг олгодог.

### ***Parliament house program - Парламентын ордны хөтөлбөр***

Энэ хөтөлбөр нь Австралийн ардчилсан засаглалын үйл ажиллагаа, зорилго, үнэт зүйлийн талаарх сургалт бөгөөд хөтөлбөр нь 4-12 насны сурагчдад зориулсан даваабаасан гарагийн 09.00-16.00 цагийн хооронд 15–50 хүртэлх хүүхдүүдийн бүрэлдэхүүнтэйгээр үнэ төлбөргүй зохион байгуулдаг сургалт юм.

Сургалт доорх сэдвийн хүрээнд явагддаг.

- how laws are made through Parliament – Парламентаар хууль хэрхэн баталдаг;
- the responsibilities of representatives – Төлөөлөгчдийн үүрэг, хариуцлага;
- the formation of government – Засгийн газар байгуулах;
- how government is kept accountable – Засгийн газарт хариуцлага хэрхэн тооцох агуулгын хүрээнд зохион байгуулдаг.

### ***Prepare for your program – хөтөлбөрт бэлтгэх***

Парламентын ордонд хийх хөтөлбөрийг илүү үр дүнтэй сонирхолтой болгоход сурагчид өөрсдөө хөтөлбөрөө боловсруулах боломжтой байдаг. Сургалтын түгээмэл сэдэвт:

- Парламентын ордны аялал (сурагчдад тайлбартай);
- Австралийн парламентын хийдэг ажлын талаар;
  - Парламент гэж юу вэ?
  - Хууль хэрхэн баталдаг вэ?
- Танхимдаа дүрд тоглох;
- Австралийн сургалтын хөтөлбөрт нийцсэн хөтөлбөр боловсруулах;

- Парламентын үйл ажиллагааны тухай.

### ***Video conferencing program – Видео хурал хийх хөтөлбөр***

Парламентын Боловсролын газар нь одоогийн байдлаар цахим хурлыг Zoom апликэйшн ашиглан нэг дор 30 хүртэл оролцогчдод интерактив хөтөлбөрийг зохион байгуулж байна. Тус хөтөлбөр нь 5 -12 насны сурагчдад зориулсан ажлын таван өдөр өглөөний 09.00-16.00 цагийн хооронд хамгийн ихдээ 35 хүртэлх хүүхдүүд оролцох боломжтойгоор 30-60 минутын хугацаанд зохион байгуулдаг бөгөөд сургалт үнэ төлбөргүй байдаг. Цахим хуралд оролцогчдод зориулсан хэвлэмэл гарын авлага, сургалтын материалыг бэлтгэн гаргадаг.

### ***Professional learning – Мэргэжлийн сургалт***

Парламентын Боловсролын газар нь бага, дунд сургуулийн багш нарт зориулан дараах сэдвийн хүрээнд сургалт явуулдаг. Үүнд:

- Австралийн парламентын тухай мэдлэгийг дээшлүүлэх;
- Австралийн засгийн газрын тогтолцоо, хэрхэн ажилладаг талаар судлах;
- Австралийн парламентын үүрэг, ач холбогдлыг судалж, үйл ажиллагаатай танилцах;
- Сургалтын хөтөлбөрт суурилсан интерактив сургалтын гарын авлага болон стратеги төлөвлөгөө бэлтгэх.

Дээрх сургалтууд нь Даваа, мягмар, лхагва гарагийн 16.00 – 18.00 цагийн хооронд цахим хэлбэрээр явуулдаг.

## **БНСУ**

### ***Үндэсний Ассамблейн Сургалтын Институт***

Үндэсний Ассамблейн Тамгын газрын харьяанд Сургалтын Институт нь хууль, эрх зүйн сургалтаар дамжуулан мэдлэгт суурилсан улсыг бүтээх зорилгоор бүтээлч, уран сэтгэмж, авьяас чадварыг хөгжүүлэх чиг үүрэгтэй институт юм.<sup>145</sup> Тус Институт нь Үндэсний Ассамблейн гишүүд, туслахууд, тамгын газрын ажилтнууд болон харьяа байгууллагууд, орон нутгийн зөвлөл, иргэдийн зөвлөл зэрэг бүх талуудад боловсрол олгох сургалт явуулдаг байна. Тус институт нь Үндэсний Ассамблейн Тамгын газрын Захиргааны асуудал хариуцсан нарийн бичгийн даргын удирдлагад ажилладаг.


Тогтвортой хөгжингүй парламентыг байгуулахын тулд УИХ-ын гишүүдийн чадавхыг хөгжүүлэх сургалтад анхаарч, орон нутаг болон холбогдох байгууллагуудад сар, жилийн төлөвлөгөөний дагуу төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулдаг.

1975 онд Үндэсний Ассамблейн албан хаагчдын сургалтын хүрээлэн нэрээр анх байгуулагдаж байсан бол өөрчлөгдөн явсаар 2017 оны 3 дугаар сарын 27-нд Үндэсний Ассамблейн Сургалтын Институт болсон.<sup>146</sup>

<sup>145</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

<sup>146</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

## **Бүтэц зохион байгуулалт**



### **Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалт**

Үндэсний Ассамблейн сургалтын хэлтсээс зохион байгуулдаг цахим сургалтын хөтөлбөр дараах ерөнхий агуулгатай байдаг<sup>147</sup>.

- Мэргэшүүлэх боловсрол;
- Хууль тогтоомжийн тухай хууль, төсвийн төсөл батлах үйл явцын тухай ойлголт, үндсэн хууль, захиргааны эрх зүй гэх мэт сургалтууд;
- Мэдээлэл зүйн боловсрол;
- Бусад (хувь хүний хөгжлийн чадвар эзэмшүүлэх сургалтууд);
- Хууль, эрх зүйн заавал эзэмших боловсрол;
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлийн ялгаварлалтаас сэргийлэх сургалт<sup>148</sup>.

Үндэсний Ассамблейн Сургалтын Институт нь өөрийн бие даасан цахим хуудастай ба төрийн албан хаагчид, холбогдох байгууллагын ажилчид, мөн энгийн иргэд хүртэл хөтөлбөрийн дагуу цахимаар бүртгүүлэн хамрагдах боломжтой байдаг. 2020 оны сургалтын хөтөлбөрт орсон судалгаагаар энгийн иргэдэд зориулсан сургалт 7 сарын 17-ны байдлаар 2 удаа зохион байгуулагдаад байна<sup>149</sup>. Тухайлбал,

- Ардчилсан иргэний 6 дугаар үндэсний чуулган;
- Олон нийтийн байгууллагын зөвлөлийн 2020 оны сургалт.

Үндэсний Ассамблейн гишүүд болон төрийн албан хаагч, холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдийн сургалт сард дунджаар 2-3 өдрийн сургалт зохион

<sup>147</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

<sup>148</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

<sup>149</sup> <https://training.assembly.go.kr:448/napto/edu/retrieveEduList.do>

байгуулдаг бөгөөд 2020 оны нэгдүгээр улиралд дараах сургалтуудыг зохион байгуулсан байна<sup>150</sup>. Тухайлбал,

- Сонгуулийн тухай хууль, төрийн санхүүжилтийн тухай хуулийн сургалт;
- 3D хэвлэх туршлага;
- Үндэсний санхүү, татварын талаарх ойлголт;
- Windows Office Excel сургалт;
- Хүний нөөцийг хөгжүүлэх сургалт;
- Power BI Big data дүрслэх технологи.

## **СОЛОМОНЫ АРЛУУД**

Парламентын Боловсролын Алба нь 2008 онд НҮБ-ын Парламентыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан бөгөөд Парламентын ерөнхий нарийн бичгийн даргын удирдлагад ажилладаг.

Энэхүү алба нь дараах 4 үндсэн агуулгаар үйл ажиллагаа явуулдаг.

1. Олон нийтийг хамруулах долоо хоног;
2. Хичээлийн агуулгыг дэмжих үйлчилгээ;
3. Сурагчдад зориулсан хөтөлбөр;
4. Хүйсийн тэгш байдал.

### **1. Олон нийтийг хамруулах долоо хоног**

Энэ долоо хоногт засгийн газрын ордон нь үүд хаалгаа олон нийтэд дэлгэж, парламентын талаар олон нийтэд мэдлэг түгээх зорилт тавьж дараах үйл ажиллагааг явуулдаг.

- Парламентын үүрэг, үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулсан илтгэл;
- Сонгогчидтой газар дээр нь уулзаж, олон нийтийн газар, сургуулиудад зочилж, сургалт хийх, парламент ба засгийн газрын дүрд тоглуулах;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дүрэм, журам батлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

### **2. Хичээлийн агуулгыг дэмжих үйлчилгээ**

Боловсролын яам, боловсролын нэгжийн удирдлагууд, сургуулиутай холбоотой ажиллаж, багш ахлах ангийн сурагчдад зориулсан парламент, улс төр, манлайллын талаарх ном, товхимлыг бүтээж, хэвлүүлдэг.

### **3. Сурагчдад зориулсан хөтөлбөр**

Бага ба дунд ангийн сурагчид хүсэлтийн дагуу багшийн хамт засгийн газрын ордонд зочлох аялал хийдэг. Энэ үеэрээ чухал хэлтэс, газрууд, түүхэн баримтуудтай танилцаж, чуулганы танхимд орж сонирхдог. Энэ хөтөлбөрт дараах агуулгууд багтана.

- Парламентын үйл ажиллагааг бага дунд ангийн сурагчид ойлгохоор тайлбарласан зурагт ном тараадаг. Бага ангид “Парламент ба манлайлал” сэдвээр, дунд ангид “Парламент хэрхэн хууль гаргадаг вэ?” сэдвээр ном товхимол гаргадаг.
- 5 ба 9 сард нийт 1800 сурагч ордонд зочилдог ба энэ нь тус саруудад сургууль дээр нь авдаг иргэний эрхийн шалгалттай нь уялдуулахыг зорьдогтой холбоотой.
- Хэлтсийн дарга ажилчидтай уулзаж, засгийн газрын үүрэг хариуцлагын талаар яриа сонсдог.
- Тус аялал хагас өдөр үргэлжилдэг.

<sup>150</sup> <https://training.assembly.go.kr:448/napto/edu/retrieveEduList.do>

Ахлах ангийн сурагчдын төлөөлөл парламентын чуулганд оролцож, “Цаг уурын өөрчлөлтийг бууруулах хуулийн төсөл” гэх мэт хэлэлцүүлэгт төлөөлөн үг хэлэх боломжоор хангагддаг. Энэ хөтөлбөрт дараах агуулгууд багтана.

- Тус хөтөлбөр 3-4 өдөр үргэлжилдэг.
- 20 ахлах сургуулиас сонгогдсон 52 сурагчдын төлөөлөл
- Эхний өдрүүдэд хэлэлцүүлгийн сэдэвт бэлдэх зорилгоор загварчилсан хуралдааныг зохион байгуулж, жинхэнэ хэлэлцүүлэгт өргөн барих санаачилгуудыг дэвшүүлдэг.
- Уг хөтөлбөр нь үндэсний, бүсийн, олон улсын шинж чанартай парламентын хуралдаанд хүүхэд залуусын манлайлан оролцох чадварыг хөгжүүлэхийг зорьдог.

#### **4. Хүйсийн тэгш байдал**

Эмэгтэйчүүдийг улс төрд оролцуулж, шийдвэр гаргах түвшинд ажиллуулах шаардлагатай байгааг онцлон анхаардаг. Залуу эмэгтэй манлайлагчдыг таньж илрүүлэн, тэднийг удирдан манлайлахад туслах алсын хараатай ажилладаг.

#### **ХБНГУ**

Их, дээд сургуулийн оюутнууд болон шинэхэн төгсөгчдийг парламентад дадлага хийлгэх явдал улам дэлгэрч байна. Дадлагын хөтөлбөр нь авьяаслаг залуучууд парламентын эрдэм шинжилгээ, судалгаа болон бусад хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх, нээлттэй парламентыг хөгжүүлэх, парламентад шинээр мэргэжилтэй ажилтан авч ажиллуулах ашиг тустай аж.<sup>151</sup>[1]

Германы Бундестагийн Тамгын газар нь хууль-эрхзүй, улс төр-эдийн засгийн чиглэлээр суралцдаг оюутнуудад дадлага хийх боломжоор хангаж, ирээдүйд сайн улс төрч болоход нь тэднийг бэлтгэж, дэмжлэг үзүүлдэг.[2]

Германы Бундестагийн Парламентын семинарууд нь улс төрийн боловсрол олоход “үргүүлэгч”-ийн үүрэг гүйцэтгэхэд чиглэсэн байдаг аж. Семинарыг чуулганы хуралдаантай долоо хоногийн Лхагва, Пүрэв, Баасан гарагт явуулдаг. Хагас өдрийн турш үргэлжлэх уг мэдээллийн арга хэмжээний цөм агуулга нь тухайн групп (бүлэг)-ийн өөрсдийн сонгосон сэдвээр фракц/жигүүр (нам, эвслийн бүлэг) тус бүрийн төлөөлөл ярилцлага хийх байдаг. Семинарын хөтөлбөрт Бундестагийн үйл ажиллагааны танилцуулга, Парламентын ордонтой буюу чуулганы хуралдаантай танилцах болон Бундестагийн урилгаар үдийн хоолонд орох багтдаг аж. Семинарт оролцох групп нь хамгийн багадаа 10, хамгийн ихдээ 35-аас хэтрэхгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

#### **Багш нарт зориулсан семинар**

Германы Бундестаг нь улс төр, газарзүй болон түүхийн багш нарт зориулсан семинар зохион байгуулдаг.

Семинарын хөтөлбөр нь парламентын үйл ажиллагаатай танилцах, парламентын дэд ерөнхийлөгчтэй ярилцах, Боловсролын буюу бусад байнгын хорооны гишүүнтэй уулзах, чуулганы нэгдсэн хуралдааныг үзэхээс бүрддэг. Түүнчлэн, парламентын ордонтой мөн танилцана.

<sup>151</sup> Дэлхийн банк: Парламентын ажилтны сургалтын хөтөлбөр-World Bank Parliamentary Staff Training Program, John K. Johnson, State University of New York's Center for International Development file://Johnson - Parliamentary Staff Training Program Pa.pdf

## **Сэтгүүлчийн мэргэжлийн оюутан, сурагчдын семинар**

Германы Бундестагийн зорилтот бүлэгт зориулсан дараагийн семинар бол ирээдүйн сэтгүүлчдэд зориулсан семинар юм. Энэхүү семинарын хүрээнд парламентын үүрэг зорилго болон үйл ажиллагааг тайлбарлан таниулж, аль болох олон депутат, фракцийн (нам, эвслийн бүлгийн) хэвлэлийн төлөөлөгч болон Германы Бундестагийн Хэвлэл, мэдээллийн ажилтантай ярилцах боломжоор хангадаг. Оролцогч бүлгийг 20 хүнээр хязгаарладаг аж. Жилд цөөхөн семинар зохион байгуулдаг тул олон санал ирвэл сугалаагаар шийддэг байна.<sup>152</sup>

### **ШИНЭ ЗЕЛАНД**

Тус улс нь парламентын үйл ажиллагааг ард иргэдэд хүртээмжтэй хүргэх зарчмаар парламентын боловсролын асуудлыг чухалчлан үзэж Парламентын ажлын албаны стратеги төлөвлөгөөндөө тусгасан байна.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны 2016-2020 оны стратеги төлөвлөгөөний Стратеги зорилт 2-т<sup>153</sup>: “Оюутан, сурагчдын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Шинэ Зеланд улсын ардчилал, парламентын үйл ажиллагааны талаар мэдээллийг авах, оюутан сургчид болон ард иргэдийг парламентын түүх, үйл явцтай танилцуулах, өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд тухайн иргэн парламентын цахим хуудаснаас мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.” хэмээн заасан байна.

Ингэснээр Парламентын үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангахад чухал ач холбогдолтой юм.

Энэ хүрээнд Шинэ Зеландын Парламентаас дараах хөтөлбөр, үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

1. Парламент хэрхэн ажилладаг вэ? танилцах хөтөлбөр
2. Парламентын гишүүд, спикер нь иргэдтэй хийх уулзалтын хөтөлбөр
3. Хэлэлцүүлгийн дүрд тоглох хөтөлбөр
4. Парламентын үйл ажиллагааг сурталчилсан цахим хуудас
5. Виртуал танилцуулга
6. Багш, сурагчдад зориулсан гарын авлагачаар хангах

#### **1. Парламент хэрхэн ажилладаг вэ? танилцах хөтөлбөр**

Энэ нь парламентын бүтэц, үйл ажиллагааны талаар оюутан, сургчид, олон нийтэд танилцуулах зорилготой 90 минутын хөтөлбөр<sup>154</sup> юм.

Өргөн хүрээний энэхүү хөтөлбөрт парламентын үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, үүрэг үйл ажиллагаа, улмаар парламент бидний амьдралд үзүүлэх үр нөлөөний талаарх танилцуулга сургалт болон парламентын ордонтой танилцах аяллууд багтана.

Хөтөлбөрийн мэдээллийг тухайн бүлгийн нас, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэх ба оюутнууд өөрсдийн сургалтын хөтөлбөртэй холбоотойгоор тухайлсан асуултуудыг асуух боломж нөхцөлөөр хангасан байдаг.

Танилцах бүлэг нь насанд хүрэгчдийг оролцуулан 42-оос дээшгүй хүнээс бүрдэнэ. Үүнээс том бүлгүүдийг дотор нь бүлэгт хувааж, хоорондоо 30 минутаас доошгүй зайдайгаар зочлуулдаг. Бүлэгт багтах насанд хүрэгчдийн тоог сурагчдын тоонд хувилна. Хөтөлбөрт хамрагдахыг хүсвэл урьдчилан цаг авах хэрэгтэй.

<sup>152</sup> Германы Бундестаг-Deutscher Bundestag <https://www.bundestag.de/besuche/seminar>

<sup>153</sup> <https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>

<sup>154</sup> Хөтөлбөрийн хугацааг хүсвэл 60 минут болгон багасгаж болно.

Мөн танилцах аяллын үеэр бүлгүүд парламентын үйл ажиллагааны танхимуудаас (чуулганы танхим, хэлэлцүүлгийн танхим, аль нэг хорооны танхим, Театретте буюу хэвлэлийн мэдээний хурал, Парламентын номын сан) сонгон танилцах боломжтой байдаг.

Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа хангалттай болон парламентын гишүүдийн зав чөлөөтэй эсэхээс хамаарч бүлгүүд зочлох үеэрээ өөрсдийн тойргийн гишүүдтэй уулзах боломж нээлттэй байдаг.

## **2. Парламентын спикерийн “Иргэдтэй уулзах хөтөлбөр” (Outreach program)**

Энэхүү хөтөлбөр нь парламентын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор парламентын гишүүд Спикерийн хамт их, дээд сургууль болон дунд сургуулиудаар аялдаг 1 өдрийн хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн зорилго нь иргэд парламентын гишүүдтэй уулзах, улмаар парламентын үйл ажиллагааг илүү сайн мэдэж авах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Нэг өдрийн хөтөлбөр ихэвчлэн сургуульд зочлохоор эхэлнэ. Тэнд парламентын спикер болон гишүүдийг оролцуулсан парламентын хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулж иргэдийг парламентын үйл ажиллагаатай бодитоор танилцах боломжийг бүрдүүлдэг. Мөн тэдэнтэй өдрийн зоог барьж, энэ үеэр орон нутгийн иргэд парламентын гишүүдээс асуулт асуух, парламентын XR App-аар парламентын ордонд виртуал аялал хийх зэрэг чөлөөт үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулдаг. Үдээс хойш нь дахин өөр нэг сургуулиар зочлох маягаар үргэлжилнэ.

Иргэдтэй уулзах аяллыг жилд 6 удаа зохион байгуулдаг.

## **3. Хэлэлцүүлгийн дүрд тоглох хөтөлбөр**

Энэ хөтөлбөр нь сурагчид хэлэлцүүлгийн танхимд зочилж Парламентын бүтэц, үйл ажиллагаатай танилцан, сургалтын төвийн загвар танхимд хуулийн төсөл (загвар) дээр мэтгэлцэх боломжийг бүрдүүлнэ. Хөтөлбөр нь 2 цагийн турш үргэлжилдэг бөгөөд 5-13 дугаар ангийн сурагчдад тохиромжтой юм. Ингэж хуулийг бүтээх үйл явцад өөрийн биеэр оролцсоноор үүнийг ойлгох, бодитоор танъж мэдэх, парламентын зарим үүргийг ухамсарлах өндөр ач холбогдолтой байдаг байна. Хэлэлцүүлгийг 5-13 дугаар ангийн 25 хүртэлх хүүхдийн бүрэлдэхүүнтэй байх нь тохиромжтой гэж үздэг.

Сурагчид хөтөлбөрт оролцохдоо боловсролын үйлчилгээтэй холбогdon тусгай захиалгын маягт бөглөн өөрийн боломжит өдөр, цагаа урьдчилан захиална.

Боловсролын үйлчилгээний төвөөс захиалгыг зөвшөөрсөн бол хэлэлцүүлэгт бэлтгэх зөвлөмжийг явуулна. Энэхүү зөвлөмжид хэлэлцүүлэгт хэрхэн бэлтгэх болон хэлэлцэх хуулийн төслийн сонголтын талаарх мэдээллийг оруулсан байна.

Сурагчид өөрсдийн сонгосон хууль тогтоомжийн хүрээнд ярилцах сэдвээ урьдчилан бэлтгэсэн байна.

Энэ мэтчилэн хүүхдүүдэд багаас нь парламентын тухай боловсрол мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна сургалтын ном хэрэглэгдэхүүн, эх сурвалж зэргийг бэлтгэн ашиглаж байна. Тухайлбал, багш, сурагчдад Парламент, түүний үйл ажиллагааны тухай сургалтын гарын авлага, “Ayes on Education” гэх парламентын өдөр тутмын үйл ажиллагааны тухай сонин зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гаргасан бөгөөд мөн бусад эх сурвалжуудыг цахим хуудсандaa үнэ төлбөргүй байршуулан өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлжээ. Сургалтын гарын авлагыг сурагчдын нас, сэтгэхүйн онцлог (бага, дунд, ахлах анги), хичээлийн хөтөлбөр зэрэгтэй уялдуулан боловсруулсан байна.

Мөн Маори (Māori-Шинэ Зеландын угуул хүмүүс) сурагчдад зориулан угуул Маори хэлээр сургалтын гарын авлага бэлтгэсэн. Энэ нь парламентын үйл ажиллагааны тухай бодит мэдрэмжийг төрүүлэхүйц онцлог бүхий зургаан картаас бүрдэнэ. Тэдгээрийн агуулга нь:

- Шинэ Зеландын парламент: Ардчиллын үйл ажиллагаа
- Парламент гэж юу вэ?
- Парламент юу хийдэг вэ?
- Парламент дахь хүмүүс
- Парламент дахь Маори
- Парламент ба би: Би хаана нь багтах вэ? зэрэг байна.

Шинэ Зеландын хөтөлбөрийн бичиг баримтууд, парламентын нэр томъёоны зүүлт тайлбарууд, гүнзгийрүүлэн судлахад зориулсан хэрэгтэй цахим хаягууд бүхий багшийн гарын авлагатай.

Түүнчлэн технологийн дэвшлийг ашиглан “Парламент XR” хэмээх апликашнаар дамжуулан сургчид хаана ч гар утас болон бусад мэдээлэл технологийн төхөөрөмжүүдээс виртуал өртөнцөөр аялан Парламентын тухай мэдлэгийг олох боломжтой.

Парламентын албан ёсны цахим хуудсандаа багш, сурагчдад зориулсан тусгайлсан мэдээллийн хэсгийг /хуудас/ бий болгон ажиллуулсан нь оюутан сурагчдад тухайн цаг үеийн асуудлуудыг дэвшүүлэх, нягтлан үзэх, хүмүүс ямар шийдвэр гаргахыг ажиглах, улмаар өөрсдөө хэрхэн оролцоого ойлгох зэрэг боломжийг бүрдүүлжээ.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Их Британи

- Нийтийн танхимын жил бүрийн ажлын төлөвлөгөө <https://www.parliament.uk/mps-lords-and-offices/offices/commons/the-board/board-decisions/strategy-business-planning/annual-business-plans/>
- Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба <https://erskinemay.parliament.uk/section/6391/participation/>
- Парламентын боловсрол олгох төв <https://www.parliament.uk/educationcentre>
- Парламентын боловсрол олгох хичээлийн хэрэглэгдэхүүнүүд <https://learning.parliament.uk/resources/>
- 2019-2020 оны хичээлийн жилд зориулсан парламентын боловсрол олгох хөтөлбөр, арга хэмжээ <https://assets-learning.parliament.uk/uploads/2019/12/UK-Parliament-Schools-Booklet.pdf>
- Британийн “Өсвөрийн парламент” <https://www.byc.org.uk/uk/ukyouthparliament>
- Иргэний боловсрол хичээлийн товч танилцуулга <https://www.gov.uk/government/publications/national-curriculum-in-england-citizenship-programmes-of-study>

### Австрали

- Австралийн парламентын боловсролын газар [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Parliamentary\\_Education\\_Office](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Education_Office)

### БНСУ

- Үндэсний Ассамблейн сургалтын институт <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>  
<https://training.assembly.go.kr:448/napto/edu/retrieveEduList.do>

### Соломоны Арлууд

- Соломоны Арлуудын үндэсний парламентын иргэний боловсрол <http://www.parliament.gov.sb/index.php?q=node/783#1>
- Үндэсний парламентын тайлан <http://parliamentaryeducators.org.au/uploads/Documents/APEC%202013%20-%20JR%20-%20Solomon%20Islands.pdf>
- Парламентыг бэхжүүлэх төслийн тайлан 2004-2008 <https://agora-parl.org/sites/default/files/UNDP%20-%20Solomon%20Islands%20Parliamentary%20Strengthening%20Project%3B%202004-2008%20-%20EN%20-%20PS.pdf>

### ХБНГУ

- Дэлхийн банк: Парламентын ажилтны сургалтын хөтөлбөр-World Bank Parliamentary Staff Training Program, John K. Johnson, State University of New York's Center for International Development file://Johnson - Parliamentary Staff Training Program Pa.pdf
- Германы Бундестаг-Deutscher Bundestag <https://www.bundestag.de/besuche/seminar>

### Шинэ Зеланд

- Шинэ Зеландын парламент <https://www.parliament.nz/en/visit-and-learn/educators-and-students/education-programmes/how-parliament-works/>
- Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны 2016-2020 оны стратеги төлөвлөгөө <https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>

**БУСАД ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ШИНЭ ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН  
СУРГАЛТ, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

Э.Энхтүвшин, О.Билгүүтэй, Г.Уянга

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО  
СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮГНЭЛТ  
СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- ПОЛЬШ
- БНСУ
- ХБНГУ
- АЗЕРБАЙЖАН
- КАМБОЖ
- ШОТЛАНД
- ЭНЭТХЭГ
- ПАКИСТАН



## **Судалгааны Зорилго**

Судалгаанд хууль тогтоох дээд байгууллага болох парламентын зүгээс шинээр сонгогдсон парламентын гишүүдэд зориулсан чиглүүлэх сургалт болон тогтмол сургалт, түүний хөтөлбөрийг харьцуулан судлахыг зорьсон. Судалгаанд доорх улс орнуудыг сонгоходоо эрх зүйн орчин, эдийн засаг, сургалтын агуултыг олон янз хэлбэрээр хүргэж байгаа байдал болон сайн туршлага гэж хүлээн зөвшөөрөгдсөн зэргийг шалгур болгон сонгосон.

Үг сэдвийн хүрээнд өмнө нь 2016 онд судалгааны хүрээлэнгээс (Тамгын газрын судалгааны хэлтэс) хийгдсэн харьцуулсан судалгаанд судлагдсан улс орныг хамруулахгүйгээр Польш, Азербайжан, БНСУ, ХБНГУ, Камбож, Шотланд, Энэтхэг, Пакистан улсуудыг судалсан болно.

## **Судалгааны тоөч дүгнэлт**

Судалгаанд Азербайжан, БНСУ, ХБНГУ, Польш, Шотланд (Их Британи), Энэтхэг, Пакистан улсуудыг хамруулсан ба тэдгээр улсуудын мэргэжил арга зүйн мэдлэг чадвар олгох чиглүүлэх сургалт нь дотоод журам, дэг, хорооны тогтолцоо, хууль тогтоомж, парламентын төлөөллийн чиг үүрэг, хяналт, захиргаа, номын сан, баримтжуулалт, судалгаа шинжилгээ, архивын үйлчилгээ зэрэг олон чиглэлийг ерөнхийдөө хамарч хийдэг бөгөөд үүнд мэдээлэл, харилцааны технологи улам бүр голлох байр суурийг эзэлж байна. Учир нь зөвхөн онолын мэдлэгээс гадна мөн материал хэрэгсэл, түүнийг ашиглах чадавхын асуудал үүсэж байна. Судалгаанд ихэнх парламент онлайн үйлчилгээтэй бөгөөд гишүүд хуулийн төслийн хэлэлцүүлгийн явц, парламентын ажлын бусад асуудлаар цаг алдалгүй шинэ мэдээлэл авах боломжтой болсон.

Судалгаанд дээрх орнуудын шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан чиглүүлэх хөтөлбөр болон гишүүдийг олон талын мэдээллээр хангах зорилгын хүрээнд зохион байгуулдаг сургалт, семинарын талаарх мэдээллийг хамруулав. Судалгаанд хамрагдсан бүх орнуудад голчлон дараах сэдвүүд түгээмэл байна. Үүнд:

- Парламентын үйл ажиллагаа чиглэл, гишүүдийн эрх үүрэг;
- Хууль тогтоох, хууль боловсруулах дүрэм журам;
- Техник хэрэгсэл болон цахим сургалт;
- Санхүү, төсөв төлөвлөгөө аудитын шинжилгээ;
- Парламентын гишүүдийн бүрэн эрх, ёс зүйн хариуцлага;
- Байнгын хороодын үйл ажиллагаа;
- Судалгаа, номын сангийн үйл ажиллагаа;
- Бүс нутгийн засаг захиргаа, олон нийттэй харилцах.

Судалгаанаас үзэхэд дээрх орнуудад Парламентын гишүүдийн чиглүүлэх сургалтыг семинар, хэлэлцүүлэг хэлбэрээр хүргэдэг ба ойролцоогоор 2-7 хоногийн хугацаатайгаар холбогдох ажлын хэсгээс (Ерөнхий нарийн бичгийн ажлын алба, Ассамблейн Сургалтын Институт, Парламентын судалгаа, сургалтын товчоо, парламентын байгууллага) зохион байгуулдаг байна.

## **СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

**Польш улсад:** Шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан чиглүүлэх сургалтыг ерөнхий нарийн бичгийн газрын ажлын албанаас 2-3 өдрийн хугацаатай зохион байгуулдаг.

**БНСУ:** Үндэсний Ассамблейн сургалтын институтээс сар, жилийн төлөвлөгөөний дагуу Үндэсний Ассамблейн гишүүдэд чиглүүлэх болон чадавхыг нэмэгдүүлэх сургалт тогтмол явуулдаг.



Герман Улсад: Шинээр сонгогдсон гишүүдэд парламентын үйл ажиллагааг танилцуулах ажлыг парламентын захиргааны олон нэгжүүд хариуцан явуулах бөгөөд холбогдох ерөнхий мэдээллийг Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга Гишүүдэд түгээх, гишүүдийн бүрэн эрхийн хугацааны эхний шатанд хийгдэх ажлуудыг танилцуулж, дараагаар нь шинэ гишүүдэд зориулан практик ач холбогдол бүхий нарийвчилсан мэдээ, мэдээлэл олгодог.

Азербайжан улсад: Гишүүнд чиг баримжаа олгох хөтөлбөр нь шинэ гишүүн, чуулганы гишүүн, туршлагатай гишүүдийн хэрэгцээнд үйлчлэх гурван үе шаттай.

Шотланд улсад: Гишүүдэд сонгогдсон үүргээ гүйцэтгэхэд нь туслах парламентын үйл явц, горимын талаар гүнзгий танилцуулах зорилготой ба сонгуулийн дараа дөрөв хоногийн хугацаатай чиг баримжаа олгох хөтөлбөрийг зохион байгуулахад оршиж байна.

Энэтхэг улсад: Парламентад шинээр сонгогдсон гишүүд болон парламентын гишүүд, ажлын албаны ажилтнуудад 5-8 төрлийн сургалт зохион байгуулдаг байна.

Камбож улсад: Ассамблейн Тамгын газрын ажлын албанаас чиглүүлэх сургалтыг дээд доод 2 танхимтай хамтран 7 хоногийн хугацаатай зохион байгуулдаг.

Пакистан улсад: Парламентын гишүүний сургалтын хөтөлбөр нь шинэ гишүүдийн чиглүүлэх хөтөлбөрөөс гадна парламентын гишүүдийг 23 чиглэлээр чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулна.

#### **Судалгаанд хамрагдсан улсуудын сургалтын агуулгын хураангуй:**

Улсын нэр Танхим Гишүүдийн тоо	Сургалтын агуулга	Зохион байгуулдаг хэлтэс, ажлын алба	Хугацаа
1 Польш <sup>155</sup> Хоёр танхимтай Дээд танхим (Senate 100) Доод танхим (Sejm 460) Нийт 560 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>Парламентын түүх</li> <li>Үндсэн хууль, төрийн эрх бүхий байгууллагын бүтэц</li> <li>Хуулийн төсөл боловсруулах зарчим, хууль тогтоомжийн журам</li> <li>Захиргааны болон санхүүгийн хуулийн анхан шатны мэдээлэл</li> <li>Парламентын үйл ажиллагаа</li> <li>Парламентын гишүүний эрх үүрэг</li> <li>Тойротг ажиллах чиглэл.</li> </ul>	Ерөнхий нарийн бичгийн газрын ажлын алба	2-3 өдөр
2 БНСУ <sup>156</sup> Үндэсний Ассамблей Нийт 300 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт шалгалттай холбоотой сургалт</li> <li>Төсөв, тооцооны үнэлгээний талаар мэдлэг олж авах сургалт</li> <li>Орон нутгийн бодлого</li> <li>Шаардлагатай мэргэшсэн мэдлэгийг хөгжүүлэх сургалт</li> <li>Хууль тогтоох үйл ажиллагааны талаар туршлага, ноу-хау (know-how) хуваалцах зорилгоор форум зохион байгуулах сургалт</li> <li>Үндэсний Ассамблейнгүйд болон дотоодын эрдэмтдийн хооронд мэдлэг, мэдээлэл солилцох сургалт</li> </ul>	Үндэсний Ассамблейн Сургалтын Институт	-

<sup>155</sup> Introductory Note by Mr. Wojciech Sawicki (Secretary General of the Senate off the Republic off Poland) (April 1992)

<sup>156</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentView.do>

3	ХБНГУ Хоёр танхимтай Бундестаг Нийт 709 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын мандаттай холбоотой хууль эрх зүй, санхүү</li> <li>• Бундестагийн чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлууд</li> <li>• Шинээр батлах Дэгийн төсөл</li> <li>• Сонгууль болон санал өгөх санамж бичиг</li> <li>• Асуулга тавих, асуултын хариуг сонсох, хэлэлцэх удирдамж</li> </ul>	Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга	
4	Азербайжан <sup>157</sup> (Milli Majlis) Нийт 125 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын үндсэн чиг үүрэг</li> <li>• Парламентын үйл ажиллагаа</li> <li>• Хууль тогтоох үйл ажиллагаа, хяналт тавих чиглэлээр</li> <li>• Гишүүдийн үүрэг, хариуцлага</li> <li>• Бодлогын судалгаа, дүн шинжилгээ</li> <li>• Олон нийтийн дипломат байдал</li> </ul>	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)	-
5	Шотланд <sup>158</sup>  Scottish Parliament Нийт 128 гишүүнтэй	Шинэ гишүүдийн Чиглүүлэх	Шотландын парламентын байгууллага (SPCB)	4 хоног
6	Энэтхэг <sup>159</sup>  Доод танхим (House of people/ Лок сабха) Дээд танхим (Cousil of State/Rajya Sabha) Нийт 788 гишүүнтэй	Хэрхэн үр дүнтэй парламентчин байх вэ? <ul style="list-style-type: none"> <li>• Танхимд асуудлыг хэлэлцэх парламентын асуулт, дэг журам</li> <li>• Хуулийн төсөл</li> <li>• Төсвийн үйл явц</li> <li>• Парламентын хороод</li> <li>• Хууль тогтоомжийг хэрхэн яаж хийх вэ</li> <li>• Парламентын эрх ба ёс зүй</li> <li>• Цахим Парламент-Гишүүдийн портал;</li> <li>• Цалин, тэтгэмж, тэтгэвэр, гишүүдэд үзүүлэх үйлчилгээ (орон сууц, тээвэр, эмнэлгийн байгууламж гэх мэт);</li> <li>• Парламентын судалгаа, номын сан ба гишүүдийн лавлагаа үйлчилгээ сэдвээр тус тус 4хоногийн сургалт зохион байгуулсан байна.<sup>160</sup></li> </ul>	-Парламентын судалгаа, сургалтын товчоо (BPST) -Лок Сабхагийн Нарийн бичгийн дарга нарын хамт	4 хоног
7	Камбож  Хоёр танхимтай Нийт 187 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Хуулийн шинжилгээ болон судалгаа</li> <li>• IT чиглэлийн судалгаа</li> <li>• Гадаад хэлний мэдлэг</li> <li>• Санхүүгийн менежментийн мэдлэг</li> <li>• Манлайлал, протокол, олон улсын харилцаа</li> <li>• Протокол хөтлөх, мэдээлэл боловсруулах, мэргэшсэн сургач багш бэлтгэх</li> <li>• Олон улсын парламентын туршлага солилцох</li> <li>• Хуулийн талаар орон нутагт мэдлэг олгох сургалт</li> <li>• Бүс нутгийн засаг захиргаа болон тамгын газрын чадавхыг сайжруулах</li> </ul>	Ассамблейн тамгын газар	7 хоног

<sup>157</sup> <https://2012-2017.usaid.gov/azerbaijan/press-releases/new-members-parliament-attend-introductory-orientation-program>

<sup>158</sup> [http://www.parliament.scot/SPCB/SPCB\(2015\)Paper\\_0071.pdf](http://www.parliament.scot/SPCB/SPCB(2015)Paper_0071.pdf)

<sup>159</sup> <https://rstv.nic.in/lok-sabha-secretariat-organises-orientation-programme-new-mps.html>

<sup>160</sup> <https://theindianawaaz.com/lok-sabha-secretariat-organises-orientation-programme-for-newly-elected-members/>

	Пакистан <sup>161</sup>  Хоёр танхимтай Нийт 446 гишүүнтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Процедурын дүрэм (<i>Rules of procedure</i>)</li> <li>• Парламентын үйл ажиллагаа</li> <li>• Асуулт хариултын цаг</li> <li>• Хууль тогтоох үйл явц</li> <li>• Хууль тогтоох хүрээг судалж тооцох</li> <li>• Төсвийн явц, дүн шинжилгээ</li> <li>• Байнгийн хорооны үйл ажиллагаа</li> <li>• Олон нийтийн сонсгал.</li> </ul>	Парламентын үйлчилгээний институт	

### ***Судалгаанд хамрагдсан улсуудын дэлгэрэнгүй мэдээлэл:***

#### **ПОЛЬШ УЛС**

Үндсэн хуулийн дагуу явагддаг сонгуулийн үр дүнд парламентын шинэ гишүүд улс төрд ордог ба эдгээр хүмүүсийн парламентын мэдлэг, туршлага хуримтлуулах сургалтыг ерөнхий нарийн бичгийн ажлын албаас (Agencies of Secretary General) зохион байгуулдаг байна.<sup>162</sup>

Тухайн сургалтын үеэр парламентын шинэ гишүүд парламентын ажлын үндсэн зарчим, парламентын суудал авсантай холбоотой тэдний эрх, үүрэг ба үүнээс гадна парламентад ямар чиглэлээр ажиллах ёстойг суралцдаг байна.

#### ***Шинээр сонгогдсон гишүүдийн сургалтын агуулга***

Сургалтын агуулга хэдэн гишүүн оролцох, мөн тэдний улс төрийн туршлагаас хамааран харилцан адилгүй байдаг боловч дараах сэдвүүдийг голчлон үздэг:

- Тухайн улс дахь парламент болон дэлхийн парламентын түүх
- Үндсэн хууль, төрийн эрх бүхий байгууллагын бүтэц, бүрэн эрх
- Хуулийн төсөл боловсруулах зарчим, хууль тогтоомжийн журам
- Захиргааны болон санхүүгийн хуулийн анхан шатны мэдээлэл
- Парламентын үйл ажиллагаа
- Парламентын гишүүний эрх үүрэг
- Тойрогт ажиллах чиглэл.

#### ***Сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах***

Сургалтын хөтөлбөрийг Ерөнхий нарийн бичгийн даргын (Secretary General) шууд удирдлага дор тамгын газраас (Administration of the Parliament) бэлтгэдэг ба судалгааны алба болон номын сан (A Research Department and Library) бэлтгэл ажилд тусладаг.<sup>163</sup> Сургалтын материалыг тамгын газраас бэлтгэдэг ба гарын авлага брошюр, цахим мэдээлэл, тараах материал гэх мэт шаардлагатай материалыг боловсруулдаг. Шинэ гишүүдийн сургалт ойролцоогоор 2-оос 3 өдөр үргэлжилдэг. Мөн парламентын гишүүдийн ерөнхий эрх, холбогдох мэдээллүүдээр дараах сэдвүүдээр мэдлэг олгодог.

- Парламентын бүтэц
- Танхимын үйл ажиллагаа
- Парламентын гишүүний бүрэн эрх
- Хуулийн төсөлд санал өгөх дүрэм журам

<sup>161</sup> <https://www.pips.gov.pk/services/capacity-building-and-skill-development-services>

<sup>162</sup> Introductory Note by Mr. Wojciech Sawicki (Secretary General of the Senate off the Republic off Poland) (April 1992)

<sup>163</sup> (Secretary General of the Senate off the Republic off Poland) (April 1992) page 107

- Асуух лавлах эрх
- Байнгын хороодын үйл ажиллагаа
- Гадаад бодлого

Мөн шинэ гишүүдийг парламентын үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор дараах сэдвүүдийг танилцуулдаг:

- Парламентын шинэ гишүүдийг тангараг өргөх тухай
- Парламентын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд
- Парламентын номын сангийн үйлчилгээ
- Нийтийн хоолны газар, эрүүл мэндийн, үйл ажиллагааг хариуцдаг хэлтсийн үйлчилгээ
- Парламентын гишүүдийн цалин, тэтгэмжийн талаарх мэдээлэл
- Парламентын шинэ гишүүдэд үзүүлэх орон сууцны үйлчилгээ
- Электрон төхөөрөмжүүдийн талаарх сургалт
- Зогсоолын байгууламжийн талаарх мэдээлэл, утасны лавлагаа, харуул хамгаалалтын талаарх мэдээлэл<sup>164</sup>

Удаан хугацааны турш парламентид ажилласан туршлагатай гишүүдийн хажууд шинэ гишүүд харьцангуй мэдээлэл багатай байдаг тул танилцуулах сургалт илүү дэлгэрэнгүй ерөнхий мэдээллийг агуулсан энгийн байдаг.

## **БНСУ**

Үндэсний Ассамблейн сургалтын институт нь хууль, эрх зүйн сургалтаар дамжуулан мэдлэгт суурилсан улсыг бүтээх зорилгоор бүтээлч байдал, чадварыг хөгжүүлэх чиг үүрэгтэй институт юм.<sup>165</sup> Тус институт нь Үндэсний Ассамблейн гишүүд, туслах ажилтнууд, тамгын газрын ажилтнууд болон харьяа байгууллагууд, орон нутгийн зөвлөл, иргэдийн зөвлөл зэрэг бүх талуудад боловсрол олгох сургалт явуулдаг байна.

Тогтвортой хөгжингүй парламентыг байгуулахын тулд парламентын гишүүдийн чадавхыг хөгжүүлэх сургалтад анхаарч, орон нутаг болон холбогдох байгууллагуудад сар, жилийн төлөвлөгөөний дагуу төрөлжсөн сургалтуудыг явуулдаг.

1975 онд Үндэсний Ассамблейн албан хаагчдын сургалтын хүрээлэн нэрээр анх байгуулгадаж байсан бол өөрчлөгдөн явсаар 2017 оны 3 сарын 27-нд Үндэсний Ассамблейн сургалтын институт болсон.<sup>166</sup>

## **Үндэсний Ассамблейн гишүүдэд зориулсан сургалтын агуулга**

- Хяналт шалгалттай холбоотой сургалт
- Төсвийн талаар мэдлэг олж авах сургалт
- Орон нутгийн бодлого
- Шаардлагатай мэргэшсэн мэдлэгийг хөгжүүлэх сургалт
- Хууль тогтоох үйл ажиллагааны талаар туршлага, ноу-hau (know-how) хуваалцах зорилгоор форум зохион байгуулах сургалт
- Үндэсний Ассамблейн гишүүд болон дотоодын эрдэмтдийн хооронд мэдлэг, мэдээлэл солилцох сургалт<sup>167</sup>

<sup>164</sup> (Secretary General of the Senate off the Republic off Poland) (April 1992) page 116

<sup>165</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

<sup>166</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

<sup>167</sup> <https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do>

БНСУ-ын Үндэсний Ассамблейн сургалтын институт нь өөрийн бие даасан веб хуудастай ба гишүүд болон төрийн албан хаагчид, холбогдох байгууллагын ажилчид, мөн жирийн иргэд хүртэл хөтөлбөрийн дагуу цахимаар бүртгүүлэн хамрагдах боломжтой болдог.

2020 онд хөтөлбөрт орсон судалгаагаар сард ойролцоогоор 2-3 сургалт зохион байгуулагддаг байна<sup>168</sup>. 1- 3 сар хүртэл зохиогдсон сургалтын сэдэвт:

- Сонгуулийн тухай хууль, төрийн санхүүжилтийн тухай хуулийн сургалт (01.09-01.22)
- 3D хэвлэх туршлага (01.29-01.31)
- Үндэсний санхүү, татварын талаарх ойлголт (02.11-02.13)
- Windows Office Excel сургалт (02.17-02.17)
- Хүний нөөцийг хөгжүүлэх сургалт (02.25-02.25)
- Power BI Big data дүрслэх технологи (03.09-03.11)

## **ХБНГУ**

Германы Бундестагийн хувьд шинээр сонгогдсон гишүүдэд парламентын үйл ажиллагааг танилцуулах ажлын парламентын захиргааны олон нэгжүүд хариуцан явуулдаг. Холбогдох ерөнхий мэдээллийг Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга Гишүүдэд түгээх бөгөөд гишүүдийн бүрэн эрхийн хугацааны эхний шатанд хийгдэх ажлуудыг танилцуулж, дараагаар нь шинэ гишүүдэд зориулан практик ач холбогдол бүхий нарийвчилсан мэдээ, мэдээлэл олгоход анхаардаг байна.

Сонгуулийн дараа Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга нь бүх гишүүдэд албан бичгийн хамт парламентын мандаттай холбоотой бүхий л хууль эрх зүй, санхүү болон практик ач холбогдол бүхий мэдээ, мэдээллийг гарын авлага, санамж бичиг хэлбэрээр хүргүүлдэг байна. Эдгээрт гишүүдэд зориулсан баримт бичгүүдэд: Шинэ Бундестагийн чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалт, шинээр батлах Дэгийн төсөл, сонгууль болон санал өгөх санамж бичиг болон асуулга тавих, асуултын хариуг сонсох, хэлэлцэх удирдамж зэрэг орж байна. Парламентын Тамгын газар нь Гишүүдийн туслах, зөвлөхүүд болон парламентын бүлгүүдийн ажилтнуудад зориulan Гишүүдийн асуулт асуух, асуулга тавих, хуулийн төсөл бэлтгэх зэрэг чуулганы хуралдаанд бэлтгэхэд нь зориулан мэдээллийн цагаар хэрэгтэй мэдээ, мэдээллийг нь өгдөг байна.

Үүнээс гадна Гишүүдэд Бундестагийн гишүүдийн бүрэн эрхийн тухай баримт бичиг бэлтгэн хүргүүлдэг байна. Түүнчлэн Гишүүдийн цалин хөлсний талаарх тайлбарын хамт Гишүүний албан өрөөг тохижуулах төсөв, нэмэлт өрөө тохижуулах зардал, Гишүүний мандаттай холбоотой аялал болон төлөөллийн үүрэгтэй холбоотой зардлууд багтаж байна. Парламентын мандатыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмууд нь мэдээллийн нэгэн чухал хэсэг бөгөөд эдгээр нь Германы Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль болон Германы Бундестагийн ёс зүйн дүрэмд тус тус тусгасан байна. Ёс зүйн дүрэмд парламентын мандатаас гадна цалин хөлс бүхий үйл ажиллагаа, хандив зэргийг мэдэгдэх, мэдээлэх зэрэг орсон байна. Татвар, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тэтгэвэр зэргийн талаар тайлбар зэрэг ордог бөгөөд холбогдох хуулиудын хувийг хүргэдэг байна. Гишүүдэд туслах ажилтнуудыг ажилд авахад нь хөдөлмөрийн хууль, дүрэм, хөдөлмөрийн гэрээний загвар олгох зэрэг дэмжлэг, удирдамжаар хангадаг байна. Энэхүү салбарын хариуцсан захиргааны ажилтнууд нь парламентын бүлгүүдийн эхний уулзалтууд дээр мөн амаар мэдээ, мэдээлэл өгдөг байна.

<sup>168</sup> <https://training.assembly.go.kr:448/napto/edu/retrieveEduList.do>

Шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийн гол эх үүсвэр нь Гишүүний удирдамж байна. Удирдамж нь захиргаа, судалгаа болон техникийн үйлчилгээний талаарх мэдээллээс гадна чухал шаардлагатай утасны жагсаалт, парламентын өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах мэдээ, мэдээлэл багтсан байна.

Үүнээс гадна Герман Бундестагийн захиргаанд гишүүдийн албан өрөө, техник хэрэгслийн хангамж хариуцсан нэгжүүд байх бөгөөд тэдгээр нь өрөө, тасалгаа, техник хэрэгсэл, утас зэрэг шаардлага тоног төхөөрөмжөөр хангана.

Парламентын бүлгүүд нь шинэ гишүүдийг ажилдаа хөл тавихад нь ихээхэн үүрэгтэй бөгөөд парламентын бүлгийн анхны хуралдаанаар Парламентын нарийн бичгийн дарга нар нь парламентын бүлгүүдэд шаарддагдах техник үйлчилгээний талаар танилцуулна.

Парламентын бүлгүүд нь мөн хороод болон Бундестагийн бусад албан тушаалтны томилгоог Хороодын гишүүд тодорхой болсны дараагаар Будестагийн Захиргааны ажилтнуудаас бүрдэх хариуцдаг тул гишүүдэд урьдчилан аль нэг хороо, эсхүл бусад албандаа ажиллах хүсэл сонирхлынх нь талаар тандалт анкет судалгаа явуулна.

Хороодын ажилтнууд нь шинэ гишүүдэд зориулан хороодын үйл ажиллагааг танилцуулна. Гишүүдэд мөн судалгааны хэсгийн үзүүлж буй гишүүдийн захиалгын дагуу судалгаа, анализ, статистик лавлагааг гаргах зэрэг үйлчилгээний талаар танилцуулдаг байна. Судалгааны хэлтсийн судалгааны чиглэл нь хороодын чиг үүрэгтэй уялдах бөгөөд судлаачид нь ихэвчлэн хуульч, эсхүл түүх, эдийн засаг/бизнес менежмент, байгалийн шинжлэх ухаан, улс төр судлал зэрэг мэргэжилтэй байдаг байна. Дээрх сургалтуудад гишүүдийн туслах, зөвлөхүүд нь мөн оролцох эрхтэй байдаг. Үүнээс гадна Өргөдлийн байнгын хороо зэрэг тусгай чиг үүрэгтэй байнгын хороодод өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан сургалтууд зохион байгуулдаг байна.

Түүнчлэн дээрх сургалтуудаас гадна жил бүр хэрэгждэг хоёр Олон улсын парламентын тэтгэлэгт хөтөлбөр байдаг бөгөөд ихэвчлэн гишүүдийн бүрэн эрхийн хугацааны эхэнд Бундестагийн Ерөнхийлөгч гишүүдэд сайн дурын үндсэн дээр оролцохыг уриалдаг байна. Хөтөлбөр нь дэлхийн 25 орны залуучуудад парламентын үйл ажиллагаатай, улс төрийн шийдвэр гаргах процессийн танилцах чиг үүрэг бүхий Бундестагт 4 сарын хугацаатай дадлага хийх боломж байдаг бол Конгресс-Бундестагийн Залуучууд Солилцооны хөтөлбөрийн хүрээнд гишүүдийн өөрсдийн тойргийн оюутан эсхүл мэргэжилтнүүдэд АНУ-д улсад суралцах нэг жилийн тэтгэлэг олгодог байна. Аль аль тохиолдолд гишүүдэд Бундестагийн захиргаанаа бүхий л асуултад хариулах бөгөөд асуулт нь парламентын ордонд болж буй асуудлыг хэрхэн зохих дэмжлэг туслалцааг үзүүлдэг байна.

## **АЗЕРБАЙЖАН**

Азербайжан улсын гишүүнд чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID) болон Азербайжан улсын парламентын тамгын газартай хамтран зохион байгуулдаг.

Гишүүнд чиг баримжаа олгох хөтөлбөр нь шинэ гишүүн, чуулганы гишүүн, туршлагатай гишүүдийн хэрэгцээнд үйлчлэх гурван үе шаттай. Үүнд:

1. Анх удаа сонгогдсон парламентын гишүүдэд зориулан боловсруулсан бөгөөд парламентын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар, парламентын үйл ажиллагааны хууль тогтоох, төлөөлөх, хяналт тавих чиглэлээр гишүүдийн үүрэг, хариуцлагын талаар товч мэдээлэл өгдөг.
2. I үе шатанд тусгагдсан сэдвүүдийн хүрээнд өргөжиж, бодлогын судалгаа, дүн шинжилгээ, олон нийтийн харилцаа зэрэг нэмэлт сэдвүүдийг танилцуулдаг.

- Гишүүдийн олон үүргийн эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлэх ур чадварын сургалтуудыг нэвтрүүлж, хууль тогтоомжийн чухал асуудлаар семинар, бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулдаг.

## **КАМБОЖ**

Сүүлийн 30 жилийн хугацаанд Камбож улс тогтвортгуй хүнд үеийг туулсан нь улс төрийн шинэ дэглэмрүү шилжиж парламентын байгууллагууд нь институцийн болон бүтцийн өөрчлөлтөд орсонтой холбоотой.<sup>169</sup> 1970 онд Камбож нь хоёр парламенттай монарх засаглалтай байсан ба 1970-1975 онд хоёр парламенттай Бүгд Найрамдах Улс, 1975-1979 онуудад нэг парламенттай коммунист дарангуйлагч дэглэмтэй, 1979-1993 онд нэг парламенттай социалист дэглэмтэй, 1993 оноос хойш Камбож улс Үндсэн хуульт хаант засаглалтай болсон. Олон давтамжтай, огцом өөрчлөлт нь парламент болон бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сулруулсан ба үүнтэй уялдуулж парламентын чадавхыг хөгжүүлэх чадваржуулах сургалт зохион байгуулахаас гадна богино, дунд урт хугацааны төлөвлөгөө гаргасан.<sup>170</sup> Шинээр сонгогдсон гишүүдийн сургалт, хөтөлбөр нь Парламентыг чадавхжуулах богино хугацааны төлөвлөгөөнд багтдаг. 2008 оны Үндэсний Ассамблейн сонгууль болон 2012 оны сенатын сонгуулиас хойш Ассамблейн тамгын газартай хамтран шинээр сонгогдсон гишүүдэд 7 хоногийн турш тэдний үүрэг, парламентад үзүүлэх нөлөө хариуцлагын талаар сургалт зохион байгуулдаг.<sup>171</sup>

### *Богино хугацааны парламентын чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө*

- Хууль тогтоох үүргийг бэхжүүлэх;
- Гүйцэтгэх засаглалыг хянах хяналтыг бэхжүүлэх;
- Хууль боловсруулах журам;
- Парламентын шинэ гишүүдэд зориулсан сургалт;
- Парламентын албан хаагчдын сургалт, чадавхийг бэхжүүлэх.
- Хүний нөөц, байгууллагын хөгжлийг бэхжүүлэх
  - Парламентын албан хаагчдын сургалт, чадавхийг бэхжүүлэх;
  - Парламентын үр нөлөөг дээшлүүлэх стратеги.
- Хуулийн шинжилгээ болон судалгаа;
- IT чиглэлийн судалгаа (Интернет, Вебсайт, Мэдээлэл хянах-удирдах, ашиглах, дүн шинжилгээ хийх);
- Гадаад хэлний мэдлэг (франц, англи) орчуулах, бичих чадвар сайжруулах сургалт;
- Санхүүгийн менежментийн мэдлэг, төсөв төлөвлөлт, аудитын чиглэлээр мэргэшсэн ажилтнуудыг чадавхжуулах;
- Манлайлал, протокол, олон улсын харилцаа гэх мэт бусад ур чадвар төрийн захиргаа, улсын санхүү, хяналт шалгалт, стратегийн төлөвлөлт;
- Протокол хөтлөх, мэдээлэл боловсруулах, мэргэшсэн сургагч багш бэлтгэх
- Олон улсын парламентын туршлага солилцох;
- Хуулийн талаар орон нутагт мэдлэг олгох сургалт;
- Бүс нутгийн засаг захиргаа болон тамгын газрын чадавхыг сайжруулах.

### *Дунд хугацааны парламентын чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө*

- Хууль шалгах дүрэм журам;
- Комиссын түвшний стратеги төлөвлөгөө;

<sup>169</sup> Strategic Framework and Action Plan for the capacity building of the Cambodian Parliament page 4.

<sup>170</sup> Strategic Framework and Action Plan for the capacity building of the Cambodian Parliament page 10.

<sup>171</sup> Strategic Framework and Action Plan for the capacity building of the Cambodian Parliament page 13.

- Төсвийн үүргийг бэхжүүлэх (budget process);
- Мэдээлэл, олон нийттэй харилцах.

*Урт хугацааны парламентын чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө*

- Танхимын чадавхыг бэхжүүлэх;
- Төсөв боловсруулах, хянах үүрэг;
- Парламентын аудитын чадавхийг хөгжүүлэх;
- Парламентын гишүүдийн төлөөлөх чадварыг хангах.

## **ШОТЛАНД**

Шотланд Улсын парламентын байгууллага Scottish Parliamentary Corporate Body (SPCB) нь Шотландын парламентын засаг захиргааны ажлыг хариуцдаг байгууллага юм. Мөн комиссын гишүүдэд үйлчилгээ үзүүлэх, парламентын тогтоосон бусад томилгоонд үүрэг гүйцэтгэдэг. 2016 оны Шотланд Улсын бүх нийтийн сонгууль 2016 оны 5-р сарын 5-ны өдөр болсон.

2016 оноос өмнөх сонгуулиудын дараа Шотландын парламентын байгууллага (SPCB) нь шинээр сонгогдсон болон дахин сонгогдсон гишүүдийг албан ёсоор дэмжиж ажиллах зорилгоор гишүүдэд оффисын хуваарилалт, мэдээллийн технологийн үйлчилгээ, ажилчдыг ажиллуулахад шаардлагатай бүх хэрэгслийг хангах үүрэгтэй байсан.

2016 оны сонгуулийн дараа шинээр сонгогдсон гишүүдэд чиглэсэн хөтөлбөрийг Шотландын парламентын байгууллага (SPCB) нь шинээр сонгогдсон гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд нь туслах, парламентын үйл явц, горимын талаар дэлгэрэнгүй танилцуулах зорилготой юм.

Шотландын парламентын байгууллага (SPCB) нь Сонгуулийн дараа 5-р сарын 9-өөс 5-р сарын 12-ны хооронд дөрөв хоногийн хугацаатай чиг баримжaa олгох сургалтыг дараах хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.<sup>172</sup>

### Өдөр 1

- 09.00: Бүртгэл/Ордны танилцуулга/
- 12.30: Өдрийн хоол
- 14.00: Зураг авалт
- 14.15: Танхимын чиг үүргийн стандарт /Chamber business standards and interest/
- 16.30: Хаалт
- 18.30: Оройн хүлээн авалт

### Өдөр 2

- 14.00: Ажлын алба байгуулах/Setting up an office/
- 16.30: Хаалт

### Өдөр 3

- 14.00: Байнгын хороод, Хууль тогтоомжийн танилцуулга
- 16.00: Хаалт
- 18.00: Киркийн парламент Kirking of the Parliament

### Өдөр 4

- 10:00: Анхдугаар хуралдаан/First meeting of the Parliament/
- 14.00: Хурал даргалах дарга сонгох/Election of Presiding Officer/



<sup>172</sup> [http://www.parliament.scot/SPCB/SPCB\(2015\)Paper\\_0071.pdf](http://www.parliament.scot/SPCB/SPCB(2015)Paper_0071.pdf)

## **ЭНЭТХЭГ**

Энэтхэгийн Парламентын сургалт, судалгааны товчоо Bureau of Parliamentary Studies and Training (BPST) нь 1976 онд Лок Сабха /Lok Sabha/ Нарийн бичгийн даргын удирдлага дор байгуулагдсан бөгөөд товчоо нь судалгааны ажил гүйцэтгэхээс гадна Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад хууль тогтоогчийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд тодорхой чиглэлээр сургалт явуулдаг.

Энэхүү товчоо нь Парламентын гишүүд болон Парламентын албаны ажилтнууд, Засгийн газрын дунд шатны ажилтнууд болон бусад төрийн байгууллагын албан хаагчдад сургалт явуулна. Мөн түүнчлэн товчоо нь Парламентын албан хаагчдад зориулсан Парламентын дадлагажигч хөтөлбөр, Хууль тогтоох, боловсруулах талаар хоёр олон улсын сургалтын хөтөлбөрийг зохион байгуулдаг.

2019 оны Энэтхэгийн бүх нийтийн сонгууль 2019 оны 4-р сарын 11-нээс 5-р сарын 19-ний хооронд долоон үе шаттайгаар явагдаж, саналыг тоолж, үр дүнг 5-р сарын 23-нд зарласан. Парламентын судалгаа, сургалтын товчоо (BPST), Лок Сабхагийн Нарийн бичгийн даргын дор шинээр сонгогдсон гишүүдэд чиглүүлэх хөтөлбөрийг Нью Дели хотын Парламентын ордны “Аннести”ронд 7-р сарын 3,4-ний өдрөөс 7-р сарын 9, 10-ны хооронд зохион байгуулсан.

- 7-р сарын 3-ны өдөр болох нээлтийн ажиллагаанд Лок Сабхагийн дарга, Холбооны Батлан хамгаалахын сайд, Энэтхэгийн үндэсний конгрессийн гишүүн нар шинээр сонгогдсон гишүүдэд үг хэлнэ.
- 7-р сарын 4-ний өдөр Холбооны дотоод хэргийн сайд (*Union Minister of Home Affairs*): "Хэрхэн үр дүнтэй парламентчин байх вэ?", Зам тээвэр, хурдны зам, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн сайд (*Union Minister of Road Transport & Highways and Micro, Small & Medium Enterprises*): "Танхимд асуудлыг хэлэлцэх парламентын асуулт, дэг журам" сэдвээр
- 7-р сарын 9-ний өдөр “Хууль эрх зүйн үйл явц - Хуулийн төсөл”, Төмөр зам, худалдаа, аж үйлдвэрийн холбооны сайд (*Union Minister of Railways, Commerce & Industry*) Төсвийн үйл явц,”Парламентын хороод (түүний дотор Санхүүгийн хороо зэрэг)” сэдвээр
- 7-р сарын 10-ны өдөр Хууль зүй, Хууль зүй, Электроник, мэдээллийн технологи, харилцаа холбооны сайд (*Union Minister of Law & Justice, Electronics & Information Technology and Communication*) “Хууль тогтоомжийг хэрхэн яаж хийх вэ”, “Парламентын эрх ба ёс зүй” сэдвээр
- Лок Сабхагийн нарийн бичгийн дарга нар нь гишүүддээ:
  - Цахим Парламент- Гишүүдийн портал;
  - Цалин, тэтгэмж, тэтгэвэр, гишүүдэд үзүүлэх үйлчилгээ (орон сууц, тээвэр, эмнэлгийн байгууламж гэх мэт);
  - Парламентын судалгаа, номын сан ба гишүүдийн лавлагаа үйлчилгээ сэдвээр тус тус 4 хоногийн сургалт зохион байгуулсан байна.<sup>173</sup>

## **ПАКИСТАН УЛС**

Пакистан Улсын парламентын үйлчилгээний институт (*Pakistan Institute for parliamentary services-PIPS*) нь хууль тогтоох байгууллагын чиг үүргийг дэмждэг зохион байгуулалтын нэгжүүдийн менежментийг сайжруулах зорилгын хүрээнд байгуулагдсан.<sup>174</sup>

<sup>173</sup> <https://theindianawaaz.com/lok-sabha-secretariat-organises-orientation-programme-for-newly-elected-members/>

<sup>174</sup> <https://www.pips.gov.pk/services/capacity-building-and-skill-development-services>

Парламентын үйлчилгээний институт нь Парламентын гишүүдэд зориулан дараах сургалтын модулийн хүрээнд чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Процедурын дүрэм (*Rules of procedure*);
- Парламентын үйл ажиллагаа;
- Асуулт хариултын цаг;
- Хууль тогтоох үйл явц;
- Хууль тогтоох хүрээг судалж тооцох;
- Төсвийн явц, дүн шинжилгээ;
- Байнгын хорооны үйл ажиллагаа;
- Олон нийтийн сонсгол. (Нэмж дурдахад тус институт нь парламентын тамгын газрын удирдлага, хороодын ажилтнууд болон парламентын хүний нөөцийн менежментийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт нэмэлтээр зохион байгуулдаг.)

Шинэ гишүүдийн чиглүүлэх сургалтаас гадна ач холбогдол бүхий 23 чиглэлээр парламентын гишүүдийг чадавхжуулах сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулдаг. Сургалтын модулиуд нь PIPS сургалтын стандарт, журамд үндэслэсэн болно. PIPS сургалтын хөтөлбөрт дараах сургалтын аргачлалыг ашигладаг. Үүнд:

- Сургагч багшаар ахлуулсан хэлэлцүүлэг;
- Лекц унших;
- Бүлгийн хэлэлцүүлэг;
- Санал бодол солилцох (*Brainstorming*);
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ;
- Сэтгэхүй дасгал (*Associative Thinking Exercise*);
- Кейс ;
- Тайлан дээрх хэлэлцүүлэг (*Commenting on Statements*);
- Оролцогчид илтгэх тавих.

Сургалтын хөтөлбөрийг чанаржуулахын тулд олон улсын хууль тогтоох экспертуудийг Пакистан Улсын хууль тогтоох экспертуудтэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг ба Висконсиний Сенатын(Wisconsin Senate) тэтгэвэрт гарсан нарийн бичгийн дарга, олон улсын төсвийн шинжээч, хууль тогтоох, боловсруулах төслийг хариуцсан мэргэжилтнүүд, Пакистаны хуучин хууль тогтоогчид, Пакистаны Нарийн бичгийн дарга, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг сургагч багшаар томилдог.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Congressional Research Service, Annual report 2015  
[https://www.loc.gov/crsinfo/about/crs15\\_anrpt.pdf](https://www.loc.gov/crsinfo/about/crs15_anrpt.pdf)
- Harvard partners with 3 think tanks for Congressional Training program,  
<http://www.thinktankwatch.com/2016/03/harvard-partners-with-3-think-tanks-for.html>
- <http://australianpolitics.com/2013/10/15/orientation-day-for-new-members-of-the-house-of-representatives.html>
- [http://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Parliamentary\\_Service\\_Legislation/PSC\\_Annual\\_Report\\_2013-14/Administration\\_of\\_the\\_Parliamentary\\_Service](http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Service_Legislation/PSC_Annual_Report_2013-14/Administration_of_the_Parliamentary_Service)
- [http://www.asgp.co/sites/default/files/documents//OKHNEALGPJGGSOTUSVLBXNES\\_COY\\_HAR.pdf](http://www.asgp.co/sites/default/files/documents//OKHNEALGPJGGSOTUSVLBXNES_COY_HAR.pdf)
- [http://www.asgp.co/sites/default/files/documents//TXBWIWDRWMKOJDRSJPF LZLTN\\_RVC PHI.doc](http://www.asgp.co/sites/default/files/documents//TXBWIWDRWMKOJDRSJPF LZLTN_RVC PHI.doc)
- <http://www.parl.gc.ca/About/House/OntheJob/Orientation-NewMP-e.html>
- <http://www.parliamentofindia.nic.in/lsls/intro/p10.htm>
- <https://www.parliament.nz/en/get-involved/features-pre-2016/document/00NZPHomeNews201409221/induction-for-new-members-of-parliament#RelatedAnchor>
- Introduction of the new members of the Parliament: The role of the Secretariat, Association of Secretaries Generals of the Parliament, New member resource center, Congressional Management Foundation,  
<http://www.congressfoundation.org/congressional-operations/new-member-resource-center>
- Newly elected members of congress, Harvard, Kennedy School,  
<http://iop.harvard.edu/get-inspired/newly-elected-members-congress>
- RULES of the HOUSE OF REPRESENTATIVES ONE HUNDRED FOURTEENTH CONGRESS (JANUARY 6, 2015)  
<http://clerk.house.gov/legislative/house-rules.pdf>



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫГ ТОМИЛОХТОЙ ХОЛБООТОЙ БҮРЭН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

О.Нарантуяа

Улсын Их Хурлын дарга нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан 22 бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд үүний дотор зарим байгууллагын удирдлагыг томилох, санал болгох бүрэн эрхтэй.

Холбогдох 8 хуульд зааснаар УИХ дарга нь 7 байгууллагын удирдах албан тушаалтанд томилуулахаар санал болгож, тэднийг УИХ томилж, чөлөөлж байна. Ирээдүйн өв сангийн тухай хуульд зааснаар Хяналтын зөвлөлд өөрийн сонгосон хүнээ мөн санал болгоно.

УИХ дарга нь өөрийн зөвлөхүүдийг томилж байна.

## Монгол Улсын Үндсэн хууль

Хорин тавдугаар зүйлийн 6-д “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар УИХ-д ажлаа хариуцан тайлagnадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах” онцгой бүрэн эрхтэй.

## Улсын Их Хурлын тухай хууль

11 дүгээр зүйл. УИХ-ын даргын бүрэн эрх  
11.1.16.хуульд өөрөөр заагаагүй бол УИХ-д ажлаа шууд хариуцан тайлagnадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох санал гаргаж ...”

Санал болгох бүрэн эрх

Томилох бүрэн эрх

Доорх хүснэгтэд заасан албан тушаалтнуудыг санал болгоно

УИХ-ын тухай хууль

11.1.18.УИХ-ын даргын зөвлөхүүдийг ажилд томилох, чөлөөлөх шийдвэр гаргах

	<b>Хуулийн нэр</b>	<b>Зохицуулалтын агуулга</b>
<b>1</b>	Төв банкны тухай хууль	<b>26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага</b> 1. ... Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.
<b>2</b>	Улсын Их Хурлын тухай хууль	<b>11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх</b> 11.1.21.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх; <b>40 дүгээр зүйл. Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга</b> 40.1. Тамгын газрыг хууль зүй, улс төрийн өндөр мэргэшил бүхий Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө.
<b>3</b>	Төрийн аудитын тухай хууль	<b>13 дугаар зүйл. Ерөнхий аудитор</b> 13.1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно.
<b>4</b>	Хүний эрхийн үндэсний комиссын тухай	<b>13 дугаар зүйл. Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа</b> 13.4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.
<b>5</b>	Сонгуулийн төв байгууллагын тухай	<b>4 дүгээр зүйл.Хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журам</b> 4.3.Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно.
<b>6</b>	Статистикийн тухай	<b>13 дугаар зүйл. Үндэсний статистикийн хорооны удирдлага</b> 1.Үндэсний статистикийн хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаагаар томилно.
<b>7</b>	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	11.2.Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, ... нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилно.
<b>8</b>	Ирээдүйн өв сангийн тухай	<b>15 дугаар зүйл. Хяналтын зөвлөл</b> 15.5.2.Монгол Улсын Их Хурлын даргын сонгосон санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээний туршлагатай, нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;

**АВСТРАЛИИ, БНСУ-ЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ЦАЛИН ХӨЛС,  
НЭМЭГДЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ**

*O.Нарантуяа, Р.Нургүл*

**АГУУЛГА**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

- Австрали улсын Парламентын ажлын алба
- БНСУ-ын Үндэсний Ассамблейн Тамгын газар

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

Улсын Их Хурлын 2019 оны 12-р сарын 20-ны өдрийн 106-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө” (цаашид Стратеги төлөвлөгөө гэх)-г хэрэгжүүлэх хүрээнд Стратеги төлөвлөгөөний 6.1 “УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж чадавхыг бэхжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** Австрали болон БНСУ-ын Парламентын ажлын албадын цалин хөлсний систем, нэмэгдлийн талаарх туршлагыг судалж харьцуулсан лавлагаа, мэдээлэл бэлтгэх, улмаар УИХ-ын Тамгын газраас уг стратегийн зорилтыг хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг тодорхойлоход арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгааны явцад Австрали болон БНСУ-ын парламентын ажлын албаны албан хаагчдын цалин хөлс болон нэмэгдлийн талаарх эрх зүйн зохицуулалт, цалин урамшууллын хэлбэр, хэмжээ, системийн талаарх туршлагыг судлав.

**Судалгааны үр дүн:** Австрали, БНСУ зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудад парламентын үндсэн чиг үүргийг хариуцлагатай, чанартай хэрэгжүүлж хүчирхэг, ардчилсан парламентын засаглалыг төлөвшүүлэхэд парламентын ажлын албаны мэргэшсэн байдал, албан хаагчдын цалин хөлс, урамшууллын систем, зохицуулалт, удирдлага, менежментийн арга барил чухал болох нь харагдаж байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 1. Австрали улсын парламентын ажлын алба

Парламентын ажлын алба (*Department of Parliamentary Services*) нь Австралийн төрийн албанаас тусдаа бие даасан статустай бөгөөд эдгээр албад тус тусын хуулиар зохицуулагдана<sup>175</sup>.

Парламентын ажлын алба нь Парламентын ажлын албаны тухай хууль (*Parliamentary Service Act 1999*), Төрийн алба нь Төрийн албаны тухай хуулийг (*Public Service Act 1999*) тус тус дагаж мөрддөг.

**Төрийн албаны албан тушаалын ангилал** нь Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны албан тушаалын ангиллын тухай журмаар (*Public Service Classification Rules 2000*) зохицуулагдана.

Төрийн албаны тухай хуульд Комиссар буюу Төрийн албаны комиссын тэргүүн нь хууль тогтоомжийн дагуу Төрийн албаны албан тушаалын ангиллын журмыг тогтооно гэж заасан<sup>176</sup>.

**Парламентын ажлын албаны албан тушаалын ангиллыг** Парламентын ажлын албаны тухай хууль болон Парламентын ажлын албаны албан тушаалын ангиллын тухай журмаар (*Parliamentary Service Classification Rules 2010*) зохицуулж байна.

Энэхүү журмыг Парламентын ажлын албаны Комиссартай (Төрийн албаны комиссын тэргүүн) зөвлөлдөж хууль тогтоомжийн дагуу Төлөөлөгчдийн танхимын дарга болон Сенатын дарга тогтооно<sup>177</sup>.

Жич: Парламентын ажлын албаны Комиссар нь Парламентын удирдлагад тус албаны удирдлагын бодлого, туршилагын талаар зөвлөх, мөн тэдний хүсэлтээр тус албатай холбоотой асуудлыг хянан шалгаж тайлагнах чиг үүрэгтэй байна<sup>178</sup>. Түүнийг Парламентын ажлын албаны тухай хуулийн дагуу Парламентын удирдлага томилох бөгөөд Төрийн албаны комиссын тэргүүний үргийг давхар гүйцэтгэнэ<sup>179</sup>.

Энэ 2 албаны албан тушаалын ангилал нь ялгаатай бөгөөд Парламентын ажлын алба нь **PSL** (*Parliamentary Service Level*), Төрийн алба нь **APS** (*Australian Public Service*) ангилалд хамаарна.

*Парламентын ажлын алба болон Ерөнхий сайд, Засгийн газрын ажлын албаны ажилтнуудын албан тушаалын ангилал, цалингийн хэмжээ*

**Парламентын ажлын алба.** Энэ нь PSL ангилалд хамрагдах бөгөөд ажилтнуудын албан тушаалын ангилал болон цалингийн хэмжээг Хүснэгт 1 болон Хүснэгт 2-т харуулав.

<sup>175</sup> <https://www.apsc.gov.au/movement-between-parliamentary-service-and-aps>

<sup>176</sup> Төрийн албаны тухай хууль (*Public Service Act 1999*), 23.1 дүгээр зүйл  
<https://www.legislation.gov.au/Details/C2013C00310>

<sup>177</sup> Парламентын ажлын албаны тухай хууль (*Parliamentary Service Act 1999*.) 23.1 дүгээр зүйл,  
<https://www.legislation.gov.au/Details/C2019C00092>

<sup>178</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Parliamentary\\_Service\\_Commissioner\\_and\\_Parliamentary\\_Service\\_Merit\\_Protection\\_Commissioner](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Service_Commissioner_and_Parliamentary_Service_Merit_Protection_Commissioner)

<sup>179</sup> Парламентын ажлын албаны тухай хууль (*Parliamentary Service Act 1999*.) 5 дугаар бүлэг, 43 дугаар зүйл  
<https://www.legislation.gov.au/Details/C2015C00157>

**Хүснэгт 1. Парламентын ажлын албаны албан тушаалын ангилаал болон цалингийн хэмжээ<sup>180</sup>**

Ангилал	2014 оны 6-р сарын байдлаар	Гэрээ хэрэгжсэн өдөр	12 сарын дараа	18 сарын дараа
PSL 1		\$44,913	\$45,811	\$46,270
PSL 1.*		\$46,485	\$47,415	\$47,889
PSL 1.*		\$48,113	\$49,074	\$49,565
PSL 1.4	\$47,480	\$48,904	\$49,882	\$50,381
PSL 1.5	\$49,142	\$50,616	\$51,628	\$52,145
PSL 1.6	\$50,862	\$52,388	\$53,435	\$53,970
PSL 1.7	\$52,642	\$54,221	\$55,306	\$55,859
PSL 1.8	\$54,484	\$56,119	\$57,241	\$57,814
PSL 1.9	\$55,297	\$56,956	\$58,095	\$58,676
* Энэ нийтийн захьин Парламентийн хөтөлбөр үзүүлжилтийн замжилтийн				
PSL 2		\$56,404	\$58,096	\$59,258
PSL 2.1		\$58,378	\$60,129	\$61,332
PSL 2.2		\$60,552	\$62,369	\$63,616
PSL 3				
PSL 3.1	\$61,900	\$63,757	\$65,032	\$65,682
PSL 3.2	\$64,685	\$66,626	\$67,958	\$68,638
PSL 4				
PSL 4.1	\$65,978	\$67,957	\$69,316	\$70,010
PSL 4.2	\$68,287	\$70,336	\$71,743	\$72,460
PSL 4.3	\$70,677	\$72,798	\$74,254	\$74,996
PSL 4.4	\$71,693	\$73,844	\$75,321	\$76,074
PSL 5				
PSL 5.1	\$73,126	\$75,320	\$76,826	\$77,594
PSL 5.2	\$75,685	\$77,956	\$79,515	\$80,310
PSL 5.3	\$78,452	\$80,806	\$82,422	\$83,246
PSL 6				
PSL 6.1	\$80,020	\$82,421	\$84,069	\$84,910
PSL 6.2	\$82,821	\$85,305	\$87,011	\$87,882
PSL 6.3	\$85,719	\$88,291	\$90,057	\$90,957
PSL 6.4	\$88,720	\$91,381	\$93,209	\$94,141
PSL 6.5	\$89,937	\$92,635	\$94,488	\$95,433
PEL 1				
PEL 1.1	\$97,379	\$100,300	\$102,306	\$103,329
PEL 1.2	\$100,287	\$103,811	\$105,887	\$106,946
PEL 1.3	\$104,315	\$107,444	\$109,593	\$110,689
PEL 1.4	\$107,966	\$111,205	\$113,429	\$114,563
PEL 1.5	\$111,183	\$114,518	\$116,809	\$117,977
PEL 2				
PEL 2.1	\$113,405	\$116,807	\$119,143	\$120,335
PEL 2.2	\$117,374	\$120,895	\$123,313	\$124,546
PEL 2.3	\$121,482	\$125,127	\$127,629	\$128,906
PEL 2.4	\$125,734	\$129,506	\$132,096	\$133,417
PEL 2.5	\$130,135	\$134,039	\$136,720	\$138,087
PEL 2.6*	\$134,370	\$138,504	\$141,274	\$142,687

\* PEL 2.\* нь зөвхөн гүйцэтгэлийн ийндр үзүүлэгчээс зурсан "Байгууллагын гэрээ 2017"-ийн бүсэгийн замжилтийн менежментийн салбарын дагуу хөгжлийн салбарт зөвхөн ийндр үзүүлэгчээс зурсан.

**Хүснэгт 2. Парламентын ажлын албаны албан тушаалын ангилаал болон цалинг нэгжж бүрээр ялгаж харуулав<sup>181</sup>:**

Ангилал		2014 оны 6-р сарын байдлаар	Гэрээ хэрэгжсэн өдөр	12 сарын дараа	18 сарын дараа
<b>Тохиижилт ўйлчилгээ (PSL 1/2/3)</b>					
PSL 1	1	\$52,127	\$53,691	\$54,765	\$55,312
	2		\$55,570	\$56,681	\$57,248
	3	\$54,617	\$56,256	\$57,381	\$57,954
PSL 2	1	\$56,459	\$58,153	\$59,316	\$59,909
	2	\$58,435	\$60,188	\$61,392	\$62,006
	3	\$60,552	\$62,369	\$63,616	\$64,252
PSL 3	1	\$61,900	\$63,757	\$65,032	\$65,682
	2	\$64,685	\$66,626	\$67,958	\$68,638
<b>Тохиижилт ўйлчилгээ (PSL 4/5)</b>					
PSL 4	1	\$65,978	\$67,957	\$69,316	\$70,010
	2		\$70,336	\$71,743	\$72,460
	3		\$72,798	\$74,254	\$74,996
	4	\$71,693	\$73,844	\$75,321	\$76,074
PSL 5	1	\$73,126	\$75,320	\$76,826	\$77,594
	2		\$77,956	\$79,515	\$80,310
	3	\$78,452	\$80,806	\$82,422	\$83,246
<b>Парламентийн хамгаалалтын алба (PSL 1/2)</b>					
PSL 1	1	\$52,127	\$53,691	\$54,765	\$55,312
	2		\$55,570	\$56,681	\$57,248
	3	\$54,617	\$56,256	\$57,381	\$57,954
PSL 2	1	\$56,459	\$58,153	\$59,316	\$59,909
	2		\$60,188	\$61,392	\$62,006
	3	\$60,552	\$62,369	\$63,616	\$64,252
<b>Цахижлан, механик засвар, обедлын ўйлчилгээ (PSL 2/3)</b>					
PSL 2	1	\$56,459	\$58,153	\$59,316	\$59,909
	2	\$57,944	\$59,682	\$60,876	\$61,485
PSL 3	1	\$62,610	\$64,488	\$65,778	\$66,436
	2	\$64,685	\$66,626	\$67,958	\$68,638
<b>Парламентийн нормын сан: Судалгааны нормы</b>					
		2014 оны 6-р сарын байдлаар	Гэрээ хэрэгжсэн өдөр	12 сарын дараа	18 сарын дараа
PSL 4	1	\$65,978	\$67,957	\$69,316	\$70,010
	2		\$70,336	\$71,743	\$72,460
	3		\$72,798	\$74,254	\$74,996

**PSL (Parliamentary Service Level) –**

**Парламентын ажлын албаны ажилтнуудын албан тушаалын ангилаал**

**PEL (Parliamentary Executive Level) – Удирдах албан тушаалын ангилаал**

**Parl AV буюу дүү, дурс болсон мультимедиа ўйлчилгээ**

	4	71,693	\$73,844	\$75,321	\$76,074
	1	\$73,126	\$75,320	\$76,826	\$77,594
	2		\$77,956	\$79,515	\$80,310
	3	\$78,452	\$80,806	\$82,422	\$83,246
Парламентийн нормын сан: Номын сан болсон мэдрээллийн санчийн ислийн толижилжилт ўйлчилгээ					
	4	71,693	\$73,844	\$75,321	\$76,074
	1	\$65,978	\$67,957	\$69,316	\$70,010
	2		\$70,336	\$71,743	\$72,460
	3		\$72,798	\$74,254	\$74,996
	4	\$71,693	\$73,844	\$75,321	\$76,074
	5	\$73,126	\$75,320	\$76,826	\$77,594
	6		\$77,956	\$79,515	\$80,310
	7	\$78,452	\$80,806	\$82,422	\$83,246
Тайланс, протоколын алба					
	4	71,693	\$73,844	\$75,321	\$76,074
	1	\$73,126	\$75,320	\$76,826	\$77,594
	2		\$77,956	\$79,515	\$80,310
	3	\$78,452	\$80,806	\$82,422	\$83,246
	4	\$80,020	\$82,421	\$84,069	\$84,910
	5		\$85,305	\$87,011	\$87,882
	6		\$88,291	\$90,057	\$90,957
	7		\$91,381	\$93,209	\$94,141
	8		\$89,937	\$92,635	\$94,488
	9		\$90,575	\$92,500	\$95,433

<sup>180</sup> Парламентын ажлын албаны "Байгууллагын гэрээ 2017" (Department of Parliamentary Services Enterprise Agreement 2017), хуудас 65

[https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Publications](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Department_of_Parliamentary_Services/Publications)

<sup>181</sup> Парламентын ажлын албаны "Байгууллагын гэрээ 2017" (Department of Parliamentary Services Enterprise Agreement 2017), хуудас 66-67

[https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Publications](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Department_of_Parliamentary_Services/Publications)

Парламентын ажлын албаны “Байгууллагын гэрээ 2017”-ын 42.1-р зүйлд заасны дагуу энэхүү гэрээ хэрэгжиж эхэлсэн өдрөөс цалин 3 хувиар, 12 сарын дараа 2 хувиар, 18 сарын дараа 1 хувиар тус тус нэмэгдүүлэхээр заасан.

Жич: *Байгууллагын гэрээ нь ажил олгогч, ажилтан, холбогдох холбоодын хооронд байгууллагдах бөгөөд гэрээнд ажилтнуудын ажиллах нөхцөл, цалин хөлс болон бусад зүйлийн талаар тусгана. Уг гэрээг 4 жилийн хугацаатай байгуулдаг<sup>182</sup>.*

**Ерөнхий сайд болон Засгийн газрын ажлын алба.** Энэ нь төрийн албаны APS (*Australian Public Service*) ангилалд хамрагдана. Тус албаны ажилтнуудын албан тушаалын ангилал, цалингийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 3. Ерөнхий сайд болон ЗГ-ын ажлын албаны албан тушаалын ангилал болон цалингийн хэмжээ<sup>183</sup>*

Ангилал		Байгууллагын гэрээ 2017-2020 хэрэгжихээс өмнө	Хэрэгжих өдөр (+3%)	12 сарын дараа (+2%)	18 сарын дараа (+0.9%)
EL2	ZoD	\$148,759	\$153,222	\$156,286	\$157,693
	EL2.4	\$140,471	\$144,685	\$147,579	\$148,907
	EL2.3	\$132,990	\$136,980	\$139,719	\$140,977
	EL2.2	\$125,508	\$129,273	\$131,859	\$133,045
	EL2.1	\$118,027	\$121,568	\$123,999	\$125,115
EL1	ZoD	\$123,603	\$127,311	\$129,857	\$131,026
	EL1.4	\$115,572	\$119,039	\$121,420	\$122,513
	EL1.3	\$110,849	\$114,174	\$116,458	\$117,506
	EL1.2	\$106,127	\$109,311	\$111,497	\$112,500
	EL1.1	\$101,404	\$104,446	\$106,535	\$107,494
APS6	ZoD	\$97,137	\$100,051	\$102,052	\$102,971
	APS6.4	\$88,675	\$91,335	\$93,162	\$94,000
	APS6.3	\$85,941	\$88,519	\$90,290	\$91,102
	APS6.2	\$82,816	\$85,300	\$87,006	\$87,790
	APS6.1	\$78,908	\$81,275	\$82,901	\$83,647
APS5	APS5.4		\$78,559	\$80,130	\$80,851
	APS5.3	\$76,271	\$76,803	\$78,339	\$79,044
	APS5.2	\$72,862	\$75,048	\$76,549	\$77,238
	APS5.1	\$71,342	\$73,482	\$74,952	\$75,626
APS4	APS4.4		\$71,176	\$72,600	\$73,253
	APS4.3	\$69,103	\$69,638	\$71,031	\$71,670
	APS4.2	\$66,417	\$68,410	\$69,778	\$70,406
	APS4.1	\$64,615	\$66,553	\$67,885	\$68,495
APS3	APS3.3		\$63,726	\$65,001	\$65,586
	APS3.2	\$61,870	\$62,684	\$63,938	\$64,513
	APS3.1	\$59,400	\$61,182	\$62,406	\$62,967
APS2	APS2.4		\$58,380	\$59,548	\$60,084
	APS2.3	\$56,680	\$57,303	\$58,449	\$58,975
	APS2.2	\$55,634	\$56,119	\$57,241	\$57,757
	APS2.1	\$53,190	\$54,786	\$55,881	\$56,384
APS1	APS1.3		\$51,001	\$52,022	\$52,490
	APS1.2	\$49,516	\$49,311	\$50,297	\$50,750
	APS1.1	\$45,286	\$46,645	\$47,577	\$48,006

**APS (Australian Public Service) – Төрийн албаны ажилтнуудын албан тушаалын ангилал**

<sup>182</sup> <http://www.cwu.org.au/what-is-an-enterprise-agreement.html#EA>

<https://www.fwc.gov.au/enterprise-agreements-benchbook/what-is-an-enterprise-agreement>

<sup>183</sup> Ерөнхий сайд болон Засгийн газрын ажлын албаны “Байгууллагын гэрээ” (Enterprise Agreement 2017-2020) хуудас 22-23, <https://www.pmc.gov.au/resource-centre/pmc/enterprise-agreement-2017-2020>

**EL** (Execute Level) – Удирдах албан тушаалын ангилал

Ерөнхий сайд болон Засгийн газрын ажлын албаны “Байгууллагын гэрээ 2017-2020”-ын 188-р зүйлд заасны дагуу энэхүү гэрээ хэрэгжиж өдрөөс цалин 3 хувиар, 12 сарын дараа 2 хувиар, 18 сарын дараа 0.9 хувиар тус тус нэмэгдүүлэхээр заасан байна<sup>184</sup>.

## 2.БНСУ-ЫН Үндэсний Ассамблейн Тамгын газар

БНСУ-ЫН Үндэсний Ассамблейн Тамгын газар нь нийт 3483 албан хаагчтай. Үүнд:

- Ерөнхий нарийн бичгийн дарга болон дэд дарга буюу нарийн бичгийн дарга-4 хүн
- YA гишүүдийн зөвлөх, туслах-2221 хүн
- Төрийн албан хаагч (энд 1-9 дүгээр түвшний бүх төрийн албан хаагчид хамаарна)-1258 хүн ажилладаг.

Дээрх албан хаагчдийн эрх зүйн байдлыг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг.

- Үндэсний Ассамблейн тухай хууль
- Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай, Судалгааны албаны тухай, Номын сангийн тухай, Төсвийн албаны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн албаны боловсон хүчний хөгжлийн тухай хууль
- Төрийн албан хаагчийн цалин хөлслний журам
- YA Тамгын газрын хүний нөөцийн журам

YA Тамгын газрын төрийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу 1-9 дүгээр түвшний төрийн албан хаагчид болон гэрээт албан хаагчид байдаг. 5 болон түүнээс дээш түвшний албан хаагчийг YA дарга томилох бөгөөд 5 дугаар түвшинээс дооших албан хаагчийг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга томилно. Гэхдээ YA дарга зарим албан хаагчийг томилох бүрэн эрхээ Ерөнхий нарийн бичгийн даргад шилжүүлж болно.

Гэрээт албан хаагчид нь энгийн гэрээт албан хаагч-тамгын газрын чиг үүрэгт заасан албан тушаалд ажиллаж байгаа албан хаагч, тусгай нөхцөлөөр ажиллах албан хаагч-тодорхой чиглэлээр мэргэшсэн мэдлэг, ур чадвар шаарддаг ажил гүйцэтгүүлэхээр хугацаатай томилогдсон албан хаагч, хагас цагийн ажилтан-долоо хоногт 15 цаг, 35 цагаас багаар хугацаатай ажиллах албан хаагч, цагийн ажилтан-төрийн албан хаагчийн үүргийг гүйцэтгэхээр 1.6 жил хүртэл хугацаагаар томилогдсон, төрийн албаны тухай хуулийн дагуу ердийн ажлын цагаар ажиллах албан хаагчийг хэлнэ.

*Тамгын газрын ажилтнуудад тавигдах ерөнхий шаардлага:*

### 1. Ажлын байранд тавигдах шаардлага

- Ажлын төрөл, мэргэжлийн байдал
- Ажилд шаардлагатай ур чадварын түвшин
- Ажилд шаардлагатай хувь хүний шинж чанарууд
- Ажлын зохион байгуулалтын жин
- шаардлагатай бусад нөхцөл

### 2. Төрийн албан хаагчид тавигдах шаардлага

- Карьер, боловсрол, мэргэжил
- Сургалтын гүйцэтгэл
- Шийдвэр гаргах болон ажил гүйцэтгэх ур чадвар

<sup>184</sup> Ерөнхий сайд болон Засгийн газрын ажлын албаны “Байгууллагын гэрээ” (Enterprise Agreement 2017-2020) хуудас 21, <https://www.pmc.gov.au/resource-centre/pmc/enterprise-agreement-2017-2020>

- Манлайллын чадвар
- Зан ааш болон итгэл даах чадвар
- Шударга байдал
- эрүүл мэнд
- бусад шаардлагатай зүйл.

Тамгын газар нь сул орон too гарсан тохиолдолд төрийн албан хаагчийн шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгүүлсэн хүнээс сонгоно. Нөөцөд байх хугацаа 2 жил.

Тухайн сул орон too гарсан албан тушаалын чиг үүргээс хамаарч тусгай шаардлага тавих бол энэхүү шаардлагыг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно. Төрийн албан хаагчийн нөөцөд байгаа хүнээс ажилд аваходаа тусгай шалгалтыг YA боловсон хүчний хороо шалгаруулж авна. Тус хороонд Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга болон 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Шалгалт өгч тэнцсэн албан хаагч зөвхөн тухай албан тушаал дээр ажиллах бөгөөд өөр ажил, албан тушаал дээр ажиллахыг хориглоно. Шалгалтад тэнцсэн албан хаагч нь ажиллахад шаардлагатай сургалт, практик олгох богино хугацааны сургалтад хамруулдаг.

Харин судалгааны ажилтанд тавих шалгуурт дараах хугацааг хангасан байхыг шаарддаг. Албан тушаалаас хамаарч судалгааны ажлын дадлага, туршлага нь 7-15 жил судалгааны чиглэлээр ажилласан байхыг шаарддаг.

Үндэсний Ассамблейн Тамгын газар, Судалгааны алба, Номын сан болон Төсвийн алба нь бие даасан статустай, өөрийн харьялах төсөвтэй байдаг. Тиймээс харьялах дарга нь ажлын байрны орон too гарсан тохиолдолд ажил горилогчид тавих тусгай шаардлагыг боловсруулах эрхтэй байдаг.

### **Цалин хөлс, нэмэгдлийн талаар**

Тамгын газрын төрийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн цалин хөлсний журамд зааснаар үндсэн цалинг тогтоох бөгөөд төрийн албан хаагчийн нэмэгдэлтэй холбоотой харилцааг Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журмаар зохицуулдаг.

### **Цалин хөлс**

Төрийн албан хаагчийн үндсэн цалингийн шатлал болон гэрээт албан хаагчийн цалингийн хэмжээг хүний нөөц хариуцсан дарга тогтооно.

**Тамгын газрын удирдах албан тушаалтны цалин** (1 жилээр тооцсон цалингийн хэмжээ)

	Цалингийн дээд хэмжээ	Цалингийн доод хэмжээ
Удирдах албан тушаалтан	110,428,000 вон	103,611,000 вон

**Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ** (нэг сарын үндсэн цалингийн хэмжээ)  
(Воноор)

Албан тушаалын түвшин	Цалингийн доод хэмжээ	Цалингийн дээд хэмжээ
1 дүгээр түвшин (хэлтэс, албаны дарга, захирлууд хамаарна)	4,081,400	7,013,700
2 дугаар түвшин (дэд дарга, дэд захирал болон түүнтэй адилтгах албан тушаалтан хамаарна)	3,674,300	6,449,500
3 дугаар түвшин	3,314,900	5,946,500

4 дүгээр түвшин	2,841,100	5,310,500
5 дугаар түвшин	2,538,900	4,923,900
6 дугаар түвшин	2,094,500	4,354,700
7 дугаар түвшин	1,879,600	3,941,500
8 дугаар түвшин	1,675,800	3,571,700
9 дүгээр түвшин	1,642,800	3,270,500

**Парламентын гишүүний ажлын албаны албан хаагчид**  
**(Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээгээр дүйцүүлэн цалинждаг)**  
**(Воноор)**

Албан тушаалын түвшин	Цалингийн хэмжээ
Гишүүний туслах	4,970,100 (4 түвшний 21 зэрэглэл)
Гишүүний нарийн бичгийн дарга	4,685,400 (5 түвшний 24 зэрэглэл)
Гишүүний бусад нарийн бичиг болон туслах ажилтнууд	Төрийн албан хаагчийн 6-9 дүгээр түвшний цалингийн схемээр цалинждаг.

**Тамгын газрын 1-5 дугаар түвшний ажилтнуудын жилийн цалингийн хэмжээ**  
**(нэмэгдэл багтсан дүн)<sup>185</sup>**

Албан тушаалын түвшин	Цалингийн дээд хэмжээ	Цалингийн доод хэмжээ
1 дүгээр түвшин	110,428,000	73,609,000
2 дугаар түвшин	102,058,000	68,003,000
3 дугаар түвшин	64,159,000/95,510,000	56,974,000
4 дүгээр түвшин	50,783,000/87,373,000	47,564,000
5 дугаар түвшин	72,041,000	34,385,000

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны судлаачдын хувьд Тамгын газрын ажилтнуудаас өөр цалингийн сүлжээгээр цалинждаг.

(Сарын үндсэн цалин, воноор)

Албан тушаалын түвшин	Цалингийн дээд хэмжээ	Цалингийн доод хэмжээ
<b>Ахлах судлаач</b> (докторын зэрэгтэй судлаачид болон зарим гэрээт хуульчид хамаардаг)	6,773,600	2,538,900
<b>Судлаач</b> (Төрийн албаны 5, 4 дүгээр түвшинд хамаарах судлаач, албан хаагчид хамаардаг)	4,509,600	1,879,600

### Нэмэгдлийн төрөл, хэмжээ

Төрийн албан хаагчид нь төрийн албаны тухай хуулийн 47, 48 дугаар зүйл, Төрийн албан хаагчийн цалин хөлсний журмын 31 дүгээр зүйлд заасны дагуу дараах нэмэгдэл болон урамшуулал авна. Үүнд:

- **Ажлын нөхцөлийн нэмэгдэл-** Энэ нэмэгдлийг ихэвчлэн цэрэг, цагдаагийн байгууллагын ажилтнуудад олгодог. Цалиниийн 4.1 хувь
- **Гүйцэтгэлийн урамшуулал-** энэ нь төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан албан тушаалын ангилал тус бүрээр ялгамжтай олгодог.<sup>186</sup>

<sup>185</sup> <http://www.assembly.pe.kr/news/articleView.html?idxno=261>

1 Түвшин	2 Түвшин	3 Түвшин	4 Түвшин	5 Түвшин	6 Түвшин	7 Түвшин	8 Түвшин	9 түвшин
20 хувь	20 хувь	20 хувь	20 хувь	18 хувь	18 хувь	15 хувь	12 хувь	10 хувь
Ахлах судлаач, удирдах албан тушаалтан					Судлаач болон ажилтнууд			
15 хувь					16 хувь			

- **Гэр бүлийн тэтгэмж**-Энэ нэмэгдлийг хилийн чанадад ажиллаж байгаа төрийн албан хаагчид ам бүлийн тоог 4 хүнээр тооцон олгодог.
- **Орон сууцны тэтгэмж**-ажлын үр дүн, цалингийн шатлалаас хамаарч тогтоодог.
- **Хүүхэд асрах чөлөөний тэтгэмж**- Бага насны хүүхэдтэй эцэг, эх хүүхэд асрах чөлөө авч болох бөгөөд авах хугацаанаас хамаарч тэтгэмжийн хэмжээг сарын цалингийн 80-85 хувиар тэтгэмж олгоно.
- **Хүнд нөхцөлийн нэмэгдэл**-Энэ нэмэгдлийг ажлын тусгай орчинтой газарт ажилладаг төрийн албан хаагдад олгодог. Дотоодод ажиллах нөхцөлөөс хамаарч 5000-60.000 вон, гадаадад 720-2500 долларын нэмэгдэл олгодог.
- **Онцгой нөхцөлийн нэмэгдэл**- Энэ нэмэгдлийг ихэвчлэн батлан хамгаалахын тушаалаар ажиллаж байгаа албан хаагчдад олгодог.  
Энэ нэмэгдлийг 30 хоногоос илүүгүй хугацаанд албан үүрэг давхар гүйцэтгэсэн албан хаагчид олгоно. 200.000 вон
- **Илүү цагийн хөлс**- Энэ нэмэгдлийг албан тушаалын ангилал бүрээр тогтмол тоогоор баталсан байдаг бөгөөд жилд ажиллах илүү цагийн хөлсний дээд, доод хязгаарыг тогтоосон байна. Хэрэв онцгой нөхцөл байдлын улмаас илүү цагаар ажиллахаар бол өдөрт 4 цаг, сард 57 цагаас илүү ажиллуулахыг хориглодог.

(1000 воноор)

	Дээд хязгаар	Доод хязгаар
Ахлах судлаач	108.706	36.199
Судлаач, албан хаагч	100.507	36.199

- **Амралтын өдрөөр ажилласны нэмэгдэл**- Бүх нийтийн амралтын өдөр болон 7 хоногийн амралтын өдрөөр ажилласан бол өдрийн цалинг 1.5 хувиар нэмэгдүүлж бодно.
- **Албан тушаалын чиг үүргийн нэмэгдэл** -Судалгаа, шинжилгээний ажилтнуудын хувьд сарын цалингийн 7.8 хувь
- **Хоолны нэмэгдэл**- сард 140.000 вон
- **Баярын өдрийн амралтын нэмэгдэл** –Цагаан сар болон ургацын баяраар олгодог. Сарын цалингийн 60 хувь
- **Гүйцэтгэлийн урамшуулал буюу жилийн эцэст олгох урамшуулал-1** сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тус тус олгодог.

<sup>186</sup> Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журмын 2 хавсралт (2020.01.07)

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Австрали улс

- Enterprise Agreement 2017-2020,  
<https://www.pmc.gov.au/sites/default/files/publications/pmc-enterprise-agreement-2017-2020.pdf>
- Department of Parliamentary Services Enterprise Agreement 2017,  
[https://www.aph.gov.au/About\\_Parliament/Employment/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Employment\\_Conditions](https://www.aph.gov.au/About_Parliament/Employment/Department_of_Parliamentary_Services/Employment_Conditions)
- Parliamentary Service Act 1999, <https://www.legislation.gov.au/Details/C2019C00092>
- Parliamentary Service Classification Rules 2010  
<https://www.legislation.gov.au/Details/F2010L00760>
- Public Service Classification Rules 2000  
<https://www.legislation.gov.au/Details/F2014C01338>
- Public Service Classification Rules 2000  
<https://www.legislation.gov.au/Details/F2014C01338>

### БНСУ

- Үндэсний Ассамблейн тухай хууль
- YA Тамгын газрын тухай хууль  
<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%82%AC%EB%AC%B4%EC%B2%98%EB%B2%95>
- YA Судалгааны албаны тухай хууль  
[http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9E%85%EB%B2%95%EC%A1%B0%EC%82%AC%EC%B2%98%EB%B2%95/\(16327\)](http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9E%85%EB%B2%95%EC%A1%B0%EC%82%AC%EC%B2%98%EB%B2%95/(16327))
- Солонгосын төрийн албаны тухай хууль  
<http://www.law.go.kr/LSW/lstLinkProc.do?&lsNm=%EA%B5%AD%EA%B0%80%EA%B3%EB%AC%B4%EC%9B%90%EB%B2%95&chrClsCd=010202&mode=20&ancYnChk=0#>
- Солонгосын төрийн албан хаагчийн цалин хөлсний журам  
<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EB%B3%B4%EC%88%98%EA%B7%9C%EC%A0%95>
- Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журам  
<http://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?lspLslnfSeq=106597&chrClsCd=010202&ancYnChk=0>
- Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журмын 2 хавсралт (2020.01.07)  
<http://www.law.go.kr/LSW/lstByInfoPLinkR.do?lslSeq=204635&lsNm=%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90%EC%88%98%EB%8B%B9+%EB%93%B1%EC%97%90+%EA%B4%80%ED%95%9C+%EA%B7%9C%EC%A0%95&bylNo=0002&bylBrNo=03&bylCls=BE&bylFyId=20180921&bylEfYdYn=Y>
- 국회 인사규칙- YA боловсон хүчний журам  
<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9D%88%EC%82%AC%EA%B7%9C%EC%B9%99>
- 국회 사무처 직제 Үндэсний Ассамблейн Тамгын газрын албан тушаалын схем  
<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%82%AC%EB%AC%B4%EC%B2%98%EC%A7%81%EC%A0%9C>
- 국회 입법조사처 직제 Үндэсний Ассамблейн Судалгааны албаны албан тушаалын схем  
<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EC%9E%85%EB%B2%95%EC%A1%B0%EC%82%AC%EC%B2%98%EC%A7%81%EC%A0%9C>

**ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА, ЦАГДААГИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ТЭДГЭЭРИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА  
ЯВУУЛАХ ХЭРГИЙН ХАРЬЯАЛАЛ БОЛОН МӨРДӨН БАЙЦААХ АЛБАНЫ ОРОН ТОО,  
АЛБАН ХААГЧДЫН ҮНДСЭН ЦАЛИН, НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭНИЙ  
ТАЛААРХ ЛАВЛАГАА**

Д.Халиун, Д.Жигваагүнсэл,  
Р.Оргилмаа

Энэхүү судалгаанд нэгдүгээрт, захиалгчийн хүсэлтийн дагуу Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын холбогдох хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, тэдгээрийн холбогдох хууль (ЭБШХ, ЭХХШТХ)-аар мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэргийн харьяаллын талаар; хоёрдугаарт, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын бүтэц болон тус байгууллагын мөрдөн байцаах албаны орон тоо, албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээний талаар тус тус судалсан болно.

**Нэг. Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг болон дээрх байгууллагуудад Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002/ болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/-аар мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэргийн харьяаллын талаар**

**1.1. Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг**

Тагнуулын ерөнхий газар нь тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх зорилго бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн бөгөөд Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.4 дэх заалтад “Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон уул гэмт хэрэг үйлдсэн буюу сэжиглэгдэж буй этгээдийг эрэн сурвалжлах;” үүргийг гүйцэтгэнэ гэж заасан.

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, Авлигын эсрэг хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн. Тус байгууллага нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах; Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах; Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх.

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн. Цагдаагийн албаны тухай хуулийн хоёрдугаар бүлэгт байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байгаа бол мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.4 дэх заалтад Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд “хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна.

(Дэлгэрүүлж Хүснэгт 2-оос үзнэ үү.)

**1.2.Холбогдох байгууллагын Эрүүгийн байцаан шийтгэх хууль /ЭБШХ/ болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /ЭХХШТХ/аар мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэргийн харьяаллын талаар**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/-ийн 2.3 дугаар зүйлийн 3-т “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хэд хэдэн байгууллагын эрх хэмжээнд харьяалагдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.” гэж заасан.

Хүснэгт 1

Байгууллагын нэр, харьялал		Эрх зүйн актын нэр	Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017
Тагнуулын байгууллага	Хуулиар харьялуулсан гэмт хэрэг	23	32	
	Өөрсдөө илрүүлсэн гэмт хэрэг	3	5	
	<b>Нийт дүн</b>	<b>28</b>	<b>37</b>	
Авлигатай тэмцэх байгууллага	Хуулиар харьялуулсан гэмт хэрэг	8	12	
	Өөрсдөө илрүүлсэн гэмт хэрэг	1	1	
	<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>13</b>	

Байгууллагын эрх хэмжээнд харьяалагдах гэмт хэргийг ЭБШХ /2002/ болон ЭХХШТХ /2017/-ийн хүрээнд харьцуулж үзвэл, Тагнуулын байгууллагын хувьд **ЭБШХ /2002/**-ийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан 23 гэмт хэрэг, Тагнуулын байгууллагын өөрсдөө илрүүлсэн 3 гэмт хэрэг /Үүнд: хүн худалдаалах, мөнгө угаах, эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/, **НИЙТ 26** гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна гэж заасан.

Харин 2017 онд батлагдсан **ЭХХШТХ**-аар тус хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1-т заасан 32 гэмт хэрэг, Тагнуулын байгууллагын өөрсдөө илрүүлсэн 5 гэмт хэрэг /Үүнд: хүн худалдаалах; валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх; улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх; мөнгө угаах; Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 3.3-т заасан гэмт хэрэг/, **НИЙТ 37** гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна гэж заасан байна.

Авлигатай тэмцэх байгууллагын хувьд **ЭБШХ /2002/**-ийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан 8 гэмт хэрэг, Авлигатай тэмцэх байгууллагын өөрсдөө илрүүлсэн 1 гэмт хэрэг /мөнгө угаах/, **НИЙТ 9** гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна гэж заасан бол 2017 онд батлагдсан **ЭХХШТХ**-аар тус хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.1-т заасан 12 гэмт хэрэгт, Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн 1 /мөнгө угаах/, **НИЙТ 13** гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна гэж заасан байна.

Цагдаагийн байгууллагын тухайд **ЭБШХ /2002/**-ийн 27 дугаар зүйлийн 27.4-т “Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нь энэ хуулийн 27.1, 27.3-т зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна”; 2017 онд батлагдсан **ЭХХШТХ**-ийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.” гэж тус тус заасан байна.

(Дэлгэрүүлж Хүснэгт 3-аас үзнэ үү.)

**Хоёр.Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын бүтэц болон тус байгууллагын мөрдөн байцаах албаны орон тоо, албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээний талаар**

Авлигатай тэмцэх газрын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг Улсын Их Хурлын 2019 оны “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 67-р тогтоолоор шинэчлэн баталсан. Тус тогтоолд орон тооны дээд хязгаарыг 232 албан хаагч байхаар тогтоосон бөгөөд тогтоолын 1-р хавсралтаар Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтцийг, 2-р хавсралтаар албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоожээ.

Харин албан хаагчдын зэрэг дэв, бусад нэмэгдлийг Монгол Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журам”<sup>187</sup>-д заасны дагуу олгоно.

Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 76 дугаар тогтоолоор батлан 2020 оны 03 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2019 оны Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг баталсан байна. Цагдаагийн алба хаагчид нь тус тогтоолын 3 дугаар хавсралтад заасан төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлээр цалинжиж байна.

Цагдаагийн алба хаагчдын цалингийн нэмэгдлийг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор баталсан журмуудыг баримтлан олгодог байна.



<sup>187</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/3241?lawid=5801>

## 1.1.ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Хүснэгт 2

### 1.1.БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Байгууллагын нэр	Тагнуулын байгууллага (ТЕГ)	Авлигатай тэмцэх байгууллага (АТГ)	Цагдаагийн байгууллага (ЦЕГ)
Эрх зүйн актын нэр, батлагдсан огноо	Тагнуулын байгууллагын тухай хууль (1999.07.08)	Авлигын эсрэг хууль (2006.07.06)	Цагдаагийн албаны тухай хууль (2017.02.09)
Байгууллагын үндсэн чиг үүрэг	<p><b>10 дугаар зүйл. Тагнуулын ерөнхий газар, түүний чиг үүрэг</b></p> <p>10.1.Тагнуулын ерөнхий газар нь тагнуулын байгууллагудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх зорилго бүхий Засгийн газрын тохиуулагч агентлаг мөн.</p> <p>10.5.Монгол Улсын Зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газрын цэргийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хучний Жанжин штабын даргатай хамтран батална.</p> <p>10.6.Хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газрын хилийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга, хил хамгаалах байгууллагын даргатай хамтран батална.</p> <p><b>10.10.Тагнуулын ерөнхий газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>10.10.1.гадаад тагнуулын ажиллагаа явуулах;</p> <p>10.10.2.сөрөх тагнуулын ажиллагаа явуулах;</p> <p>10.10.3.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх;</p> <p>10.10.4.эдийн засгийн тагнуулын ажиллагаа явуулах;</p> <p>10.10.5.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар мэдээлэл боловсруулж</p>	<p><b>15 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газар</b></p> <p>15.1.Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн.</p> <p><b>18 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх</b></p> <p><b>18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>18.1.1.улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;</p> <p>18.1.2.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;</p> <p>18.1.3.авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;</p> <p>18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг</p>	<p><b>ХОЁРДУГААР БҮЛЭГ</b></p> <p><b>ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ</b></p> <p><b>10 дугаар зүйл. Гэмт хэрэгтэй тэмцэх</b></p> <p>10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.1.гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;</p> <p>10.1.2.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;</p> <p>10.1.3.гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;</p> <p><b>10.1.4.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;</b></p> <p>10.1.5.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;</p> <p>10.1.6.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>10.1.7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэргэдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;</p> <p>10.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;</p> <p>10.1.9.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;</p>

<p>холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах;</p> <p>10.10.6.цэрэг-стратегийн болон хилийн тагнуулын ўйл ажиллагаа явуулах;</p> <p>10.10.7.тероризмтой тэмцэх;</p> <p>10.10.8. хуульд заасан бусад чиг үүрэг.</p> <p><b>11 дүгээр зүйл.Тагнуулын ерөнхий газрын үүрэг</b></p> <p>11.1.Тагнуулын ерөнхий газар дараахь үүрэг гүйцэтгэнэ:</p> <p><b>11.1.4.Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьялануулсан гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон уул гэмт хэрэг үйлдсэн буюу сэжиглэгдэж буй этгээдийг эрэн сурвалжлах;</b></p>	<p>дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>18.1.5.авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;</p> <p>18.1.6.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний ўйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;</p> <p>18.1.7.төрийн ўйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.</p> <p><b>18.2.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:</b></p> <p>18.2.1.хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилга гаргах;</p> <p>18.2.2.мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.</p> <p>18.3.Авлигатай тэмцэх газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана.</p> <p>18.4.Авлигатай тэмцэх газар дараахь бүрэн эрхтэй:</p> <p>18.4.1.авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;</p> <p>18.4.2.авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр,</p>	<p>10.1.10.гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах;</p> <p>10.1.11.гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татаан оролцуулах.</p> <p>10.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна.</p> <p><b>11 дүгээр зүйл. Нийтийн хэв журам хамгаалах</b></p> <p>11.1.Цагдаагийн байгууллага нь нийтийн хэв жуурмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.1.1.зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьялануулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах;</p> <p>11.1.2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;</p> <p>11.1.3.замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>11.1.4.насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>11.1.5.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>11.1.6.гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын ўйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>11.1.7.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага,</p>
--	--	---

	<p>журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;</p> <p><b>18.4.3.авлигын</b> эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;</p> <p><b>18.4.4.аж</b> ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;</p> <p><b>18.4.5.авлигын</b> гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <p><b>18.4.6.авлигын</b> холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;</p> <p><b>18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;</b></p> <p><b>18.4.8.чиг</b> үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;</p> <p><b>18.4.9.</b> ёөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;</p> <p><b>18.4.10.гүйцэтгэх</b> ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;</p> <p><b>18.4.11.хуулиар харьяалуулсан хэргийг</b> шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;</p> <p><b>18.4.12.ёөрийн</b> үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах;</p> <p><b>18.4.13.хөрөнгө,</b> орлогын мэдүүлэг гаргавал</p> <p>сээрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;</p> <p><b>11.1.8.олон</b> нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах.</p> <p><b>11.2.Гэмт</b> хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээ, мэдээллийг төлбөртэй авч болно.</p> <p><b>12 дугаар зүйл. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах</b></p> <p><b>12.1.Цагдаагийн</b> байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p><b>12.1.1.нийтийн</b> эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;</p> <p><b>12.1.2.эрх</b> бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх;</p> <p><b>12.1.3.гамшиг,</b> аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусlamж үзүүлэх;</p> <p><b>12.1.4.дипломат</b> төлөөлөгчийн газрыг хамгаалах;</p> <p><b>12.1.5.شاардлагатай</b> тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах;</p> <p><b>12.1.6.төрийн</b> тусгай хамгаалалтын хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх;</p> <p><b>12.1.7.нийтийг</b> хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх;</p> <p><b>12.1.8.яллагдагч,</b> шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх.</p> <p><b>12.2.Цагдаагийн</b> байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална.</p> <p><b>13 дугаар зүйл. Захиргааны хяналт тавих</b></p> <p><b>13.1.Цагдаагийн</b> байгууллага захиргааны</p>
--	--

	<p>зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;</p> <p>18.4.14.хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;</p> <p>18.4.15.мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;</p> <p>18.4.16.хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;</p> <p>18.4.17.авлигатай тэмцэх асуудлаар гадаад орууудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.</p> <p>18.5.Авлигатай тэмцэх газар Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр тодорхой хэргийг цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран шалгаж болно.</p> <p>18.6.Авлигатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, энэ хуульд заасан журмыг баримтална.</p>	<p>хяналтын чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.1.хүн ам, экологийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй хордуулах, мансууруулах бодис болон галт зэвсэг, сум хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, хадгалж хамгаалах, ашиглах талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>13.1.2.иргэн, хуулийн этгээд галт зэвсэг ёмчлех, эзэмших, ашиглах болон галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх журмын биелэлтэд хяналт тавих;</p> <p>13.1.3.зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл хөтлөх;</p> <p>13.1.4.эцэг, эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;</p> <p>13.1.5.эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцыг таниулах ажиллагаа явуулах;</p> <p>13.1.6.гээгдэл эд хөрөнгө, мөнгийг бүртгэх, шаардлагатай бол хадгалах, хууль ёсны эзэмшигчид нь олгох, хэрэв хууль ёсны эзэмшигч олдохгүй бол төрийн, эсхүл орон нутгийн холбогдох байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;</p> <p>13.1.7.жолоодох эрхийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг олгох, бүртгэх;</p> <p>13.1.8.хуульд заасан бусад.</p> <p>13.2.Цагдаагийн байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрхийг эдэлнэ.</p>
--	--	---

## 1.2. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХЭРГИЙН ХАРЬЯАЛАЛ

Хүснэгт 3

1.Тагнуулын байгууллага		
<b>Эрх зүйн актын нэр</b>	<b>Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002</b> /Энэ хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	<b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017</b>
<b>Өөрчлөлт ороогүй</b>	<b>27 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах байгууллага</b> 27.1.Тагнуулын байгууллагын мөрдөн байцаагч: -Эрүүгийн хуулийн 79/Эх орноосоо урвах/, 80/Тагнуул хийх/, 83/Зэвсэгт үймээн дэгдээх/, 84/Хорлон сүйтгэх/, 86/Үндэсний эв нэгдлийг бусниулах/, 87/Төрийн нууц задруулах/, 89/Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх/, 133/Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих/, 178 <sup>2</sup> /Терроризмыг санхүүжүүлэх/, 302/Төрлөөр устгах/, 303/Хөлсний цэрэг ашиглах <b>-Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b> 113 /Хүн худалдаалах/, 166 <sup>1</sup> /Мөнгө угаах/,	<b>6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага</b> 1.Тагнуулын байгууллага дараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна: 1.1.Эрүүгийн хуулийн 9.1/Эх орноосоо урвах/, 19.5/Зэвсэгт үймээн дэгдээх/, 19.6/Хорлон сүйтгэх/, 19.9/Үндэсний эв нэгдлийг бусниулах/, 19.10/Тагнуул хийх/, 19.12/Төрийн нууцыг задруулах/, 19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/, 21.13/Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 29.5/Төрлөөр устгах/, 29.6/Хөлсний цэрэг ашиглах/, 29.10/Терроризмыг санхүүжүүлэх/, <b>1.2.тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b> 13.1/Хүн худалдаалах/, 18.6/Мөнгө угаах/,
<b>Өөрчлөн найруулсан</b>	81/Төр, нийгмийн зүтгэлтэний амь биед халдах/, 82/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах/, 88/Төрийн нууц мэдээ, баримт бичиг, биет зүйлийг үрэгдүүлэх/, 178 <sup>1</sup> /Терроризм/, 178 <sup>3</sup> /Терроризмыг сурталчлах/, 224.2/Олон улсын нислэгийн журам зөрчих/, 300/Үй олноор хөнөөх зэвсэг бүтээх, олж авах, тараах, 301/Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох/; <b>-Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b> 175/Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.	19.2/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, saatuulaah/, 19.3/Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 19.13/Төрийн нууцыг үрэгдүүлэх/, 20.1/Террорист үйлдлийн талаар зориуд худал мэдээлэх/, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/, 27.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/, 29.3/Үй олноор хөнөөх зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, борлуулах/, 29.7/Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8/Террорист үйлдэл хийх/, 29.9/Террорист үйлдэлд бэлтгэх/, <b>1.2.тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b> 18.5/Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/,
<b>Шинэ хуульд</b>	85/Хорлон saatuulaah/;	-

<b>дараах төмьёоллоор тусгагдаагүй</b>	177/Зандалчлах/, 178/ Зандалчлах тухай санаатай худал мэдээлэх/, 297/Зэвсэгт мөргөлдөөн гаргах/,	
<b>Шинээр тусгагдсан</b>	-	<p>14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/,      14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/,      14.7/Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/,      14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/,      14.9/Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах/,      19.4/Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/,      19.7/Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/,      19.8/Экстремист үйл ажиллагаа явуулах/,      19.11/Төрийн нууцыг хууль бусаар олж авах/,      29.1/Түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/,      29.11/Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт;  <b>1.2.тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b>      18.2/Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/,      20.7 дугаар зүйлийн 3.3-т заасан гэмт хэрэгт. /20.7 дугаар зүйл.      Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/   </p>

## 2.Авлигатай тэмцэх байгууллага

<b>Эрх зүйн актын нэр</b>	<b>Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002</b> /Энэ хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	<b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017</b>
<b>Өөрчлөлт ороогүй</b>	<b>27 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах байгууллага</b> 27.3.Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нь Эрүүгийн хуулийн 273.2./Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйл болон <b>өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн</b> 166 <sup>1</sup> /Мөнгө угаах/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.	<b>6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага</b> 2.Авлигатай тэмцэх байгууллага дараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна: 22.8/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 2.2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт.
<b>Өөрчлөн найруулсан</b>	263.2./Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 268/Хээл хахууль авах/, 269/Хээл хахууль өгөх/, 270 <sup>1</sup> /Хууль бусаар хөрөнгөжих/,	22.1/Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.4/Хахууль авах/, 22.5/Хахууль өгөх/, 22.10/Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/,

<b>Шинэ хуульд дараах томъёоллоор тусгагдаагүй</b>	264.2./Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265.2/Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266.2./Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 270.2./Хээл хахууль зуучлах/	-
<b>Шинээр тусгагдсан</b>	-	22.3/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.6/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7/Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.9/Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.11/Дураараа аашлах/, 22.12/Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт;

### 3.Цагдаагийн байгууллага

<b>Эрх зүйн актын нэр</b>	<b>Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002</b> /Энэ хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	<b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017</b>
<b>Холбогдох зохицуулалт</b>	<b>27 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах байгууллага</b> 27.4.Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нь энэ хуулийн 27.1, 27.3-т зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.	<b>6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага</b> 3.Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

### 4.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

<b>Эрх зүйн актын нэр</b>	<b>Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002</b> /Энэ хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/	<b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017</b>
<b>Холбогдох зохицуулалт</b>	<b>26 дугаар зүйл. Хэрэг бүртгэх эрх бүхий байгууллага</b> 26.1.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн хөнгөн гэмт хэрэгт бүртгэлт явуулна. <b>27 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах байгууллага</b> 27.2.Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн болон энэ хуулийн 27.1-т зааснаас бусад тагнуулын байгууллагын ажилтны үйлдсэн хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.	<b>6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага</b> 4.Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.

**Хоёр.Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллагын бүтэц болон тус байгууллагын мөрдөн байцаах албаны орон тоо, албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийн хэмжээний талаар**

**2.1.Авлигатай тэмцэх байгууллагын бүтэц, орон тоо, цалин, нэмэгдлийн талаарх мэдээлэл**

Авлигатай тэмцэх газрын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг Улсын Их Хурлын 2019 оны “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 67-р тогтоол<sup>188</sup>-оор шинэчлэн баталсан. Тус тогтоолд орон тооны дээд хязгаарыг 232 албан хаагч байхаар тогтоосон бөгөөд тогтоолын 1 дүгээр хавсралт<sup>189</sup>-аар Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтцийг, 2-р хавсралт<sup>190</sup>-аар албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоожээ.

1.Авлигатай тэмцэх газар доор дурдсан бүтэцтэй байна:<sup>191</sup>

1.1.Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс:

1.2.Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс:

1.2.1.Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний алба;

1.2.2.Хяналт шалгалтын алба.

1.3.Мөрдөн шалгах хэлтэс:

1.3.1.Нэгдүгээр алба;

1.3.2.Хоёрдугаар алба;

1.3.3.Гуравдугаар алба.

1.4.Гүйцэтгэх ажлын хэлтэс:

1.4.1.Нэгдүгээр алба;

1.4.2.Хоёрдугаар алба.

1.5.Тусгай хэлтэс:

1.6.Тамгын хэлтэс:

1.6.1.Санхүү, аж ахуйн алба;

1.6.2.Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба.

1.7.Судалгаа шинжилгээний алба.




<sup>188</sup> <https://www.legalinfo.mn/law/details/14518>

<sup>189</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/9916?lawid=14518>

<sup>190</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/9917?lawid=14518>

<sup>191</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/9916?lawid=14518>

## Бүтэц, зохион байгуулалтын схем<sup>192</sup>



### Мөрдөн шалгах хэлтэс

Авлигатай тэмцэх газрын үндсэн бүтцэд байх тус хэлтэс нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэгтэй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хуульчлагдсан дараах төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах;
- Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах;
- Хахууль авах;
- Хахууль өгөх;
- Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтыг хахуульдах;
- Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх;
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих;
- Дураар аашлах;
- Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах;
- Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах.

**Бүтэц, орон тоо:** Мөрдөн шалгах хэлтэс нь дотроо 3 албатай (Бүтэц, зохион байгуулалтын схемээс үзнэ үү), 57 орон тоотой. Үүнээс хэлтсийн дарга-1, орлогч бөгөөд албаны дарга-1, албаны дарга-2, ахлах мөрдөн байцаагч-9, мөрдөн байцаагч-42, техникийн ажилтан-1, гомдол мэдээлэл, тоо бүртгэл хариуцсан ажилтан-1 байна.

**Цалин хэлс, нэмэгдэл:** Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг УИХ-ын 2019 оны 67-р тогтооплын 2-р хавсралтаар дараах байдлаар шинэчлэн тогтоосон. Тухайлбал:

<sup>192</sup> <https://www.iaac.mn/page/19?menu=45>

## Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ<sup>193</sup>

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авлигатай тэмцэх газрын дарга	2 383 680
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	2 220 400
3	Хэлтсийн дарга	2 128 700
4	Албаны дарга	2 016 560
5	Ахлах ажилтан	1 919 430
6	Ажилтан	1 809 360
7	Туслах ажилтан	1 033 500

Харин албан хаагчдын зэрэг дэв, бусад нэмэгдлийг Монгол Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан **“Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журам”**<sup>194</sup>-д заасны дагуу олгоно.

Журам ёсоор Төрийн албаны тухай болон Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв олгох, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг баримтална.

### 1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох

Авлигатай тэмцэх газрын албан хаагч нь тэргүүн комисsar, эрхэлсэн комисsar, ахлах комисsar, комисsar, дэд комисsar зэрэг дэвтэй байна.

Албан хаагчдын албан тушаалын ангилал, төрийн албанд ажилласан нийт хугацаа, мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадвар, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан дор дурдсанаар зэрэг дэв олгоно:

Зэрэг дэв	Албан тушаал	Төрийн албанд ажилласан нийт хугацаа /жилээр/
Тэргүүн комисsar	Авилгалтай тэмцэх газрын дарга	10 жилээс доошгүй
Эрхэлсэн комисsar	Дэд дарга, хэлтсийн дарга	8 жилээс доошгүй
Ахлах комисsar	Албаны дарга, хэлтсийн ахлах ажилтан	5 жилээс доошгүй
Комисsar	Хэлтэс, албаны ажилтан	3 жилээс доошгүй
Дэд комисsar	Хэлтэс, албаны туслах ажилтан	1 жилээс доошгүй

Тэргүүн комисsar зэрэг дэвийг Авлигатай тэмцэх газрын санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч, бусад зэрэг дэвийг Авлигатай тэмцэх газрын дарга олгоно.

Төрийн албанд ажилласан нийт хугацаанд төрийн бүх төрлийн албан тушаалд ажилласан хугацааг оруулж тооцно.

Албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг түүний албан тушаалын үндсэн цалингаас дараах хувиар тооцож олгоно:

Зэрэг дэв	Тэргүүн комисsar	Эрхэлсэн комисsar	Ахлах комисsar	Комисsar	Дэд комисsar
Нэмэгдлийн хувь	35	32	28	25	20

<sup>193</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/9917?lawid=14518>

<sup>194</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/3241?lawid=5801>

## *2. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох*

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дараах хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

Төрийн алба хаасан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно:

- төрийн албанд ажилласан;
- төрийн албанд ажиллах хугацаандаа мэргэжил, мэргэшлээ дээшлүүлсэн, аспирантур, докторантурт суралцсан;
- төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй байсан.

## *3. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох*

Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, хэлтэс, албаны дарга, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил эрхэлсэн албан хаагчид сарын үндсэн цалингийн 40 хувь, бусад албан хаагчид 25 хувиар тус тус бодож албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.

## *4. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох*

Эрдмийн зэрэг, цолтой албан хаагчдад эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгоходоо Засгийн газраас баталсан Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журмыг баримтална.

## **2.2. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ОРОН ТОО, ЦАЛИН, НЭМЭГДЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 76 дугаар тогтоолоор батлан 2020 оны 03 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<sup>195</sup>


Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ) нь дараах алба, газруудаас бүрдэнэ.

- а/ Эрүүгийн цагдаагийн алба;
- б/ **Мөрдөн байцаах алба;**
- в/ Хэрэг бүртгэх алба;
- г/ Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба;
- д/ Тээврийн цагдаагийн алба;
- е/ Санхүү, аж ахуйн алба;
- ж/ Захиргааны удирдлагын газар;
- з/ Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба;

<sup>195</sup> <https://www.legalinfo.mn/law/details/13078>

и/ Интерполын үндэсний төв товчоо;  
к/ Экологийн цагдаагийн алба.

[Цалин хөлс, нэмэгдэл](#): Цагдаагийн өрөнхий газрын даргын 2019 оны А195 тоот тушаалаар баталсны дагуу Мөрдөн байцаах алба нь доорх бүтцээр ажиллаж байна.<sup>196</sup>



Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчийн цалин хөлс, нэмэгдлийг дараах байдлаар хуульчилжээ:<sup>197</sup>

87.9. Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:

- 87.9.1.төрийн тусгай алба хаасан хугацааны;
- 87.9.2.албан ажлын онцгой нөхцөлийн;
- 87.9.3.цагдаагийн мэргэжлийн зэргийн;
- 87.9.4.эрдмийн зэрэг, цолны;
- 87.9.5.хуульд заасан бусад.

87.10. Цагдаагийн байгууллагын алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно гэж заасан байна.

2019 оны Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг баталсан байна.<sup>198, 199</sup> ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны ажилтнууд нь тус тогтоолын 3 дугаар хавсралтад заасан TT8-TT16 албан тушаалын зэрэглэлээр 1-5 хүртэл шатлалаар цалинждаг байна.

Цагдаагийн алба хаагчдын цалингийн нэмэгдлийг [Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор баталсан доорх журмуудыг](#) баримтлан олгож байна.<sup>200</sup> Үүнд:

<sup>196</sup> <http://mbg.police.gov.mn/news/content/type/131/menuid/87>

<sup>197</sup> <https://www.legalinfo.mn/law/details/12469>

<sup>198</sup> <https://www.legalinfo.mn/law/details/14892?lawid=14892>

<sup>199</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/10381?lawid=14892>

<sup>200</sup> <https://www.legalinfo.mn/law/details/9876?lawid=9876>

- Цагдаагийн алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам;
- Цагдаагийн алба хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам;
- Цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдлийн хувь хэмжээ;
- Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам” зэрэг болно.<sup>201</sup>



---

<sup>201</sup> <https://www.legalinfo.mn/annex/?lawid=9876>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.legalinfo.mn/annex/details/3241?lawid=5801>
- <https://www.legalinfo.mn/law/details/14518>
- <https://www.legalinfo.mn/annex/details/9916?lawid=14518>
- <https://www.iaac.mn/page/19?menu=45>
- <https://www.legalinfo.mn/annex/details/3241?lawid=5801>
- <https://www.legalinfo.mn/law/details/13078>
- <http://mbg.police.gov.mn/news/content/type/131/menuid/87>
- <https://www.legalinfo.mn/law/details/12469>
- <https://www.legalinfo.mn/law/details/14892?lawid=14892>
- <https://www.legalinfo.mn/law/details/9876?lawid=9876>
- <https://www.legalinfo.mn/annex/?lawid=9876>



## БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ТӨСВИЙН АЛБАНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Д.Жигваагүнсэл, О.Билгүүтэй

Энэхүү судалгаанд БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтэц, чиг үүрэг болон хууль эрх зүйн орчны талаар авч үзсэн болно.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн алба /National Assembly Budget Office/ (NABO) нь Үндэсний Ассамблейн тухай хууль болон Үндэсний Ассамблейн Төсвийн албаны хуулийн дагуу 2003 онд байгуулагдсан бөгөөд Үндэсний Ассамблейн даргын шууд удирдлагын дор ажилладаг байна.

*Зураг 1. Үндэсний Ассамблейн даргын удирдлагад ажилладаг нэгжүүд<sup>202</sup>*



### 1. Бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа:

Үндэсний Ассамблейн Төсвийн Алба (YATA) нь улсын төсөв, санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийж, үнэлэх, дүгнэх замаар Үндэсний Ассамблейд дэмжлэг үзүүлэх ерөнхий чиг үүрэгтэй. Төсвийн албаны мэргэжилтнүүд болон шинжээчид бие даасан, хараат бус, хөндлөнгийн судалгаа, шинжилгээгээр хангадаг.

Тус алба нь Төлөвлөлт, менежментийн хэлтэс, Төсвийн шинжилгээний хэлтэс, Тооцоолол, татварын анализийн хэлтэс, Эдийн засгийн шинжилгээний хэлтэс гэсэн үндсэн 4 хэлтэстэй. (Дэлгэрэнгүйг Зураг 2-оос харна уу.) Төсвийн алба нь захирал, орлогч дарга, 3-8 дугаар түвшний судлаач болон төрийн албан хаагчдаас бүрдэнэ. Хэлтсүүд нь дараах чиг үүрэгтэй:

#### 1. Төлөвлөлт менежментийн хэлтэс

- Үйл ажиллагааны төлөвлөгөө, ерөнхий хяналт, төрөл бүрийн хөтөлбөрүүдийн зохицуулалтыг гүйцэтгэх;
- Холбогдох нэгжүүдэд зөвлөх болон зохицуулах чиглэл өгөх;
- Үндэсний ассамблейн гишүүд болон хороодоос хүссэн судалгаа, шинжилгээний хүсэлтийг хүлээн авах, ангилах;
- Хүний нөөцийн менежмент болон, төсвийн хэрэгжилтийн зохицуулалт хийх.

#### 2. Төсвийн шинжилгээний хэлтэс

- Үндэсний төсөв, дансны тооцоо, сангүүд (үндэсний томоохон хөтөлбөр), эдийн засгийн менежментийн анализ хийх;

<sup>202</sup> СТ-18/218 Төсвийн хараат бус байгууллагын эрх зүйн орчны харьцуулсан судалгаа

- Нэгдсэн төсвийн үлдэгдэл, улсын өрийн хэмжээ, төсвийн тогтвортой байдал зэрэгт судалгаа хийх;
- Төрөл бүрийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт дээр үнэлгээ болон, хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;
- Төрийн байгууллагууд болон засгийн газрын гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог хариуцах.

### 3. Тооцоолол, татварын анализын хэлтэс

- Төсөвтэй холбоотой хууль тогтоомжид зардлын тооцоо хийх;
- Дунд болон урт хугацааны үндэсний төсвийн төлөвлөлт гаргах;
- Орлогын тооцооллын талаар төсөлд хавсаргасан хууль тогтоомжийн нэр томьёонд дүн шинжилгээ, зөвлөмж гаргах;
- Татварын тогтолцоо болон бодлогын талаар судалгаа, шинжилгээ хийх.

### 4. Эдийн засгийн шинжилгээний хэлтэс

- Эдийн засгийн чиг хандлага болон макро эдийн засгийн урьдчилсан төлөвлөлтөд судалгаа хийх;
- Аж үйлдвэр болон хөдөлмөр эрхлэлт, санхүүд суурилсан эдийн засгийн чиг хандлагад дүн шинжилгээ хийх;
- Урт хугацааны эдийн засгийн стратеги бодлого болон хүн амын бүтцийн талаар, судалгаа, төлөвлөлт хийх;
- Засгийн газрын бодлогод эдийн засаг хэрхэн нөлөөлж буйг судлах.


Төсвийн алба нь төсвийн болон эдийн засгийн статистикийн нэгдсэн систем болох NABOSTATS ([www.nabostats.go.kr](http://www.nabostats.go.kr)-ыг 2018 оны 9-р сарын 1-ээс ажиллуулж эхэлсэн. Энэ нь нэг цэгийн статистик мэдээллийн систем бөгөөд хэрэглэгчид YATA-ны хууль тогтоомж, төсөв боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн талаарх хэлэлцүүлэгт шаардлагатай үндэсний, орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагын санхүү, эдийн засгийн харилцааны талаарх нэгдсэн статистик, дүн шинжилгээний мэдээллүүдийг авах боломжтой юм.

Энэ хүрээнд Төсвийн албанаас Үндэсний Ассемблейн Байнгын хороодын гүйцэтгэж буй хууль тогтоомжийн ажлыг дэмжих зорилгоор Хороо болгоноор тогтмол ашиглагддаг статистикийн хураангуйг нэгтгэн гаргадаг.

NABOSTATS систем нь дараах статистик мэдээллээр хангадаг байна. Тухайлбал:

*Хүснэгт. Төсвийн албаны гүйцэтгэсэн статистик судалгааны төрлүүд  
(2019 оны байдлаар)*

	Судалгааны төрөл	Тоо
1	Байнгын хорооны статистик судалгаа	206
2	Хүн ам болон нийгмийн судалгаа	25
3	Эдийн засгийн статистик судалгаа	32
4	Хойд Солонгосын статистик судалгаа	98
5	Олон улсын статистик судалгаа	27
6	Үндэсний Ассемблейн хэлэлцүүлгийн товхимол	4
7	Төсвийн статистик судалгаа	75
8	Татварын статистик судалгаа	31
9	Орон нутгийн санхүү	10
10	Төрийн байгууллагын статистик	11



### Хууль эрх зүйн орчин:

Үндэсний Ассамблейн тухай хуулийн<sup>203</sup> 22-2 дугаар зүйлээр Үндэсний Ассамблейн Төсвийн албаны эрх зүйн үндсийг дараах байдлаар тогтоож өгсөн байна. Тухайлбал:

1. Төрийн санхүү болон сангийн менежмент, төсвийн зохицуулалттай холбоотой асуудлыг судлан шинжлэх, үнэлэх, дүгнэх түүнчлэн парламентын үйл ажиллагааг дэмжих зорилготой Үндэсний Ассамблейн төсвийн албыг байгуулна.
2. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь дарга, шаардлагатай бусад албан хаагчидтай байна.
3. Төсвийн албаны даргыг Үндэсний Ассамблейн Удирдах хороо (House Steering Committee)-ны зөвшөөрөлтэйгээр Үндэсний Ассамблейн тэргүүн томилж, чөлөөлнэ.
4. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Ассамблейн Төсвийн албатай холбоотой шаардлагатай бусад асуудлыг тусдаа хуулиар зохицуулна гэж заажээ.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны үйл ажиллагааг 11 зүйл бүхий бие даасан хуулиар зохицуулж байна.

### **Үндэсний Ассамблейн Төсвийн албаны хууль<sup>204</sup>-иас**

#### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Тус хуулийн зорилт нь Үндэсний Ассамблейн төсвийн алба, түүний чиг үүрэг болон холбогдох бусад асуудлыг тогтооход оршино.

#### **2 дугаар зүйл. Эрх зүйн байдал**

Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь (цаашид төсвийн алба гэх) Үндэсний Ассамблейн даргын удирдлаганд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. Төсвийн алба нь эрх зүйн байдлын хувьд бие даасан байна.

#### **3 дугаар зүйл. Чиг үүрэг**

Төсвийн алба нь төрийн сангудын удирдлага, төсвийн тайлан, тооцоотой холбогдох дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Төсвийн тайлан, төрийн сангудыг эрхлэн явуулахтай холбогдох төсөл, төсвийн

<sup>203</sup> National Assembly act, [https://korea.assembly.go.kr:447/res/law\\_06\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/law_06_read.jsp)

<sup>204</sup> National Assembly Budget Office Act, <http://korea.nabo.go.kr/about/laws.php>  
(<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9%EA%B5%AD%ED%9A%8C%EC%98%88%EC%82%EC%A0%95%EC%B1%85%EC%B2%98%EB%B2%95>)

- тооцоололтой холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;
- Төсвийн болон төрийн сангугудын зардалтай холбогдох асуудлаар болон өртөгтэй холбогдох тооцоолол гаргах;
- Макро эдийн засгийн хандлага болон төрийн санхүүтэй холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;
- Үндэсний хэмжээний чухал төсөл, хөтөлбөр, дунд болон урт хугацааны санхүүгийн нөхцөл байдлын талаар шинжлэх, үнэлэх;
- Зөвлөл болон Үндэсний Ассамблейн гишүүдээс шаардсан аливаа асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, гүйцэтгэх.

#### **4 дүгээр зүйл. Дарга**

- Төсвийн албаны дарга нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарах ба дэд сайдтай адил хэмжээний цалин хангамжтай байна.
- Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ туршлагатай бөгөөд асуудалд төвийг сахисан байр сууринаас хандах үүрэгтэй.
- Дарга нь Үндэсний Ассамблейн тэргүүний тушаалаар томилсон Төсвийн албаны төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, үйл ажиллагааг нь удирдах чиг үүрэгтэй.

#### **5 дугаар зүйл. Зөвлөх хороо**

- Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22-2,3-т заасны дагуу Үндэсний Ассамблейн дарга нь Төсвийн албаны даргыг томилоходоо эхлээд Зөвлөх хорооноос санал болгосон хүнийг авч хэлэлцэнэ.
- Зөвлөх хорооны гишүүд нь төсвийн албаны чиг үүрэгтэй холбогдох асуудлаар туршлагатай, улс төрийн хувьд төвийг сахисан байх ба Үндэсний Ассамблейн гишүүн болон Үндэсний Ассамблейн ажлын албан хаагч бус этгээд байна.
- Зөвлөх хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг журмаар<sup>205</sup> зохицуулна.

#### **6 дугаар зүйл. Томилгоо**

Төсвийн албаны 5 болон түүнээс дээш зэрэглэл(grade) бүхий төрийн албан хаагчдыг Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө. Үндэсний Ассамблейн дарга нь эрх мэдлийнхээ зарим хэсгийг журмын дагуу шилжүүлсэн тохиолдолд бусад албан хаагчдыг Төсвийн албаны дарга томилж, чөлөөлж болно.

#### **7 дугаар зүйл. Бүтэц**

- Төсвийн албаны туслах байгууллага нь дэд дарга, ерөнхий захирал болон захиралтай байна. Дээрх албан тушаалын нэrsийг журмын дагуу өөрөөр тогтоож болно.
- Төсвийн албаны даргын дор дэд дарга ерөнхий захирал ажиллах ба мөн дэд захирлууд тэдгээрийн үйл ажиллагаанд шууд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллахыг зөвшөөрнө. Төсвийн албаны даргын харьяанд үндсэн бүтцэд хамаарахгүй ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.
- Төсвийн албаны даргын дэргэд зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл ажиллаж болно. Төсвийн албаны бүтэц, бүрэлдэхүүнийг журмаар тогтооно. Албаны нэгжийн чиг үүрэг тэдгээрийг байгуулах болон дэд захирлуудтай холбогдох асуудлыг Төсвийн албаны дарга өөрөө тодорхойлно.

##### **7.2 (Судалгааны ажилтнуудын албан тушаалын хяналт)**

- Хэлтсийн дарга судалгааны ажилтнуудыг ажилд аваходаа ажилтнуудаас албан тушаалын шалгалт авна.
- 1-р зүйлийн дагуу хэлтсийн дарга албан тушаалын шалгалтын үр дүнд үндэслэн ажлын ур чадварын үнэлгээ гаргах ба (Төрийн албан хаагчийн хууль) 34.3-т заасны дагуу шаардлагатай бол байгууллагын дарга ур чадварын шалгалт авч болно.

<sup>205</sup> <http://www.law.go.kr/LSW//lumLsLinkPop.do?lspttninfSeq=140839&chrClsCd=010202&ancYnChk=0>

- 1-р зүйлийн дагуу албан тушаалын шалгалт авах, 2-р зүйлийн дагуу ур чадварын шалгалт авах зэрэг шаардлагатай асуудлыг Үндэсний Ассамблейн журмаар зохицуулна.

## **8 дугаар зүйл. Хороод болон Үндэсний Ассамблейн гишүүдэд материал танилцуулах**

Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ Хороо болон Үндэсний Ассамблейн гишүүдийн хүсэлтийн дагуу тэдэнд шаардлагатай материалыг танилцуулах үүрэгтэй.

## **9 дүгээр зүйл. Тайлан**

Төсвийн албаны дарга болон бусад албан хаагчид нь Үндэсний Ассамблейн хороод болон гишүүдийн хүсэлтийн дагуу судалгаа, тайлан ба холбогдох тайлбарыг хороодод гаргаж өгнө. Албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэх явцад холбогдох төрийн байгууллага болон тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хууль журамд оруулбал зохих өөрчлөлт, хууль бус асуудлын талаар Үндэсний Ассамблейн төсөв, санхүүгийн болон бусад хариуцсан хороодод мэдээлэл, илтгэл хүргүүлэх үүрэгтэй.


## **10 дугаар зүйл. Мэдээлэл авах**

Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай байгаа баримт мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрлөөр авах, танилцах эрхтэй байна. Төрийн байгууллагууд нь тухайн мэдээллийг нууцлах онцгой шалтгаангүй бол гаргаж өгөх үүрэгтэй.

## **11 дүгээр зүйл. Төлөөлөх**

Энэ хууль болон холбогдох журамд заасан, мөн энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлуудыг Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблейн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

Зураг 2. БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтэц<sup>206</sup>



<sup>206</sup> [http://korea.nabo.go.kr/eng/01\\_about/organization.page](http://korea.nabo.go.kr/eng/01_about/organization.page)

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- National assembly act, 1948
- National Assembly Budget Office Act, 2003
- [http://korea.nabo.go.kr/eng/01\\_about/laws.page](http://korea.nabo.go.kr/eng/01_about/laws.page)
- <https://www.oecd.org/gov/budgeting/Korea.pdf>
- Principles for independent fiscal institutions and case studies, OECD, 2016.
- <http://www.law.go.kr/LSW//lumLsLinkPop.do?lspttninfSeq=140839&chrClsCd=010202&ancYnChk=0>
- <http://www.law.go.kr/LSW/lsLinkProc.do?lsNm=%EA%B5%AD%ED%9A%8C%EC%98%88%EC%82%B0%EC%A0%95%EC%B1%85%EC%B2%98%EB%B2%95&chrClsCd=010202&mode=20&ancYnChk=0#>
- <http://korea.nabo.go.kr/#>



**ВИРТУАЛ ОРЧИН ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
АНХААРАХ АСУУДЛУУД**

(Мэдээлэл, лавлагаа)

*Д.Халиун, Р.Нургүл*

**АГУУЛГА**

**МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ ТОЙМ**

**ВИРТУАЛ ОРЧИН ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АНХААРАХ АСУУДЛУУД**

1. Парламентын гишүүдэд тулгарч буй асуудлууд
2. Парламентын ажилтнуудын анхаарах асуудлууд

**МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ ТОЙМ**

Судалгаанд дэлхий даяар тархаад буй цар тахлын үед улс орнуудын парламент болон парламентын ажлын алба үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд виртуал орчинд хэрхэн ажиллах, шинэ нөхцөл байдалд дасан зохицох болон түүнтэй холбоотой үүсэж болзошгүй асуудлууд, тэдгээрийг хэрхэн зохицуулах талаар The Asia Foundation болон Global Partners Governance байгууллагуудын гаргасан зөвлөмж, мэдээллийг орчуулан хүргэж байна.

Энэхүү мэдээлэл, лавлагаа нь “[Парламентын гишүүдэд тулгарч буй асуудлууд](#)” болон “[Парламентын ажилтнуудын анхаарах асуудлууд](#)” гэсэн 2 сэдэвтэй байна.

Эхний сэдвийн хүрээнд виртуал парламентын гол зарчмууд; виртуал орчин дахь парламентын хэрэгжүүлэх хамгийн чухал чиг үүргүүд; виртуал хуралдааныг зохион байгуулах зөвшөөрөл, шийдвэр гаргах талаар; цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан парламентын эрх мэдлийг цөөн тооны гишүүдийн төлөөлөлд шилжүүлэх тохиолдолд хэрхэн ажиллах; парламентын виртуал хуралдааныг үр дүнтэй явуулахад шаардлагатай нөөц, боломж; гишүүд тойротоо хэрхэн үр дүнтэй ажиллах; виртуал парламентын ажлыг олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхтэй холбогдох зөвлөмж, мэдээллийн талаар дурдсан.

Харин 2 дахь сэдэв нь виртуал орчинд парламентын ажилтнуудын баримтлах гол зарчмууд; виртуал парламентын шинэ процесс, процедур; парламентын гишүүд болон тэдгээрийн ажилтнуудад үзүүлэх зөвлөгөө, дэмжлэг; парламентын ажилтнуудын үр дүнтэй ажиллах боломжийг хэрхэн бүрдүүлэх; байгууллагын соёл ба харилцаан дэмжлэг үзүүлэх тогтолцоо; дотоод болон гадаад харилцаа холбооны талаарх зөвлөмж, мэдээллийг агуулсан байна.

## ВИРТУАЛ ОРЧИН ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АНХААРАХ АСУУДЛУУД

Албан бус орчуулга

### 1. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДЭД ТУЛГАРЧ БҮЙ АСУУДЛУУД

Ковид-19 цар тахлын тархалттай холбоотой улс орнуудын парламент виртуал хуралдааныг нэвтрүүлж байна. Энэхүү товч тойм нь парламентын хуралдааныг виртуал хэлбэрээр хэрхэн явуулах болон парламентын гишүүдийн анхаарах гол асуудлын талаар мэдээлэл өгөх юм.

#### Виртуал парламентын гол зарчим

Хэдийгээр хуралдааны үйл явц болон дэгийн журам уламжлалт хэлбэрээс өөр байх боловч парламентын үйл ажиллагааны үндсэн зарчим хадгалагдах ёстой. Үүнд:

- **Хариуцлагатай байх:** Энэхүү хямралын үед гүйцэтгэх засаглалын болон бусад териин байгууллагуудад хариуцлага тооцох үр дүнтэй аргыг тодорхойлох;
- **Хамааралтай байх:** Парламент олон нийтэд хандаж үг хэлэх гол үргээ хэрэгжүүлэх боломжоор хангагдах;
- **Шударга ёсыг баримтлах:** Виртуал хуралдааны үеэр парламент дахь цөөнхийн эрхийг хүндэтгэх;
- **Ил тод байдал:** Иргэдэд парламент дахь төлөөлөлтэйгээ хувиараа болон бүлгээрээ харилцах боломж бүрдүүлэх;
- **Үр ашигтай байдал:** Хамгийн сайн үр дүнтэй үйл ажиллагаа, туршлагыг бий болгох зэрэг болно.

#### Парламентын хэрэгжүүлэх хамгийн чухал чиг үүрэг

Парламентын хуралдааныг виртуал хэлбэрээр явуулах нь төвөгтэй байх бөгөөд ихэнх орны парламент хамгийн чухал, тулгамдсан асуудлаа эхний ээлжинд авч үзэж байна. Парламент бүрийн хувьд хямралтай тэмцэх арга хэлбэр ялгаатай бөгөөд энэ нь одоо байгаа нөөц, чадавх, дотоодын улс төрийн давуу байдал зэргээр тодорхойлогдох боловч төлөөлөх, хууль тогтоох, хянан шалгах З үндсэн чиг үүргийг онцгойлон анхаарна.

- **Шилжилтийн хугацаа.** Парламент хязгаарлагдмал нөхцөлд ажиллаж байгаа энэ үед ажлын шинэ горим, арга барилд шилжихэд тодорхой хугацаа буюу шилжилтийн хугацаа хэрэгтэй.
- **Хамтдаа шийдэх.** Парламентын гишүүд энэхүү хямралын үед ямар арга хэмжээ авахаа хамтдаа шийдэх хэрэгтэй.
- **Виртуал орчин.** Хуралдааныг виртуал хэлбэрээр явуулахад уламжлалт хэлбэрээр явагддаг байсан үйл явцыг виртуал орчинд тохируулж зохицуулах хэрэгтэй.
- **Хяналтыг** үе шаттайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх замаар зохион байгуулах ёстой.

#### Виртуал хуралдааныг зохион байгуулах зөвшөөрөл олгож, шийдвэр гаргах

Парламентын хуралдааныг виртуал хэлбэрээр явуулах янз бүрийн логистик шийдвэрүүд байхаас гадна улс төрийн нөлөөлөл ч байна.

- Спикер, Товчоо эсхүл, Удирдлагын хороо хуралдааныг виртуал хэлбэрээр зохион байгуулах шийдвэрийг гаргаж, нарийвчилсан зохицуулалт хийж болно.
- Парламентын гишүүд тэр дундаа цөөнхийн гишүүдтэй зөвлөлдөх шаардлага болон эрхийн хэм хэмжээ тодорхой байх хэрэгтэй.
- Шийдвэрийг парламент бүрэн бүрэлдэхүүнээрээ гаргах, эсхүл түр хугацаанд хэрэгжээд дуусах зохицуулалт байж болно.

## **Парламентын эрх мэдлийг цөөн тооны гишүүдийн төлөөлөлд шилжүүлэх**

Практикт парламентын хуралдааныг виртуал хэлбэрээр явуулахад цөөн тооны гишүүн оролцуулах нь илүү хялбар байдаг.

- **Сонгож оролцуулах.** Энэ тохиолдолд гишүүдээ сонгож оролцуулах шалгуурыг тодорхойлох нь чухал бөгөөд цөөнхийн эрх, жендэрийн тэнцвэрийг хангах хэрэгтэй.
- **Холимог загвар.** Зарим гишүүд биечлэн, зарим нь виртуал хэлбэрээр оролцох бөгөөд энэ тохиолдолд биечлэн оролцоогүй байдал сул тал болохгүй байхыг анхаарах нь чухал юм.
- **Тусгай хороо байгуулах.** Шинэ хороо байгуулах бөгөөд түүний эрх хэмжээг тодорхой тогтоох нь чухал юм. Одоо байгаа хороодын үйл ажиллагаатай давхцахгүй, мөн тэдний үйл ажиллагаанд саад болохгүй байхад анхаарах хэрэгтэй.

## **Парламентын виртуал хуралдааныг үр дүнтэй явуулахад шаардлагатай нөөц боломж**

Зайнаас ажиллах нь шинэ технологийг ашиглаж сурахаас гадна зайнаас ажиллах, харилцах шинэлэг үйл ажиллагаа болон дэг журмыг хөгжүүлж байна.

- **Шаардлагатай техник хэрэгсэл, сургалт.** Парламентын гишүүдийг гэр, оффис дээрээ виртуал хуралдаанд оролцоход шаардагдах техник хэрэгслээр хангах, мөн сургалт явуулах шаардлагатай болно. Үүнд шинэ ажилтан авах, одоо байгаа ажилтныг сургах зэрэг багтана.
- **Шинэ технологи.** Шинэ технологийг нэвтрүүлэхдээ хэрэглэхэд хялбар байх, өртөг зардал, аюулгүй байдал зэрэг олон шалгуур тавигдана.
- **Онлайн харилцааны төлөв байдал.** Зайнаас ажиллах нь онлайн хэлбэрт зохицсон харилцааны шинэ төлөв байдлыг бий болгоно. Виртуал хуралдааны протокол хөтлөх нь уламжлалт хуралдааныхаас ялгаатай тул шинэ удирдамж гаргах хэрэгтэй. Энэ нь Парламентын удирдлага, мөн хэлэлцүүлэг болон байнгын хороодын хуралдааныг удирдан явуулах даргалагчид гишүүдийн оролцоог тэгш зохистой хангахад ач холбогдолтой байна.
- **Хамт олны (бүлгийн) санал бодол.** Хамт олны санал бодлыг дэмжих нь чухал. Нам, фракц бүлгүүд нь бүлгийн хурал зохион байгуулахыг хүсч болох тул парламентын гишүүдэд намаараа болон хувиараа харилцах албан бус орон зай (тухайлбал, виртуал кафе) хэрэг болно.
- **Олон улсын туршлага солилцох.** Улс орнуудын технологийн шинэчлэлийг судлахаас гадна практикт хэрэглэх боломж, өөрчлөлт шинэчлэлтийн талаар судлах хэрэгтэй.

## **Парламентын гишүүд тойротоо хэрхэн үр дүнтэй ажиллах вэ**

Энэхүү хямралын үед иргэд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад гишүүдээс тусламж хүсч байгаа тул гишүүдийн тойротоо ажиллах ажил нэмэгдэх хандлагатай байна.

- Иргэдийн онлайн харилцаа холбооны хэрэгслийн хүртээмж, мэдлэгээс хамаарч гишүүд тойротоо биечлэн уулзах уулзалтыг өөр хэлбэрээр зохион байгуулах янз бүрийн хувилбарууд байна. Ихэнх парламентын гишүүд орон нутгийн сошиал медиа бүлгүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж байна.
- Парламентын нэмэлт эх үүсвэр болон зөвлөмж нь парламентын гишүүн болон түүний ажилтнууд өөрсдийн санал хүсэлтийг харгалzan тойргийнхoo эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохицуулах боломжийг олгоно.

## **Виртуал парламентын ажлыг олон нийтэд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн мэдээлэх**

Иргэд онлайн хуралдааныг үзэх боломжтой боловч шууд оролцох боломж улам хүндрэх магадлалтай. Парламентын гишүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцаа чөөрчлөгдж магадгүй. Жишээлбэл, сэтгүүлчид улс төрчидтэй бодит амьдрал дээр ярилцахаас илүүтэйгээр нийгмийн сүлжээ дэх мэдээллийг эх сурвалжаа болгох хандлага нэмэгдэнэ.

- **Дотоод харилцаа холбоог зохицуулах төлөвлөгөө** нь гарч буй ахиц дэвшлийг мэдээлэх, үйл ажиллагаатай танилцах боломжийг парламентын гишүүдэд олгоно. Виртуал хуралдааны **өртөгтэй холбоотой** мэдээллийг иргэдэд өгөх нь чухал ач холбогдолтой юм.
- Улс төрчдийн хувьд нийгмийн сүлжээг хэдийнээ ашиглаад эхэлсэн бөгөөд энэ нь заримдаа тэднийг доромжлох, **ёс зүйгүй харьцах** зэрэг асуудлыг үүсгэж байна. Ялангуяа парламентын эмэгтэй гишүүд ялгаварлан гадуурхалт, дарамт үзүүлэх асуудалтай тулгарах нь харьцангуй элбэг байх магадлалтай. Энэ нөхцөлд нийгмийн сүлжээг хэрхэн үр дүнтэй, зүй зохистой ашиглах талаар **дэмжлэг, зөвлөгөө** тустай байх болно.
- Хуралдааны явцыг дамжуулахтай холбоотойгоор **шууд дамжуулах**, эсхүл тодорхой хугацааны дараа дамжуулах эсэхийг шийдэх шаардлагатай. Шууд нэвтрүүлж буй тохиолдолд технологийн аливаа асуудал, алдаа зэрэг нь илт харагдах бол тодорхой хугацааны дараагаар дамжуулах нь нэвтрүүлгийн агуулгыг өөрчилсөн байх асуудлыг үүсгэж болзошгүй.
- Виртуал хэлбэрээр ажиллах нь технологийн талаар өндөр мэдлэг бүхий хүмүүстэй харилцах **өргөн боломжийг** нээж байна. Парламентын цахим хуудас нь харилцах сувгийн нэг хэлбэр боловч хэдийнээ өргөн хэрэглэгдэж буй сувгуудтай нэгдэх замаар оролцоог нэмэгдүүлэх боломжтой юм (Facebook, Instagram, YouTube, зурагт, радио).

## **2.ПАРЛАМЕНТЫН АЖИЛТНУУДЫН АНХААРАХ АСУУДЛУУД**

Дэлхий даяар Парламентууд COVID-19 цар тахлын хариу арга хэмжээ болгон виртуал хуралдааны туршилтууд хийж байна. Энэхүү товч тэмдэглэлд Парламентын ажилтнуудад виртуал парламентын горимд шилжихтэй холбоотой анхаарах гол асуудлуудыг тоймлосон болно.

### **Виртуал Парламентын ажилтнуудыг бүрдүүлэх гол зарчмууд**

- **Чухал чиг үүргүүдийг тодорхойлох:** Парламентын бүхий л чиг үүргийг нэн даруй виртуал горимд шилжүүлэх нь боломжгүй зүйл юм. Хамгийн гол чиг үүргүүдийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэх ёстой бөгөөд хямрал үргэлжлэх тохиолдолд улмаар нэмэгдүүлж болох юм.
- **Байгаа нөөц бололцоог ашиглах:** Байгаа нөөц, хүчин чадалд шалгалт хийх нь үйлчилгээг дасан зохицуулах, тохируулах ажлыг эхлүүлэх сайн суурь болохоос гадна асуудал үүсгэж болзошгүй аливаа дутагдлыг илрүүлнэ.
- **Дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх:** Гишүүд, ажилтнууд шинэ технологи нэн даруй ашиглаж эхлэхэд бэлэн бус байх тул сургалт, дэмжлэг үзүүлэх нь нэн чухал юм. Онлайн хэлэлцүүлэг, хуралдааны шинэ ойлгомжтой дүрэм, журам байх шаардлагатай бөгөөд хамт олны уур амьсгал бүрдүүлэх, алсын зайнаас ажиллаж буй ажилтнуудын эрүүл мэнд, хамгааллыг хангах албан бус сүлжээг дэмжих шаардлагатай.

- **Асуудлыг урьдчилан тооцоолох:** Шинэ технологи нь үргэлж сорилт дагуулж байдаг, виртуал хуралдааны үед гарах аливаа асуудал, доголдол нь маш тод харагдах боломжтой юм. Иймд болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө болон нөөц сонголтуудыг бэлэн байлгах.
- **Бодит хүлээлтийн талаар мэдээлэх:** Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах баг нь Парламентын тэдний төлөө үр дүнтэй ажиллаж байгаа талаар мэдээлэхэд иргэний нийгэм, иргэдтэй хамтран ажиллах шаардлагатай.

### **Виртуал парламентын шинэ процесс, процедур бий болгох**

Виртуал орчинд ажиллаж буй парламентууд нь хоорондоо уялдаа холбоо бүхий процедурын, практикийн болон улс төрийн сорилтуудтай тулгарах юм. Парламентууд нэлээдгүй хугацаанд дэлхий даяар тархаж буй технологийн болон дижитал хөгжлийн хандлагыг харгалзан технологийг илүү үр дүнтэй ашиглах асуудлыг судалж ирсэн байдаг. Ингэхдээ богино хугацаат “түр зуурын” болон парламентын дижитал стратегитай холбоотой урт хугацааны арга хэмжээ хоёрыг ялгаж зааглах нь чухал юм.

- Нэгдүгээрт, **нэн тэргүүний чухал шаардлагатай үйлчилгээ** болон тэвчиж болох үйлчилгээг тодорхойлох. Виртуал ажлын горимд шилжих нь төвөгтэй байх бөгөөд **үндсэн үйлчилгээнд** ач холбогдол өгсөн шилжилтийн үе байж болзошгүй.
- Аливаа шинэ процедурыг тодорхой болгож, тодорхой мэдээлэх. Мөн ямарваа нэгэн **асуудал гарсан тохиолдолд** ажилтнууд ямар арга хэмжээ авах нь тодорхой байх ёстой.
- Эхний ээлжид байгаа нөөц боломждоо тулгуурлан **хялбар хэлбэээр** явуулж, нэгдсэн чуулган болон хороод зэрэг парламентын үйл ажиллагааны хэсгүүдэд анхаарлаа хандуулах.
- Виртуал хуралдааныг уламжлалт аргаар явагддаг хэлбэрт шууд нийцүүлэхээс илүүтэйгээр **виртуал орчинд** тохируулах. Тухайлбал, зарим тохиолдолд санал хураалтыг асинхрон буюу нэгэн зэрэг бус байдлаар явуулах.
- Урт хугацаандаа Парламентууд нь хуримтлуулсан туршлагаа ашиглан иргэдийн оролцоог цахимаар хангах ажлыг өргөжүүлэхэд **техникийн ололт амжилтуудыг ашиглах** боломжтой юм.
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, **туршлагаа баримтжуулах** нь сургамж авах, хяналт тавих болон сайн, зөв шийдэлд хүрэхэд туршилт хийх шаардлага, болон тэр болгон нэг дэх оролдлогоос төгс ажиллагааг хангах боломжгүйг хүлээн зөвшөөрөхөд дэмтэй юм.

### **Парламентын гишүүд болон тэдгээрийн ажилтнуудад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх нь**

Парламентын гишүүд болон ажилтнууд алсын зайнаас ажиллах технологи болон горимын талаар мэдлэг, мэдээлэл хангальтай бус байж болно.

- Технологийн мэдлэг, онлайн чадавх нь харилцан адилгүй байх ба ихэнх гишүүд болон тэдгээрийн ажилтнуудад шинэ тоног **төхөөрөмж, сургалт болон зөвлөгөө** шаардагдаж болзошгүй.
- Виртуал парламент нь эхний ээлжинд цомхон хүрээнд явагдаж байгаа нөхцөлд Парламентын гишүүд болон тэдгээрийн ажилтнуудад **ямар үйлчилгээ авах боломжтой болон боломжгүй** талаар, бусад үйлчилгээг яаж авах болон ямар шалтгаанаар тус шийдвэрийг гаргасныг тодорхой ойлгуулах шаардлагатай.

- Парламентын гишүүд болон тэдгээрийн ажилтнуудыг **техниктэй холбоотой** болон шинэ технологи ашиглахтай холбоотой асуудлыг хэн шийдвэрлэж, хариуцах вэ? Хуралдааны үеэр гарах яаралтай асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт хүний нөөц шаардагдаж болзошгүй.
- Хамгийн нийтлэг асуултуудтай холбоотой шинэ **удирдамж** гаргаж, ирүүлж буй **санал хүсэлт**, асуултуудыг харгалзан тогтмол шинэчлэх. Энэ нь зөвхөн техникийн асуудлыг төдийгүй онлайн горимд ажиллахад протоколын асуудлыг хамарна.
- Ихэнх парламентын хувьд ахлах ажилтнуудаас Парламентын гишүүдэд өгөх хувийн зөвлөгөөг маш өндөрөөр үнэлдэг – үүнийг виртуал Парламентын орчинд хэрхэн хангаж ажиллахыг тусгайлан зохицуулах шаардлага гарч болзошгүй.

### **Парламентын ажилтнууд үр дүнтэй ажиллах боломжтой байх**

Үр дүнтэй виртуал парламентад нэмэлт хүний нөөц, техник болон логистикийн нэмэлт нөөц шаардагдах юм. Парламентын ордон (барилга байгууламж)-д ажиллах шаардлага гарах магадлал маш өндөр юм.

- **Шинэ технологийн** сонголтыг хийхэд маш олон хүчин зүйл нөлөөлнө. Тухайлбал, ашиглахад хялбар байдал, өртөг зардал, хэрэглэж хэвшсэн байдал болон аюулгүй байдал, нууцлал зэрэг. Мэдээллийн технологийн системийг хэн, хаанаас удирдаж явуулах вэ?
- **Сургалтыг** дан ганц техник талаасаа бус, алсын зайнаас ажиллах шинэ горим, онлайн протокол зэрэг асуудал талаас харгалзах нь чухал юм.
- Парламентын ажилтнуудаас хэн нь **ажлын байран** дээрээ ажиллах шаардлагатай, хэн нь **алсын зайнаас** ажиллах вэ?
- Алсын зайнаас буюу **гэрээсээ ажиллаж** байгаа ажилтнуудад ямар нэмэлт нөөц шаардлагатай вэ? Технологи, аюулгүй байдал, нууцлалыг хангасан IT, утасны төлбөр гм. Алсын зайнаас ажиллаж буй ажилтнуудад ажлын байранд нь байгаа нөөц (ном, ширээ, файл, аюулгүй байдал, нууцлалыг хангасан IT гм.) шаардлагатай тохиолдолд хэрхэх вэ? Тийм бол тус асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
- Ажилтнууд нь өвчний, эсхүл харилцаа холбооны догоолдлын улмаас ажиллах боломжгүй байх нөхцөл байдал үүсэх боломжтой юу? Одоо ажиллаж байгаа ажилтнууддаа ажлын **бусад чиг үүрэгтэй холбоотой сургалт** явуулах шаардлага гарч болзошгүй.
- **Сайн туршлагыг** бусад парламентуудтай хуваалцах нь томоохон дэмжлэг болох юм.

### **Байгууллагын соёл ба харилцан дэмжлэг үзүүлэх тогтолцоо**

Үр дүнтэй виртуал, эсхүл хэсэгчлэн виртуал парламент нь боловсон хүчин, парламентын гишүүдийн хувьд хүчтэй институцийн соёлтой бол хамгийн амжилттай байх боломжтой. Хамтын ажиллагаа, мэдээллийн урсгалыг сайн хангаж өгөх нь чухал бөгөөд ингэснээр үйлчилгээний чанарын өндөр стандартыг хадгалах боломжтой.

- Ажилтнууд ажилтай холбоотой асуудлаар болон **албан бус асуудлаар** бие биетэйгээ хэрхэн ярилцаж, холбогдох вэ? Тэдэнд ярилцах орон зайд байгаа уу (жишээ нь виртуал кафе)?
- Алсын зайнаас ажиллаж байгаа ажилтнуудад ажлын болон ажлын бус цагийг хооронд нь ялгаж зааглахад хүндрэл учрах, эсхүл тусгаарлагдсан сэтгэгдэл төрж болзошгүй

юм. **Хамт олны орчныг бүрдүүлэх** санаа санаачилгууд нь хүнд хэцүү цаг үед институцийн соёлыг хадгалахад тусална.

### Дотоод болон гадаад харилцаа холбоо

Виртуал орчинд үйл ажиллагаа явуулах арга хэмжээ нь **харилцаа холбооны төлөвлөгөөтэй** хавсарсан байх ёстой. Виртуал үйл ажиллагаанд шилжих нь олон нийтийн оролцоог хангах боломжийг нээхээс гадна эрсдлийг дагуулна.

- Төлөвлөлтийн хэлэлцүүлэгт **парламентын холбооны багийг** боломжийг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулах/хариу арга хэмжээ авах зорилгоор зайлшгүй оролцуулах. Хэрэв парламент зөвхөн хязгаарлагдмал буюу цомхон хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа бол энэ талаар тодорхой мэдээлж, хүлээлтийг зохих ёсоор зохицуулах шаардлагатай.
- Харилцааны сувгууд нь парламентын цахим хуудас зэргийг ашиглаж болох ч иргэдийн хэдийн ашиглаж заншсан сувгууд (Facebook, Instagram, YouTube гм., телевиз, радио зэрэгтэй)-тай хамт ашиглах замаар илүү их үр дүнд хүрэх боломжтой юм.
- Шинэ технологи, журмыг Засгийн газар, улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг бусад байгууллагуудын ашиглаж буй процесстий **нэгтгэх** шаардлагатай.

### Нэмэлт мэдээлэл

- ОУПХ-оос улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ, туршлагын талаар мэдээллийг нэгтгэж, тогтмол шинэчилж байгаа бөгөөд [Inter-Parliamentary Union \(IPU\)](#) холбоосоор орж үзэх боломжтой.

**Эх сурвалж:** The Asia Foundation болон Global Partners Governance байгууллагуудын гаргасан “Virtual Parliaments: Issues for Parliamentary Staff”, Virtual Parliaments: Issues for Parliamentarians мэдээллээс орчуулав.



**ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ДЭГ ЗӨРЧСӨН ГИШҮҮНД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Д.Амаржаргал (Ph.D),  
Г.Билгээ, П.Уранчимэг,*

**АГУУЛГА**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**

1. Австралийн Холбооны Улс
2. Бүгд Найрамдах Герман Улс
3. Оросын Холбооны Улс
4. Бүгд Найрамдах Солонгос Улс
5. Япон Улс
6. Бүгд Найрамдах Сингапур Улс
7. Бүгд Найрамдах Франц Улс
8. Бүгд Найрамдах Болгар Улс
9. Бүгд Найрамдах Словак Улс

**ХАВСРАЛТ**



## СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

### **Судалгааны хамрах хүрээ**

Судалгаанд гадаадын зарим оронд парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн зохицуулалтын талаар судалсан болно.

Судалгаанд Австрали, ХБНГУ, ОХУ, БНСУ, Япон, Сингапур, Болгар, Франц, Словак зэрэг 9 улсын парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагын талаар нарийвчлан судалсан.

Үүнээс парламентын засагтай 6 улс:

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс;
- Бүгд Найрамдах Сингапур Улс;
- Бүгд Найрамдах Болгар Улс;
- Бүгд Найрамдах Словак Улс;
- Австралийн Холбооны Улс;
- Япон Улс.

Ерөнхийлөгчийн болон холимог засагтай 3 улс:

- Оросын Холбооны Улс;
- Бүгд Найрамдах Солонгос Улс;
- Бүгд Найрамдах Франц Улсыг хамруулсан болно.

### **Судалгааны үр дүнгийн тойм**

Судалгааны дүнг нэгтгэн, хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг:

- сануулах;
- хуралдаанд уг хэлэх эрхийг хасах;
- хуралдаанд оролцох эрхийг хасах;
- торгох;
- бусад гэж ангилан Хүснэгт 1-р харуулсан болно.

Судалгаанд хамрагдсан орнуудад парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагын нийтлэг төрөлд хуралдаанд оролцох эрхийг хасах, сануулах, торгуулийн шийтгэл багтаж байна. Эдгээр шийтгэлийн хамгийн их хэрэглэгдэж байгаа байдлаар авч үзвэл:

□ **Хуралдаанд оролцох эрхийг хасах шийтгэлийн хувьд** судалгаанд авагдсан нийт 9 улсаас 8 улсад тус шийтгэлийг хуралдааны дэг зөрсөн гишүүнд ногдуулдаг бол \*Словак Улсын Үндэсний Зөвлөлийн хувьд **санал хураалтаас бусад хэлбэрээр хуралдаанд оролцох эрхийг хасах** шийтгэлийг ногдуулж байна.

Хуралдаанд оролцох эрхийг хасах **шийтгэлийг ногдуулж буй хугацааны хувьд** 5 улсад зөрчлийн хэмжээнд тохируулан хугацааг тогтоосон байгаа бөгөөд хамгийн багадаа 1 цаг (Австрали) байгаа бол хамгийн ихдээ Сингапур Улсын Парламентын гишүүнд тухайн чуулганы хугацааг дуустал (Парламентын тухай хуулийн 20 дугаар зүйл, Хуралдааны дэгийн 58, 59 дүгээр зүйл) ногдуулах зохицуулалтууд тусгагдсан байна.

ХБНГУ, БНСУ /зарим зөрчилд 90 хоног/, Япон Улсын Парламентын хувьд хуралдаанд оролцох эрхийг хасах шийтгэлийн дээд хязгаарыг 30 хоногоор тогтоосон байна.

\*ОХУ-ын Холбооны Хурлын доод танхим болох Төрийн Думын хувьд 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын 5220-7 дугаар тогтоолоор

Төрийн Думын Регламентад өөрчлөлт оруулж “хуралдаанд оролцох эрхийг хасах” шийтгэлийг “гишүүний үг хэлэх хугацааг дуусгавар болгох” шийтгэлээр сольсон байна.<sup>207</sup>

#### Шийтгэлийг ногдуулах үндэслэлийн хувьд:

- Парламентын тухай хууль, дэг журам зөрчсөн, сануулга авсан ч дагаж мөрдөөгүй бол (§145.1-2 БНСҮ);
- Парламентын дотоод дэг журам, нэр хүндийг ноцтой зөрчсөн гишүүнийг (§38.1 ХБНГУ);
- Зэмлэлийг үл тоосон, эсхүл 2 удаа зэмлүүлсэн бол (§145.1-2 Франц);
- Танхимаас гарах шаардлагыг биелүүлээгүй бол (§94 а Австрали);
- Хуралдаан даргалагчийг үл тоомсорлох, санаатайгаар олон дахин хуралдааныг үймүүлж, дэгийг зөрчсөн бол Спикер (Дэгийн §59 Сингапур).

#### Шийтгэлийг ногдуулах нөхцөлийн хувьд:

- Нэр дуудах шийтгэл ногдуулж, хуралдаанд оролцох эрхийг хасах асуудлаар санал хураалт явуулна (§94 б Австрали);
- Парламентын дотоод дэг журмын зөрчсөн, парламентын нэр хүндийг унагаж сануулга авсан эсэхээс үл хамаарч (§38.1 ХБНГУ);
- Гишүүн, эсхүл аливаа этгээд парламентыг үл хүндэтгэх үйлдэл (*contempt*)<sup>208</sup> гаргасан бол Парламентын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан шийтгэл (Үүнд: тухайн чуулган дуусах хүртэл хугацаанаас дээшгүй хугацаагаар хорих, хуралдаанд оролцох эрхийг хасах, торгууль, донгodoх/хатуу донгodoх)-ийг бүгдийг, эсхүл аль нэгийг нь Парламент ногдуулна (Хуулийн §20.1, 21.1 Сингапур).

#### Шийтгэлийн хугацааны хувьд:

*Зөрчлийн хэмжээнд тохируулан хугацааг тогтоож өгсөн байдал:*

- 1 цаг, 24 цаг, дараалсан 3 хуралдаан, дараалсан 7 хуралдаан (§94 д Австрали);
- 15 хоног, 30 хоног (§73.2-3 Франц)
- Шийтгэл авсан гишүүн танхимаас нэн даруй гараагүй бол шийтгэлийн хугацааг сунгахаар заасан (§38.3 ХБНГУ);
- 1 хуралдааны турш, 2-3 хуралдааны турш (§161-162 Болгар);
- Тухайн хуралдааны өдрийг дуустал, тухайн чуулганыг хугацааг дуустал (Дэгийн §58, 59.48 Хуулийн §20.1 с Сингапур).

*Дээд хэмжээг тогтоосон байдал:*

- 30 хүртэл хоног (§38.1 ХБНГУ, §242 Япон);
- 30 хүртэл хоног, зарим зөрчилд 90 хүртэл хоног (§163.3 БНСҮ).

*Шийтгэл ногдуулах субъектийг заасан байдал:*

- Шийтгэлийн хугацааг Парламент тогтооно (§59.3 Сингапур);
- Ёс зүйн тусгай хорооны хяналт шалгалтаар дамжуулан шийдвэр гаргаж шийтгэнэ (§155 БНСҮ).

#### Үйлчлэх хүрээний хувьд:

- Нэгдсэн болон хорооны хуралдааны танхим, иргэд, зочдын парламентын хуралдаантай танилцах хэсэг (§94 е Австрали);
- Парламентын ордон (§60 Сингапур, §73.1 Франц).

<sup>207</sup> ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Регламент, <http://duma.gov.ru/duma/about/regulations/>

<sup>208</sup> “contempt” гэж Парламентын () тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан зөрчлүүдийг ойлгоно. Сингапурын Парламентын тухай хуулийн 2 дугаар зүйл.

Парламентын тухай хуулийн 5 дугаар бүлэг. Үүнд: “Парламент, эсхүл хорооны дэг журам, шийдвэрийг, эсхүл Спикерийн хууль, дэгийн дагуу тавьсан шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан ...”  
<https://sso.agc.gov.sg/Act/PPIPA1962?ProIds=P1I-#pr1>

**Санал хураалтаас бусад хэлбэрээр хуралдаанд оролцох эрхийг хасах /танхимаас гарах үүрэгтэй/:**

- Тухайн өдрийн хуралдаанд (§32.2 Словак).

□ **Сануулгын шийтгэлийн хувьд** судалгаанд авагдсан 9 улсаас 7 улсад хуралдааны дэг зөрчсөн гишүүнд тус шийтгэлийг ногдуулж байна. Үүнээс сэдвээрээ ярих болон дэг журмын сануулгыг ХБНГУ, ОХУ, Франц, Словак зэрэг улсын Парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хэрэглэж байна.

\*Харин Австрали, Сингапур Улсын Парламентын хувьд хуралдааны дэг зөрчсөн гишүүнийг нэрээр дуудах буюу нэрийг нэрлэх шийтгэлийг хэрэглэдэг бөгөөд Парламентын Төлөөлөгчдийн танхимиын Спикер, эсхүл хуралдаан даргалагч тухайн шийтгэлийг ногдуулахаас өмнө гишүүнд анхааруулга өгч болох боловч үүнийг даргалагчийн үүрэгт тухайллан тусгаагүй байна (Австрали).<sup>209</sup>

**Сануулах шийтгэлийн төрлийн хувьд:**

- сэдвээрээ ярих сануулга болон дэг журмын сануулга (§36 ХБНГУ, §52 а, б ОХУ, §32.1-2 Словак, §54.6, §71.2 Франц);
- сэдвээрээ ярих сануулга (§156 Болгар);
- дэг журмын сануулга (§145.1 БНСУ, §116 Япон).

\*Сануулгын шийтгэл ногдуулах тоо, хэмжээний хувьд судалгаанд авсан орнуудаас ХБНГУ-ын Бундестагийн хуралдааны дэгээр нарийвчлан тогтоосон байна. Үүнд: §36.2-т “3 удаа хэлэлцэж буй асуудалтай холбоотой үг хэлэх талаар сануулга авсан, эсхүл 3 удаа дэг журмын сануулга авсан ба 2 дахь сануулгын хүрээнд 3 дахь сануулгын үр дагаврын талаар түүнд хэлэх...”-ээр заасан.

□ **Торгуулийн шийтгэлийн хувьд** судалгаанд авагдсан нийт 9 улсаас 6 улс хуралдааны дэг зөрчсөн гишүүнд торгуулийн шийтгэл ногдуулдаг байна. Торгуулийн хэмжээг мөнгөн дүнгээр тогтоосон орнуудын хувьд хамгийн багадаа 1000 евро (Словак, ХБНГУ), хамгийн ихдээ 50 000 сингапур доллар (30 000 гаруй евро)-аас хэтрэхгүй (Сингапур Улсын Парламентын тухай хуулийн 37-р зүйл,) байхаар тогтоосон байна. Франц, Сингапур, Болгар, БНСУ-ын парламентуудын хувьд хуралдааны дэг зөрчсөн гишүүнд ногдуулах торгуулийг цалинтай уялдуулж тогтоосон байна. Тухайлбал, Болгар, Сингапур зэрэг улсын Парламентын хувьд парламентын гишүүний хуралдаанд оролцох эрхээ хасуулсан шийтгэлийн хугацаанд цалинг олгохгүй.

**Торгууль ногдуулах нөхцөлийн хувьд:**

- Парламентын дэг журам, нэр хүндийг зөрчсөн, сануулга өгсөн эсэхээс ул хамаарна (§37.2 ХБНГУ);

**Торгуулийн хэмжээний хувьд:**

Торгуулийн хэмжээг мөнгөн дүнгээр тогтоосон байдал:

- 1 000 евро (§139.2 Словак);
- 1 000, 2000 евро (§37.2 ХБНГУ);
- 50 000 сингапур доллараас хэтрэхгүй (Хуулийн §37 Сингапур).

Торгуулийн хэмжээг цалинтай уялдуулж тогтоосон:

- Нэг, зургаан сарын цалингийн 25 хувь, нэг, хоёр сарын цалингийн 50 хувь, 6 сарын цалинтай тэнцүү (§76-77 Франц);

<sup>209</sup> Австралийн Парламентын Төлөөлөгчдийн танхимиын хуралдааны дэгийн тайлбар, 2018 он [https://www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/Practice7/HTML/Chapter14/Powers\\_of\\_Chair\\_to\\_enforce\\_order](https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter14/Powers_of_Chair_to_enforce_order)

- Хуралдаанд оролцох эрхээ хасуулсан өдрийн цалинг олгохгүй (§162 Болгар, Хуулийн §29.3 Сингапур);
- Хуралдаанд оролцох эрхээ хасуулсан өдрийн хөдөлмөрийн хөлс, хуулийн тесэл боловсруулах үйл ажиллагааны хөлс болон онцгой үйл ажиллагааны хөлсний 50 хувь (§155.3 БНСУ).

□ **Хуралдаанд үг хэлэх эрхийг хасах шийтгэлийн хувьд** судалгаанд хамрагдсан нийт 9 улсаас 5 улс (ХБНГУ, БНСУ, Япон, Франц, Болгар)-д хуралдааны дэг зөрчсөн гишүүнд тус шийтгэлийг ногдуулдаг бол ОХУ, Словак, Сингапур Улсуудын хувьд гишүүний үгийг дуусгавар болгох буюу гишүүний үгийг таслах зохицуулалт тусгагдсан байна. Шийтгэлийн хугацааны хувьд хэлэлцэж буй асуудлын хэлэлцүүлгийг дуустал, эсхүл тухайн өдрийн хуралдаанд гишүүний үг хэлэх эрхийг хасахаар зохицуулсан байна.

#### Шийтгэлийг ногдуулах нөхцөлийн хувьд:

- Сануулгын шийтгэлийг ногдуулсны дараа (§36.2 ХБНГУ, §145.2 БНСУ, §116 Япон, §71.3 Франц);
- Сануулга, донгодах, хатуу донгодах шийтгэлээс хоёрыг нь ногдуулсны дараа (§160.1 Болгар); мөн
- үг хэлэх/асуулт асуух хугацаа хэтэрч, Спикер дуусгавар болгохыг санал болгосон ч үргэлжлүүлсэн бол (§160.2 Болгар).

#### Шийтгэлийн хугацааны хувьд:

- Хэлэлцэж буй асуудлын хэлэлцүүлгийг дуустал (§36.2 ХБНГУ);
- Тухайн өдрийн хуралдаан (§145.2 БНСУ);
- Тухайн өдрийн хуралдаанд, хэлэлцүүлэгт дараагийн өдөр үргэлжлэх бол хэлэлцэж буй асуудлыг дуустал (§116 Япон);
- Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчөөр шийдвэрлээгүй бол, хуралдааныг дуустал (§71.3 Франц).

#### Гишүүний үг хэлэх хугацааг дуусгавар болгох буюу гишүүний үгийг таслах:

\*ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Регламентын 52.2-т заасны дагуу гишүүн сэдвээрээ ярих сануулга авч, дахин зөрчил гаргасан бол Төрийн Думын хуралдааны даргалагч түүний үгийг тасална.

\*Францын Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн 54 дүгээр зүйлийн 54.6-д заасны дагуу “Гишүүн сэдвээрээ ярих сануулга авч, сануулгыг үл тоосон, эсхүл гишүүн зөвшөөрөлгүй үг хэлж, Ерөнхийлөгч /Үндэсний Ассамблейн дарга/-ийн үгээ дуусгах шаардлагыг хүлээж аваагүй бол Ерөнхийлөгч гишүүний үг хэлэхийг зогсоож, түүний хэлсэн үгийг тэмдэглэлд оруулахгүй байхыг тушаана”.

#### □ **Бусад**

#### **Парламентын хуралдааны дэг зөрсөн гишүүнийг “нэрлэх” шийтгэл<sup>210</sup>**

“Нэрлэх/ нэр дуудах” (улмаар гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасах) шийтгэл нь Их Британийн парламентад анх 1641 онд хэрэглэгдсэн бөгөөд хурал даргалагчийн ногдуулж болох хамгийн хүнд шийтгэлд тооцогддог байна. Тухайлбал, Австралийн парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгийн 64 дүгээр зүйлд “Танхим болон Холбооны танхимд байгаа ямар ч гишүүнийг нэрээр нь дуудахгүй бөгөөд зохих ёсоор дараах байдлаар дуудна гэж заасан. Үүнд: Засгийн газрын гишүүн, Парламентын гишүүн,

<sup>210</sup> [https://www.aph.gov.au/About%20Parliament/House%20of%20Representatives/Powers%20practice%20and%20procedure/Practice7/HTML/Chapter14/7chap14\\_2\\_6.html#\\_ftn453](https://www.aph.gov.au/About%20Parliament/House%20of%20Representatives/Powers%20practice%20and%20procedure/Practice7/HTML/Chapter14/7chap14_2_6.html#_ftn453)

Сонгогдсон тойргийн гишүүн.”

Төлөөлөгчдийн танхимд Спикерийг үл хүндэтгэсэн, бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн, холбогдолгүй, хамааралгүй асуудлаар ярих, үг хэлж буй гишүүний яриаг тасалж буй гишүүнд нэр дуудах шийтгэлийг ногдуулна. Тус шийтгэлийг ногдуулахаас өмнө Спикер тухайн гишүүнд сануулга өгч болох боловч тэгэх үүргийг хүлээдэггүй байна. Хэрэв гишүүн учлал гүйж, Спикер хүлээн авсан тохиолдолд цааш ямар нэгэн арга хэмжээ авахгүй, харин тус шийтгэлийг ногдуулсан тохиолдолд Спикер тухайн гишүүнийг хуралдаанд оролцуулахгүй байх, эсхүл Парламент шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авахыг хүлээж болно. Спикер хоёрдугаар хувилбарыг сонгосон тохиолдолд өөр нэг гишүүн, ихэнх тохиолдолд Танхим дахь Засгийн газрын тэргүүн<sup>211</sup>-гишүүнийг хуралдаанд оролцох эрхийг хасах саналыг нэн даруй оруулах бөгөөд тухайн саналыг хэлэлцэхгүй, өөрчлөхгүйгээр санал хураалт явуулна. Саналыг дэмжсэн тохиолдолд гишүүн Танхимаас гарч явах үүрэгтэй.<sup>212</sup>

Мөн дээрхтэй адил шийтгэлийн төрөл Сингапур Улсын Парламентад хэрэглэгддэг байна. (Парламентын хуралдааны дэгийн 58-59 дүгээр зүйл)



<sup>211</sup> Leader of the Government in the House

<sup>212</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/Practice7/HTML/Chapter14/Powers\\_of\\_Chair\\_to\\_enforce\\_order](https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter14/Powers_of_Chair_to_enforce_order)

**Хүснэгт 1. Парламентын хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага**

Улсын нэр		АВСТРАЛИ		ХБНГУ	ОХУ	БНСУ	ЯПОН	СИНГАПУР	ФРАНЦ	БОЛГАР	СЛОВАК
№	Хариуцлагын төрөл	Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг	Бундестагийн хуралдааны дэг	ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Регламент	Үндэсний Ассамблейн тухай хууль	Парламентын тухай хууль Зөвлөхүүдийн танхимын хуралдааны дэг	Парламентын тухай хууль <sup>213</sup> Хуралдааны дэг	Үндэсний Ассамблейн хуралдааны дэг	Үндэсний Ассамблейн хуралдааны дэг	Үндэсний зөвлөлийн дэгийн тухай хууль	
1	Сануулах	тусгагдаагүй	Хэлэлцэж буй асуудалтай холбоогүй уг хэлэх, дэг зөрчвөл 1 удаа § 36.1	Регламентын заалтыг зөрчвөл сануулах § 52.2.a, b	Нээлттэй хуралдаан дээр сануулга өгөх § 145.1	сануулга өгөх, уг хэлэх эрхийг нь хязгаарлах, хэлсэн үгээ татаж авахын аль нэгийг шаардана § 234-235 Хуулийн § 116	тусгагдаагүй	Ерөнхийлөгч /УА-ийн дарга/ сэдвээрээ ярихыг сануулна § 54.6  Ерөнхийлөгч дэг сахихыг сануулна § 71.2	Спикер сануулга өгнө § 156	Хуралдаан даргалагч хэлэлцэж буй асуудлын сэдвээс гажсан бол сануулах §32.1-2	
2	Хуралдаанд уг хэлэх эрхийг хасах /Уг хэлэх хугацааг дуусгавар болгох	тусгагдаагүй	3 удаа сануулга авсан бол § 36.2	*Уг хэлэх хугацааг дуусгавар болгох § 52.2	Сануулгыг дагах мөрдөхгүй бол уг хэлэх эрхийг хасна § 145.2	*Уг хэлэх хугацааг дуусгавар болгох § 58-61	Сануулга авсан гишүүн чуулганы хуралдааны төгсгөл хүртэл уг хэлэх эрхгүй § 71.3	Уг хэлэх/асуулт асуух хугацаа хэтэрч, Спикер яриагаа дуусгавар болгохыг санал болгосон ч үргэлжлүүлсэн бол § 160	*Уг хэлэх хугацааг дуусгавар болгох §32.2		
3	Хуралдаанд оролцох эрхийг хасах	Спикерийн захирамжийг дагахгүй бол 1 цаг, 24 цаг түүнээс дээш хугацаагаар түдгэлзүүлэх, § 94.e	30 хүртэл хоногоор оролцуулахгүй байж болно § 38.1	тусгагдаагүй	30 хүртэл хоногоор хуралдаанд суухыг хориглох§ 163.3	шаардлагыг биелүүлэхгүй бол уг хуралдааны өдөр дуусах хүртэл, эсхүл маргааш өдрийг дуустал § 242	тухайн өдрийн хуралдаанаас гарахыг шаардах эрхтэй, татгалзсан тохиолдолд чуулганы	15 хоногийн хугацаанд ордонд хүрэлцэн ирэхийг хориглоно. Давтан хариуцлага хүлээх бол хугацааг 30 хоног хүртэл сунгана § 73.2, 73.3	ногдуулсан сахилгын шийтгэлийг бүдүүлэг, зохисгүй байдлаар эсргүүцсэн, доромжилсон,	шаардлагыг хүлээн аваагүй бол Спикер зөрчил гаргасан гишүүнийг тухайн өдрийн хэлэлцүүлэгт оролцох эрхийг	

<sup>213</sup> Сингапурын Парламентын тухай хууль, 2000 он <https://sso.agc.gov.sg/Act/PPIPA1962#pr21->

					30 хоног хүртэл § 242	хугацааг дүүсах хүртэлх хугацаагаар § 58-60		хүч хэрэглэсэн бол 1-3 хуралдаанд оролцох эрхийг хасна § 161, 162	нь хасна. Гишүүн санал хураалтад оролцох эрхтэй байна. § 32.2	
4	Торгох	тусгагдаагүй	Дотоод дэг журам, нэр хүнд зөрчсөн гишүүн 1000 евро, давтан гаргасан бол 2000 еврогоор торгуулна § 37.1	тусгагдаагүй	Сануулга, үүчлалт хүсэх үед цалингийн ½, § 155.4.1 30 хоног оролцох эрхийн хассан бол 3 сарын цалин олгохгүй § 155.4.2	тусгагдаагүй	50 000 доллар хүртэл,  Хуулийн § 20  Хуралдаанд оролцох эрхээ хасуулсан өдрийн цалинг олгохгүй  Хуулийн § 29.3	Дэг сахиулахыг сануулсан тухай тэмдэглэл нь гишүүний цалингийн 1/4-ийг 1 сарын турш § 71.6 1 удаагийн энгийн зэмлэл 1 сарын турш цалингийн хагсаар § 76.1 зэмлэл болон түр түдгэлзүүлсэн бол 2 сарын турш цалингийн хагсаар § 76.2 санал хураалтад саад хийвэл 1 сарын цалингийн 1/4, давтан үйлдвэл 6 сар олж сунгагдана § 77-1.1, 77-1.2	Хуралдаанд оролцох эрхээ хасуулсан өдрийн цалинг олгохгүй § 162	өөр гишүүний өмнөөс санал өгснийг тогтоосон тохиолдолд 1000 европийн торгууль §139.2
5	Бусад хариуцлага	Гишүүнийг нэрлэх болон түдгэлзүүлэх § 94.b, d	тусгагдаагүй	Нээлттэй хуралдаан дээр үүчлал хүсэх § 155.2	Нэгдсэн чуулганы нээлттэй хуралдаан дээр үүчлал хүсэх § 122.2  Гишүүнээс хасах хуулийн § 122.4	Гишүүнийг нэрлэх,  Баривчлах, хорих,  Гишүүнийг огцруулах  Хуулийн § 20 c	Хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавина § 71.2 ҮХ-ын Ерөнхийлөгч /ҮА-ийн дарга/-ийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй бол дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана §	Донгodoх шийтгэл § 158  Хатуу донгodoх шийтгэл § 159	Донгodoх шийтгэл, Гишүүнийг огцруулах §139.2-3	

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ДЭГ ЗӨРЧСӨН ГИШҮҮНД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

#### 1. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС<sup>214</sup>

Тус улсын Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн 8 дугаар бүлэгт тус танхимын хуралдаанд дэг журамтай хэлэлцүүлэг явуулах болон биеэ авч явах ерөнхий журмын талаар тусгасан байна.<sup>215</sup>

##### Эмх журамгүй үйлдэл

Дараах тохиолдолд “эмх журамгүй үйлдэл” гэж үзнэ (Дэгийн §91):

- 1) хуралдаанд санаатайгаар саад учруулсан бол;
- 2) дэгийг санаатайгаар зөрчсөн бол;
- 3) зүй бус үг хэрэглэсэн, зүй бус үгээ буцааж авахаас татгалзсан бол;
- 4) дэг сахихаас санаатайгаар татгалзсан бол;
- 5) Спикерийг санаатайгаар үл тоомсорлосон бол;
- 6) Спикер хуралдааны дэг зөрчсөн гэж үзсэн бол.

##### Хүлээлгэх хариуцлага (Дэгийн §94)

Спикер нь гишүүний эмх журамгүй үйлдэл гаргагсдад дараах арга хэмжээг авна:

###### 1) *Танхимаас гаргах захирамж:*

- хуралдааны дэг зөрчсөн гишүүнийг танхимаас нэг цагийн хугацаатай гаргах захирамж гаргах ба уг захирамжийг хэлэлцэхгүй;
- хэрэв тухайн гишүүн танхимаас нэн даруй гараагүй бол Спикер нь Дэгийн 94.b-д заасан журмын дагуу арга хэмжээ авна.

###### 2) *Гишүүнийг нэрлэх болон хуралдаанаас түдгэлзүүлэх* (Дэгийн §94.b):

- Спикер хуралдааны дэг зөрчсөн гишүүнийг нэрлэж болно;
- Спикер гишүүнийг ийнхүү нэрлэсний дараа тухайн гишүүнийг хуралдаанаас түдгэлзүүлэх буюу хуралдаанд оролцуулах эсэх талаар санал хураалт явуулна. Энэ асуудлыг хэлэлцэхгүйгээр шийдвэрлэнэ.

###### 3) *Зайлшгүй арга хэмжээ авах:*

- хэрэв Спикер нь танхимын нэр төрийг хамгаалах зайлшгүй шаардлага байна гэж үзвэл хуралдааны дэг зөрчсөн гишүүнийг танхимаас нэн даруй гарахыг захирамжилж болно;
- хэрэв гишүүн танхимаас нэн даруй гарахгүй бол Спикер нь Дэгийн 94.b-д заасны дагуу гишүүнийг нэрлэнэ;

<sup>214</sup> Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг. Гарын авлага. Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл. 2019. 42 дэх тал

<sup>215</sup> Ruling - a formal decision made by the President or Speaker, usually on a matter of procedure in the Senate or the House of Representatives.

Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн 8 дугаар бүлэг. [https://publicofficialsfinancialdisclosure.worldbank.org/sites/fdl/files/assets/law-library-files/Australia\\_House\\_of\\_Representatives\\_Standing\\_Orders\\_as%20of%20March%202006\\_EN.pdf](https://publicofficialsfinancialdisclosure.worldbank.org/sites/fdl/files/assets/law-library-files/Australia_House_of_Representatives_Standing_Orders_as%20of%20March%202006_EN.pdf) хандсан 2020.08.29

- шаардлагатай гэж үзвэл тодорхой хугацаагаар хуралдаанаас түдгэлзүүлэх эсэх талаар санал хураалт явуулна;
- хэрэв санал хураалт дэмжигдээгүй бол гишүүн танхимд буцаж ирж болно.

**4) Хуралдаанаас түдгэлзүүлэх хугацаа:**

- гишүүнийг хуралдаанаас түдгэлзсэн бол дараах хугацааг баримтална:
  - анх удаа түдгэлзүүлсэн бол 24 цагийн хугацаанд;
  - тухайн хуанлийн жилд хоёр дахь удаа түдгэлзүүлсэн бол түдгэлзүүлсэн өдрөөс хойш дараалсан 3 хуралдааны хугацаанд;
  - тухайн хуанлийн жилд гурав, түүнээс олон удаа түдгэлзүүлсэн бол түдгэлзүүлсэн өдрөөс хойш дараалсан 7 хуралдааны хугацаанд;
- дээрх хугацааг тогтооход өмнөх чуулганаар түдгэлзүүлж байсан, эсхүл танхимаас нэг цагийн хугацаатай гаргаж байсан захирамж хамаarahгүй.

**5) Хуралдааны танхимаас гаргах:**

- үүнд, гишүүнийг танхимаас нэг цагийн хугацаатай гаргах болон хуралдаанаас 24 цаг, эсхүл түүнээс дээш хугацаанд түдгэлзүүлснийг хамааруулна.

**6) Хуралдааны танхимаас албадан гаргах:**

- хэрэв гишүүн нь танхимаас гаргах захирамжийг дагахаас татгалзвал Спикер түүнийг хуралдааны танхимаас албадан гаргах, эсхүл түр saatuuлах байранд аваачихыг дэг сахиулагчид (Sergeant-at-Arms)<sup>216</sup> тушааж болно.

**Хуралдааныг завсарлуулах, эсхүл хойшлуулах (Дэгийн §95)**

Хуралдааны танхимд эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд Спикер дараах арга хэмжээг авах ба ингэхдээ санал хураалт явуулахгүй:

- тухайн хуралдааныг завсарлуулах ба эргэж хэзээ хуралдахыг мэдэгдэх;
- тухайн хуралдааныг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулах.

**2. БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС<sup>217</sup>**

Герман Улсын Бундестагийн хуралдааны дэгийн 4 дүгээр бүлэгт “Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдааныг зарлан хуралдуулах, хуралдааныг удирдах, дэг сахиулах” асуудлыг тусгасан байна.

**1) Сануулах, уг хэлэх эрхийг хасах арга хэмжээ:**

- гишүүн уг хэлэх хугацаагаа хэтрүүлсэн бол хуралдаан даргалагч түүнийг нэг удаа сануулсны дараа уг хэлэх эрхийг хасна (Дэгийн §35);
- гишүүн уг хэлэхдээ хэлэлцэж буй асуудлаас өөр асуудал руу хальсан бол хуралдаан даргалагч сануулна (Дэгийн §36);
- Бундестагийн дэг зөрчин бусдын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл хийж буй гишүүнийг хуралдаан даргалагч нэрийг нь дуудаж сануулга өгнө;
- уг хэлэгч нь 3 удаа сэдвээрээ ярих сануулга, эсхүл 3 удаа дэг сахих сануулга авсан ба 2 дахь сануулгын хүрээнд 3 дахь сануулгын үр дагаврын талаар түүнд хэлсэн бол хуралдаан даргалагч тус гишүүний уг хэлэх эрхийг хасаж, уг гишүүнд тухайн асуудлын хэлэлцүүлгийн явцад дахин уг хэлэх эрх олгохгүй.

<sup>216</sup> an officer of the Department of the House of Representatives (and carrier of the Mace) who carries out the orders of the House and who assists to keep order in Parliament House.

<https://www.aph.gov.au/Help/Glossary> хандсан 2020.08.28

<sup>217</sup> Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестангийн хуралдааны дэг. Гарын авлага, Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл. 2019 он.

2) **Торгох** (Дэгийн §37):

- Бундестагийн дэг, нэр хүндийг зөрчсөн гишүүнд Бундестагийн Ерөнхийлөгч 1000 еврогийн тorgууль ногдуулж болно;
- ийнхүү тorgууль ногдуулах нь хуралдаан даргалагч урьдчилан сануулга өгсөн эсэхээс үл хамаарч ногдуулна;
- зөрчлийг давтан гаргасан бол тухайн гишүүнийг 2000 еврогоор тorgоно. Дэгийн 38 дугаар зүйлийн 2 дугаар заалт үүнд ижил үйлчилнэ.

3) **Танхимаас хөөх** (Дэгийн §38):

- Бундестагийн дэг, нэр хүндийг ноцтой зөрчсөн гишүүнийг хуралдаан даргалагч танхимаас хөөж гаргах эрхтэй;
  - энэ шийтгэлийг оногдуулах нь урьдчилан сануулга өгсөн, тorgууль ногдуулсан зэргээс үл хамаарна;
  - хуралдаан даргалагч нь тухайн хуралдаан дусахаас өмнө танхимаас хөөгдсөн гишүүн цаашид хэдэн удаагийн хуралдаанд оролцох эрхгүй болсныг зарлана;
  - гишүүнийг 30 хүртэл хоногоор хуралдаанд оролцуулахгүй байхаар шийтгэж болно;
- гишүүнийг танхимаас хөөх шийтгэлийг дараагийн хуралдаан дээр хэрэгжүүлэхээр хойшлуулж болно;
  - гэхдээ хуралдаан даргалагч Бундестагийн дэг, нэр хүндийг ноцтой зөрчсөн үйлдлийг тогтоож, тухайн үедээ үүнийг зарлах ба шийтгэлийг дараагийн хуралдаан дээр хэрэгжүүлнэ гэдгээ зөрчил гаргасан гишүүнд мэдэгдэнэ;
- тухайн гишүүн нь хуралдааны танхимыг нэн даруй орхин гарах үүрэгтэй;
  - хэрэв шаардлагыг биелүүлэхгүй бол хуралдаан даргалагч нь гишүүний энэ үйлдлээс болж шийтгэлийн хугацааг сунгахад хүргэхийг түүнд сануулна;
- тухайн гишүүн нь хуралдаанд оролцох эрхээ хасуулсан хугацаандаа Байнгын хороодын хуралдаанд мён оролцохгүй;
- тухайн гишүүн нь хуралдаанд хууль бусаар оролцохыг завдсан бол хуралдаан даргалагч нь шийтгэлийн хугацааг сунгахад хүргэхийг түүнд сануулна (Дэгийн §38.3.2).

**Хариуцлагын арга хэмжээг үл зөвшөөрөх** (Дэгийн §39):

Тухайн гишүүн нь сануулга, тorgууль, танхимаас хөөх хариуцлагын арга хэмжээг үл зөвшөөрч байгаа бол дараагийн хуралдаан хүртэл өөрийн байр суурь, үндэслэлийг бичгээр илэрхийлж болно.

### 3. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС<sup>218</sup>

#### Хуралдааны дэгийг сахиулах

ОХУ-ын Төрийн Думын Регламентын 52.2 дахь хэсэгт зааснаар “**хуралдааны дэгийг сахиулах** гэдэг нь хуралдаан даргалагч Төрийн Думын Регламентад заасан хуралдааны дэгийг сахиулах гэдгийг ойлгоно” гэсэн байна. Хуралдаанд оролцогчид дараах дэгийг сахина:

- Төрийн Думын хуралдаан дээр үг хэлж байгаа этгээд нь депутатын ёс зүйн журмыг зөрчих, Төрийн Думын бусад депутатыг болон бусдыг доромжилсон, нэр хүндийг нь гутаасан бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, хэн нэгнийг үндэслэлгүйгээр гүтгэх, илт худал мэдээлэл ашиглах, хууль бус үйлдэлд уриалах эрхгүй (Регламентын §45);

<sup>218</sup> Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент, гарын авлага. Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл. 2019 он.

- хуралдаан дээр хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр хэн ч үг хэлэхгүй (Регламентын §58.1);
- Төрийн Думын гишүүд хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд ярих үүрэгтэй (Регламентын §56.4);
- Регламентын нэг онцлог зохицуулалт бол Төрийн Думд үг хэлж байгаа Төрийн Думын депутат, Холбооны Зөвлөлийн гишүүн, төрийн албан хаагч “мөнгөөр илэрхийлэгдэх үнийн үзүүлэлтийг ОХУ-ын хуульд өөрөөр заагаагүй бол рублиэр илэрхийлнэ” (Регламентын §45).

### **Дэг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

Хуралдаан даргалагч нь хуралдааны дэгийг зөрчигчдөд дараах төрлийн арга хэмжээ авна. Үүнд:

- сануулах;
- алдааг засч залруулах;
- үгийг нь таслах;
- хуралдааны танхимаас гаргах.

Хэрэв арга хэмжээ авахаар бол хуралдаан даргалагч нь тухайн депутатын хуралдааны дэгийг хэрхэн зөрчсөн, ямар арга хэмжээ авах тухай тайлбарлана.

Хуралдаан даргалагч нь дараах тохиолдолд хуралдааны дэг зөрчигчдөд **урьдчилан сануулга өгөх** ба дахин зөрчсөн бол **үгийг нь масална**. Үүнд:

- Регламентын 45 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлээгүй бол (Регламентын §45);
- депутат нь хэлэлцэж байгаа сэдвээсээ өөр асуудал руу орж ярьсан бол (Регламентын §52.2.б, §56.4);

Хуралдаан даргалагч нь хуралдааны явцад ОХУ-ын Үндсэн хууль, үндсэн хуульчлагдсан хууль, бусад хууль тогтоомж, журмыг зөрчсөн, мөн үг хэлэхэд гарсан алдааг **засч залруулах** арга хэмжээ авах (Регламентын §52.2.в), хуралдаанд уригdsan хүмүүс нь Төрийн Думын ажилд хөндлөнгөөс оролцсон бол **хуралдааны танхимаас гаргах** арга хэмжээг тус тус авна (Регламентын §52.2.г).

### **4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС<sup>219</sup>**

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 13 дугаар бүлэгт “Хуралдааны дэг, хамгаалалтын алба”, 14 дүгээр бүлэгт “Сахилгын шийтгэл”-ийн талаар тусгасан байна. Спикер нь Үндэсний Ассамблейг төлөөлөх, чуулганы хуралдааныг даргалах, дэг журмыг сахиулах, Үндэсний Ассамблейн Тамгын газрыг удирдах чиг үүргийг хэрэгжүүлэхийг энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан байна.

### **Дэг зөрчсөн үйлдэл**

Хуралдаанд оролцогчид чуулганы нэгдсэн, эсхүл Байнгын хорооны хуралдааны танхимд Үндэсний Ассамблейн тухай хуульд заасан хуралдааны дараах дэгийг сахина. Тухайлбал:

#### **1) гутаан доромжлох, парламентыг үл хүндэтгэх**

- гишүүн нь хуралдааны үед бусдыг доромжлох, гуравдагч этгээдийн хувийн байдлын талаар үг хэлэхийг хориглоно (Хуулийн §146);

<sup>219</sup> Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль, гарын авлага, 2019 он.

- 2) үг хэлэхэд саад хийхийг хориглох
  - гишүүн нь бусад гишүүнд хүч хэрэглэх, хуралдааны үед ёс зүйгүй үг хэлэх, эсхүл бусдыг үг хэлэхэд саад учруулах үйлдэл хийхийг хориглоно (Хуулийн §147);
- 3) хуралдааны үйл ажиллагаанд саад болж болзошгүй зүйлсийг оруулахгүй байх
  - гишүүн нь чуулганы нэгдсэн, эсхүл Байнгын хорооны хурлын танхимд хуралдааны үйл ажиллагаанд саад болж болзошгүй зүйл, хоол, ундааг авч орохыг хориглоно (Хуулийн §148);
- 4) хууль бусаар спикер, эсхүл хорооны даргын суудлыг эзлэхгүй байх
  - гишүүн нь хуралдааны даргалагчийн суудлыг хууль бусаар эзлэхийг хориглоно (Хуулийн §148.2);
- 5) танхим руу орох, танхимаас гарахад саад болохгүй байх
  - хэн ч гишүүнийг нэгдсэн хуралдаан болон хорооны чуулганд оролцохоор нэгдсэн хурлын танхим, эсхүл хорооны хурлын танхимд орж гарахад саад учруулахыг хориглоно (Хуулийн §148.3).

Гишүүн дор дурдсан үйлдлүүдийн аль нэгийг гаргасан бол Ёс зүйн тусгай хороо уг үйлдлийг шалгаж, хариуцлага тооцох эсэх талаар шийдвэр гаргана (Хуулийн §155). Үүнд:

- 1) Үндсэн хуулийн 46.1<sup>220</sup>, 46.3<sup>221</sup>-т заасан зөрчил гаргасан бол;
- 2) энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхийг хориглосон журмыг зөрчсөн бол;
- 3) энэ хуулийн 29.2 дугаар зүйлд заасан ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хориглосон журмыг зөрчсөн бол;
- 4) энэ хуулийн 54-2.2 дугаар зүйлд заасан “ажил үүргийн шугамаар олж мэдсэн төрийн нууцад хамаарах мэдээллийг нийтэд мэдэгдэх буюу задруулж болохгүй” гэснийг зөрчсөн бол;
- 5) энэ хуулийн 102 дугаар зүйлд<sup>222</sup> заасан хэлэлцэх асуудал болон зөвшөөрснөөс өөр уг хэлэх, эсхүл энэ хуулиар тогтоосон уг хэлэх хугацааны хязгаарлалтыг зөрчиж үйл ажиллагаанд саад учруулсан бол;
- 6) энэ хуулийн 118.3 дугаар зүйлийг<sup>223</sup> зөрчиж олон нийтэд дэлгэгдээгүй материалыг бусдад үзүүлэх, дамжуулах, өөрчилж зассан бол;
- 7) энэ хуулийн 118.4 дүгээр зүйлд<sup>224</sup> заасныг зөрчих, зарлахыг хориглосон агуулгыг олон нийтэд дэлгэсэн бол;
- 8) энэ хуулийн 145.1 дүгээр зүйлд<sup>225</sup> заасан хурлын танхимын дэгийг зөрчих, спикер болон Байнгын хорооны даргын зааврыг зөрчсөн бол;
- 9) энэ хуулийн 146 дугаар зүйлийг<sup>226</sup> зөрчиж хуралдаан дээр бусдыг доромжлох, хувийн сэдлээр шүүмжлэх уг хэлсэн бол;
- 10) энэ хуулийн 148.2 дугаар зүйлийг зөрчиж спикер, эсхүл хорооны даргын суудлыг хууль бусаар эзэлсэн, эсхүл энэ хуулийн 145 дугаар зүйлд зааснаар спикер, эсхүл хорооны даргын шаардсаныг биелүүлээгүй бол (энэ үйлдлийг үйлдсэн бол Ёс зүйн тусгай хорооноос шалгахгүйгээр шийдвэр гаргаж болно);

<sup>220</sup> 46.1 Members of the National Assembly shall have the duty to maintain high standards of integrity.

<sup>221</sup> 46.3 Members of the National Assembly shall not acquire, through abuse of their positions, rights and interests in property or positions, or assist other persons to acquire the same, by means of contracts with or dispositions by the State, public organizations or industries.

<sup>222</sup> §102. Хэлэх уг нь хуралдааны хэлэлцэх асуудал болон зөвшөөрөгдсэн сэдвээс гажиж болохгүй.

<sup>223</sup> §118.3. Гишүүн нь бусдад хуралдааны тэмдэглэлийг үзүүлэх, эсхүл хуулж нийтлэх, хуулбарлуулахыг хориглоно.

<sup>224</sup> §118.4. Нээлттэй болоогүй хурлын агуулгыг нийтэд зарлаж болохгүй.

<sup>225</sup> §145.1. Аль нэг гишүүн нэгдсэн хуралдаан, эсхүл хорооны хурлын танхимд энэ хууль, эсхүл Үндэсний Ассамблейн дүрэм журмыг зөрчиж, танхимын хэв журмыг алдагдуулсан бол спикер, эсхүл хорооны дарга түүнд сануулга егех, эсхүл уг үйлдлийг зогсоож болно

<sup>226</sup> §146. Гишүүн нэгдсэн чуулган, эсхүл хорооны хуралдаан дээр бусдыг доромжлох, гуравдагч этгээдийн хувийн байдлын талаар уг хэлэхийг хориглоно.

- 11) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Үндэсний Ассамблейн чуулган эхэлснээс 7 хоногийн дотор нэгдсэн, эсхүл Байнгын хорооны хуралдаанд ирээгүй болон спикер, Байнгын хорооны даргын хуралдаа суух тухай шаардлагыг хүлээн авснаас 5 хоногийн дотор ирээгүй бол;
- 12) огцруулах асуудлаар явуулж буй Төрийн байгууллагын хяналт, шалгалт явуулах тухай хуульд заасан хяналт, шалгалтын үйл ажиллагаанд оролцох үүргээ зөрчсөн бол.

#### **Сахилгын шийтгэлийн төрөл, түүнийг зарлах** (Хуулийн §163)

Дээрх зөрчилд дараах сахилгын шийтгэлийг оногдуулах ба сахилгын шийтгэл оногдуулах шийдвэр гарсан тохиолдолд Спикер энэ тухай нээлттэй хуралдаан дээр зарлана. Үүнд:

- 1) нээлттэй хуралдаан дээр **сануулга өгөх**;
- 2) нээлттэй хуралдаан дээр **учвлалт хүсэх**;
- 3) 30 хүртэл хоногоор **хуралдаанд суухыг хориглох**:
  - төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулсан бол 90 хүртэлх хоног,
  - хэлэлцэх асуудал болон зөвшөөрснөөс өөр үг хэлэх, эсхүл хуулиар тогтоосон үг хэлэх хугацааны хязгаарлалтыг зөрчиж үйл ажиллагаанд саад учруулсан бол 90 хүртэлх хоног;
  - хуралдаанд суугаагүй хугацааг тооцон Үндэсний Ассамблейн гишүүний хөдөлмөрийн хөлс олгох хуульд заасан хөдөлмөрийн хөлс, хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны хөлс болон онцгой үйл ажиллагааны хөлсийг 50 хувиар бууруулна;
- 4) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Үндэсний Ассамблейн чуулган эхэлснээс 7 хоногийн дотор нэгдсэн, эсхүл Байнгын хорооны хуралдаанд ирээгүй болон спикер, Байнгын хорооны даргын хуралдаа суух тухай шаардлагыг хүлээн авснаас 5 хоногийн дотор ирээгүй бол дараах сахилгын шийтгэлийг ногдуулна:
  - нээлттэй хуралдаан дээр сануулга өгөх, учвлалт хүсэх. Энэ тохиолдолд сарын хөлсийг 50 хувь хасахаар шийдвэрлэж тухайн сар болон дараагийн сарын цалингаас хасна. Цалин хөлс олгогдсон тохиолдолд буцаан авна;
  - хуралдаанд 30 хоногийн турш суулгахгүй байх. Энэ тохиолдолд шийтгэхээр шийдвэрлэсэн сараас эхлэн 3 сарын цалин олгохгүй бөгөөд олгогдсон бол бүгдийг буцаан авна;
  - хөөх тухай шийдвэр гараагүй тохиолдолд нэгдсэн чуулганаар өөр төрлийн сахилгын шийтгэл оногдуулж болно;
- 5) гишүүн нэгдсэн хуралдаан, эсхүл Байнгын хорооны хуралдааны танхимд Үндэсний Ассамблейн тухай хуульд заасан журмыг зөрчиж, танхимын дэг журмыг алдагдуулсан бол спикер, эсхүл Байнгын хорооны дарга нь түүнд сануулга өгөх, эсхүл уг үйлдлийг нь зогсооно (Дэгийн §145);
- 6) гишүүн дээрх шаардлагыг дагаж мөрдөхгүй бол хуралдаан даргалагч нь түүний тухайн өдрийн хурал дээр үг хэлэх эрхийг хасах, эсхүл танхимаас хөөж болно (Дэгийн §145);
- 7) хуралдаан даргалагч нь хуралдааны танхимд дэг журам сахиулах боломжгүй гэж үзсэн бол тухайн хуралдааныг хойшлуулах, эсхүл завсарлуулах тухай зарлаж болно (Дэгийн §145);

- 8) бүрэн эрх хасагдсан хүний сонгох эрхийг хязгаарлах (Хуулийн 164 дугаар зүйл): Энэ хуулийн 163<sup>227</sup> дугаар зүйлд зааснаар сахилгын шийтгэл авч хөөгдсөн гишүүн хөөгдсөний улмаас орон гарсан суудалд нэр дэвшиж болохгүй (Дэгийн §164).

## 5. ЯПОН УЛС

Тус улсын Парламентын тухай хууль (The Diet law)<sup>228</sup>-ийн 14-15 дугаар бүлэгт хуралдааны дэг сахиулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хуралдаан даргалагч нь чуулганы үед, мөн чуулганы завсарлагааны үед дэгийг сахиулахад дүрмийн дагуу цагдаагийн хүчийг ашиглаж болно. Цагдаагийн ажилтнуудыг хуралдаан даргалагчийн хүсэлтийн дагуу Засгийн газраас явуулах ба тэд хуралдаан даргалагчийн удирдлагад ажиллана.

Гишүүн хуралдааны дэг зөрчсөн, эмх замбараагүй байдал бий болгосон, эсхүл Танхимын нэр хүндэд халдсан бол хуралдаан даргалагч нь түүнд дараах шаардлагуудыг тавина:

- сануулга өгөх;
- үг хэлэх эрхийг нь хязгаарлах;
- хэлсэн үгээ татаж авах.

Хэрэв хуралдаан даргалагчийн шаардлагыг биелүүлэхгүй бол тухайн өдрийн хуралдааныг дусах хүртэл, эсхүл дараагийн өдрийг дуустал хуралдаанд оролцохыг хориглоно.

Харин Танхимын эмх замбараагүй байдал хяналтаас гарсан бол хуралдаан даргалагч нь тухайн хуралдааныг хойшлуулахыг тус улсын Парламентын тухай хуульд болон Дээд танхимын дэгийн 232 дугаар зүйлд тус тус заасан байна.

Танхимд байгаа гишүүдийн хувийн асуудлаар доромжилсон үг хэллэг хэрэглэхийг хориглох ба хэрэв хуралдааны үед өөрийгөө доромжуулсан гэж үзсэн гишүүн Танхимд сахилгын арга хэмжээ авах талаар өргөдөл гаргаж болно.

### Дэг зөрчигчдөл авах арга хэмжээ

Дээд танхимын дэг (The Rules of the House of Councillors)-д зааснаар хуралдааны дэг зөрчигдвэл дараах сахилгын арга хэмжээг авна. Үүнд:

- нэгдсэн хуралдааны үед Дээд танхимын Ерөнхийлөгч (President of the House of Councillors) хуралдааныг завсарлуулах, хуралдааныг хойшлуулах, эсхүл дэг зөрчсөн гишүүнийг танхимаас гаргах арга хэмжээ авна (Дэгийн §232);
- Хорооны хуралдааны үед дэг зөрчигдвэл Хорооны дарга хуралдааныг завсарлах, эсхүл хуралдааныг хаах арга хэмжээ авна (Дэгийн §233);
- Хорооны хуралдаан, танхимын хуралдаан, эсхүл бусад хуралдааны дэг зөрчигдвэл Дээд танхимын Ерөнхийлөгч сахилгын хороонд мэдэгдэнэ (Дэгийн §234);
- доромжилсон үг хэллэгийг таслан зогсоох, эсхүл татаж авах шаардлагыг биелүүлэхгүй байгаа этгээдийн талаар Дээд танхимын Ерөнхийлөгч, Парламентын тухай хуулийн 116 дугаар зүйлд зааснаас гадна сахилгын хороонд шилжүүлэх арга хэмжээ авч болно.
- доромжилсон үг хэллэгийг таслан зогсоох талаар гаргасан Хорооны даргын сануулгыг биелүүлээгүй этгээдийг Хорооны дарга Парламентын тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаас гадна сахилгын арга хэмжээ авахаар Дээд танхимын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ (Дэгийн §235);

<sup>227</sup> Сахилгын шийтгэлийн төрөл, түүнийг зарлах

<sup>228</sup> <https://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm> хандсан 2020.08.28

- хэн нэгэн этгээд нууц мэдээллийг задруулсан бол Дээд танхимын Ерөнхийлөгч Сахилгын хороо руу арга хэмжээ авахуулахаар явуулна (Дэгийн §236);
- Сахилгын дарга сахилгын арга хэмжээ авахуулах шаардлагагүй гэж үзсэн ч гэсэн аль нэг гишүүн сахилгын арга хэмжээ авахуулах талаар санал хураалгаж болно (Дэгийн §237);
- сахилгын арга хэмжээ авах асуудлыг Дээд танхимын Ерөнхийлөгч Танхимд нэн даруй оруулна. Арга хэмжээ авахдаа Дээд танхимын Ерөнхийлөгч Сахилгын хороогоор хэлэлцүүлэхгүйгээр танхимд санал хураалт явуулна (Дэгийн §238);
- сахилгын арга хэмжээнд холбогдсон гишүүдийг Сахилгын хороо дуудаж асуулт асууна (Дэгийн §239);
- сахилгын арга хэмжээ авахуулж буй гишүүн хуралдаанд, эсхүл Хорооны хуралдаанд оролцохгүй. Гэсэн ч Дээд танхимын Ерөнхийлөгч, эсхүл Хорооны даргын зөвшөөрлөөр өөрийгөө хамгаалуулахаар өөр гишүүнийг хуралдаанд суулгаж болно (Дэгийн §240);
- Сахилгын хороо нь хэргийг шалгаж, уучлалт гүйх, эсхүл сануулах тухай тогтоолын төслийг бэлтгэн Дээд танхимын Ерөнхийлөгчид өргөн барина (Дэгийн §241);
- танхимаас түр түдгэлзүүлэх хугацаа 30 хоногоос хэтрэхгүй. Гишүүн удаа дараа зөрчил гаргаж байсан ч дээрх хугацаанаас хэтрүүлж болохгүй (Дэгийн §242);
- гишүүн нь танхимд суух эрхээ түдгэлзүүлсэн тохиолдолд Тусгай хороо болон хорооны Зөвлөгөөний гишүүнчлэлээ алдана (Дэгийн §243);
- хэрвээ сахилгын арга хэмжээ авахуулж байгаа гишүүн танхимд ирвэл Дээд танхимын Ерөнхийлөгч түүнийг танхимыг нэн даруй орхихыг шаардана. Хэрэв гишүүн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол Дээд танхимын Ерөнхийлөгч дахин Сахилгын хороонд хүргүүлэх болно (Дэгийн §244);
- танхимын нэр хүндийг гутаах, эсхүл дэгийг ноцтой (*particularly reprehensible manner*) зөрчсөн үйлдэл гаргасан тохиолдолд гишүүний хуралдаанд оролцох эрхийг түдгэлзүүлж танхимаас гаргана (Дэгийн §245);
- Сахилгын хорооноос гишүүнийг хөөх (*recommendation for expulsion*) санал дэвшүүлсэн шийдвэрийг гишүүдийн 2/3 буюу түүнээс дээш гишүүд дэмжээгүй бол танхим дэг зөрчсөн этгээдэд өөр сахилгын арга хэмжээ ногдуулна (Дэгийн §246);
- Танхим сахилгын арга хэмжээ авна гэж шийдвэрлэсэн л бол Дээд танхимын Ерөнхийлөгч хаалттай хуралдааны шийдвэрийг нээлттэй хуралдаан дээр ч зарлана (Дэгийн §247).

## 6. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

Бүгд Найрамдах Сингапур Улсын **Парламентын тухай хуулийн** 4 дүгээр бүлэг “Парламентын бүрэн эрх”-т Парламентаас зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэх хариуцлага ногдуулах талаар, 5 дугаар бүлэгт “Зөрчил, шийтгэл”-тэй холбоотой асуудлыг тусгасан байна.

Хуулийн 20, 21 дүгээр зүйлд ёс журамгүй үйлдэл гаргасан, парламентыг үл хүндэтгэсэн, бүрэн эрхээ хэтрүүлсэн гишүүнд дараах шийтгэлийг бүгдийг, эсхүл аль нэгийг ногдуулж болно гэж заасан байна. Үүнд:

- тухайн чуулган дуусах хүртэл хугацаанаас дээшгүй хугацаагаар хорих;
- хуралдаанд оролцох эрхийг хасах;
- торгууль (50 000 сингапур доллараас хэтрэхгүй);
- донгодах/хатуу донгодах.

**Парламентын хуралдааны дэгийн**<sup>229</sup> 55-61 дүгээр зүйлд Парламент дахь дэг журамтай холбоотой асуудлыг тусгасан байна.

Хуралдаан даргалагч нь зөрчил гаргасан аливаа гишүүнийг тухайн өдрийн хуралдаанаас гарахыг шаардах эрхтэй. Үүнд Дэг сахиулах үүрэг бүхий албан тушаалтныг (Sergeant-at-Arms) оролцуулж болно.

Хуралдаан даргалагч дээрх арга хэмжээг хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүнийг нэрлэх (улмаар хуралдаанд оролцох эрхийг хасах) шийтгэлийг ногдуулж болно.

Хуралдаан даргалагчийг үл тоомсорлох, санаатайгаар олон дахин хуралдааныг үймүүлж, дэгийг зөрчсөн тохиолдолд нэр дуудсан гишүүнийг Парламентын Ерөнхий Нарийн Бичгийн даргаар дамжуулж зарлан, парламентын шийдвэрлэсэн хугацаагаар хуралдаанд оролцох эрхийг хасна. Үүнд дэг зөрчсөн асуудлыг хэлэлцэх, өөрчлөх, хойшлуулахыг зөвшөөрөхгүй.

Хоёр ба түүнээс дээш гишүүн хамсан зөрчил гаргаснаас бусад тохиолдолд нэг удаад зөвхөн нэг гишүүнийг нэр дуудна.

Дэгийн зөрчил гаргаж, хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан тохиолдолд хуралдаан даргалагчийн тушаалаар Дэг сахиулах үүрэг бүхий албан тушаалтны шаардлагыг биелүүлээгүй бол дахин санал авахгүйгээр тухайн чуулганы<sup>230</sup> хугацааг дуустал хуралдаанд оролцох эрхийг нь хасна.<sup>231</sup> Шийтгэл авсан гишүүн Парламентын ордныг даруй орхиж гарах ёстой (Дэгийн 59.4 дэх заалт).

Парламент бүхэлдээ эмх замбараагүй байдалд орсон тохиолдолд хуралдаан даргалагчийн шийдвэрээр хуралдааныг тогтоосон хугацааны дагуу түр завсарлуулж, эсхүл хойшлуулж болно.

## 7. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС<sup>232</sup>

Үндэсний Ассамблейн гишүүдийн хуралдаанд оролцох, ямар үйлдлийг зөрчил гэж тооцож хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг Үндэсний ассамблейн дэгийн тухай регламент<sup>233</sup> буюу Дэгээр зохицуулна.

Үндэсний Ассамблейн дэгийн 42 дугаар зүйлд зааснаар гишүүд хуралдаанд заавал оролцено. Хэрэв гишүүн нь сард 2-оос дээш удаагийн хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр суугаагүй бол гишүүний 1 сарын хөдөлмөрийн хөлснөөс 25 хувийг суутгана.

2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр энэ Дэгийн 70 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөөр дараах үйлдэл хийсэн Үндэсний Ассамблейн гишүүдийг зөрчил гаргасан гэж үзэн сахилгын шийтгэл оногдуулна. Үүнд:

- дэг журам зөрчсөн жагсаал, цуглаан, үймээн өдөөх;
- бусад гишүүнийг доромжлох, эсхүл тэдэнд заналхийлэх;
- нээлттэй хуралдаан дээр хүчирхийллийг өдөөх;
- Үндэсний ассамблей болон Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчийг доромжлох, эсхүл өдөөн турхирах;

<sup>229</sup> <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf> хандсан 2020.08.28

<sup>230</sup> <https://www.parliament.gov.sg/parliamentary-business/glossary/Details/session/Session> хандсан 2020.08.28

<sup>231</sup> When the Member or Members named by him as having refused to obey his direction has or have been removed from Parliament, he or they shall thereupon, without any further question being put, be suspended from the service of Parliament during the remainder of the session (Дэгийн 59.4 дэх заалт).

<sup>232</sup> МХШҮХ-ийн Судалгаа, Мэдээлэл, Лавлагааны албаны судалгаа, Парламентын гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт: Бусад орны туршлага (Харьцуулсан судалгаа СТ-18/203)

<sup>233</sup> Règlement de l'Assemblée Nationale. [www2.assemblee-nationale.fr](http://www2.assemblee-nationale.fr)

- БНФУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Парламентын гишүүдийг доромжлох, эсхүл өдөөн турхирах, эсхүл тэдэнд заналхийлэх;
- Үндэсний Ассамблейн ордонд халдлага зохион байгуулах;
- Үндэсний Ассамблейн дэгд заасан бусад ёс зүйн зөрчил гаргах.

Зөрчил гаргасан гишүүдэд дараах сахилгын шийтгэлийг хүлээлгэнэ. (Дэгийн §71) Үүнд:

- шаардлага тавих;
- хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих;
- арга хэмжээ авах /донгдох/;
- гишүүний эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлэх.

Хуралдааны тэмдэглэлээр шаардлагыг Үндэсний Ассамблейн товчоо<sup>234</sup>, эсхүл Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч тавина. Тухайлбал, Ерөнхийлөгчийн саналаар, эсхүл өөрийгөө хохирогч хэмээн үзсэн гишүүний бичгээр гаргасан гомдлын дагуу Товчоо нь хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавина. (Дэгийн §72)

Энгийн арга хэмжээ авах болон түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээг Үндэсний Ассамблейн товчооны саналаар гаргах ба үүнийг хэлэлцэхгүй Үндэсний Ассамблейд сонсгоно. (Дэгийн 72-р зүйл)

Зарим сахилгын шийтгэлээр Үндэсний Ассамблейн гишүүнд олгогдсон эрхийг хэсэгчлэн түдгэлзүүлнэ. Тухайлбал, хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих нь гишүүний эрхийн 1/4-ийг түдгэлзүүлэх бол энгийн арга хэмжээ авах нь гишүүний бүрэн эрхийн тэн хагасыг 1 сарын турш тус тус түдгэлзүүлэх үр дагавартай. (Дэгийн §73)

Мөн түр хугацаагаар түдгэлзүүлэх сахилгын шийтгэл нь гишүүний эрхийн тэн хагасыг 2 сарын турш түдгэлзүүлэх үр дагавартай бөгөөд энэ нь сахилгын шийтгэл оногдуулсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд оролцох, Үндэсний ассамблейн ордонд хүрэлцэн ирэхийг тус тус хориглоно. Харин тухайн гишүүнд энэ сахилгын шийтгэлээр давтан хариуцлага хүлээх бол хугацааг 30 хоног хүртэл сунгана. (Дэгийн §73)

Сахилгын шийтгэлтэй хугацаандaa бусад гишүүн, эсхүл гишүүдэд дахин халдах болон Ерөнхийлөгчийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй бол дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана. Цаашлаад ноцтой халдлагыг үйлдвэл Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч нь нэн даруй Ерөнхий прокурорыг дуудах ёстой. (Дэгийн §77)

Хуралдаан дээр санал хураалтыг залилах тохиолдолд гишүүний эрхийн 1/4-ийг 1 сарын турш түдгэлзүүлэх ба мөн хуралдаан дээрээ санал хураалтын журмыг дахин зөрчвөл дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана. (Дэгийн §77)

#### *Хүснэгт 2. Сахилгын шийтгэлийн төрөл*

<b>Сахилгын шийтгэлийн төрөл</b>	<b>Хариуцлага хүлээлгэх субъект</b>	<b>Санаачилга гаргах эрх бүхий субъект</b>	<b>Гишүүний эрхийг хэсэгчлэн түдгэлзүүлэх</b>	<b>Тайлбар</b>
Шаардлага тавих	Ерөнхийлөгч	Товчооны саналаар		
Хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих	- Үндэсний Ассамблейн товчоо, - Үндэсний	- Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчийн саналаар, - өөрийгөө хохирогч	гишүүний эрхийн 1/4-ийг түдгэлзүүлэх	

<sup>234</sup> Үндэсний Ассамблейн товчоо - Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдлагаар хангах хамтын дээд байгууллага ба Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч, 6 дэд ерөнхийлөгч, 3 квестор, 12 нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ.

	Ассамблейн Ерөнхийлөгч	хэмээн үзсэн гишүүний бичгээр гаргасан гомдлын дагуу		
Арга хэмжээ авах /донгodoх/	Үндэсний Ассамблейн товчоо	Үндэсний Ассамблейн товchoоны саналаар	гишүүний эрхийн тэн хагасыг 1 сарын турш түдгэлзүүлэх	
Гишүүний эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлэх	Үндэсний Ассамблейн товчоо	Үндэсний Ассамблейн товchoоны саналаар	гишүүний эрхийн тэн хагасыг 2 сарын турш түдгэлзүүлэх	-Үндэсний Ассамблейн ўйл ажиллагаанд оролцохыг хориглоно, -Үндэсний Ассамблейн ордонд хүрэлцэн ирэхийг хориглоно
	Үндэсний Ассамблейн товчоо	Нарийн бичгийн даргын саналаар	гишүүний эрхийн 1/4-ийг 1 сарын турш түдгэлзүүлэх	санал хураалтын журмыг зөрчсөн тохиолдолд

## 8. БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС<sup>235</sup>

Парламентын дэг (Үндэсний Ассамблейн зохион байгуулалт болон үйл ажиллагааны дэг - *Rules of Organisation and Procedure of the National Assembly*)-ийг 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр баталж мөн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна.

12 дугаар бүлгийн 3 дугаар дэд хэсэгт парламентын горим (*parliamentary behavior*)-той холбоотой асуудлыг тусгасан бөгөөд Үндэсний ассамблейн гишүүд нь Үндэсний ассамблейн эрх мэдлийг харгалзан бусад гишүүд болон хүмүүст хүндэтгэлтэй хандана. 2) Үндэсний ассамблейн гишүүд нь өөрсдийн суудлаас спикерийн үгийг тасалдуулахгүй байх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх үйлдэл гаргахгүй байх, бусдыг сүрдүүлэхгүй байх, хувийн амьдралтай холбоотой, эсхүл иргэдийн нэр хүндэд хохирол учруулах мэдээллийг ил болгох, мөн хуралдааны дэгийг зөрчсөн аливаа үйлдэл гаргахыг хориглоно.

### Шийтгэлийн арга хэмжээ (Дэгийн §156)<sup>236</sup>

Зөрчил гаргасан парламентын гишүүнд дараах шийтгэлийг хүлээлгэнэ. Үүнд:

- **сануулах** (reminder):
  - хэлэлцүүлгийн асуудлаас хальж хазайсан бол (Дэгийн §157);
- **донгодох** (reprimand):
  - Спикер бусад гишүүдийг доромжилсон үг хэллэг хэрэглэсэн, үйлдэл гаргасан, эсхүл бусдыг сүрдүүлсэн бол (Дэгийн §158);
- **хатуу донгодох** (censure):
  - Спикер хуралдааны дэгийг зөрчсөн, эсхүл чуулганы танхимд эмх замбараагүй байдал үүсгэсэн бол (Дэгийн §159);
- **үг хэлэх эрхийг нь хасах** (taking away the word):
  - тухайн хуралдааны хугацаанд гишүүнд сануулах, донгодох, хатуу доннодох зэрэг шийтгэлийн 2 удаа ногдуулсан бол (Дэгийн §160);
  - үг хэлэх/асуулт асуух хугацаа хэтэрч, Спикер яриагаа дуусгавар болгохыг санал болгосон ч үргэлжлүүлсэн бол (Дэгийн §160);
- **1 удаагийн хуралдаанд оролцох эрхийг хасах** (removal from a sitting):
  - ногдуулсан сахилгын шийтгэлийг бүдүүлэг, зохисгүй байдлаар эсэргүүцсэн бол (Дэгийн §160);
  - нэгдсэн чуулганы хуралдааныг хэвийн явуулахад удаа дараа саад учруулсан бол (Дэгийн §160);
  - бусдын картаар санал өгсөн бол (Дэгийн §160);
- **2-3 удаагийн хуралдаанд оролцох эрхийг хасах** (removal from up to three sittings) зэрэг байна:
  - Үндэсний Ассамблей, Сайд нарын зөвлөл, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон төрийн бусад байгууллагыг доромжилсон бол (Дэгийн §161);
  - Чуулганы танхим, Үндэсний Ассамблейд хүч хэрэглэсэн, хэрэглэхийг уриалсан бол (Дэгийн §161).

Хуралдаанд оролцох эрхийг хассан шийтгэл ногдуулсан гишүүний тухайн хуралдаанд оролцоогүй өдрийн хөлсийг олгохгүй бөгөөд Парламентын гишүүдэд ногдуулсан сахилгын

<sup>235</sup> МХШҮХ-ийн Судалгаа, Мэдээлэл, Лавлагааны албаны судалгаа, Парламентын гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт: Бусад орны туршлага (Харьцуулсан судалгаа СТ-18/203)

<sup>236</sup> Үндэсний Ассамблейн зохион байгуулалт болон үйл ажиллагааны дэг <https://www.parliament.bg/en/rulesoftheorganisations> хандсан 2020.08.29

шийтгэлийн талаарх мэдээллийг Үндэсний ассамблейн веб хуудсанд нийтэлнэ. Сахилгын шийтгэл хүлээн авсан гишүүн шийтгэл ногдуулнаас хойш З хоногийн дотор Спикерт тухайн шийтгэлийг эсэргүүцэн гомдол гаргах эрхтэй байх ба Спикер гомдлыг хүлээн авах, хэрэгсэхгүй болгох, эсхүл ногдуулсан сахилгын шийтгэлийг өөрчлөх эрхтэй байна. (Дэгийн §163)

Үндэсний Ассамблейн веб хуудсанд Байнгын хороо, дэд хороо, ажлын хэсэг болон холбогдох нэгдсэн чуулганы хуралдааныг хүндэтгэн үзэх шаалтгаангүй тасалсан талаарх мэдээллийг сар бүр нийтэлнэ. Мэдээллийг тухайн сар дууссанаас хойших 7 хоногийн дотор нийтэлнэ. (Дэгийн §164)

## 9. БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛС<sup>237</sup>

Парламент дахь сахилга баттай холбоотой харилцааг Үндсэн хууль (75 дугаар зүйл – “Парламентын гишүүний тангараг”) болон Үндэсний зөвлөлийн дэгийн тухай хуулийн “Сахилгын арга хэмжээ” гэсэн 20 дугаар бүлэг (2, 32, 39, 57,135-139 дүгээр зүйл)-ээр зохицуулна.<sup>238</sup>

Дор дурдсан зөрчилд парламентын гишүүнд сахилгын шийтгэл ногдуулна (Дэгийн §135):

- парламентын хэвийн үйл ажиллагааг тасалдуулсан бол;
- өөр бусад гишүүний өмнөөс санал өгсөн бол;
- гишүүн өргөсөн тангаргаа ноцтой зөрчсөн зэрэг орж байна.

Хуралдааныг хэвийн явуулахтай холбоотой зөрчил гаргасан гишүүнд Хуралдаан даргалагч дор дурдсан арга хэмжээг авна (Дэгийн §32). Үүнд:

- хэлэлцэж буй асуудлын сэдвээс хальж хазайсан бол сануулах (Дэгийн §32.1);
- зөвшөөрөл олгосон минутаас хэтрүүлэн ярьсан бол гишүүний үгийг таслах, гишүүн биеэ зүй бус авч явсан бол шаардлага тавих, шаардлагыг хүлээн аваагүй бол Спикер зөрчил гаргасан гишүүнийг тухайн өдрийн хэлэлцүүлэгт оролцох эрхийг нь хасна. Гишүүн санал хураалтад оролцох эрхтэй байна (Дэгийн §32.2);
- галт зэвсэг, тэсрэх бодис, мэдээ алдуулах төхөөрөмж болон бодис, эсхүл зөөврийн харилцаа холбооны хэрэгслийг Нэгдсэн чуулганы танхимд оруулахыг хориглоно, энэхүү заалтыг зөрчсөн этгээдийн тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг нь хасна (Дэгийн §32.3);
- 32.2-3-т заасны дагуу хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүнийг тухай өдрийн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй хуралдааныг тасалсанд тооцно;
- 32.1-3-т заасан шийтгэл хүлээсэн гишүүн шийтгэл ногдуулмагц гомдол гаргах эрхтэй байх бөгөөд гомдлыг Үндэсний зөвлөл шийдвэрлэнэ.

Өөр бусад гишүүний өмнөөс санал өгөх зөрчилд донгодах, торгууль, огцруулах зэрэг шийтгэлүүдийг тусгасан байна.

- санал хураалтад аль ч гишүүнийг өөр бусад гишүүд, эсхүл өөр этгээд орлохыг хориглоно. Өөр гишүүний өмнөөс санал өгсөн гишүүнд 136.2.b (a Member in the case of breach of the ban on voting for another Member)-д заасан журмын дагуу шийтгэлийг ногдуулна (39.6);
- гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын хороо нь гишүүнийг өөр гишүүний өмнөөс санал өгснийг тогтоосон тохиолдолд Үндэсний зөвлөлд гишүүнд донгодах шийтгэл, мөн 1000 еврогийн торгууль ногдуулахыг санал болгоно. (Дэгийн §139.2);

<sup>237</sup> МХШҮХ-ийн Судалгаа, Мэдээлэл, Лавлагааны албаны судалгаа, Парламентын гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт: Бусад орны туршлага (Харьцуулсан судалгаа СТ-18/203)

<sup>238</sup> [https://www.nrsr.sk/web/Static/en-US/NRSR/Dokumenty/rules\\_of\\_procedure.pdf](https://www.nrsr.sk/web/Static/en-US/NRSR/Dokumenty/rules_of_procedure.pdf) хандсан 2020.08.29

- гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын хороо нь гишүүнийг тангаргаа ноцтой зөрчсөн, эсхүл гишүүний өмнөөс санал өгөхийг хориглосныг зөрчсөн нь тогтоогдвол гишүүнийг огцруулах санал гаргаж болно (Дэгийн §139.3).

Парламентын гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлаар дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- Гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын хороо нь парламентын гишүүнийг ёс зүйн алдаа гаргасан гэж тооцсон тохиолдолд зөрчил гаргасан гишүүнд 500 хүртэл еврогийн тorgууль ногдуулахыг Үндэсний зөвлөлд санал болгоно (Дэгийн §139.1).

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Lundie, R. (2013). That's It, You're Out: Disorderly Conduct in the House of Representatives from 1901 to 2013. Parliamentary Library. [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_Departments/Parliamentary\\_Library/pubs/rp/rp1314/DisorderlyConduct](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/pubs/rp/rp1314/DisorderlyConduct)
- The Washington Post, April 13, 2016.
- <https://www.washingtonpost.com/news/worldviews/wp/2016/04/12/this-is-all-it-takes-to-get-kicked-out-of-britains-parliament/>
- МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны албаны судалгаа, Парламентын гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт: Бусад орны туршлага (Харьцуулсан судалгаа СТ-18/203)
- Австралийн парламентын Төлөөлөгчдийн танхимын цахим хуудас, нэр томьёоны тайлбар толь <https://www.aph.gov.au/Help/Glossary>
- Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг, гарын авлага, 2019 он.
- Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестангийн хуралдааны дэг, гарын авлага, 2019 он.
- Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент, гарын авлага, 2019 он.
- Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль, гарын авлага, 2019 он.
- Л.Өлзийсайхан, Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс, 2010 он.
- Л.Өлзийсайхан. Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. 2019 он.
- Японы дээд танхимын цахим хуудас, Парламентын тухай хууль <https://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm>
- Сингапурын парламентын цахим хуудас, Парламентын хуралдааны дэг, 2017 он
- <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf>
- Lundie, R. (2013). That's It, You're Out: Disorderly Conduct in the House of Representatives from 1901 to 2013. Parliamentary Library
- <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>
- [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed\\_protect/---protrav/---ilo\\_aids/documents/legaldocument/wcms\\_117333.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---ilo_aids/documents/legaldocument/wcms_117333.pdf)
- <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm#ChapterXVIII>


## ХАВСРАЛТ

*Хүснэгт 1. 1901-2016 онд Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг зөрчих үед авсан арга хэмжээний тоо<sup>239</sup>*

Хугацаа	Шийтгэлийн тоо	Хувь
1 цаг үг хэлэх эрхийг хасах	1 422	75.8
Танхимаас 15 минут гаргах	1	0.1
Тухайн өдрийн хуралдааны үлдсэн хугацаанд оролцох эрхийг хасах	89	4.7
24 цаг хуралдаанд оролцох эрхийг хасах	203	10.8
Тухайн өдрийг оролцуулаад 2 өдөр оролцох эрхийг хасах (Танхимын шийдвэр)	1	0.1
Тухайн өдрийн хуралдааны үлдсэн хугацаанд мөн дараагийн 3 удаагийн хуралдаанд оролцох эрхийг хасах	4	0.2
1 долоо хоног; 7 өдөр; тухайн өдрийн хуралдааны үлдсэн хугацаанд мөн дараагийн 7 өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах	18	1
Тухайн өдрийг оролцуулаад 7 өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах (Танхимын шийдвэр)	1	0.1
1 сар оролцох эрхийг хасах		
Чуулганы үлдсэн хугацаанд оролцох эрхийг хасах (Танхимын шийдвэр)	1	0.1
Асуудлыг хэрэгсэхгүй болгосон	132	7
Санал хураалтаар хүчингүй болгосон	3	0.2
<b>Нийт</b>	<b>1 876</b>	<b>100</b>

1901-2016 онд Австралийн Холбооны Улсын Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны зөвхөн нэг тохиолдолд чуулганы үеэр гурван удаа нэрлэх шийтгэл хүлээж шалтгаанаар нэг сарын хугацаанд гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасах тохиолдол гарсан байна. Харин 18 тохиолдолд чуулганы хугацаанд хоёр удаа нэрлэх шийтгэл хүлээж долоо хоног, эсхүл долоон хуралдаанд оролцох эрхийг хассан байна.

Мөн энэ хугацаанд 22 гишүүнийг нэрлэж, хуралдаанаас гарах шаардлагыг татгалзсаны улмаас Дэг сахиулах үүрэг бүхий албан тушаалтан (Sergeant-at-Arms)-ы тусlamжтайгаар танхимаас гаргасан байна.



<sup>239</sup> Lundie, R. (2013). *That's It, You're Out: Disorderly Conduct in the House of Representatives from 1901 to 2013*. Parliamentary Library

Хүснэгт 2. 1996-2016 онд Австралийн Холбооны Улсын 38-44 дэх парламентын бүрэн эрхийн хугацаанд гишүүдийн дэг зөрчсөн шийтгэл ногдуулсан үндэслэл<sup>240</sup>

Шийтгэл ногдуулсан үндэслэл	38	39	40	41	42	43	44	Нийт
Хуралдааны хэлэлцэх асуудлын товын дарааллыг алдагдуулах	5	3	–	1	27	23	29	88
Хурлын даргыг үл хүндэтгэх	5	2	6	3	8	4	11	39
Дэгийн зөрчил гаргах	5	7	4	36	53	29	36	170
Үг хэлэхэд саад учруулах	48	108	80	177	78	222	448	1161
Хурлын дарга эсхүл гишүүнийг хувийн сэдлээр шүүмжлэх	–	2	5	1	1	–	–	9
Суудалдаа суухаас татгалзах		–	–	–	1	–	–	6
Үгээ буцааж татахаас татгалзах	3	1	2	4	–	–	–	10
Танхимаас гарахыг татгалзах	2	–	–	1	–	–	–	3
<b>Нийт</b>	<b>73</b>	<b>123</b>	<b>97</b>	<b>223</b>	<b>168</b>	<b>278</b>	<b>524</b>	<b>1486</b>



<sup>240</sup> Lundie, R. (2013). *That's It, You're Out: Disorderly Conduct in the House of Representatives from 1901 to 2013*. Parliamentary Library

## ПАРЛАМЕНТЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ЦАГЛАВРЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Г.Алтан-Оч (Ph.D)  
Р.Оргилмаа, Б.Туул*

Энэхүү харьцуулсан судалгаанд Герман (манай эрх зүйн орчны суурь жишиг болон захиалагчийн даалгавраар), Дани (захиалагчийн даалгавар), Исланд (манайхтай төстэй, хүн ам цөөхөн, парламентын гишүүний тоо-63), ОХУ (пост-коммунист, хөрш) болон БНСУ (Азийн төлөөлөл, ардчилал, сонгодог парламентын жишиг)-ыг сонгож, парламентад хэлэлцэх асуудлын дарааллыг хэрхэн тогтоож, төлөвлөдөг талаар авч үзлээ.

Парламентын чуулганы хуралдааны цаглавар буюу тов, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох асуудлыг зарим оронд Үндсэн хуулиндаа тусгаж, бүх улсад парламентын дотоод журам буюу дэгийн тухай хуулиар зохицуулж байна.

Парламентын чуулганы цикл харилцан адилгүй байна. Герман, Дани, Солонгост жилийн турш нэг чуулгантай бол (9-р сараас дараа оны 7-р сар хүртэл), ОХУ-2, Исланд-4 чуулгантай байдаг. Чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг циклийн хугацаагаар буюу жилээр, хагас жилээр, улирлаар төлөвлөдөг байна. Тухайн чуулганы хуралдааны циклэд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө буюу жагсаалтад оруулах боломжтой хуулийн төслийг өргөн мэдүүлэх сүүлчийн хугацаа мөн харилцан адилгүй байна. Үүнд:

- 4-р сарын 1 (Дани, Исланд)
- 1-р сарын 31 (Солонгос)
- 3 Хуралдааны долоо хоног буюу цаглаврын 1 сарын өмнө (Герман)
- Тодорхойгүй (Орос)

Хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоохдоо Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөл, төсвийн тодотгол болон хүсэлт гаргасан улс орны өмнө тулгамдсан яаралтай бусад чухал асуудлыг тэргүүн ээлжинд багтаана (Дани). Мөн Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг парламентын гишүүний өргөн барьсан хуулийн төслийн өмнө дараалуулдаг байна (Исланд). Хэлэлцэх асуудлыг ач холбогдоор нь доорх байдлаар эрэмбэлэх боломжтой байна. Үүнд:

1. Улс орны өмнө тулгамдсан нэн яаралтай чухал асуудал
2. Хүчингүй болгох хуулийн төсөл
3. Олон улсын гэрээг батлах хуулийн төсөл
4. Хориг тавигдсан хуулийн төсөл
5. Төсвийн төсөл, төсвийн тодотгол
6. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөл
7. Парламентын гишүүний өргөн барьсан төсөл
8. Бусад



Чуулганы хуралдааны хөтөлбөрийг (огноо, цагийн хуваарь, хэлэлцэх асуудал) ажлын долоо хоногоор төлөвлөж, урьдчилан баталдаг байна. Хөтөлбөрийг ихэнх оронд хамтын байгууллага (парламентын чуулган өөрөө буюу зөвлөл, хороо г.м.) тогтоодог бол зарим улсад спикер тогтоодог (Дани, Солонгос). Ингэхдээ дээд тал нь 3 долоо хоногоор (Герман) төлөвлөж байна. Өдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг ерөнхийдөө өглөө 09:00 цагт нээж, дундаа завсарлахгүйгээр хоногтоо багтаан (24:00 цаг) өндөрлүүлэхээр төлөвлөдөг байна (Герман, Исланд).

### **1. Герман**

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бундестаг нь өөрийн ерөнхийлөгч,

түүний орлогчид болон нарийн бичгийн дарга<sup>241</sup> нарыг сонгоно. Бундестаг нь өөрийн дотоод журмыг тогтооно.” гэж заасны дагуу Бундестагийн дотоод журам нь бие даасан дүрмийн (журмын) эрх зүйд хамаарна. Холбооны Үндсэн хуулийн Шүүх 1952 онд, шинээр сонгогдсон Бундестаг нь өөрийн дотоод журмыг батална хэмээн шийдвэрлэсэн байдаг аж. Шинэ дотоод журам боловсруулах нь практикт ихээхэн хүндрэлтэй тул өмнөх парламентын дотоод журмыг суурь болгон зарим өөрчлөлтийг шинээр тусган баталж ирсэн түүхтэй байдаг. Гэхдээ 1951, 1970, 1980 онуудад зарчмын өөрчлөлт оржээ.<sup>242</sup>

“Холбооны Улсын Их хурал”<sup>243</sup> (парламентын доод танхим) буюу Бундестагийн Ерөнхийлөгч, түүний орлогч нараас Бундестагийн удирдлага бүрдэнэ. Удирдлагын гишүүд нь ээлжлэн чуулганы хуралдааныг даргалдаг. Зөвхөн маш чухал хуралдааны турш Ерөнхийлөгч нь даргалдаг.<sup>244</sup>

Чуулганы нэгдсэн хуралдааныг явуулахад онцгой чухал үүрэгтэй оролцдог байгууллага бол Бундестагийн удирдлагын дэргэдэх Ахмадын зөвлөл юм. Түүний үндсэн чиг үүрэг нь хэлэлцэх асуудалд хэзээ, хэр хугацаагаар ямар асуудал оруулахыг тогтоох явдал юм. Мөн хуралдааны долоо хоногийн үндсэн төлөвлөгөөг энэ зөвлөл баталдаг.

Парламентын ажлын алба (Тамгын газар)-ны гүйцэтгэх удирдлагыг Бундестагийн бүрэлдэхүүнд харгалзуулан томилдог учир тэрээр Ахмадын зөвлөлд Бундестагийн удирдлагын нэгэн адил багтдаг. Мөн зөвлөх эрхтэй нэг гишүүн Холбооны Улсын Засгийн газрыг Ахмадын зөвлөлд төлөөлдөг.

Чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг дараах байдаар тогтооно:<sup>245</sup>

- Ахмадын зөвлөл тохиролцох, эсвэл
- Бундестаг урьдчилан батлах, эсвэл
- Чуулганы хуралдаанаас эрх шилжүүлсэн, эсвэл маш яаралтай шалтгаанаар онцгой тохиолдолд Бундестагийн ерөнхийлөгч тогтоох. Хэрэв тухайн үед ерөнхийлөгч завгүй байгаад чуулганыг зарлан хуралдуулсан бол дараа нь зөвшөөрөл нөхөн гаргавал зохино. Депутатуудын гуравны нэг, эсвэл Холбооны Улсын Канцлер<sup>246</sup>, эсвэл Холбооны Улсын Ерөнхийлөгч шаардсан бол Бундестагийн ерөнхийлөгч чуулганыг заавал зарлан хуралдуулдаг.

Хэлэлцэх асуудлыг урьдчилан тогтоож байгаа нь төлөвлөгдөөгүй асуудлаар гэнэтийн санал хураалтанд депутатыг оруулахаас зайлсхийх зорилготой аж. Ийнхүү урьдчилан зарлагдсан хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах талаар депутат нь өмнөх өдрийн 18:00 цаг хүртэл санал гаргах эрхтэй. Гэхдээ парламентын бүлгээс уг саналыг гаргавал илүү үр дүнтэй байдаг. Хэрэв бүлгийн (нийт гишүүдийн 5%) хэмжээний цөөнх эсэргүүцэхгүйгээр санал нийлсэн бол хэлэлцэх асуудлын дараалалд шинээр асуудал оруулж болно.

Хэлэлцэх асуудлын дараалалд албадан оруулах хугацааг 6 цаглаврын (хуанлийн) долоо хоног байсныг 1995 онд 3 долоо хоног болгон богиносгосон аж. Энэ юу гэсэн үг вэ гэвэл, нэгэнт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хамгийн оройтлоо гэхэд 3 долоо хоногийн дараа хэлэлцэх асуудлын дараалалд оруулдаг байна.

Хэрэв хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргах чадамжгүй (ирц хангалтгүй) нөхцөл байдал

<sup>241</sup> Schriftführer-германаар-үгчилбэл “бичгийн эрхлэгч”

<sup>242</sup> Германы Бундестаг-Deutscher Bundestag-германаар

[https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go\\_eri/gescho02-244656](https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go_eri/gescho02-244656)

<sup>243</sup> үгчилбэл

<sup>244</sup> Бундестагийн дотоод журам-Deutscher Bundestag: Organisation der Abgeordneten

[https://de.wikipedia.org/wiki/Deutscher\\_Bundestag#Gesch%C3%A4ftsordnung](https://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Gesch%C3%A4ftsordnung)

<sup>245</sup> Дотоод журмын тайлбар-Erläuterungen zur Geschäftsordnung-германаар

[https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go\\_eri/gescho07-244670](https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go_eri/gescho07-244670)

<sup>246</sup> Ерөнхий сайд

Үүссэн бол ерөнхийлөгч тухайн өдрөө чуулганыг дахин хуралдуулах тов гаргаж болно.

Зураг №1. Хуралдааны цаглавар<sup>247</sup>

The image shows the official calendar of the German Bundestag sessions for the year 2020. The calendar is a grid where each row represents a month from January to December. Each cell contains a date, a color-coded background, and sometimes additional text indicating the type of session or its purpose. The colors used include grey, blue, red, green, yellow, and white. A legend on the right side of the grid provides a key for these colors, though it's mostly in German. The legend includes terms like 'Plenarsitzung' (Plenary Session), 'Fraktionssitzung' (Party Group Session), 'Kabinettssitzung' (Cabinet Session), 'Bundesratssitzung' (Session of the Federal Council), 'Bundestagsausschusssitzung' (Session of a Bundestag Committee), 'Bundestagsdelegationsitzung' (Session of a Bundestag Delegation), and 'Bundestagspräsident' (President of the Bundestag). The legend also notes that grey cells represent 'gewöhnliche Plenarsitzungen' (regular plenary sessions) and yellow cells represent 'extraordinäre Plenarsitzungen' (extraordinary plenary sessions).

Januar	Februar	März	April	Mai	Juni	Juli	August	September	Oktober	November	Dezember
1 Mi Neujahr 1	1 Sa	1 So	1 Mi	1 Fr Tag der Arbeit	1 Mi Plenarsitzung 23	1 Mi	1 Sa	1 Mi	1 So	1 So Abstimmungen	1 Sa
2 So	2 So	2 So	2 So	2 Mi	2 Mi	2 So	2 Mi	2 Mi	2 Fr	2 Mi	2 Mi
3 Fr	3 Mi	3 Mi	3 Mi	3 So	3 Mi	3 Fr	3 Mi	3 Mi	3 So	3 Mi	3 Mi
4 So	4 Mi	4 Mi	4 Mi	4 Mi	4 Mi	4 So	4 Mi	4 Mi	4 Mi	4 Mi	4 Mi
5 So	5 Mi	5 Mi	5 Mi	5 So	5 Mi	5 So	5 Mi	5 Mi	5 Mi	5 Mi	5 Mi
6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi	6 Mi
7 Do	7 Fr	7 Sa	7 So	7 So	7 So	7 So	7 So	7 So	7 Mi	7 Mi	7 Mi
8 Mi	8 Mi	8 So	8 So	8 So	8 So	8 Mi	8 Mi	8 Mi	8 Mi	8 Mi	8 Mi
9 Do	9 So	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi	9 Mi
10 Fr	10 Mi	10 Mi	10 Fr	10 Fr	10 Mi	10 Fr	10 Mi	10 Mi	10 Mi	10 Mi	10 Mi
11 Sa	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi	11 Mi
12 So	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi	12 Mi
13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi	13 Mi
14 Mi	14 Fr	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi	14 Mi
15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi	15 Mi
16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi	16 Mi
17 Fr	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi	17 Mi
18 Sa	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi	18 Mi
19 So	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi	19 Mi
20 Mi	20 Mi	20 Mi	20 Fr Frühlings- einzug	20 Mi	20 Mi	20 Mi	20 Mi	20 Mi	20 Mi	20 Mi	20 Mi
21 Mi	21 Fr	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi	21 Mi
22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi	22 Mi
23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi	23 Mi
24 Fr	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi	24 Mi
25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi	25 Mi
26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi	26 Mi
27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi	27 Mi
28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi	28 Mi
29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi	29 Mi
30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi	30 Mi
31 Mi				31 So Plenarsitzung		31 Mi	31 Mi	31 Mi	31 Mi	31 Mi	31 Mi

### Тайлбар:

**ягаан**-Бундестагийн хуралдааны долоо хоног  
**ногоон**-Холбооны зөвлөлийн нэгдсэн хуралдаан  
**цэнхэр**-Европын Парламентын их хурал  
**шар**-EX-ны Зөвлөлийг ахлах хугацаа

Цаглавраас харахад, Бундестагийн хуралдааны цаглавар нь Холбооны зөвлөл (парламентын дээд танхим) болон Европын парламентын цаглавартай уялдаатай байдаг аж. Хуралдаан ерөнхийдөө хуанлийн 9-р сард эхэлж, дараа оны 7-р сар хүртэл тасралтгүй үргэлжилдэг. Жилийн 7, 8-р сард завсарладаг байна.

Германы Холбооны Улсын Их хурал (Бундестаг)-ын хуралдааны цаглавар нь “Хуралдааны долоо хоног”-оос бүрдэнэ. Ахмадын зөвлөл нь хуралдааны долоо хоногийг тогтоох бөгөөд депутатуудад зарлана. Депутатын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасанчлан хуралдааны өдрүүдэд заавал биеэр оролцох бөгөөд ирцийн жагсаалтад бүртгүүлэх үүрэгтэй.

Зураг №1-ээс үзэхэд, Чуулганы хуралдаан сард дунджаар 2 долоо хоног (2, 4-р сард тус тус 1 удаа; сондгой сард 3 удаа) хуралддаг.

<sup>247</sup> Sitzunkalender-германаар

**Зураг №2. Чуулганы хуралдааны долоо хоног<sup>248</sup>**  
**Лхагва гараг**

Sitzungsverlauf			
16. September 2020 (175. Sitzung)			
Uhrzeit	TOP	Thema	Status/ Abstimmung **
13:00		Sitzungseröffnung	beendet
13:00	1	⊕ Befragung der Bundesregierung	beendet
14:05	2	⊕ Fragestunde	beendet
15:10	ZP 1	⊕ Aktuelle Stunde - Demokratie und nationale Souveränität in Belarus	beendet
16:30	3, ZP 2	⊕ Einführende Generalsedebatte Nachhaltigkeit	⊕ Details einblenden
18:15	4, ZP 3-5	⊕ Mobilität der Zukunft	⊕ Details einblenden
19:30	5, ZP 6	⊕ Demokratie, handlungsfähiger Staat, Finanzen	⊕ Details einblenden
20:45		Sitzungsende	⊕ Details einblenden

\*\*) Die amtlichen Ergebnisse finden Sie im [Amtlichen Protokoll](#) sowie im [Plenarprotokoll](#) der jeweiligen Sitzung am nächsten Werktag.

**Пүрэв гараг**

17. September 2020 (176. Sitzung)			
Uhrzeit	TOP	Thema	Status/ Abstimmung **
09:00		Sitzungseröffnung	beendet
09:00	6, ZP 7, TOP 3 c	⊕ Klima, Umwelt und natürliche Lebensgrundlagen	⊕ Details einblenden
10:25	7, ZP 8	⊕ Wachstum und ökologisch-soziale Marktwirtschaft	⊕ Details einblenden
11:45	8, ZP 9	⊕ Arbeit im Wandel	⊕ Details einblenden
13:00	9, ZP 10	⊕ Innovation, Bildung und Digitalisierung	⊕ Details einblenden
14:20	10, 7a,r, ZP 11-16	⊕ Entwicklung und internationale Zusammenarbeit	⊕ Details einblenden
15:30	11	⊕ Nachhaltig leben und konsumieren	⊕ Details einblenden
17:05	32, ZP 17	⊕ Überweisungen im vereinfachten Verfahren	Überweisung beschlossen
17:10	33	⊕ Abschließende Beratungen ohne Aussprache	⊕ Details einblenden
17:25	ZP 19	⊕ Aktuelle Stunde - Auswirkungen der Afrikanischen Schweinepest	beendet
18:30	12	⊕ Wohnungseigentum	⊕ Details einblenden
19:35	13, 21 b,c	⊕ Covid-19-Rechtsverordnungsweltergeltungsgesetz	⊕ Details einblenden
20:20	14	⊕ Finanzielle Entlastung der Kommunen	⊕ Details einblenden
21:05	15, ZP 20	⊕ Abfallrahmenrichtlinie der EU	⊕ Details einblenden
21:40	16	⊕ Bundesverfassungsgerichtsgesetz (Auslandseinsätze)	⊕ Details einblenden
22:15	17	⊕ Änderung des Kraftfahrzeugsteuergesetzes	⊕ Details einblenden
22:45	18	⊕ COVID-19-Insolvenzaussetzungsgesetz	⊕ Details einblenden
23:10	19	⊕ Änderung des Batteriegesetzes	⊕ Details einblenden
23:25		Sitzungsende	⊕ Details einblenden

<sup>248</sup> Sitzungswoche-германаар

## Баасан гараг

18. September 2020 (177. Sitzung)			
Uhrzeit	TOP	Thema	Status/ Abstimmung
09:00		Bitzungseröffnung	beendet
09:05	20	⊕ Zukunft der Krankenhäuser	⊕ Details einblenden
09:30	5d	⊕ EZB-Politik	⊕ Details einblenden
10:25	22, ZP 21	⊕ Kapitalanleger-Musterverfahrensgesetz	⊕ Details einblenden
11:00	23	⊕ Digitalpakt 2.0	abgelehnt
11:40	24	⊕ Stand der Deutschen Einheit 2020	
12:20	ZP 18, 25	⊕ Konsequenzen aus dem Brand in Moria	
13:00	26	⊕ Bundeswehreinsatz in Irak	
13:40	ZP 22, 7f	⊕ Nord Stream 2	
14:00	28	⊕ Änderung des Bundeswehrgesetzes	
15:00	29	⊕ Gleichstellung von Frauen und Männern	
15:40	30, ZP 23	⊕ Schutz von Rechtsstaatlichkeit und Demokratie	
16:20	31	⊕ Änderung der Abgabenordnung	
17:00	ZP 24	⊕ Aktuelle Stunde - Hinrichtung Navid Afkars und die deutsche Iranpolitik	
18:05		Bitzungsende	

Үг судалгааг хийж буй долоо хоног буюу 2020.09.14-18-ны өдрүүд хамрагдах Хуралдааны долоо хоногийн хөтөлбөрөөс харахад, чуулганы хуралдаан Лхагва гарагт 13:00-20:45, Пүрэв гарагт **09:00-23:25**, Баасан гарагт 09:00-18:05 цагт хуралдахаар товлогдож, хэлэлцэх асуудлын хамтаар төлөвлөгдсөн байна. Түүний дараагийн Хуралдааны долоо хоног нь 2020.09.28-10.02-ны өдрүүдэд тохиож, Мягмар гарагаас Баасан гарагт хуралдахаар төлөвлөгдсөн байх бөгөөд 09:00-19:40 цаг хүртэл (Баасанд 14:50 цаг хүртэл) хуралдах байдалтай байна. Эндээс үзэхэд чуулганы хуралдааныг ерөнхийдөө өглөө 09:00 цагт нээж, завсарлахгүй үргэлжлүүлэн хамгийн оройдоо 23:25 цагт өндөрлүүлж байна.

Байнгын хороо (БХ)-ны дарга нь Ахмадын зөвлөлийн тогтоосон хуралдаан зохион байгуулах боломжийн хүрээнд (цагийн хуваарь) хорооныхоо хурлыг бие даан зарлан хуралдуулна. Гэхдээ зарим онцгой тохиолдолд байнгын хороо шийдвэр гаргаж болно. Хэрэв БХ-ны бүлэг, эсвэл БХ-ны бүх гишүүдийн 1/3-ээс олон гишүүн шаардсан бол БХ-ны дарга нь цагийн хуваарыг багтаан хамгийн боломжит товыг зарлах үүрэгтэй. Хэрэв Бундестагийн бүлэг, эсвэл нийт гишүүдийн 5%, эсвэл БХ санал нэгтэй шийдсэн бол цагийн хуваарийн гадуур буюу Бундестагийн бус байранд БХ-ны хуралдааныг зөвхөн товлож болно.

Хэрэв БХ өмнө нь шийдээгүй бол БХ-ны хуралдааны тов болон хэлэлцэх асуудлыг БХ-ны дарга тогтооно. Хэлэлцэх асуудлыг БХ-ны гишүүдэд хуралдаан болохоос байнга 3 өдрийн өмнө тараана. БХ нь хэлэлцэх асуудлыг зөвхөн олонхийн саналаар өөрчлөх боломжтой бөгөөд хэрэв бүлэг буюу БХ-ны гишүүдийн 1/3 эсэргүүцэхгүй бол нэмэлт оруулах боломжтой байдаг аж. БХ-ны хуралдааны хэлэлцэх асуудлыг газар (байр), тов (боломжтой бол хуралдаан үргэлжлэх хугацаа)-ын хамт холбогдох яам болон Холбооны зөвлөлд зарлана.

Хэрэв бүлэг, эсвэл Бундестагийн 5% шаардсан бол БХ-нд шийдвэрийн төсөл ирсэнээс хойш **10** хуралдааны долоо хоног өнгөрсөн бол БХ-ны дарга буюу илтгэгч нь шийдвэрийн зөвлөмжийн байдлын талаар Бундестагт илтгэх үүрэг хүлээнэ. Хэрэв шаардсан бол Бундестагийн хэлэлцэх асуудлын дараалалд уг илтгэлийг оруулна.

## **2.Дани**

Дани Улсын парламент Фолкетинг (Folketing)-ийн үйл ажиллагаа Аравдугаар сарын эхний өдрөөс Зургадугаар сарын 05 хүртэл үргэлжилнэ. Парламент жилд 100 орчим өдөр хуралддаг байна. Чуулганы хуралдаан Мягмар, Лхагва гарагт 13:00 цагт, Пүрэв, Баасан гарагт 10:00 цагт тус тус эхэлдэг байна.

Чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тус улсын Үндсэн хууль болон Дани Улсын парламентын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулж байна. Тус улсын Парламентын Ерөнхийлөгч нь чиг үүргийнхээ дагуу хуулийн төсөл, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй танилцан, шаардлага хангасан төслүүдийг хэлэлцүүлэхээр хүлээн авдаг байна. Хүлээн авсан төслүүд болон бусад асуудлаар ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоохоос гадна тус дараалалд өөрчлөлт оруулах эрхтэй байна.<sup>249</sup> Ингэхдээ Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөл, төсвийн тодотгол, Ерөнхий сайд, салбарын сайдын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу улс орны өмнө тулгамдсан бусад асуудлуудыг дараалал харгалзахгүй яаралтай хэлэлцэх үүрэг хүлээнэ.

Ихэнх хуулийн төслийг санаачлагч Засгийн газарт парламентын жилийн эхээр хуулийн төслүүдээ өргөн барихыг зөвлөдөг байна. Дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс өмнө хуулийн төслөө өргөн баривал тухайн жилдээ багтаан хэлэлцэх боломжтой ба эс бөгөөс тухайн парламентын жилээр хэлэлцэх асуудлын дараалалд оруулах боломжгүй байна.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДАРААЛЛЫГ ТОГТООХ**

### **Үндсэн хууль<sup>250</sup>. 39 дүгээр зүйл.**

Фолкетингийн Ерөнхийлөгч нь хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон, чуулганы хуралдааныг зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч нь Фолкетингийн гишүүдийн 2/5-ын болон Ерөнхий сайдын бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон, чуулганы хуралдааныг зарлан хуралдуулна.

### **41 дүгээр зүйл**

2. Ямар ч хуулийн төсөл Фолкетинг-ээр 3 удаа хэлэлцэгдсэний эцэст батлагдана.
3. Фолкетингийн гишүүдийн 2/5-ийн Фолкетингийн Ерөнхийлөгчид бичгээр гаргасан саналаар хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг тухайн төслийн 2 дахь хэлэлцүүлэг болсноос ажлын 12 өдрөөс багагүй хугацааны дараа хэлэлцэх ёстой байна.
4. Шинэ сонгуулийн хугацаа тулсан хийгээд парламентын жилийн эцэст эцэслэн баталж чадаагүй хуулийн төслүүд болон бусад асуудлыг хэлэлцэхгүй орхино<sup>251</sup>.

### **Парламентын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль<sup>252</sup>. Хэлэлцүүлгийн дараалал.**

#### **32 дугаар зүйл**

2. Чуулганы хуралдааны өдрийн төгсгөлд Парламентын Ерөнхийлөгч нь дараагийн өдрийн хуралдааны тов буюу өдөр, цаг, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулна. Хэлэлцүүлгийн дарааллын агуулга, хэлэлцэх асуудлуудын талаарх мэдээллийг Данийн парламентын цахим хуудсуудын аль нэгэнд тавьж, хуралдааны эцэст гишүүдэд мэдэгдэнэ. Чуулганы дараагийн хуралдааны өдөр, цаг, хуулийн төслийн хэлэлцэх дарааллыг тогтсон хэдий ч Парламентын Ерөнхийлөгч нь хуралдааны цагийг өөрчилж болно.
3. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцүүлгийн дарааллыг тогтоогоогүй тохиолдолд

<sup>249</sup> <http://archive.ipu.org/parline-e/reports/2087.htm>

<sup>250</sup> [https://www.constituteproject.org/constitution/Denmark\\_1953?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Denmark_1953?lang=en)

<sup>251</sup> shall be dropped

<sup>252</sup> [https://www.thedanishparliament.dk-/media/pdf/publikationer/english/standing\\_orders\\_of\\_the\\_danish\\_parliament.ashx](https://www.thedanishparliament.dk-/media/pdf/publikationer/english/standing_orders_of_the_danish_parliament.ashx)

Парламентын Ерөнхийлөгч дарааллыг өөрчлөх, түүнчлэн парламентад уг асуудлыг хэлэлцэхгүй байх шалтгааныг мэдэгдсэнээр дарааллаас хасах эрхтэй байна. Гишүүдийг хороодод болон комисст хуваарилах зэрэг ажлаас гадна зөвхөн чуулганы тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон асуудлуудыг хэлэлцэнэ.

4. Данийн парламентын гишүүдийн 2/5 болон Ерөнхий сайдын тус тус бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Парламентын Ерөнхийлөгч нь хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон, чуулганы хуралдааныг зарлан хуралдуулах эрхтэй.

5. Дараагийн долоо хоногийн хөтөлбөр буюу Парламентын Ерөнхийлөгчийн баталсан хуралдааны хэлэлцүүлгийн дараалал нь Данийн парламентын аль нэг цахим хуудсанд, тухайн долоо хоногийн хуралдааны хамгийн сүүлийн өдөр тавигдана.

### **3. Исланд**

Исланд Улсын парламент Алтингийн<sup>253</sup> чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг Алтингийн дэгийн тухай хуулиар<sup>254</sup> зохицуулж байна. Парламентын Спикер болон Дэд спикерүүдээс бүрдсэн Спикерийн хороо<sup>255</sup> нь Засгийн газрын кабинет болон намын бүлгүүдтэй зөвшилцэн чуулган бүрийн өмнө тухайн чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргадаг байна.

Долоо хоног бүрийн чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг Спикерийн хорооны хуралдаанаар хэлэлцэн тогтох, Спикер баталгаажуулна. Хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоохдоо Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг парламентын гишүүдийн бие даан өргөн барьсан хуулийн төслийн өмнө хэлэлцэх журмыг баримтална.

Хуульд заасан хугацаа буюу чуулганы хуралдааны эхээр, Дөрөвдүгээр сарын 1-нээс өмнө өргөн баригдсан төслүүдийг тухайн парламентын жилд чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулах бөгөөд эс бөгөөс хойшлуулдаг байна. Гэвч парламентын гишүүдийн 3/5 хэлэлцэх эсэх саналыг дэмжсэн бол Дөрөвдүгээр сарын 1-нээс хойш өргөн мэдүүлсэн төслийг гишүүдэд тарааж танилцуулснаас хойш 5 хоногийн дараа хэлэлцэх боломжтой болно.<sup>256</sup>

### **Алтингийн дэгийн тухай хууль. 10 дугаар зүйл**

Спикер болон Дэд спикерүүд нь Спикерийн хороог бүрдүүлнэ. Спикерийн хороонд төлөөлөл нь ороогүй парламентын бүлэг нь, тус хорооны зөвшөөрөлтэйгээр хорооны хуралдаанд оролцох ажиглагчийг томилон ажиллуулж болно.

Спикерийн хороо нь Алтингийн үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд парламентын чуулган бүрийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг<sup>257</sup> бэлтгэнэ. Хэлэлцэх асуудлыг дараах 4 дэд чуулганы хуралдаанд хуваарилна.

- Намрын чуулган (Х/01-Зул сарын баярын амралт хүртэл)
- Өвлийн чуулган (Зул сарын баярын амралтын дараагаас-Улаан өндөгний баяр хүртэл)
- Хаврын чуулган (Улаан өндөгний баярын амралтын дараагаас-Тавдугаар сарыг дуустал)
- Есдүгээр сард хуралдах парламентын хуралдаан буюу хороодын хуралдаан.

Ямар өдөр чуулган хуралдах, ямар өдөр байнгын хороод болон парламентын бүлгүүд хуралдах, ямар өдөр гишүүд тойротгоо ажиллах гэсэн хуралдааны ерөнхий төлөвлөгөөг

<sup>253</sup> Althingi

<sup>254</sup> Althingi Standing Orders <https://www.althingi.is/english/about-the-parliament/standing-orders-of-the-althingi/>

<sup>255</sup> Speaker's committee

<sup>256</sup> [https://www.althingi.is/pdf/Althingi2013\\_enska.pdf](https://www.althingi.is/pdf/Althingi2013_enska.pdf)

<sup>257</sup> schedule

баталж гаргана. Төлөвлөгөөгөөр баталсан өдрүүдэд чуулганы хуралдаан оройны 20:00 цагаас хэтрэхгүй байна. Парламентын бүлгүүд зөвшилцэн шийдвэрлэсэн болон тус хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу парламентаар зөвшөөрсөн бол тогтсон цагийг өөрчилж болно. Спикер урьдчилан мэдэгдэлгүй хуралдааныг сунгаж болно. Мягмар гарагт хуралдааныг шөнийн 00:00 цаг хүртэл сунгаж болно.

## **79 дүгээр зүйл**

Спикер нь парламентын бүлгүүдийн дарга нар эсхүл тэдгээрийн төлөөлөгчидтэй парламентын үйл ажиллагааны талаар хэлэлцэн, Алtingийн чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон долоо хоног бүрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд санал авна.

## **4. ОХУ**

Төрийн Думын депутатуудын хэлэлцэх асуудлын хуваарийг Регламент<sup>258</sup> болон дотоод зохион байгуулалтын хороо боловсруулж Төрийн Думын чуулганы хуралдаанаар батална. Төрийн Думын тогтоолоор батлагдсан хуваарийн дагуу хавар, намар цуглана.

Төрийн Думын хуралдаан Лхагва, Баасан гаригуудад хуралдаа бөгөөд Төрийн Дум үүнээс гадна ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болно. Хуралдаан явуулах тов, цагийг Дэгээр тогтооно.

Төрийн Думын ээлжит хуралдааны хуваарийг Төрийн Думд өргөн мэдүүлсэн дарааллыг харгалзан боловсруулна.

## **Төрийн Думын регламент. 40 дүгээр зүйл**

1. Төрийн Дум нь хавар, намрын чуулганд Думын тогтоолоор батлагдсан Төрийн Думын депутатуудын ажлын хуваарийн дагуу цуглана.
3. Төрийн Думын хуралдаан Лхагва, Баасан гаригуудад хуралдана. Төрийн Дум үүнээс гадна ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болно. Хуралдаан явуулах цагийг Дэгээр тогтооно.

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДАРААЛЛЫГ ТОГТООХ**

Төрийн Думын Лхагва гарагийн хуралдаанаар Төрийн Думын хэлэлцэх асуудлын жагсаалтыг баталдаг. Танхимын үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудлыг зөвшилцэх, хуралдааны бэлтгэлийг хангах зорилготой Төрийн Думын Зөвлөл нь Төрийн Думын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож хэлэлцэх асуудлын төслийг Төрийн Думын хуралдаанаар батлуулдаг. Сар тутам хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг сэдэвчлэн (төрийн байгуулалт, Үндсэн хуульд заасан иргэдийн эрх, эрх чөлөө; эдийн засгийн бодлого; нийгмийн бодлого; төсөв, татвар, санхүүгийн хууль тогтоомж; батлан хамгаалах, аюулгүй байдал; ОХУ олон улсын гэрээнд нэгдэн орох) гаргадаг.

Төрийн Думаар хэлэлцэх асуудлын төслийг хуулийн төслийг Төрийн Думд өргөн мэдүүлсэн дарааллыг харгалзан хийнэ. Төрийн Думын ажлын дараалалд хуулийн төслийг дор дурдсанаар оруулна:

- а) гуравдугаар хэлэлцүүлэгт оруулж байгаа хуулийн төсөл;
- б) хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулж байгаа хуулийн төсөл;
- в) анхдугаар хэлэлцүүлэгт оруулж байгаа хуулийн төсөл.

## **САНАЛ ХУРААЛТЫН ЦАГ**

Төрийн Думын Лхагва гарагийн хуралдаанд өмнө хэлэлцсэн дараах хуулийн төслүүдээр танхимд санал хураалт явуулна:

<sup>258</sup> Оросын Холбооны Улсын төрийн думын регламент <http://www.consultant.ru/law/review/lawmaking/reglduma/>

- а) гуравдахь хэлэлцүүлэгт орж байгаа хууль;
- б) хүчингүй болсонд тооцох хууль;
- в) ОХУ-ын Олон улсын гэрээ батлах тухай хуулийн төсөл;
- г) Холбооны Зөвлөлөөс хориг тавьсан хууль;
- д) ОХУ-ын Ерөнхийлөгчийн хориг тавьсан хууль;
- е) ОХУ-ын Үндсэн хуулиар Төрийн Думын бүрэн эрхэд хамааруулсан асуудлаарх тогтоолын төсөл.

Төрийн Думын Зөвлөлийн шийдвэрээр, эсхүл Төрийн Думын нийт гишүүдийн олонхын саналаар баталсан танхимын шийдвэрээр “санал хураалтын цаг”-ийг өөр өдөр явуулахаар шийдвэрлэж болно.

### **“ЗАСГИЙН ГАЗРЫН ЦАГ”**

Төрийн Думын регламентийн 41 дүгээр зүйлд Төрийн Думаар хэлэлцэх асуудлын дараалалд Төрийн Думын депутатуудын асуултад хариулах цаг (“Засгийн газрын цаг” гэх)–ийг тусгана. Төрийн Думын Зөвлөл нь тухайн сарын “Засгийн газрын цаг”-аар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд туссан асуудлыг тухайн долоо хоногийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна гэж заасан байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч буюу Төрийн Думын нийт гишүүдийн тавны нэгийн шаардсанаар, эсхүл Төрийн Думын даргын саналаар ээлжит бус хуралдааныг зарлах, түүний хуралдах өдрийг товлох, хуралдуулах зэрэг ажлуудыг зохион байгуулна.

### **5. БНСУ**

Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоох төрийн дээд байгууллага болох парламентыг Үндэсний Ассамблей<sup>259</sup> гэнэ. Үндэсний Ассамблейн удирдах байгууллага нь дарга, хоёр дэд дарга, нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ. Үндэсний Ассамблейн чуулганы нэгдсэн хуралдаан ээлжит ба ээлжит бус гэсэн хоёр хэлбэрээр хуралддаг. Жил бүрийн төсвийн асуудлаарх чуулган 9 дүгээр сарын 10-нд эхэлдэг.

Ээлжит бус чуулганыг Ерөнхийлөгчийн санаачлагаар, эсвэл парламентын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь зөвшөөрсөн тохиолдолд 30 хоногоос илүүгүй хугацаагаар зарлан хуралдуулдаг байна. Ерөнхийлөгч хүсэлт гаргаж ээлжит бус хуралдаан хуралдсан тохиолдолд шалтгаан нь маш тодорхой байх ёстой байдаг.

Парламентын ээлжит чуулганы үргэлжлэх хугацаа нь 100 хоногоос илүүгүй байдаг байна. Үндэсний Ассамблейн гишүүдийн тавны нэг нь хүрэлцэн ирсэн тохиолдолд нэгдсэн хуралдаан чуулдаг байна.

### **Үндэсний Ассамблейн жилийн ажлын төлөвлөгөө**

Спикер нь Үндэсний Ассамблей дахь нам, эсвлийн бүлгийн төлөөлөгч гишүүдтэй зөвшилцэж жилийн ажлын үндсэн төлөвлөгөөг батална. Үндэсний Ассамблейн сонгуулиар бүрдсэн шинэ Үндэсний Ассамблейн хувьд тухайн жилийн үндсэн төлөвлөгөөг 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тогтооно.

Ээлжит чуулганы хугацаа 100 хоног (ээлжит чуулганыг жил бүрийн 9-р сарын 1-ний өдөр зарлан хуралдуулна), ээлжит бус чуулганы хугацаа 30 хоног (8 дугаар сарын 16-ны өдрөөс ээлжит бус чуулган эхлэх тохиолдолд 8 дугаар сарын 31-ны өдөр хүртэл) байна.

<sup>259</sup> Бүгд Найрамдах Солонгос Улсын үндэсний ассамблейн тухай хууль  
[https://korea.assembly.go.kr:447/res/law\\_06\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/law_06_read.jsp)

## **Хуулийн төсөл өргөн барих төлөвлөгөөг мэдэгдэх**

Засгийн газар нэн яаралтайгаас бусад үед жил бүрийн 1 дүгээр сарын 31-ний өдрөөс өмнө тухайн жилд өргөн барих хуулийн төсөлтэй холбоотой төлөвлөгөөг Ассамблейд мэдэгдэнэ.

### **Хэлэлцэх хуулийн төслийн жагсаалтыг гаргах**

Спикер нэгдсэн чуулганд өргөн барьсан дарааллын дагуу хэлэлцэх хуулийн төслийн жагсаалтыг гаргана.

Хэлэлцэх хөтөлбөрийн дундаас нэгдсэн хөтөлбөрийг үйлдэхдээ Үндэсний Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хороотой зөвшилцөх бөгөөд зөвшилцэж чадаагүй тохиолдолд спикер дангаар шийдвэрлэнэ.

Спикер энэ зүйлийн 2, 3-т заасан хөтөлбөрийг шууд гишүүдэд хүргүүлэх болон цахим сүлжээгээр дамжуулж зарлана. Спикер онцгой тохиолдол гэж үзсэн бол зөвхөн хурлын өдөр, цагийг гишүүнд хүргүүлж хурлыг нээж болно.

Үндэсний Ассамблейн хуралдааны төлөвлөгөөнд багтсан хуулийн төслийг хэлэлцэх хуралдаан хуралдаагүй эсхүл тухайн хуулийн төслийг хуралдаанаар хэлэлцэж амжаагүй тохиолдолд спикер хөтөлбөрийг дахин тогтооно.

### **Хуралдааны төлөвлөгөөг өөрчлөх**

20 ба түүнээс дээш тооны гишүүд гарын үсэг зурж санал гаргаснаар спикер бүлэг тус бүрийг төлөөлж буй гишүүдтэй зөвшилцэж шаардлагатай гэж үзсэн тохиолдолд спикер ээлжит чуулганы хөтөлбөрийг хэсэгчилж өөрчлөх эсхүл тухайн өдрийн хөтөлбөрт хэлэлцэх асуудлыг нэмж оруулах болон дараалал өөрчилж болно. Энэ тохиолдолд гишүүн гаргаж буй саналд үндэслэлийг бичгээр хавсаргах бөгөөд тухайн саналаар хэлэлцүүлэг явуулалгүйгээр санал хураалт явуулж шийдвэрлэнэ.

*Хүснэгт №1. Үндэсний ассамблейн 2020 оны төлөвлөгөө  
National Assembly Basic Plan*

Month	Convocation Date (duration)	Agenda		Remarks
		Plenary	Committees	
August (Extraordinary session)	Aug. 17 (Mon) (15 days)	1.Consideration of accounts settlement, etc. 2.Consideration of legislative bills	1.Deliberation of bills including accounts settlement and legislative bills	Deadline for the submission of and voting on accounts settlement: -before the start of regular session

СУДАЛГААНЫ САН

September ~ December (Regular session)	Sept. 1 (Tues) (100 days)	1.Speeches by negotiating groups 2.Interpellation on Government 3.Government's address on budget bills 4.Consideration of budget bills and fund operation plans 5.Consideration of bills	1.Deliberation of budget bills and legislative bills 2.ISA*	◦Deadlines for budget bills -submission: Sept. 3 (Thur) -voting: Dec. 2 (Wed)
--	---------------------------	--	--	---

**Тайлбар:** \* International Search Authority-Олон улсын судалгааны байгууллага

**Ээлжит чуулганы төлөвлөгөөнд:** Бүлгийн төлөөллүүд үг хэлэх, Засгийн газарт асуулт тавих, төсвийн тодотголд Засгийн газраас тайлбар хийх, төсвийн төслийг хэлэлцэх, бусад хуулийн төслийг хэлэлцэхээр IX–XII сард төлөвлөсөн байна.

**Ээлжит бус чуулганы төлөвлөгөөнд:** төсвийн төсөл болон төсвийн хуваарилалт, хуулийн төслүүдийг хэлэлцэх зэрэг асуудлуудаар VIII/17-ны Даваа гарагаас 15 хоног хуралдахаар төлөвлөжээ.

#### Төрийн захиргааны хяналт

“Үндэсний Ассемблей нь жил бүр ээлжит бус хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 30-аас дээшгүй хоногийн хугацаанд эрх бүхий байнгын хороод төрийн захиргааны хяналт шалгалтыг хийдэг. Мөн Ерөнхий аудиторийн шийдвэрээр ээлжит чуулганы үеэр дээрх шалгалтыг хийж болно.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дотоод журмын тайлбар-Erläuterungen zur Geschäftsordnung-германаар [https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go\\_eri/gescho07-244670](https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go_eri/gescho07-244670)
- Бундестагийн дотоод журам-Deutscher Bundestag: Organisation der Abgeordneten-германаар [https://de.wikipedia.org/wiki/Deutscher\\_Bundestag#Gesch%C3%A4ftsordnung](https://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Gesch%C3%A4ftsordnung)
- Дани Улсын парламентын тухай мэдээлэл <http://archive.ipu.org/parline-e/reports/2087.htm>, <https://www.thedanishparliament.dk/en-democracy/the-course-of-a-year>
- Дани Улсын Үндсэн хууль [https://www.constituteproject.org/constitution/Denmark\\_1953?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Denmark_1953?lang=en)
- Дани Улсын Парламентын дэгийн тухай хууль [https://www.thedanishparliament.dk-/media/pdf/publikationer/english/standing\\_orders\\_of\\_the\\_danish\\_parliament.ashx](https://www.thedanishparliament.dk-/media/pdf/publikationer/english/standing_orders_of_the_danish_parliament.ashx)
- Исланд Улсын парламентын тухай мэдээлэл <https://www.althingi.is/english/>, [https://www.althingi.is/pdf/Althingi2013\\_enska.pdf](https://www.althingi.is/pdf/Althingi2013_enska.pdf),
- [http://archive.ipu.org/parline-e/reports/2143\\_C.htm](http://archive.ipu.org/parline-e/reports/2143_C.htm)
- Исланд Улсын Парламентын дэгийн тухай хууль <https://www.althingi.is/english/about-the-parliament/standing-orders-of-the-althingi-/>
- Оросын Холбооны Улсын төрийн думын регламент <http://www.consultant.ru/law/review/lawmaking/reglduma/>
- Бүгд Найрамдах Солонгос Улсын үндэсний ассамблейн тухай хууль [https://korea.assembly.go.kr:447/res/low\\_06\\_read.jsp](https://korea.assembly.go.kr:447/res/low_06_read.jsp)



**ОХУ-ЫН ТӨРИЙН ДУМЫН РЕГЛАМЕНТАД  
ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСЭЭС ГАРГАХ  
ЭРХ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

**ОХУ-ЫН ТӨРИЙН ДУМЫН РЕГЛАМЕНТ<sup>260</sup> (1998)**

**94 дүгээр зүйл.**

1.Энэ Регламентын 217-д зааснаас бусад тохиолдолд ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутат, Төрийн Дум дахь бүлэг (фракц), хороо, комисс, ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоох байгууллага, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, ОХУ-ын Дээд шүүх, ОХУ-ын Арбитрын дээд шүүх өөрсдийн эрхлэх асуудлаар Төрийн Думын тогтоолын төслийг өргөн мэдүүлнэ.

2.Төрийн Думын тогтоолын төслийг Төрийн Думд дор дурдсан журмын дагуу өргөн барина:

а) ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Холбооны Зөвлөлийн гишүүн, ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын субъектүүдийн хууль тогтоох байгууллага, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, ОХУ-ын Дээд шүүх, ОХУ-ын Арбитрын дээд шүүх өөрийн бүрэн эрхийн асуудлаар тогтоолын төслийг Төрийн Думын даргад өргөн мэдүүлнэ;

б) Төрийн Думын хороод өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар, Төрийн Думын комисс энэ хэсгийн “в”-д зааснаас бусад тохиолдолд, Төрийн Думын депутат, Төрийн Дум дахь бүлэг Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтэс (Правового управления Аппарата)-ын дүгнэлт (заключение)-ийн хамт** Төрийн Думын даргад өргөн мэдүүлнэ;

в) Төрийн Думын хороо, Төрийн Думын мандат, депутатын ёс зүйн асуудал эрхэлсэн Комисс өөрийн эрхлэх асуудлаар Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлтийн хамт** Холбооны Зөвлөлийн даргад өргөн мэдүүлнэ.

**112 дугаар зүйл.**

1.Хариуцсан хорооны шийдвэрээр Төрийн Думын хорооны даргын гарын үсэгтэй албан бичгээр төслийг төрийн холбогдох байгууллагад санал авах, шинжлэх ухааны шинжилгээ (научная экспертиза) гаргуулахаар хүргүүлж болно.

1<sup>1</sup>.Хариуцсан хороо хуулийн төслийг Нийтийн танхимаар шинжлүүлэх шийдвэр гаргасан бол Төрийн Дум төслийг Нийтийн танхимд энэ Регламентийн 93, 94 дүгээр зүйлд заасан журмын дагуу өргөн барина.

2.Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтэс** Төрийн Думын Зөвлөлийн, эсхүл хариуцсан хорооны даалгавраар **даалгасан хугацаанд** тухайн хуулийн төслийг Үндсэн хууль, холбооны Үндсэн хуулийн болон холбооны бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа талаар **хууль зүйн шинжилгээ (правовая экспертиза)**, тухайн хуулийн төсөл батлахтай холбогдуулан холбооны хууль тогтоомжийн жагсаалтаас хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулж батлуулах **хэрэгцээг шалгах, хуулийн төслийн хууль зүйн техникийн шинжилгээ гаргана**. Хариуцсан хороо нь Тамгын газрын **Хуулийн хэлтэст тухайн хуулийн төслийн хэл зүйн дүгнэлт** гаргах даалгавар өгч болно.

---

<sup>260</sup> Регламент Государственной Думы (Принят постановлением Государственной Думы Федерального Собрания Российской Федерации от 22 января 1998 года № 2134-II ГД) - <http://duma.gov.ru/duma/about/regulations/>

**3. Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтэс нь эрх зүйн шинжилгээ (экспертиза)-нд үндэслэн дүгнэлт (заключение) бэлтгэнэ:**

- а) тухайн төсөл нь ОХУ-ын Үндсэн хууль болон түүний субъектүүдийн хуулиудад нийцэж байгаа эсэх. Хэрэв төсөл нь Үндсэн хуульд нийцээгүй гэж дүгнэлт гаргасан бол хуулийн ямар заалтад нийцэхгүй байгааг, мөн тэдгээрийн үндэслэлийг тайлбарлана;
- б) хуулийн тодорхой зүйл, заалтыг зөрчөөгүй боловч логик агуулгын хувьд зөрчилтэй эсэх. Хэрэв зөрчилтэй бол түүнийг тодорхойлж, залруулах аргыг санал болгоно;
- в) хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль, зүйл, заалтыг хамааруулсан эсэх. Хэрэв бүрэн биш бол орхигдсон хууль, зүйл, заалтыг заана.

**4. Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлтэд тухайн нэгжийн дарга буюу түүний орлогч гарын үсэг зурж баталгаажуулна. **Дүгнэлтийг даалгасан хугацаанд гаргах боломжгүй бол Тамгын газрын Хуулийн хэлтсийн үндэслэл заасан хүсэлтийн дагуу хугацааг сунгаж болно.****

#### **114 дүгээр зүйл.**

1. Хариуцсан хороо Төрийн Думын анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл, хавсаргасан материалыг Төрийн Думын Зөвлөлд хүргүүлнэ.

2. Хариуцсан хороо энэ Регламентын 105, 106-д заасны дагуу хууль санаачлагчаас ирүүлснээс гадна дараах материалыг нэмж хавсаргана:

г) **Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлт;**

#### **119 дүгээр зүйл**

8. ОХУ болон түүний субъектүүдийн бүрэн эрхэд нэгэн зэрэг хамаарахаас бусад асуудлаарх хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт хүлээн авсан бол хоёр, гурав дахь хэлэлцүүлгийг явуулахгүй байх тухай хариуцсан хорооны саналаар санал хурааж, анхны хэлэлцүүлгээр хүлээн авч болно. Анхны хэлэлцүүлгээр батлах хуулийн төсөл нь хууль зүй, хууль зүйн техник болон хэл шинжлэлийн шинжилгээ (экспертиза)-ний дүнг тусгасан Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлттэй байна. Хариуцсан хороо нь хуулийн төслийн зарим заалтыг тодорхой болгох, түүнд өөрчлөлт орлуулахын тулд Тамгын газрын Хуулийн хэлтсээр дахин дүгнэлт гаргуулахгүй...

#### **121 дүгээр зүйл.**

6. Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтэс нь хариуцсан хорооны даалгавраар энэ Регламентын 112 дугаар зүйлийн дагуу хуулийн төслийн зүйл бүрээр хууль зүйн болон хэл зүйн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Хэрэв хариуцсан хороо нь Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлттэй санал нийлэхгүй бол дүгнэлтийн агуулгыг тайлбарлуулахаар Тамгын газрын ажилтныг хорооны хуралдаанд оролцуулж болно.

7. Хуулийн төслийн талаар гаргасан хэл зүйн шинжилгээг хийхдээ төсөл нь хууль зүйн хэлний онцлогийг харгалзаж орчин цагийн орос утга зохиолын хэлний хэм хэмжээнд нийцүүлсэн, мөн хэл зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй, учир зүй (логик), техникийн редакц болон нэр томьёоны алдааг арилгах талаар зөвлөмж гаргана.

#### **124<sup>1</sup> дүгээр зүйл.**

1. Хариуцсан хороо нь Төрийн Думаар хэлэлцүүлэхээр дараах материалыг Төрийн Думын Зөвлөлд хүргүүлнэ:

в) хуулийн төслийн талаарх Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлт;

## **125 дугаар зүйл.**

1. Төрийн Думын Зөвлөл хуулийн төслийг батлахын тулд гурав дахь хэлэлцүүлгийг товлоно. Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр төсөлд өөрчлөлт оруулсан бол Төрийн Думын Зөвлөл нь хуулийн төсөл болон **Төрийн Думын Тамгын газрын дүгнэлтийг** ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, ОХУ-ын Засгийн газар, Төрийн Думын депутатуудад хүргүүлнэ.

## **130 дугаар зүйл.**

3. Зөвшилцөх комисс хуралдаан бүрээр тэмдэглэл хөтөлж, хуулийн төсөлд оруулсан өөрчлөлтийн зүйл, заалт бүрээр харьцуулсан хүснэгт гаргана. Харьцуулсан хүснэгтэд саналын зөрүүтэй асуудлыг шийдвэрлэх саналыг тусгана. Зөвшилцөх комиссын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцсон Төрийн Дум дахь ОХУ-ын Ерөнхийлөгч болон Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн саналыг зөвшилцөх комиссын шийдвэрээр гаргасан санал тус бүр дээр тодорхой тэмдэглэнэ. Зөвшилцөх комиссын хуралдааны тэмдэглэл, харьцуулсан хүснэгтэд гарын үсэг зурахаас өмнө холбооны хуулийг зөвшилцөх комиссын өөрчилсөн хувилбараар комиссын хоёр талын дарга нь Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтсээр энэ Регламентын 112 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн болон хэл зүйн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ**. Зөвшилцөх комиссын төгсгөлийн хурлын тэмдэглэлд Төрийн Дум болон Холбооны Зөвлөлөөс томилогдсон комиссын дарга нар гарын үсэг зурна.

4. Төрийн Думаас томилогдсон Зөвшилцөх комиссын дарга нь Зөвшилцөх комиссоос бэлтгэж хоёр талын дарга нарын гарын үсэг зурсан хуулийн төслийн эцсийн хувилбар, төгсгөлийн хурлын тэмдэглэл, харьцуулсан хүснэгт, Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлтийг** Төрийн Думын давтан хэлэлцүүлэгт оруулж хэлэлцүүлнэ.

## **135<sup>1</sup> дугаар зүйл.**

1. Тусгай комисс шийдвэр гаргахад “нэг тал нь нэг санал” гэсэн зарчмыг баримтлах бөгөөд Төрийн Думын комиссын бүрэлдэхүүн шийдвэрийг нийт гишүүдийн олонхийн саналаар гаргана. ОХУ-ын Ерөнхийлөгчийн тавьсан асуудал бүрээр зөвшилцөлд хүрсэн бол комисс шийдвэр гаргасанд тооцно. Эцсийн шийдвэр болон харьцуулсан хүснэгтэд гарын үсэг зурахаас өмнө комиссын дарга нь тухайн хуулийн төслийн хувилбарт Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтэст энэ Регламентын 112 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн болон хэл зүйн дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ**.

2. Тусгай комиссын ажлын төгсгөлд түүний Төрийн Думаас томилогдсон дарга хуулийг тусгай комиссын хувилбарт (харьцуулсан хүснэгтийн хамт) гарын үсэг зурж баталгаажуулан товч тайлбар, үндэслэл, **Төрийн Думын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлтийн хамт** Төрийн Думаар дахин хэлэлцүүлэхээр оруулна.

## **190 дүгээр зүйл**

4. Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтэс** нь Төрийн Думын Зөвлөл буюу хариуцсан хорооны даалгаснаар өргөн мэдүүлсэн олон улсын гэрээний төсөл, уг төсөл нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцэж байгаа талаар хууль зүйн дүгнэлт гаргаж болно.

## **193 дугаар зүйл**

2. Олон улсын гэрээний төслийг хэлэлцэхэд Төрийн Думын депутатуудад заавал тараах материалд Төрийн Думын **Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлт** байна.

## ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ЧИГ ҮҮРЭГ

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

Парламентын ажлын алба нь парламентад бүхэлд нь болон түүний танхimuуд, байнгын болон бусад хороод /комисс/, парламентын гишүүдэд хууль тогтоох болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх болон шинжлэх ухаан, техник-зохион байгуулалтын чиглэлээр өргөн хүрээнд үйлчилгээ үзүүлэх, туслах үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Парламентын ажлын алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах, захиргааны удирдлагаар дэмжих болон нарийн бичгийн дарга нарын газрын үйлчилгээг хэрэгжүүлэх ба түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл Клерк удирдан зохион байгуулж байна.

Парламентын ажлын албаны даргын нэршлийг авч үзвэл, судалгаанд хамрагдсан 32 улсын 72 хувь (23 улс) нь “ерөнхий нарийн бичгийн дарга”, 25 хувь (8 улс) нь “клерк” гэж нэрлэж байна.

### Хүснэгт 1. Гадаадын зарим орны парламентын ажлын албаны даргыг хэрхэн нэрлэдэг талаарх мэдээлэл

Парламентын ажлын албаны дарга	Улсын тоо	Засаглал	Улсын нэр
Ерөнхий нарийн бичгийн дарга (Secretary General)	23 улс	Парламентын БНУ (15 улс)	Болгар, Ботсван, Вьетнам, Босни-Герцеговин, Герман, Грек, Кыргыз, Серби, Словени, Тринидад ба Тобаго, Турк, Унгар, Хорват, Швейцар, Энэтхэг
		Үндсэн хуульт хаант улс (2 улс)	Норвег, Япон
		Ерөнхийлөгчийн засаглалтай (6 улс)	Аргентин, Кабо-Верде, Мексик, Намиби, Солонгос (Өмнөд), Чили
Клерк (Clerk)	8 улс	Парламентын БНУ (3 улс)	Самоа, Сингапур, Ирланд
		Үндсэн хуульт хаант улс (4 улс)	Австрали, Их Британи, Канад, Шинэ Зеланд
Дарга (Руководитель)	1 улс	Ерөнхийлөгчийн засаглалтай (1 улс)	ОХУ

Эндээс үзэхэд, парламентын засаглалтай 15 улсад “ерөнхий нарийн бичгийн дарга”, 3 улсад “клерк” гэсэн нэр томъёог хэрэглэж байна. “Клерк”-ийг Вестминстериин улсуудын парламентад түлхүү хэрэглэж байна.

Парламентын ажлын албаны даргын чиг үүргийг Парламентын тухай хууль тогтоомж (Унгар), Парламентын ажлын албаны дүрэм (ОХУ), улсуудын парламентын цахим хуудсанд байгаа мэдээлэлд тулгуурлаж хийв.

**Хүснэгт 2. Гадаадын зарим орны Парламентын ажлын албаны даргын чиг үүрэг**

	<b>Улсын нэр (Парламент, ажлын алба)</b>	<b>Парламентын ажлын албаны дарга</b>	<b>Чиг үүрэг</b>
1.	<b>Грек - Парламентын Тамгын газар</b>	Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын Ерөнхийлөгчид Парламентыг удирдахад, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх;</li> <li>• Тамгын газрыг удирдах (Парламентын Ерөнхийлөгчийн дараа);</li> <li>• Регламентад заасан чиг үүрэг, мөн Ерөнхийлөгчийн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.</li> </ul>
2.	<b>Их Британи - Парламентын Лордуудын танхимиын Ажлын алба</b>	Парламентын Клерк	<ul style="list-style-type: none"> <li>• Танхимиын хороодод дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, стратегийн шийдвэр гаргах хэлэлцүүлэг зохион байгуулах;</li> <li>• ажиллагсдын болон гэрээт ажиллагсдын хууль тогтоомж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих;</li> <li>• Танхимиын нэрийн өмнөөс гэрээ байгуулах;</li> <li>• газар болон бусад өмч хөрөнгийг эзэмших, удирдах;</li> <li>• Танхимиын төсөв, санхүү, нөөцийн бүртгэл, дотоод хяналтыг хэрэгжүүлэх;</li> <li>• Виктория цамхагт хадгалагдаж байгаа Парламентын бүртгэлийг хадгалах;</li> <li>• Танхимиын спикерийн эзгүйд дэд спикер, бусад эрх бүхий албан тушаалтанд дэгийн асуудлаар зөвлөгөө өгөх;</li> <li>• Танхимиын хуралдаанд сууж, хэлэлцүүлэгт хяналт тавих;</li> <li>• зарим ёслолын ажиллагаанд оролцох;</li> <li>• Танхимиын хуралдааны тэмдэглэл хөтлөлтийг хариуцах;</li> <li>• Танхимиын албан ёсны бүх шийдвэр болон мэдэгдэл гарын үсэг зурах;</li> <li>• Парламентаар хэлэлцэх хуулийн төслийн бэлтгэлийг хангах;</li> <li>• Танхимиын спикер, дэд спикерт зөвлөгөө өгөх.<sup>261</sup></li> </ul>
3.	<b>Кабо-Верде Үндэсний Ассамблейн Тамгын газар</b>	Үндэсний Ассамблейн Ерөнхий нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Тамгын газрын үйл ажиллагааг удирдлагаар хангах;</li> <li>• Үндэсний Ассамблейн даргын үйл ажиллагаанд туслах үйлчилгээг сайжруулах, боловсронгуй болгох;</li> <li>• Тамгын газрын зохион байгуулалт, техникийн үйл ажиллагааны журамд гарын үсэг зурж баталгаажуулах;</li> <li>• Тамгын газраас төрийн бусад байгууллагатай харилцах ажлын уялдаа, холбоог хангах;</li> <li>• Үндэсний Ассамблейн дарга болон Даргын товчооноос шаардлагатай гэж үзвэл Ерөнхий</li> </ul>

<sup>261</sup> The Clerk of the Parliaments: Role and Functions. <https://www.parliament.uk/about/faqs/house-of-lords-faqs/lords-cofp/>

			<p>нарийн бичгийн дарга нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Үндэсний Ассамблейн төсвийг Даргын товчоо, Зөвлөлөөс тогтоосон зарчимд нийцүүлэн бэлтгэн хэлэлцүүлэгт өргөн мэдүүлэх;</li> <li>○ Үндэсний Ассамблейн тайлан тэнцэл бэлтгэн Зөвлөлд өргөн мэдүүлэх;</li> <li>○ Үндэсний Ассамблейн албадын дотоод зохион байгуулалт, чиг үүргийн талаарх дүрэм, журмыг өөрчлөх санал оруулах.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>● Үндэсний Ассамблейн даргын захирамжийн дагуу Тамгын газрын удирдлагын түвшний бусад асуудлыг шийдвэрлэх.</li> </ul>
4.	<b>Канад</b> Сенатын болон Нийтийн танхимины Ажлын алба	Сенатын болон Нийтийн танхимины Клерк	<p>Сенатын Клерк:</p> <ul style="list-style-type: none"> <li>● Хамтын удирдлагын асуудал, түүний дотор захиргаа, санхүүгийн төлөвлөлт, удирдлагын хэтийн төлөвийн асуудлаар зөвлөх;</li> <li>● захиргаа, санхүүгийн асуудлыг зохион байгуулах;</li> <li>● Сенатын захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>● Сенатын захиргааны чиг үүрэгт хяналт тавих;</li> <li>● дотоод эдийн засгийн хороогоор дамжуулан Сенатад ажлаа тайлагнах;</li> </ul> <p>Сенатын Клерк чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Хуулийн болон Ёс зүйн Клерк, Сенатын Ушер тусална.</p> <ul style="list-style-type: none"> <li>● Хуулийн Клерк нь гишүүдэд хууль тогтоох, хянан шалгах үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай хууль тогтоомж, бусад мэдээллээр хангах үүрэгтэй.</li> <li>● Сенатын ёс зүйн Клерк нь Сенатын танхим, түүний ажиллагсдын ёс зүйн талаар санал дэвшүүлэх, Сенатын танхимины ёс зүйн хороогоор хэлэлцүүлнэ.</li> <li>● Сенатын Ушерийн гол үүрэг нь парламентын хуралдааны үед эмх журам сахиулах ба Дэгийн хуулийг мөрдүүлэхэд хуралдаан даргалагчид тусална.</li> </ul> <p>Нийтийн танхимины Клерк:</p> <ul style="list-style-type: none"> <li>● Нийтийн танхим, байнгын болон хамтарсан хороод, гишүүдэд хууль тогтоох эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үйлчилгээ үзүүлэх;</li> <li>● Танхимины үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах;</li> <li>● Танхимины санхүү, захиргааны асуудлыг хариуцах чиг үүрэг бүхий Дотоод эдийн засгийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэх;</li> <li>● Парламент хоорондын харилцааны асуудлыг хариуцах;</li> <li>● Танхимины захиргааны чиг үүргийг гүйцэтгэх эрх бүхий байгууллага болох Клеркийн удирдлагын байгууллага (CBG)-ыг тэргүүлэх.</li> </ul>
5.	<b>ОХУ</b>	Дарга	2. Тамгын газрын дарга нь бүрэн эрхийнхээ

	Төрийн Думын Тамгын газар	(Руководитель)	<p>хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ОХУ-ын Холбооны хурлын Холбооны зөвлөлийн Тамгын газар, ОХУ-ын Засгийн газар, холбооны гүйцэтгэх байгууллагууд, ОХУ-ын шүүхийн байгууллага, ОХУ-ын субъектүүдийн хуль тогтоо болон гүйцэтгэх байгууллагууд, гадаадын парламентын ажлын албад, парламентын олон улсын байгууллагуудтай хатран ажиллахад Тамгын газрыг төлөөлнө;</li> <li>• Тамгын газрын дэд дарга нарын хооронд ажил үүрэг хуваарилах;</li> <li>• Тамгын газрын ўйл ажиллагааг зохион байгуулах ба Тамгын газарт хуваарилагдсан ажил үүргийн гүйцэтгэлийг хариуцах;</li> <li>• Тамгын газрын бүтцийн нэгжүүдийг (цаашид “бүтцийн нэгж” гэх) тогтоо, тэдгээрийн харилцан ажиллах журмыг тогтоо, ўйл ажиллагаанд нь хяналт тавих;</li> <li>• холбооны төрийн алба хаагчдыг Тамгын газарт оруулах асуудлыг шийдвэрлэх;</li> <li>• Тамгын газрын ажилтнуудыг томилох;</li> <li>• ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;</li> <li>• өөрийн бүрэн эрхэд хамаарах Ажлын албаны ўйл ажиллагааны талаар тушаал гаргах.<sup>262</sup></li> </ul>
6.	<b>Самоа</b> Хууль тогтоох ассамблейн Клеркийн ажлын алба	Хууль тогтоох ассамблейн Клерк	<ul style="list-style-type: none"> <li>• Хууль тогтоох ассамблей, түүний хороодын ўйл ажиллагаанаас үүдэн гарах үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх;</li> <li>• Дэгийн хуулиар Клеркт оногдох эрх, үүргийг хэрэгжүүлэх;</li> <li>• Клеркийн ажлын албаны үр дүнтэй, эдийн засгийн хэмнэлттэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• Хууль тогтоох ассамблейг олон нийттэй холбох;</li> <li>• Хууль тогтоох ассамблейн болон байнгын хороодын хуралдааны тэмдэглэлийг Спикерийн удирдлага дор хөтлөх.</li> </ul>
7.	<b>Серби</b> Үндэсний Ассамблейн Тамгын газар	Ерөнхий нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний Ассамблейн дарга болон дэд даргад чулганд бэлтгэхэд туслах;</li> <li>• Үндэсний Ассамблейн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;</li> <li>• Тамгын газрыг удирдоагаар хангах;</li> <li>• хууль, журмаар тогтоосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.<sup>263</sup></li> </ul>
8.	<b>Унгар</b> Үндэсний Ассамблейн Ажлын алба	Ерөнхий нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний Ассемблейн шийдвэрийг боловсруулахад туслалцаа үзүүлэх;</li> <li>• хуульд заасан журмын Үндэсний Ассамблейн төсвийг удирдах;</li> <li>• Үндэсний Ассемблейн хуралдаанд оролцож болно, гэхдээ үг хэлэхгүй.<sup>264</sup></li> </ul>

<sup>262</sup> Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации <http://duma.gov.ru/duma/staff/status/>

<sup>263</sup> Серби Улсын Үндэсний Ассамблей. <http://www.parlament.gov.rs/national-assembly.467.html>

9.	<b>Швейцар</b> Холбооны Ассемблейн Тамгын газар	Ерөнхий нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Тамгын газрыг удирдлагаар хангах;</li> <li>• Үндэсний зөвлөл, Нэгдсэн Холбооны Ассемблейн нарийн бичгийн дарга нарыг удирдлагаар хангах;</li> <li>• ажлаа Захиргааны асуудал хариуцсан төлөөлөгчид хариуцан тайлгадах.<sup>265</sup></li> </ul>
10.	<b>Энэтхэг</b> Лок Сабхагийн Тамгын газар	Ерөнхий нарийн бичгийн дарга	<p>Ерөнхий нарийн бичгийн дарга нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Лок Сабхагийн спикерийн Үндсэн хууль болон бусад хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх;</li> <li>• Тамгын бусад нарийн бичгийн дарга нар, хороодын нарийн бичгийн дарга нар, Тамгын газрын нийт ажилтнуудыг удирдлагаар хангах;</li> <li>• түүний албан тушаал (эрх хэмжээ, статус, цалин хөлс) нь Энэтхэгийн Засгийн газрын хамгийн өндөр албан тушаалтан (буюу Ерөнхий сайд)-тай дүйцэхүйц байна.<sup>266</sup></li> </ul>



<sup>264</sup> Chapter XII of the Act on the National Assembly.

<https://www.parlament.hu/documents/125505/138409/Act+XXXVI+of+2012+on+the+National+Assembly/b53726b7-12a8-4d93-acef-140feef44395>

<sup>265</sup> Швейцарын Холбооны Ассемблей. <https://www.parlament.ch/en/über-das-parlament/parlamentswörterbuch/parlamentswörterbuch-detail?WorldId=91>

<sup>266</sup> Энэтхэгийн Лок Сабха. <http://164.100.47.194/lok Sabha/Secretariat/Functioning.aspx>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба” УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ, 2012 он.
- “Парламентын засаглалтай улс орнуудын төрийн эрх мэдлийн хуваарилалт”. УИХ-ын Тамгын газрын СМЛА, Судалгааны эмхэтгэл, 25-р боть, 2017 он.
- Chapter XII of the Act on the National Assembly. <https://www.parlament.hu>
- The Clerk of the Parliaments: Role and Functions. <https://www.parliament.uk>
- Положение об Аппарате Государственной Думы Федерального Собрания Российской Федерации. <http://duma.gov.ru/duma/staff/status/>
- Серби Улсын Үндэсний Ассамблей. <http://www.parlament.gov.rs>
- Швейцарын Холбооны Ассемблей. <https://www.parlament.ch>
- Энэтхэгийн Лок Сабха. <http://164.100.47.194/loksabha/Secretariat/Functioning.aspx>



## ПАРЛАМЕНТЫН НЭРЭМЖИТ ШАГНАЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г.Алтан-Оч, (Ph.D) О.Нарантуяа

Дэлхийн улс орнуудад олгодог төрийн дээд шагнал (одон, медаль) болон парламентын нэрэмжит шагналын талаар тус хүрээлэнд 2009 оноос хойш 4 харьцуулсан судалгааны ажил хийсэн байна. Энэ удаа ХБНГУ-ын парламентын нэрэмжит шагналуудыг нэмж судлан уг судалгаанд багтаав.

БНМАУ-ын Бага Хурлын тогтоолоор 1991 онд төрийн дээд шагнал болох “Эрдэнийн очир” одонг 3 (сувдан, шүрэн, оюун шигтгээт) зэрэг дэвтэйгээр сэргээн хэрэглэхээр тогтоож, олон улсын харилцааны шударга ардчилсан зарчмыг бататгаж, Монгол Улстай найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан гадаадын төр, засгийн газрын тэргүүн, төр, олон нийтийн зүтгэлтнийг шагнахаар журамласан боловч өнөөг хүртэл хэрэгжээгүй байна.

Парламентын нэрэмжит шагналыг шинжлэх ухаан, түүх, соёл парламентаризмын хөгжилд хувь нэмэр оруулсан дорвitoй бүтээлүүд, ардчиллын үнэт зүйлд оруулсан хувь нэмэр, зүтгэлийг үнэлж олгодог байна. Судалгаанаас үзэхэд, Хорватад парламентын нэрэмжит шагнал нь шинжлэх ухааны шагнал, Австрид парламентын хөгжил, түүхийн салбарын шинжлэх ухааны шагнал, Германд парламентаризмын чиглэлийн шинжлэх ухааны шагнал байдаг бол АНУ-д түүх, соёлд гаргасан онцгой амжилтыг үнэлж олгодог байна. Мөн шинжлэх ухааны шагналаас гадна жендерийн тэгш эрх, цөөнхийн эрх зэрэг ардчиллын үнэт зүйлд оруулсан хувь нэмрийг үнэлж Ардчиллын шагнал (Австри), парламентаризмын чиглэлээр хэвлэн нийтлэсэн дорвitoй бүтээлийг үнэлж Хэвлэл, мэдээллийн шагнал (Герман) олгодог.

Парламентын нэрэмжит шагналыг жил тутам (Хорват), 2 жилийн зйтай (Австри, Герман) буюу цаг хугацааны давтамж заахгүйгээр (АНУ) олгодог байна.

Парламентын нэрэмжит шагналыг бэлэн мөнгө болон үнэт зүйл дагалдаг байна. Австрид 15 мянга, Германд 10 буюу 5 мянган евро дагалдаг бол АНУ-ын Конгрессын алтан медалийн орцонд 465 гр. жинтэй цэвэр алт ордог байна.

Парламентын нэрэмжит шагналыг Австрид парламентын 2 танхимиын ерөнхийлөгч болон гол байнгын хорооны төлөөлөл багтсан 14 хүний бүрэлдэхүүнтэй сангийн дэргэдэх Итгэмжит зөвлөл, Хорватад парламентын ерөнхийлөгч, салбарын сайд болон алдартай 12 эрдэмтнээс бүрдсэн Үндэсний шинжлэх ухааны шагналын хороо, Германд нэр хүндтэй 9 эрдэмтнээс бүрдсэн Шалгаруулах комисс, харин АНУ-д парламентын 2 танхим дэмжсэн бол Санхүүгийн үйлчилгээний Байнгын хороо эцэслэн шалгаруулдаг.

Уг судалгаанд Монгол Улсын Их Хурлын нэрэмжит шагналын журмын төсөл болон ашигласан эх сурвалжийн жагсаалтад багтсан судалгааны ажлуудыг тус тус хавсаргав.

### БҮНДЭСТАГИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ

#### **Бундэстагийн Шинжлэх ухааны шагнал<sup>267</sup>**

Бундэстагийн Шинжлэх ухааны шагналыг парламентын практикийг улам гүнзгий ухаарч ойлгоход дорвitoй хувь нэмэр оруулсан, сүүлийн үед хийгдсэн парламентаризмийн чиглэлийн эрдэм шинжилгээний ажил, ихэвчлэн боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлд олгодог.

<sup>267</sup> Германы Бундэстагийн Шинжлэх ухааны шагнал-Wissenschaftspris des Deutschen Bundestages-германаар <https://www.bundestag.de/wissenschaftspris>

Шагналыг 10 000 евро дагалдана.

Эрх зүй, улс төр болон түүхийн шинжлэх ухааны нэртэй эрдэмтдээс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй Шалгаруулах комисс уг шагналыг сонгон шалгаруулдаг.

Өнөөдрийн байдлаар Бундэстагийн 2021 оны Шинжлэх ухааны шагналын шалгаруулалтад оролцох хүсэлтийг 2020 оны 7-р сарын 15-ны өдөр хүртэл Бундэстагт шуудангаар хүлээн аваад байна.

Шалгаруулалтад оролцох нөхцөлүүд:

- Эрдэм шинжилгээний бүтээлийг зохиогч өөрөө буюу гуравдагч этгээд нэр дэвшүүлж болно.
- Бүтээлийг хэвлэмэл байдлаар 3% үйлдэж өргөн мэдүүлнэ. Түүнчлэн цахим байдлаар (PDF формат) хавсаргана.
- Зөвхөн 2018 оны 4-р сарын 1-нээс хойш (сүүлийн 2 жилд) хэвлэн нийтлэгдсэн бүтээл байна.
- Зэрэг горилсон бүтээл (Б/Д-р, ШУ/Д-р) бол тухайн зэргээ хамгаалсан байвал зохино.
- Хүсэлтэд 2 хуудсаас хэтрэхгүй бүтээлийн хураангуй болон хувийн өгөгдлийг боловсруулахыг гарын үсэг зурж, зөвшөөрсөн баталгааны хамт хавсаргана. Мөн эрдмийн зэрэг горилсон бүтээлийн шүүмжийг хавсаргаж болно.
- Бундэстагийн ажлын албаны ажилтны бүтээлийг оруулахгүй.
- Зөвхөн бүрэн иж бүрдэлтэй хүсэлтийг шалгаруултад оролцуулна.
- Ирүүлсэн материалыг зөвхөн шалгаруулах үйл ажиллагаанд ашиглах бөгөөд шалгаруулалт дууссан хойно буцааж илгээх буюу устгалд оруулдаг.
- Хүсэлтээ ирүүлсэнээр оролцох нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- Шүүхэд гомдол гаргах эрхгүй.

Шинжлэх ухааны шагналыг ерөнхийдөө 2 жил тутам олгодог. Анх 1989 онд олгож эхэлсэн бөгөөд одоогоор 17 хүнийг шагнаад байна. Хамгийн сүүлд 2019 оны шагналыг Д-р Тино Фрийлинг “Хуулийн материалыд ба хууль тогтоогчийн хүсэл зориг<sup>268</sup>. Холбогдох хүсэл зоригоо илэрхийлэх тохиолдлын бүлгүүд” сэдэвт бүтээлээрээ хүртжээ. Шагнал олгосон дарааллаас харахад, заримдаа жил дараалан (5 удаа) олгосон бол 3 жилийн зайдай олгосон тохиолдол 2 удаа байна.<sup>269</sup>

### Парламентын Хэвлэл, мэдээллийн шагнал<sup>270</sup>

Германы Бундэстаг 1993 оноос хойш жил тутам Хэвлэл, мэдээллийн шагналыг олгож байна. Уг шагналыг парламентын үйл ажиллагаа, ажиллах зарчим болон хэлэлцэх асуудлын сэдвийг улам гүнзгий ухаарч ойлгоход онцгой хувь нэмэр оруулсан, парламентаризмийн чиглэлийн хэвлэн нийтлэлийн бүтээлд олгодог.

Хэвлэл, мэдээллийн шагналыг 5 000 евро дагалдах бөгөөд 2021 оны хавар Бундэстагийн Ерөнхийлөгч гардуулна.

Шагнал олгох шийдвэрийг нэр хүндтэй 7 сэтгүүлчээс бүрдсэн, хараат бус мэргэжлийн шалгаруулах комисс гаргадаг байна.

<sup>268</sup> Wille-германаар

<sup>269</sup> Германы Бундэстагийн Шинжлэх ухааны шагнал-Wissenschaftspris des Deutschen Bundestages 2021-германаар

[https://de.wikipedia.org/wiki/Wissenschaftspris\\_des\\_Deutschen\\_Bundestages#:~:text=Der%20Preis%20wird%20in%20der,ist%20mit%2010.000%20Euro%20dotiert.](https://de.wikipedia.org/wiki/Wissenschaftspris_des_Deutschen_Bundestages#:~:text=Der%20Preis%20wird%20in%20der,ist%20mit%2010.000%20Euro%20dotiert.)

<sup>270</sup> Парламентын Хэвлэл, мэдээллийн шагнал-Medienpreis Parlament 2021-германаар  
<https://www.bundestag.de/medienpreis>

Шалгаруулалтад оролцох нөхцөлүүд:

- Бүс нутгийн буюу бүс нутаг дамнасан шинжтэй өдөр тутмын буюу Долоо хоногийн сонин болон онлайн орчинд нийтлэгдсэн, радио буюу зурагтаар цацагдсан сэтгүүл зүйн бүтээлийг нэр дэвшүүлнэ.
- Бүтээл нь 2019.10.01-нээс 2020.09.30-ны хооронд нийтийн хүртээл болсон байвал зохино. Шуудангийн тамгыг үндэслэн 2020.10.05-ны өдрөөр тасалбар болгоно.
- Өөрөө (хувь хүн дангаар буюу олон хүн хамтдаа) болон гуравдагч этгээд нэр дэвшүүлж болно.
- Нэр дэвшүүлэх бичигт тухайн ажлын бичлэгийг З хувилж (дуут дүрсний бүтээлийг холбогдох цахим санах байгууламжид буулгах, жишээлбэл: DVD, карт), зохиогчийн намтар болон хувийн өгөгдөл боловсруулахыг гарын үсэг зурж зөвшөөрсөн баталгааны хамт хавсаргана. Бүрэн бус хүсэлтийг авч үзэхгүй.



## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- Ш.Хишигсүрэн “Гадаадын зарим орны төрөөс олгодог одон, медаль, цолны талаарх тойим судалгаа” СТ-09/304, Бодлогын судалгааны эмхтгэл №2
- Ц.Норовдондог, Г.Чулуун, А.Пагма, Ш.Хишигсүрэн “Төрийн одон, медаль, түүний хэлбэр, олгох журмын талаарх харьцуулсан судалгаа” СТ-10/201, Бодлогын судалгааны эмхтгэл №4
- Г.Чулуун “Төрийн дээд одон медалийн тухай хуулийн төслийн агуулгын зарим асуудалд”, Бодлогын судалгааны эмхтгэл №8
- А.Пагма, Г.Гэрэл “Гадаадын зарим орны парламентын шинжлэх ухааны шагналын талаарх товч мэдээлэл” СТ-11/421, Бодлогын судалгааны эмхтгэл №12
- БНМАУ-ын Бага Хурлын “Эрдэнийн очир одонг сэргээн хэрэглэх тухай” 1991.10.14-ний өдрийн №68 тогтоол
- УИХ-ын даргын “Б.Чимидийн нэрэмжит шагнал олгох журам батлах тухай” 2014 оны №176 захирамж
- УИХ-ын даргын “УИХ-ын Тамгын газрын нэрэмжит шагналын журам батлах тухай” 2016 оны №94 захирамж
- “Монгол Улсын Засгийн газрын хүндэт өргөмжлөл олгох журам”, Засгийн газрын 2019 оны №271 тогтоолын хавсралт №2



**Ковид-19-ийн тойм: СОНГУУЛЬД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**  
(2020.10.01-ний байдлаар)<sup>271</sup>

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

Коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын улмаас дэлхийн олон оронд үндэсний болон орон нутгийн хэмжээнд явуулахаар товлоод байсан сонгууль, ард нийтийн санал асуулгыг хойшлуулсан бол нэлээдгүй оронд эдгээр арга хэмжээг амжилттай зохион явуулсан байна.

Энэхүү мэдээлэл, лавлагаанд дэлхийн улсууд үндэсний хэмжээнд ерөнхийлөгчийн, парламентын сонгууль, ард нийтийн санал асуулгыг, орон нутгийн хэмжээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын, парламентын нөхөн сонгуулийг коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын үед зохион явуулсан, эсхүл энэхүү аюулаас сэргийлэхийн тулд хойшлуулсан, эсхүл эрсдлийг тооцоолон 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн байдлыг гаргасан болно.

Мэдээлэл, лавлагааг тоймлож үзвэл:

**1. Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30)**

- 63 улс (нутаг дэвсгэр) үндэсний болон орон нутгийн хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулсан байна. Үүнээс:
  - 49 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулгыг явуулжээ;
  - цар тахлын үед 29 улс хойшлуулсан байсан сонгууль, ард нийтийн санал асуулгаа 2020 оны 4-9 дүгээр сард багтаан явуулжээ.

Сонгууль	Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд	
	тоо	нэр
Бүх нийтийн сонгууль (general election)	7	Вануату, Гайана, Их Британи, Мали, Ниуэ, Суринам, Тринидад ба Тобаго
Ерөнхийлөгчийн сонгууль	9	АНУ, Беларусь, Бурунди, Доминиканы БНУ, Исланд, Кирибати, Малави, Польш, Того
Парламентын сонгууль	24	АНУ, Доминиканы БНУ, Египет, Израиль, Иран, Ирланд, Камерун, Кирибати, Мали, Монгол, Монтенегро, Өмнөд Солонгос, Папуа Шинэ Гвиней, Сент Кит ба Невис, Серби, Сингапур, Сири, Словак, Тажикистан, Хойд Македони, Хорват, Шри Ланка, Энэтхэг, Ямайка
Парламентын нөхөн сонгууль	5	Бангладеш, Гвиней, Украина, Чех, Япон
Ард нийтийн санал асуулга	6	Гвиней, Итали, Их Британи, Лихтенштейн, ОХУ, Швейцар
Орон нутгийн сонгууль	25	Австрали, Австри, Бенин, Герман, Доминиканы БНУ, Испани, Итали, Канад, Латви, Ливи, Малайз, Молдова, Монтенегро, Нигери, ОХУ, Польш, Румын, Серби, Тайван, Тунис, Уругвай, Франц, Швейцар, Энэтхэг, Япон
Бусад	2	- Уганда (Тусгай сонирхлын бүлгэг (Special Interest Group)-ийн сонгууль) - Тайвань (Гоминьдан (Kuomintang)-ны даргын сонгууль)

<sup>271</sup> Парламентын судалгааны хүрээлэнгээс “Ковид-19-ийн тойм: Сонгуульд үзүүлэх нөлөө” судалгааг өмнө нь 2020 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар бэлтгэснийг “Бодлогын товчоон” сэтгүүлийн 2020 оны 1 дэх дугаараас үзнэ юу.

## **2. Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд**

- 58 улс (нутаг дэвсгэр) үндэсний болон орон нутгийн хэмжээнд явуулах байсан 73 сонгууль, ард нийтийн санал асуулгын товыг хойшлуулсан байна. Үүнээс:
  - 16 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээний сонгууль, ард нийтийн санал асуулгыг хойшлуулжээ;
  - 29 улс (нутаг дэвсгэр) нь хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулгаа 2020 оны 4-9 дүгээр сард багтаан явуулжээ;
  - 12 улс (нутаг дэвсгэр) нь хойшлуулаад байсан арга хэмжээгээ 2020 оны сүүлийн 3 сард багтаан явуулахаар төлөвлөөд байна;
  - 8 улс (нутаг дэвсгэр) хойшлуулаад байсан арга хэмжээгээ 2021 онд явуулахаар төлөвлөсөн байна;
  - харин 19 улс (нутаг дэвсгэр) хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулга явуулах тодорхой товоо гаргаагүй байна.

## **3. 2020 онд багтаан сонгууль явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31)**

- 38 улс (нутаг дэвсгэр) 2020 оны сүүлийн 3 сард багтаан үндэсний болон орон нутгийн хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:
  - энэ оны сүүлээр явуулахаар товлосноос гадна цар тахлын улмаас хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулга орсон;
  - 29 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулна.

Сонгууль	2020 онд багтаан сонгууль явуулах орнууд	
	тоо	нэр
Бүх нийтийн сонгууль (general election)	11	Австрали, Белиз, Болив, Бразил, Гана, Египет, Мьянмар, Палау, Танзани, Төв Африкийн БНУ, Шинэ Зеланд
Ерөнхийлөгчийн сонгууль	8	АНУ, Буркина Фасо, Гвиней, Кот д'Ивуар, Молдова, Сейшелийн Арлууд, Тажикистан, Хойд Кипр
Парламентын сонгууль	8	Бразил, Буркина Фасо, Венесуэл, Иордан, Кыргыз, Либери, Литва, Нигери
Ард нийтийн санал асуулга	2	Либери, Чили
Орон нутгийн сонгууль	15	Австрали, Австри, Аргентин, Босни-Герцоговин, Бразил, Индонез, Канад, Ливи, Малайз, Намиби, Нигер, Нигери, Словак, Украин, Энэтхэг

Үүнийг дараах хүснэгтүүдээс дэлгэрүүлж үзнэ үү:

1. Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30);
2. Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд;
3. Сонгуулиа 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31).

## 1. Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30)

ДЭМБ-ын мэдээлснээр, сонгууль, ард нийтийн санал асуулга явуулсан дараах улсууд<sup>272</sup> эрүүл ахуй, аюулгүй байдлын тусгай арга хэмжээнүүдийг сайтар авсны үр дүнд эдгээр улсуудад сонгуулийн үеэр коронавируст халдварт /Ковид-19/-ийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

<b>Д/д</b>	<b>Улсын нэр</b>	<b>Сонгууль / Ард нийтийн санал асуулга</b>	<b>Сонгууль болох газар</b>	<b>Товлогдсон огноо</b>	<b>Хойшлогдож байсан эсэх (анх товлогдсон огноо)</b>
<b>2 ДУГААР САРД</b>					
1	Иран	<b>Парламентын сонгууль</b>		2020.02.21	
2	Тайван	Орон нутгийн нөхөн сонгууль		2020.02.22	
3	Того	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.02.22	
4	Словак	<b>Парламентын сонгууль</b>		2020.02.29	
<b>3 ДУГААР САРД</b>					
5	Австрали	Орон нутгийн сонгууль	Queensland муж	2020.03.29	
6	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Arizona, Florida, Illinois мужууд	2020.03.17	
7	Бангладеш	Парламентын нөхөн сонгууль	Gaibandha-3, Bagerhat-4, Dhaka-3	2020.03.21	
8	Вануату	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.03.19	
9	Гайана	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.03.02	
10	Гвиней	Парламентын нөхөн сонгууль		2020.03.22	
11	Гвиней	<b>Ард нийтийн санал асуулга</b>			
12	Герман	Орон нутгийн сонгууль • анхан шатны • 2 дахь шатны	Бавари муж	<ul style="list-style-type: none"> <li>• 2020.03.16</li> <li>• 2020.03.29</li> </ul>	
13	Доминиканы БНУ	Орон нутгийн сонгууль		2020.03.15	
14	Израиль	<b>Парламентын сонгууль</b>		2020.03.02	
15	Ирланд	<b>Парламентын дээд танхимиын сонгууль</b>		2020.03.30-31	
16	Камерун	<b>Парламентын дахин сонгууль</b>	Сонгуулийн 11-р тойрог	2020.03.22	
17	Канад	Зөвлөлийн сонгууль		2020.03.26	
18	Мали	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.03.29	
19	Молдова	Орон нутгийн сонгууль	Hânceşti хот	2020.03.15	
20	Польш	Нөхөн сонгууль		2020.03.22	
21	Тажикистан	<b>Парламентын сонгууль</b>		2020.03.01	

<sup>272</sup> Үүнд: Гайана, Кирибати, Ниуэ, Словак, Тажикстан, Того, Вануату зэрэг улсууд хамаарахгүй аж.

<b>22</b>	Тайвань	Гоминьдан (Kuomintang)-ны даргын сонгууль		2020.03.07	
<b>23</b>	Украин	Парламентын нөхөн сонгууль	Kharkiv мужийн 179- р тойрог	2020.03.15	
<b>24</b>	Франц	Орон нутгийн анхан шатны сонгууль		2020.03.15	
<b>25</b>	Швейцар	Орон нутгийн сонгууль	Luzern	2020.03.29	

#### 4 ДҮГЭР САРД

<b>26</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Wisconsin	2020.04.07	
<b>27</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Ohio муж	2020.04.28	Хойшлогдсон
<b>28</b>	АНУ	Конгрессын ээлжит бус сонгууль	Maryland-ын 7-р тойрог	2020.04.28	
<b>29</b>	Кирибати	<b>Парламентын сонгууль</b>		2020.04.14	Хойшлогдсон - 2020.04.07
<b>30</b>	Мали	<b>Парламентын 2 дахь шатны сонгууль</b>		2020.04.19	
<b>31</b>	Өмнөд Солонгос	<b>Парламентын сонгууль</b>		2020.04.15	
<b>32</b>	Швейцар	Орон нутгийн 2 дахь шатны сонгууль (зөвхөн шуудангаар)	Женев хот	2020.04.04	
<b>33</b>	Япон	Парламентын доод танхимын нөхөн сонгууль		2020.04.26	
<b>34</b>	Япон	Орон нутгийн нөхөн сонгууль			

#### 5 ДУГААР САРД

<b>35</b>	Бенин	Орон нутгийн сонгууль		2020.05.17	
<b>36</b>	Бурунди	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.05.20	
<b>37</b>	Нигери	Орон нутгийн сонгууль	Cross River муж	2020.05.30	
<b>38</b>	Ниуэ	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.05.30	
<b>39</b>	Суринам	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.05.25	
<b>40</b>	Энэтхэг	Орон нутгийн сонгууль	Maharashtra-гийн Хууль тогтоох зөвлөл	2020.05.21	

#### 6 ДУГААР САРД

<b>41</b>	Австри	Орон нутгийн сонгууль		2020.06.28	Хойшлогдсон - 2020.03.15
<b>42</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Вашингтон болон бусад 8 муж	2020.06.02	Хойшлогдсон
<b>43</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Georgia, Nevada, North Dakota, South Carolina, West Virginia мужууд	2020.06.09	Хойшлогдсон
<b>44</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	6 муж	2020.06.23	Хойшлогдсон

<b>45</b>	Исланд	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.06.27	
<b>46</b>	Их Британи	<b>Бүх нийтийн сонгууль</b>	Ангилья	2020.06.29	
<b>47</b>	Кирибати	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.06.22	
<b>48</b>	Малави	<b>Ерөнхийлөгчийн дахин сонгууль</b>		2020.06.23	
<b>49</b>	Монгол	<b>Парламентын сонгууль</b>		2020.06.24	
<b>50</b>	Польш	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>		2020.06.28	Хойшлогдсон - 2020.05.10
<b>51</b>	Сент Кит ба Невис	<b>Үндэсний Ассамблейн сонгууль</b>		2020.06.06	
<b>52</b>	Серби	<b>Парламентын сонгууль</b>		2020.06.21	Хойшлогдсон - 2020.04.26
<b>53</b>	Серби	Орон нутгийн сонгууль		2020.06.21	
<b>54</b>	Тайвань	Орон нутгийн дахин сонгууль		2020.06.06	
<b>55</b>	Франц	Орон нутгийн 2 дахь шатны сонгууль		2020.06.28	Хойшлогдсон - 2020.03.22
<b>56</b>	Чех	Сенатын нөхөн сонгууль	Teplice	2020.06-р сарын 05, 06, 13-ны өдрүүд	Хойшлогдсон - 2020.03.27-28, 2020.04.03-04
<b>57</b>	Энэтхэг	<b>Парламентын дээд танхмын сонгууль</b>		2020.06.19	Хойшлогдсон - 2020.03.26

#### 7 ДУГААР САРД

<b>58</b>	Австрали	Зөвлөлийн нөхөн сонгууль	Eden-Monaro, New South Wales мужууд	2020.07.04	
<b>59</b>	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Texas, Alabama, Maine мужууд	2020.07.14	Хойшлогдсон
<b>60</b>	Бангладеш	Парламентын нөхөн сонгууль	Bogura-1, Jashore-6	2020.07.14	Хойшлогдсон - 2020.03.29
<b>61</b>	Доминиканы БНУ	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>			
<b>62</b>	Доминиканы БНУ	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.05	Хойшлогдсон - 2020.05.17
<b>63</b>	Испани	Орон нутгийн нөхөн сонгууль	Euskadi/Basque, Galicia	2020.07.12	Хойшлогдсон - 2020.04.05
<b>64</b>	Малайз	Мужийн Ассамблейн нөхөн сонгууль	Pahang	2020.07.04	
<b>65</b>	ОХУ	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.07.01	Хойшлогдсон - 2020.04.22
<b>66</b>	Польш	<b>Ерөнхийлөгчийн 2 дахь шатны сонгууль</b>		2020.07.12	Хойшлогдсон
<b>67</b>	Сингапур	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.10	
<b>68</b>	Сири	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.19	Хойшлогдсон - 2020.07.19
<b>69</b>	Тунис	Орон нутгийн нөхөн сонгууль	Hassi El Ferid	2020.07.06	Хойшлогдсон 2020.03.28-29
<b>70</b>	Хойд Македони	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.15	Хойшлогдсон - 2020.04.12
<b>71</b>	Хорват	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.05	
<b>72</b>	Япон	Хотын даргын	Токио	2020.07.05	

		сонгууль			
<b>8 ДУГААР САРД</b>					
73	Австрали	Орон нутгийн нөхөн сонгууль	Tasmania мужийн Зөвлөл	2020.08.01	Хойшлогдсон
74	Австрали	Орон нутгийн нөхөн сонгууль	Хойд нутаг дэвсгэрийн Зөвлөл	2020.08.22	
75	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Puerto Rico	2020.08.09	Хойшлогдсон
76	АНУ	<b>Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль</b>	Florida, Wyoming мужууд	2020.08.18	Хойшлогдсон
77	АНУ	Ээлжит бус сонгууль	Yona Mayor, Guam	2020.08.30	Хойшлогдсон
78	Беларусь	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.08.09	
79	Египет	<b>Сенатын анхан шатны сонгууль</b>		2020.08.11-12	
80	Латви	Орон нутгийн ээлжит бус сонгууль	Рига хотын зөвлөл	2020.08.29	Хойшлогдсон - 2020.04.25
81	Ливи	Орон нутгийн сонгууль (хэсэгчилсэн)	Ghat, Kikla	2020.08.18, 25	
82	Лихтенштейн	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.08.30	Хойшлогдсон
83	Малайз	Орон нутгийн нөхөн сонгууль	Perak мужийн Ассамблей	2020.08.29	
84	Монтенегро	<b>Парламентын сонгууль</b>		2020.08.30	
85	Монтенегро	Орон нутгийн сонгууль	Tivat	2020.08.30	Хойшлогдсон - 2020.04.05
86	Нигери	Орон нутгийн нөхөн сонгууль	Nasarawa тойрог	2020.08.08	
87	Папуа Шинэ Гвиней	<b>Парламентын сонгууль</b>		2020.08.12-09.01	Хойшлогдсон
88	Тринидад ба Тобаго	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.08.10	
89	Уганда	Тусгай сонирхлын бүлгэг (Special Interest Group)-ийн сонгууль		2020.08-р сарын 11, 13, 17-ний өдрүүд	Хойшлогдсон
90	Шри Ланка	<b>Парламентын сонгууль</b>		2020.08.05	Хойшлогдсон - 2020.04.25
<b>9 ДҮГЭЭР САРД</b>					
91	Герман	Орон нутгийн сонгууль	North-Rhine, Westphalia мужууд	2020.09.13	
92	Герман	Орон нутгийн сонгууль	Saxony, Brandenburg мужууд	2020.09.27	
93	Египет	<b>Сенатын 2 дахь шатны сонгууль</b>		2020.09.08-09	
94	Иран	<b>Парламентын 2 дахь шатны сонгууль</b>		2020.09.11	Хойшлогдсон - 2020.04.17
95	Итали	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.09.20-21	Хойшлогдсон - 2020.03.29
96	Итали	Орон нутгийн сонгууль		2020.09.20-21	
97	Их Британи	<b>Ард нийтийн санал асуулга</b>	Фолклендийн арлууд	2020.09.24	Хойшлогдсон - 2020.03.26
98	Молдова	Орон нутгийн сонгууль	Nucăreni, Tîrnova	2020.09.06	Хойшлогдсон - 2020.05.17

99	Нигери	Орон нутгийн сонгууль	Edo муж	2020.09.19	
100	ОХУ	Орон нутгийн сонгууль		2020.09.13	Хойшлогдсон - 2020.04.03
101	Румын	Орон нутгийн сонгууль		2020.09.27	Хойшлогдсон - 2020.06
102	Уругвай	Орон нутгийн сонгууль		2020.09.27	Хойшлогдсон - 2020.05.10
103	Швейцар	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.09.27	Хойшлогдсон - 2020.05.17
104	Ямайка	<b>Парламентын сонгууль</b>		2020.09.03	

## 2. Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд

Д/д	Улсын нэр	Сонгууль / Ард нийтийн санал асуулга	Сонгууль болох газар	Анх төвлөгдсөн огноо	Хойшлогдсон байдал
1	Австрали	Орон нутгийн сонгууль	New South Wales	2020 оны 09-р сард	<b>2021 оны 09-р сард</b>
2	Австри	Орон нутгийн сонгууль		2020.03.15	<b>Хойшлогдсон</b>
3	Аргентин	Орон нутгийн сонгууль	Cordovan City, Río Cuarto	2020.03.29	<b>2020.09.27-нд хойшлогдсон нь дахин 2020.11.29 болж хойшлогдсон</b>
4	Армен	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.04.05	<b>Хойшлогдсон</b>
5	Бангладеш	Орон нутгийн сонгууль	Chattagram хот	2020.03.29	<b>Хойшлогдсон</b>
6	Болив	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.05.03	<b>2020.10.18</b>
7	Болив	Орон нутгийн сонгууль		2020.03-р сард	<b>Хойшлогдсон</b>
8	Босни-Герцоговин	Орон нутгийн сонгууль		2020.10.04	<b>2020.11.15</b>
9	Ботсвана	Орон нутгийн нөхөн сонгууль	Metsimotlhabe, Boseja	2020 оны 05-р сард	<b>Хойшлогдсон</b>
10	Бразил	<b>Сенатын нэмэлт сонгууль</b>	Mato Grosso муж	2020.04.26	<b>2020.11.15</b>
11	Бразил	Орон нутгийн сонгууль		2020.10.04, 25	<b>2020.11.15, 29</b>
12	Габон	<b>Парламентын хэсэгчилсэн сонгууль</b>	Lékoni-Lékori (Akiéni)	2020.04.04, 18	<b>Хойшлогдсон</b>
13	Гамби	Үндэсний Ассамблейн нөхөн сонгууль	Баруун Niamina тойрог	2020.04.16	<b>Хойшлогдсон</b>
14	Герман	Орон нутгийн сонгууль	Hessen, Saxony	2020.04-10 сард	<b>2021.03.14</b>
15	Зимбабве	Зөвлөлийн нөхөн сонгууль	Chiredzi дүүргийн 16-р тойрог	2020.04.04	<b>Хойшлогдсон</b>
16	Индонез	Орон нутгийн сонгууль		2020.09.23	<b>2020.12.09</b>
17	Их Британи	Орон нутгийн сонгууль		2020.05-р сард	<b>2021.05-р сар</b>
18	Канад	<b>Ард нийтийн санал асуулга</b>	Kamloops	2020.04.04	<b>2021.05-р сар</b>
19	Канад	Орон нутгийн сонгууль	New Brunswick	2020.05.11	

20	Хойд Кипр	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.04.26	<b>2020.10.11</b>
21	Колумби	Олон нийтийн зөвлөлийн сонгууль		2020.04.26	<b>2021.04.25</b>
22	Косово	Хотын мэрийн сонгууль	Podujeva	2020.03.15	<b>Хойшлогдсон</b>
23	Кыргыз	Орон нутгийн сонгууль		2020.04.12	<b>Хойшлогдсон</b>
24	Либери	<b>Сенатын завсрлын сонгууль</b>			
25	Либери	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.10.13	<b>2020.12.08</b>
26	Мальдив	Орон нутгийн зөвлөлийн сонгууль		2020.04.04	<b>Хойшлогдсон</b>
27	Нигери	Сенатын нөхөн сонгууль	Bayelsa, Imo, Plateau мужид	2020 оны 03-р сард	<b>2020.10.31</b>
28	Өмнөд Африк	Орон нутгийн нөхөн сонгууль		2020 оны 05-03-р сард	<b>Хойшлогдсон</b>
29	Пакистан	<b>Парламентын сонгууль</b>		2020.07.02	<b>Хойшлогдсон</b>
30	Пакистан	Орон нутгийн нөхөн сонгууль		2020 оны 03-р сард	<b>Хойшлогдсон</b>
31	Перу	Орон нутгийн нөхөн сонгууль	Ayacucho дүүргийн Chipao хот	2020.03.29	<b>Хойшлогдсон</b>
32	Словак	Орон нутгийн сонгууль		2020.04.04	<b>2020.10.03</b>
33	Соломоны арлууд	Орон нутгийн сонгууль	Central Honiara, North East Guadalcanal тойргүүд	2020 оны 06-р сард	<b>Хойшлогдсон</b>
34	Сомали	<b>Парламентын сонгууль</b>		2020.11.27	<b>Хойшлогдсон</b>
35	Сомали	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2021.02.08	<b>Хойшлогдсон</b>
36	Хонконг	<b>Парламентын сонгууль</b>		2020.09.06	<b>2021.09.05</b>
37	Чад	<b>Парламентын сонгууль</b>		2020.12.13	<b>Хойшлогдсон</b>
38	Чили	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.04.26	<b>2020.10.25</b>
39	Швейцар	Орон нутгийн сонгууль	Нойчел, Тицино, Лузерн мужууд	2020.04.06	<b>Хойшлогдсон</b>
40	Шинэ Зеланд	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.09.19	<b>2020.10.17</b>
41	Энэтхэг	Орон нутгийн сонгууль	Karnataka, Maharashtra, Rajasthan	2020 оны 7, 8, 12-р сард	<b>2020.10.20</b>
42	Этиоп	<b>Парламентын сонгууль</b>		2020.08.29	<b>Хойшлогдсон</b>

### 3. Сонгуулиа 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31)

Д/д	Улсын нэр	Сонгууль	Сонгууль болох газар	Төвлөгдсон огноо	Анх төвлөгдсон огноо
1	Австрали	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.10.17	
2	Австрали	Орон нутгийн сонгууль	Нийслэлийн нутаг дэвсгэрийн хууль тогтоох	2020.10.17	

			байгууллага		
3	Австрали	Орон нутгийн сонгууль	Victoria мужийн зөвлөл	2020.10.23	
4	Австрали	Орон нутгийн сонгууль	Queensland муж	2020.10.31	
5	Австри	Орон нутгийн сонгууль	Vienne хот	2020.10.11	
6	АНУ	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.11.03	
7	Аргентин	Орон нутгийн сонгууль	Cordovan City, Río Cuarto	2020.11.29	2020.03.29
8	Белиз	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.11-р сард	
9	Болив	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.10.18	2020.05.03
10	Босни-Герцоговин	Орон нутгийн сонгууль		2020.11.15	2020.10.04
11	Бразил	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.10.02	
12	Бразил	Сенатын нэмэлт сонгууль	Mato Grosso муж	2020.11.15	2020.04.26
13	Бразил	Орон нутгийн сонгууль		2020.11.15, 29	2020.10.04, 25
14	Буркина Фасо	Ерөнхийлөгчийн болон <b>Парламентын сонгууль</b>		2020.11.22	
15	Венесуэл	<b>Парламентын сонгууль</b>		2020.12.06	
16	Гана	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.12.07	
17	Гвиней	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.10.18	
18	Египет	<b>Бүх нийтийн сонгууль</b>		2020.11.29	
19	Индонез	Орон нутгийн сонгууль		2020.12.09	2020.09.23
20	Иордан	<b>Парламентын сонгууль</b>		2020.11.10	
21	Канад	Орон нутгийн сонгууль	Saskatchewan	2020.10.26	
22	Кот д'Ивуар	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.10.31	
23	Кыргыз	<b>Парламентын сонгууль</b>		2020.10.04	
24	Либери	Сенатын завсрлын сонгууль		2020.12.08	2020.10.13
25	Либери	<b>Ард нийтийн санал асуулга</b>		2020.12.08	2020.10.13
26	Ливи	Орон нутгийн сонгууль (хэсэгчилсэн)	Misllata, Zliten, El Khoms, El Haraba, Jadu, Kabaw, El Sayeh, Zawiya Janub	2020.10.15	
27	Литва	<b>Парламентын сонгууль</b>		2020.10.11	
28	Малайз	Мужийн Ассамблейн сонгууль	Sabah	2020.09.29	
29	Молдова	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		2020.11.01	

<b>30</b>	Мьянмар	<b>Бүх нийтийн сонгууль</b>		<b>2020.11.08</b>	
<b>31</b>	Намиби	Орон нутгийн сонгууль		<b>2020.11.26-27</b>	
<b>32</b>	Нигер	Орон нутгийн сонгууль		<b>2020.11.01</b>	
<b>33</b>	Нигери	Сенатын нөхөн сонгууль	Bayelsa, Imo, Plateau мужид	<b>2020.10.31</b>	2020 оны 03-р сард
<b>34</b>	Нигери	Орон нутгийн сонгууль	Ondo	<b>2020.10.10</b>	
<b>35</b>	Палау	<b>Бүх нийтийн сонгууль</b>		<b>2020.11.03</b>	
<b>36</b>	Сейшелийн Арлууд	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		<b>2020.10.22-24</b>	
<b>37</b>	Словак	Орон нутгийн сонгууль		<b>2020.10.03</b>	2020.04.04
<b>38</b>	Тажикистан	<b>Ерөнхийлөгчийн сонгууль</b>		<b>2020.10.11</b>	
<b>39</b>	Танзани	<b>Бүх нийтийн сонгууль</b>		<b>2020.10.28</b>	
<b>40</b>	Төв Африкийн БНУ	<b>Бүх нийтийн сонгууль</b>		<b>2020.12.27</b>	
<b>41</b>	Украин	Орон нутгийн сонгууль		<b>2020.10.25</b>	
<b>42</b>	Хойд Кипр	Ерөнхийлөгчийн сонгууль		<b>2020.10.11</b>	Хойшлогдсон 2020.04.26
<b>43</b>	Чили	<b>Ард нийтийн санал асуулга</b>		<b>2020.10.25</b>	2020.04.26
<b>44</b>	Шинэ Зеланд	<b>Бүх нийтийн сонгууль</b>		<b>2020.10.17</b>	2020.09.19
<b>45</b>	Энэтхэг	Орон нутгийн сонгууль	Kamataka, Maharashtra, Rajasthan	<b>2020.10.20</b>	2020 оны 7, 8, 12-р сард

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН  
ЕС ЗҮЙН ХОРООДЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Билгээ, Э.Энхтүвшин  
Ц.Ариунаа, О.Билгүүтэй, Б.Туул*

**АГУУЛГА**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ЁС ЗҮЙН ХОРООДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1. Парламентын ёс зүй: хяналтын үүрэг, зохион байгуулалт
2. Дотоод зохицуулалт
  - 2.1. Польш Улс
  - 2.2. Ирланд Улс
  - 2.3. Өмнөд Солонгос
3. Гадаад зохицуулалт
  - 3.1. АНУ
  - 3.2. Герман Улс
4. Хослуулсан зохицуулалт
  - 4.1. Их Британи
  - 4.2. Франц

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд УИХ-ын гишүүдийн ёс зүйн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны бүтэц дэх Ёс зүйн дэд хороо хариуцахаар зохицуулсан байдаг. Тус дэд хороог бие даасан Байнгын хороо болгон өөрчлөн байгуулахтай холбогдуулан гадаадын зарим улсын туршлагыг судлах зорилготойгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв.

Парламент нь авлигатай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд шударга ёсыг хамгийн өндөр түвшинд сахих үүрэгтэй субъект юм. Дэлхийн улс орнуудад парламентын үйл ажиллагаагаа дэгтэй, зарчимтай байлгах талаар ихээхэн анхаарч ажилладаг туршлагууд бий.

Сүүлийн жилүүдэд олон улс оронд парламентын гишүүдийн эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ ёс зүй сахиулахад ёс зүйн цогц дэглэм тогтоох болсон ба үүнд ёс зүйн дүрэм, уг дүрмийг дагаж мөрдөх тодорхой шаардлагыг тогтоосон журам, эдгээр дүрмийг дагаж мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий институцийг багтаасан байна.

Судалгаанаас үзэхэд, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий институц буюу байгууллагыг дараах гурван загварт хувааж үздэг байна. Үүнд:

- 1) дотоод зохицуулалт (self-regulation);
- 2) гадаад зохицуулалт (external regulation);
- 3) хослуулсан зохицуулалт (combination of both).

Эдгээр загвараас үл хамааран парламентын ёс зүйг сахиулах үүрэгтэй институцийн эрх зүйн байдлыг, журам нь ил тод байхыг баталгаажуулах нь чухал юм.

Судалгаанд “дотоод зохицуулалт” бүхий загвартай Польш, Ирланд, Өмнөд Солонгос зэрэг улсууд, “гадаад зохицуулалт” бүхий загвартай АНУ, Герман, мөн “хослуулсан зохицуулалт” бүхий загвартай Их Британи, Франц зэрэг улсуудын туршлагыг тус тус оруулсан болно.

**ДОТООД ЗОХИЦУУЛАЛТ** (self-regulation) - хууль тогтоох байгууллагын бүтцийн нэгж буюу Парламент өөртөө ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээлсэн зөрчлийг шалгаж, хэзээ, ямар хариуцлага авахыг шийднэ.

**Польшийн** Депутатын ёс зүйн хороо, **Ирландын** Гишүүний ашиг сонирхлын тусгай хороо, **Өмнөд Солонгосын** Ёс зүйн тусгай хороо зэрэг парламентын бүтцийн байгууллагауд нь ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, тухайн парламентад ёс зүйн зөрчилд тооцогдох үйлдлийг хянан шалгах, хариуцлага тооцох саналаа нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлж байна.

**ГАДААД ЗОХИЦУУЛАЛТ** (external regulation) - хууль тогтоох байгууллагаас хараат бус байгууллага гишүүдийн ёс зүйн дүрмийг сахиулахад хяналт тавьж Парламент, эсхүл холбогдох хороонд ажлаа тайлагнана.

Энэ загвар нь Скандинавын орнуудад түгээмэл тархсан. Тухайлбал, Омбудсмен нь төрийн албан тушаалтны (үүнд парламентын гишүүд орно) хүний эрхийн зөрчилтэй холбоотой хэрэг хамаарах бол луйвар (fraud), авлигын томоохон хэргийг дээрхээс үл хамааран холбогдох шүүх, цагдаа, мөрдөн шалгах тусгай нэгж хариуцна.

Тогтолцооны хувьд энэ байгууллага нь хэнд харьяалагдах, хэнд тайлагнах вэ гэсэн чухал асуудал гарч ирэх бөгөөд гүйцэтгэх, эсхүл шүүх эрх мэдэлд хамаарах нөхцөлд эрх мэдэл хуваарилах зарчимд нөлөөлж болзошгүй юм.

**АНУ**-ын хувьд өмгөөлөгч болон бусад ёс зүй, мөрдөн байцаалтын чиглэлээр туршлагатай мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн Конгрессын Ёс зүйн алба нь АНУ-ын Төлөөлөгчдийн

танхимын гишүүд, ажилтнуудын ёс зүйгүй байдлын талаарх гомдлыг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд асуудлыг Конгрессын Ёс зүйн хороонд шилжүүлэх үүрэг бүхий хараат бус байгууллага ажилладаг байна.

**Германы** хувьд бие даасан, хараат бус шинжээчдээс бүрдсэн Ёс зүйн зөвлөл (Ethics Council) нь тус улсын хэмжээнд төрийн болон нийгмийн бүхий л салбарт нийтээр дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг хэрхэн баримталж байгаа талаар судалгаа шинжилгээ хийж, холбогдох зөвлөмжүүдийг гаргадаг. Гэхдээ энэ байгууллагын 52 гишүүнийг Бундестагийн Спикер 4 жилийн хугацаатай томилдог байна.

**ХОСЛУУЛСАН ЗОХИЦУУЛАЛТ** (combination of both) - дээрх хоёр загварыг хослуулсан буюу Парламентын ёс зүйн асуудлаар дотооддоо өөрийгөө зохицуулах элементүүдийг бие даасан институцтэй хослуулж хариуцдаг гэж байна. Тухайлбал, **Францад** 2011 онд Үндэсний Ассамблейн гишүүдийн ёс зүйн дүрмийг хүндэтгэн мөрдөхийн тулд анхны бие даасан ёс зүйн Комиссарыг томилж, дараа нь Үндэсний Ассамблейн Товчоог байгуулсан байна.

Харин **Их Британийн** Парламентын Нийтийн танхим нь Стандарт, давуу эрхийн байнгын хороо болон хараат бус Комиссар ёс зүйн асуудлыг хариуцна. Журмын дагуу гомдлыг Комиссар хянан шалгаж, дүнгээ Байнгын хороонд тайлагнана. Хянан шалгах, шийдвэр гаргах гэсэн 2 чиг үүргийг ийнхүү зааглаж өгсөн нь шударгаар шүүлгэх эрхийн шаардлагыг хангаж байна гэж үздэг. Гэхдээ Комиссарын үйл ажиллагаанд Их Британийн хууль тогтоох байгууллага үйл явцад тодорхой хэмжээгээр хяналт тавьдаг. Үүний учир нь:

- нэгдүгээрт, Комиссарыг Нийтийн танхимаас томилно;
- хоёрдугаарт, Комиссар хянан шалгалтынхаа үр дүнг Байнгын хороонд тайлагнах бөгөөд энэ нь эргээд Нийтийн танхимд тайлагнаж, зохих шийтгэлийг санал болгоно;
- гуравдугаарт, Хороо нь Комиссараас ирүүлсэн дүгнэлтийг харгалзан үзэхгүй байж болох бөгөөд өөрөө хяналт шалгалтаа хийж болно.

## ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ЕС ЗҮЙН ХОРООДЫН ТАЛААРХ СУДАЛГАА

### 1. ПАРЛАМЕНТЫН ЁС ЗҮЙ: ХЯНАЛТЫН ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Парламент авлигатай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн ихэнх улсад парламентын төсвийн үйл явц зэрэг чухал бөгөөд эмзэг салбар дахь хууль тогтоох, төлөөлөх, нөөц хуваарилах, хянах чиг үүргээрээ дамжуулан Засгийн газарт хяналт тавих, хариуцлага тооцох эрх, үүргийг Үндсэн хуулиар олгогдсон байдаг. Тиймээс Парламент нь иргэдийн тэдэнд буюу хууль тогтоох байгууллагад итгэх итгэлийг бэхжүүлж, парламентын гишүүд өөрсдийн эрх, үүргээ улс төрийн намын, эсхүл хувийн ашиг сонирхлын үүднээс бус нийтийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэхийг баталгаажуулахын тулд шударга байдлын үлгэр жишээг харуулах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Тухайлбал, Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гишүүн зарим улс орнууд өөрийн улсын парламентын гишүүд болон төрийн албан хаагчидад зориулан үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ тогтоосон дүрэм журмыг боловсруулан баталжээ. Хэдийгээр парламентын гишүүдийн ёс зүйн дүрмүүд урьд өмнө мөрдөгдөж байсан боловч эдгээр дүрмүүд нь нэлээд хязгаарлагдмал зохицуулалттай байсан байна. Түүгээр ч зогсохгүй сүүлийн жилүүдэд сонгогчид ба тэдгээрийн сонгогдсон төлөөлөгчдөө итгэх итгэл улам бүр багасч байна. Европын холбооны доторх улсуудын үндэсний парламентадаа итгэх итгэл 2007 онд 57 хувь байсан бол 2012 онд 31 хувь болж буурчээ.

Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, парламентын гишүүдэд зөвлөгөө өгөх үүрэг бүхий байгууллагыг бий болгох гурван үндсэн загвар байх бөгөөд ингэхдээ улс орнууд хоорондоо харилцан адилгүй байна<sup>273</sup>:

- 1) дотоод зохицуулалт (self-regulation);
- 2) гадаад зохицуулалт (external regulation);
- 3) хослуулсан зохицуулалт (combination of both).

Эдгээр загвараас үл хамааран парламентын ёс зүйг сахиулах үүрэгтэй институцийн эрх зүйн байдлыг, журам нь ил тод байхыг баталгаажуулах нь чухал юм. Нөөцийн хувьд ёс зүйн хороо, эсхүл зохицуулах байгууллагыг санхүүжүүлэх нь тус институц нь үүргээ биелүүлж, бие даасан байдлаа хангахад зайлшгүй шаардлагатай. Тус институцийн төсөв нь үйл ажиллагааны явцад нэмэлт санхүүгийн нөөцөөр хангах уян хатан, тогтвортой, найдвартай байх ёстой гэж үздэг байна.

Судалгаанд “дотоод зохицуулалт” бүхий загвартай Польш, Ирланд, Герман, Өмнөд Солонгос зэрэг улсууд, “гадаад зохицуулалт” бүхий загвартай АНУ, мөн “хослуулсан зохицуулалт” бүхий загвартай Их Британ, Франц зэрэг улсуудын туршлагыг оруулсан.

### 2.ДОТООД ЗОХИЦУУЛАЛТ (self-regulation)

“Дотоод зохицуулалт” гэсэн загвар нь хууль тогтоох байгууллагын бүтцийн нэгж буюу Парламент өөртөө ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлсэн зөрчлийг шалгах, хэзээ, ямар хариуцлага тооцох талаар шийдвэр гаргаснаар хяналтаа хадгална. Энэ загварт

<sup>273</sup> Parliamentary Ethics Committees. Transparency International. 25 November 2016.

[https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary\\_ethics\\_committees\\_2016.pdf](https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary_ethics_committees_2016.pdf)

Background Study: Professional and Ethical Standards for Parliamentarians.

<https://www.osce.org/files/f/documents/7/7/98924.pdf>

Ирланд, Герман, Польш зэрэг орнуудын тогтолцоо хамаардаг аж. Өөрийгөө зохицуулах энэ тогтолцоонд Парламент нь гишүүдэд хэзээ, ямар хариуцлага хүлээлгэх талаар бол

Энэ загварт ихэвчлэн ёс зүй зөрчсөн гишүүдийг мэдээлэх, шалгах, хариуцлага тооцох үүрэг бүхий Хороо байгуулах, Парламентын гишүүдийн хамтын бие даасан хяналтад багтдаг. Ийм Хороод нь ихэвчлэн гишүүдээр, зарим тохиолдолд сөрөг хүчний гишүүдээр удирдуулдаг.

Хяналтын өөр нэг хэлбэр бол ёс зүйн дүрэмд хяналт тавихын тулд Парламентын дарга (эсхүл Төлөөлөгчдийн танхимиын спикер)-ыг байлцуулах явдал юм. Гэхдээ энэ хэлбэрийг өргөн нэвтрүүлээгүй байна.

Жишээлбэл, ХБНГУ-д Бундестагийн дарга нь гишүүдийн танхимд биеэ зохисгүй авч явах, зохисгүй үг хэллэг хэрэглэх, дэг журмыг дагаж мөрдөхгүй зэрэг жижиг зөрчлүүдийг зохицуулна, илүү ноцтой зөрчлийг Тусгай хороогоор хэлэлцүүлнэ.<sup>274</sup> Үүний зэрэгцээ тэрээр ашиг сонирхлоо мэдүүлээгүй хэргийг шалгах бүрэн эрхтэй бөгөөд хяналт шалгалтын үр дүнг Бундестагт танилцуулах, цаашдын арга хэмжээ авах үүрэгтэй аж.<sup>275</sup>

## 2.1.Польш Улс

Депутатуудын баримтлах ёс зүйн зарчмыг 1998 онд Сеймээс баталсан "Депутатуудын ёс зүйн зарчим" (Principles of Deputies' Ethics)-д тусгасан байна. Зарчимд заасны дагуу ёс зүйн зарчмыг зөрчил гаргасан депутат Депутатын ёс зүйн хорооны өмнө хариуцлага хүлээнэ. Энэ хороо нь Сейм парламентын ёс зүйн зарчмыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

Аливаа депутат, парламентын байгууллага, бусад хуулийн этгээд нь Депутатын ёс зүйн хороонд гомдол гаргаж болно. Мөн энэ Хороо холбогдох асуудлыг өөрийн санаачлагаар авч үзэж болно. Хороо гомдлыг хэлэлцэх эсэхийг шийддэг боловч энэ тухай гомдол гаргагчид мэдэгдэнэ.

Депутатын ёс зүйн хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- депутатуудын буруутай үйлдлийн хэргийг шалгах;
- депутатуудын хөрөнгө, орлогын мэдүүлэгт дүн шинжилгээ хийх;
- хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлыг шалгах;
- депутатуудын Ёс зүйн зарчмыг дагаж мөрдүүлэх, хяналт тавих.

### Гомдол хянан шийдвэрлэх

Депутатын ёс зүйн хорооны олонхын саналаар депутатыг "Парламентын ёс зүйн зарчим"-ыг зөрчсөн гэж үзвэл дараах хариуцлагын аль нэгийг хүлээлгэнэ:

- сануулах (reproach a deputy);
- хатуу сануулах (admonish a deputy);
- зэмлэх (reprimand a deputy).

Хороо гаргасан шийдвэрээ депутатад бичгээр мэдэгдэх бөгөөд давж заалдах гомдлыг нэн даруй бүртгэх боломжтой. Хэрэв депутат нь давж заалдахгүй бол уг шийдвэрийг албан ёсны мэдээнд нийтлэнэ.

Тус Хороо гомдлыг дараах журмаар хэлэлцэнэ:

- гомдлыг Депутатын ёс зүйн хорооны гишүүдэд мэдээлэх;
- нэр нь холбогдож байгаа парламентын гишүүнд мэдэгдэх;
- уг гомдлыг Байнгын хороогоор хэлэлцэх эсэх талаар гомдол гаргагчид мэдээлэх;

<sup>274</sup> Parliamentary Ethics Committees. Transparency International. 25 November 2016.

[https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary\\_ethics\\_committees\\_2016.pdf](https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary_ethics_committees_2016.pdf)

<sup>275</sup> Background Study: Professional and Ethical Standards for Parliamentarians. OSCE Office for Democratic Institutions and Human Rights (ODIHR). 2012. <https://www.osce.org/files/f/documents/7/7/98924.pdf>

- гомдол хэлэлцэх газар, хэлэлцүүлэг эхлэх цагийг талуудад мэдээлэх;
- гомдлыг хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэрийг гомдол гаргагчид мэдээлэх;

Нэр холбогдсон депутатын ёс зүйн хороонд энэ асуудлаар тодруулга өгч болно.

## 2.2.Ирланд Улс

Ирланд Улсын Парламентын танхimuуд хоёулаа гишүүдийнхээ ёс зүйн асуудлыг хариуцдаг Гишүүний ашиг сонирхлын тусгай хороотой.

Эдгээр Тусгай хороод нь Төрийн албаны ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ёс зүйг дагаж мөрдөхийн тулд гишүүдийн хийх ёстай алхмуудын талаар удирдамж боловсруулж тараах;
- гишүүдийн ёс зүйн дүрмийг боловсруулах;
- гишүүний хүсэлтээр хууль тогтоомжийн аливаа зүйл, заалт нь Төрийн албаны ёс зүйн тухай хуульд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж өгөх;
- гишүүний зөрчил гаргасан талаарх гомдлыг хянах.

## 2.3.Өмнөд Солонгос

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Ёс зүйн тусгай хороо (Special Committee on Ethics) нь 1991 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Үндэсний Ассамблейн тухай хуулийн дагуу байгуулагдсан.<sup>276</sup> Үндэсний Ассамблейн бусад Тусгай хороодоос ялгаатай нь Үндэсний Ассамблейн гишүүдийн ёс зүйн мэдлэг, хараат бус байдлыг сайжруулах зорилготой юм. Ёс зүйн тусгай хорооны бүрэлдэхүүнд дарга болон 17 гишүүнээс бүрддэг ба дэд хороо, мэргэжлийн комисс, хууль эрх зүйн мэргэжилтэн болон холбогдох ажилтнууд мөн багтана<sup>277</sup>. Тусгай хорооны дартыг Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдаанаар сонгоно, үлдсэн гишүүд нь эрх баригч болон сөрөг хүчний намуудаас тэгш эрхтэйгээр сонгогдоно.<sup>278</sup>

Үндсэн чиг үүрэг бол мэргэшлийн байдал, ёс зүй, сахилгыг тогтоох ба хаалттай байдлаар Үндэсний Ассамблейн Хуульд заасны дагуу хяналт сахилгыг хэрэгжүүлдэг. Ёс зүйн тусгай хороо нь Үндэсний Ассамблейн шаардлага зарчмыг системтэйгээр хангах үүднээс ёс зүйн дүгнэлттэй холбоотой асуудал, хууль тогтоогчдын мэргэшлийн болон сахилгын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Үүнд: Үндэсний Ассамблейн гишүүд бүрэн эрхээ хувийн ашиг сонирхолдоо ашиглах, шан хөлс авах, давхар ажил хийх, оноогдсон үүргээс зайлсхийх, хөрөнгө орлогын мэдүүлгээ худал өгөх, хандив тусламж авах, гадаадад үйл ажиллагаа (бизнес) явуулах, хуралдааны эрц зэрэгт Үндэсний чуулганы ёс зүйн хуулийн дагуу хяналт сахилгыг хэрэгжүүлдэг<sup>279</sup>. (National Assembly Ethics law 국회의원윤리실천규범 2017.4.22)

Ёс зүйн тусгай хороонд мэргэшлийн болон сахилгын арга хэмжээтэй холбоотой дэд хороод харьялагдана.

Үндэсний Ассамблейн 1996-2000 оны 15 дахь удаагийн бүрэн эрхийн хугацаанд ёс зүйн байдлын талаарх 44 сахилгын хэрэг бүртгэгдсэнээс 22 хэрэг хянан шийдвэрлэсэн бол 2000-2004 оны 16 дахь удаагийн бүрэн эрхийн хугацаанд 16 хэргийг хүлээн авч, 4 хэргийг хянан шийдвэрлэжээ.<sup>280</sup>

Ёс зүйн тусгай хороо нь дараах хуулийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

<sup>276</sup> <http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EB%B2%95>

<sup>277</sup> <https://namu.wiki/w/%EC%9C%A4%EB%A6%AC%ED%8A%9B%EB%B3%84%EC%9C%84%EC%9B%90%ED%9A%8C>

<sup>278</sup> <https://terms.naver.com/entry.nhn?docId=1231717&cid=40942&categoryId=34509>

<sup>279</sup> <http://www.law.go.kr/lslInfoP.do?lslSeq=204130&efYd=20180717#0000>

<sup>280</sup> <https://terms.naver.com/entry.nhn?docId=1231717&cid=40942&categoryId=34509>

1) Үндэсний Ассамблейн сахилгын хянан шийдвэрлэх хууль (국회법의 징계심사 관련 법규) – энэ хуулийн 155 дугаар зүйлд “Сахилгын арга хэмжээ”-ний талаар Үндэсний Ассамблей нь гишүүнийг Ёс зүйн тусгай хороогоор хянасын дараа гишүүнд Сахилгын тусгай хорооны шийдвэрээр шийтгэл хүлээлгэж болно гэж заасан байна.<sup>281</sup>

2) Үндэсний чуулганы ёс зүйн хууль (국회의원윤리강령) - Үндэсний Ассамблейн гишүүн ард түмнээс төрийн захиргааны байгууллагад томилогдон үүргээ ухамсарлан үнэнчээр гүйцэтгэж Үндэсний Ассамблейн нэр хүндийг өндөрт өргөж, ардчилсан улс төрийг хөгжүүлэх, үндэсний сайн сайхныг сурталчлахад үнэтэй хувь нэмэр оруулна гэж амласны дагуу Үндэсний Ассамблейн Ёс зүйн дүрмийг баталдаг. (1991.02.07-ны өдөр хүчин төгөлдөр болсон)<sup>282</sup>.

3) Үндэсний Ассамблейн гишүүний ёс зүйн хууль (국회의원윤리실천규범) - Үндэсний Ассамблейн гишүүний ёс зүйн хуулийн дагуу гишүүний албыг нэр төртэй хашиж аливаа гадны нөлөөнд автах, ёс зүйн алдаа гаргах, эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэн Үндэсний Ассамблейн гишүүний ёс зүйн хуулийг баталсан байна. (Үндэсний Ассамблейн 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 200 дугаар дүрмийн дагуу хэсэгчлэн нэмэлт өөрчлөлт оруулсан)<sup>283</sup>

4) Ёс зүйн тусгай хороо байгуулах тухай журам (윤리특별위원회 구성 등에 관한 규칙) - Журмын зорилго нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 46 (5), 46-2 (6) зүйлд заасны дагуу Ёс зүйн тусгай хороо, ёс зүйн хяналт шалгалтын зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой шаардлагыг хангахад оршино.

### 3.ГАДААД ЗОХИЦУУЛАЛТ (external regulation)

Харин “гадаад зохицуулалт” (external regulation) хэмээх энэ загвар нь Скандинавын орнуудад түгээмэл тархсан. Тухайлбал, Омбудсмен нь төрийн албан тушаалтны (үүнд парламентын гишүүд орно) хүний эрхийн зөрчилтэй холбоотой хэрэг хамаарах бол луйвар (fraud), авлигын томоохон хэргийг дээрхээс үл хамааран холбогдох шүүх, цагдаа, мөрдөн шалгах тусгай нэгж хариуцна. Энэхүү загвар бүхий орнууд дээрх байгууллагуудыг улс төрийн нөлөөлөл болон бусад хууль бус дарамт, шахалт, нөлөөнөөс хараат бус байлгахад ихээхэн ач холбогдол өгдөг учир парламентын дотоод хяналт буюу Парламент өөрийгөө хянах тогтолцоонос илүү үр дүнтэй, мэргэшсэн байдаг гэж үзэх нь элбэг байдаг.

Тогтолцооны хувьд энэ байгууллага нь хэнд харьяалагдах, хэнд тайлагнах вэ гэсэн чухал асуудал гарч ирэх бөгөөд гүйцэтгэх, эсхүл шүүх эрх мэдэлд хамаарах нөхцөлд эрх мэдэл хуваарилах зарчимд нөлөөлж болзошгүй юм.

#### 3.1.АНУ

Сүүлийн жилүүдэд АНУ дотоод зохицуулалтаас татгалзаж байна. 2008 оныг хүртэл хууль тогтоох байгууллага нь ёс зүйн асуудлыг парламентын 10 гишүүнтэй Албаны ёс зүйн стандартын хороо (Committee on Standards of Official Conduct) хариуцаж байв. Тус Хорооны гишүүд хянахчийн үүргийг гүйцэтгэж, хариуцлага тооцох зохих шийтгэлийг Конгресст санал болгож, түүнийгээ хэлэлцүүлэн санал хураалтаар шийдвэрлүүлдэг байжээ.

Тус Хороо нь дараах чиг үүрэгтэй байв:

- албан томилолт, бэлэг, санхүүгийн ил тод байдал, гадаад улсаас орж ирж буй орлогыг хянах;

<sup>281</sup> <https://moral.na.go.kr:444/moral/statute/statute01.do>

<sup>282</sup> <https://moral.na.go.kr:444/moral/statute/statute01.do>

<sup>283</sup> <http://www.law.go.kr/lslInfoP.do?lslSeq=193636&efYd=20170422#0000>

- гишүүд, ажилтнуудад зөвлөгөө өгөх;
- ёс зүйн зөрчлийг хянан шалгах, дүгнэлт гаргах;
- Ёс зүйн дүрмийг<sup>284</sup> тайлбарлах.

Албаны ёс зүйн стандартын хорооны нэрийг 2012 онд Ёс зүйн хороо болгон өөрчилсөн байна.

2008 онд байгуулагдсан Конгрессын Ёс зүйн алба нь АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын гишүүд, ажилтнуудын ёс зүйгүй байдлын талаарх гомдлыг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд асуудлыг Конгрессын Ёс зүйн хороонд шилжүүлэх үүрэг бүхий хараат бус байгууллага юм. Ёс зүйн албаны тайлан, дүгнэлтийг нийтэд мэдээлдэг байна. Тус албанд өмгөөлөгч болон бусад ёс зүй, мөрдөн байцаалтын чиглэлээр туршлагатай мэргэжлийн ажилтнууд багтдаг.

Ёс зүйн албыг 8 гишүүнтэй Удирдах зөвлөл удирдлагаар хангана. Зөвлөлийн гишүүд нь энгийн иргэд бөгөөд Конгрессын гишүүнд, эсхүл холбооны Засгийн газарт ажиллаж болохгүй.

Дараах тохиолдолд Конгрессын гишүүн зөрчил гаргасан тухай гомдлын талаар хяналт шалгалт явуулна:

- Конгрессын гишүүний гаргасан гомдлын дагуу;
- Ёс зүйн хорооны хамгийн ахмад хоёр гишүүний тохиролцож санаачилга гаргасны дагуу;
- иргэд Ёс зүйн хороонд шууд гомдол гаргасны дагуу.

### 3.2. Герман Улс

#### Институцийн бүтэц

ХБНГУ-ын хувьд нийтээр дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг хувь хүний ёс суртахууны өндөр төвшинд баримталдаг нь энэхүү судалгааны явцад илэрхий харагдаж байгаа нь энэ улсын хувьд ёс зүйн хэм хэмжээг нийгэм, шинжлэх ухаан, хууль эрх зүй, анагаах ухааны түвшинд өргөн хэмжээнд авч үздэгтэй холбоотой юм.

Бундестагийн гишүүдийн ёс зүйн асуудлыг Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, “Бундестагийн гишүүдийн ёс зүйн дүрэм”, “Бундестагийн гишүүдийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх журам”-ээр ёс зүйн хэм хэмжээ тогтоосон байна.

Ард түмнээс шууд сонгогдсон Парламентын доод танхим буюу Бундестагт гишүүдийн ёс зүйн асуудлыг авч хэлэлцдэг тусгай чиг үүргийн хороо байхгүй. Харин бие даасан, хараат бус шинжээчдээс бүрдсэн байгууллага болох Ёс зүйн зөвлөл (Ethics Council) энэ асуудлыг хариуцдаг байна.

Парламентын гишүүний ёс зүйн хамгийн чухал асуудал нь хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой болох нь ХБНГУ-ын жишээнээс тодорхой харагдаж байгаа бөгөөд энэ асуудлыг зохицуулах зохицуулалтыг дээр дурдсан баримт бичгүүдэд тулхүү тусгажээ.

Мөн бие даасан, хараат бус шинжээчдээс бүрдсэн байгууллага болох Ёс зүйн зөвлөл (Ethics Council) нь тус улсын хэмжээнд төрийн болон нийгмийн бүхий л салбарт нийтээр дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг хэрхэн баримталж байгаа талаар судалгаа шинжилгээ хийж, холбогдох зөвлөмжүүдийг гаргадаг. Энэхүү байгууллагын гишүүдийг Спикер 4 жилийн хугацаатай томилдог бөгөөд нийт 52 гишүүний 26-г нь Холбооны Засгийн газраас, 26-г нь Бундестагаас санал болгодог байна. Бундестагийн гишүүдийн ёс зүйн асуудлаар

<sup>284</sup> Committee on Ethics: Rules. <https://ethics.house.gov/sites/ethics.house.gov/files/ADOPTED%20-%20Committee%20Rules%20for%2020116th%20Congress.pdf>

Бундестагийн Спикер шийдвэр гаргахдаа мөн дээрх байгууллагаас санал зөвлөмж авч болно.

Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндсийг 2007 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ёс зүйн зөвлөлийн тухай хуулиар хангаж өгсөн байдаг.

Бундестагийн гишүүдийн ёс зүйн дүрэм болон түүнийг дагаж мөрдөх журмын дагуу Бундестагийн гишүүн бүр Бундестагийн Спикерт дараах мэдээллийг өгөх үүрэгтэй. Үүнд:

- гишүүний бүрэн эрхийг хүлээн авахаас өмнө хийж гүйцэтгэж байсан ажил;
- гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон болон бусад аливаа үйл ажиллагааны орлого;
- компаниудад эзэмшиж буй хувьцаа;
- цаашид хийгдэх үйл ажиллагаа, болон түүнээс авах тэтгэмжийн талаарх гэрээ;
- улс төрийн үйл ажиллагаатай холбоотой хандив болон бусад үр ашиг;
- зочид, бусад этгээдээс хүлээн авсан бэлэг.

### *Ёс зүйн дүрэм зөрчил хянах процедур*

Бундестагийн гишүүдийн ёс зүйн дүрмийн 8 дугаар зүйлд ёс зүйн зөрчил хянахтай холбоотой харилцааг зохицуулсан байна:

Бундестагийн гишүүн нь Ёс зүйн дүрмийн дагуу үүргээ биелүүлээгүй бол Спикер юун түрүүнд холбогдох гишүүний тайлбарыг авах бөгөөд дараа нь нотлох баримтын болон хууль ёсны хяналт шалгалтыг явуулна. Спикер нөхцөл байдлыг тодруулахын тулд холбогдох гишүүнээс нэмэлт мэдээлэл авч болохоос гадна холбогдох гишүүний харьялагддаг Парламентын бүлгийн даргаас байр суурийг нь тодруулан холбогдох тайлбар, асуумж авч болно.

Спикер холбогдох баримт нотолгоог судалж үзээд тухайн гишүүний гаргасан зөрчил нь ноцтой зөрчилд тооцогдохгүй буюу хайхрамжгүй хандсан үйлдэл гэж үзвэл (жишээ нь: хуульд заасан хугацаанаас өмнө мэдээлэл өгөхгүй байх гм), уг асуудлаар тухайн гишүүнд сануулга өгнө. Энэ тохиолдолд Спикер хяналт шалгалтын үр дүнг Ёс зүйн зөвлөл болон Парламентын бүлгийн дарга наарт албан ёсоор мэдэгдэнэ. Нэр холбогдсон гишүүний тайлбарыг сонссоны дараа Ёс зүйн зөвлөл тухайн гишүүний үйлдэл нь ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэнэ. Бундестагийн гишүүн нь Ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44а хэсэгт заасныг үл харгалзан Ёс зүйн зөвлөл шийдвэрээ бичгээр гарган албажуулж, олон нийтэд мэдэгдэнэ. Тухайн зөрчлийг гаргаагүй талаарх шийдвэрийг тухайн нэр холбогдсон гишүүний хүсэлтээр нийтэлж болно.

Тэргүүлэгчдийн гишүүн, эсхүл Парламентын бүлгийн дарга үүргээ биелүүлээгүй бол холбогдох Бундестагийн гишүүн эдгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хуралд оролцохгүй. Парламентын бүлгийн даргын оронд түүний орлогч дээр дурдсан журмын дагуу сонсгол хийж, мэдээлнэ. Хэрэв Спикер нь үүргээ биелүүлээгүй бол түүний орлогч дээр дурдсан журмын дагуу түүнийг орлон ажиллана.

Тайлан тавих үүргээ биелүүлээгүй гишүүнийг дахин сонссоны дараа Ёс зүйн зөвлөл албадан торгох шийдвэр гаргаж болно. Торгуулийн хэмжээ нь тухайн хэргийн хүнд байдал болон гэм буруугийн зэргээс хамаарна. Энэ торгууль нь гишүүдийн жилийн цалингийн тавин хувиас хэтрэхгүй байна. Спикер Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ. Шалгагдаж буй гишүүний хүсэлтээр торгуулийг хэсэгчлэн төлж болно. Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 31 дүгээр хэсгийн 3, 4 дэх өгүүлбэрүүдэд *mutatis mutandis* (хэлэлцэгдэж буй гол асуудалд нөлөөлөхгүйгээр шаардлагатай өөрчлөлт хийх)-ийг хэрэглэнэ.

Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44.3-т заасан тохиолдолд Спикер холбогдох гишүүний тайлбарыг сонссоны дараа баримтын болон хууль ёсны хяналт шалгалтыг явуулна. Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44a.2 дахь хэсгийн гуравдугаар өгүүлбэрийн хүрээнд зохих үйлчилгээ үзүүлсэн эсэхийг шалгаж үзэх нь авч болох цалингийн түвшингээс хамаарна. Хүлээн авсан үр өгөөж, үзүүлэх үйлчилгээ дүрэм журамд заасан тодорхой хувиас хэтэрсэн эсэхийг шалгах нь энэ асуудлыг тодруулахад нэмэр болно. Энэ хэсэгт заасан арга хэмжээг зөвхөн бэлэг, мөнгөн тэтгэмжийг хүлээн авснаас хойш гурван жилийн дотор авах боломжтой.

Спикер тухайн зөрчилтэй холбоотойгоор нөхцөл байдлыг тодруулахын тулд шалгагдаж буй гишүүнээс нэмэлт мэдээлэл өгөхийг хүсэх, тухайн гишүүний харьялагдах Парламентын бүлгийн даргаас мөн нэмэлт мэдээлэл тайлбар хүсч хүсэлт гаргаж болно. Хэрэв Спикер тухайн шалгагдаж буй гишүүнийг Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44а хэсгийн 2-т заасны дагуу зөвшөөрөгдөөгүй цалин хөлс авсан гэж үзэж байгаа бол мөрдөн байцаалтын үр дүнгийн талаар Ёс зүйн зөвлөл болон Парламентын бүлгийн дарга нарт мэдэгдэнэ. Тухайн гишүүнтэй холбогдох асуудлыг сонссоны дараа Ёс зүйн зөвлөл уг гишүүнийг Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44а хэсгийн 2-т заасныг зөрчсөн эсэхийг тогтооно. Спикер энэхүү эрхийг Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 44a.3-т заасны дагуу захиргааны актын тусламжтайгаар баталгаажуулна. Бундестагийн гишүүн нь Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар хүлээсэн гишүүний үүргээ зөрчсөн бол уг хуулийн 44а хэсэгт заасныг үл харгалзан Спикер шийдвэрээ бичгээр гарган албажуулж олон нийтэд мэдэгдэнэ. Тухайн зөрчлийг гаргаагүй талаарх шийдвэрийг тухайн нэр холбогдсон гишүүний хүсэлтээр нийтэлж болно.

#### 4.ХОСЛУУЛСАН ЗОХИЦУУЛАЛТ (combination of both)

“Хослуулсан зохицуулалт” гэсэн загвар нь Парламентын ёс зүйн асуудлаар дотооддоо өөрийгөө зохицуулах элементүүдийг бие даасан институцтэй хослуулж хариуцна.

Энэхүү үйл явцын нэг хэсгийг Парламентын байгууллагууд (Спикер, хороо) хэрэгжүүлдэг боловч загвар нь ихэвчлэн парламентын өмнө томилогдож, тайлагнадаг хараат бус зохицуулах байгууллага байдаг. Жишээ нь, Их Британид бие даасан Парламентын комисsar, эсхүл гишүүдээс бүрдэх Парламентын хороо хэлбэртэй болно. Эрх бүхий өтгээд нь хэргийг шалгаж, дүрмийг хэрэгжүүлэх талаар Парламентын гишүүдэд зөвлөгөө өгөх бол Парламентын хороо холбогдох шийдвэрийг гаргаж, хариуцлага хүлээлгэдэг.

##### 4.1.Их Британи

Их Британийн Парламентын гишүүдийн ёс зүйн дүрмийг<sup>285</sup> сайн туршлага гэж үздэг бөгөөд энэ дүрмээр парламентын гишүүдийн ёс зүйн ихэнх асуудлуудыг зохицуулсан байдаг. Тухайн дүрмийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй бие даасан байгууллага буюу тусгай байгууллага нь ёс зүйн асуудлаар парламентын гишүүдэд зөвлөгөө өгнө.

##### Институцийн бүтэц

1990-ээд оны дунд үед Их Британийн Нийтийн танхимд Стандарт, давуу эрхийн байнгын хороо (Committee on Standards and Privileges) байгуулсан, мөн хөндлөнгийн Комисsar (external commissioner)-тай болсон байна. Комисsar гомдлыг хүлээн авч шалгаад Байнгын хороонд тайлагнана. Зөрчил хянан шийдвэрлэх явц нь шударга шүүхийн зарчмыг хангахад чиглэгдсэн байна.

Комисsar нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

<sup>285</sup> House of Commons: Code of Conduct. <https://publications.parliament.uk/pa/cm201719/cmcode/1474/1474.pdf>

- Танхимд болон гишүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөгөө өгөх;
- гишүүдийн ашиг сонирхлын бүртгэлд хяналт тавих;
- гишүүд хууль, дүрэм зөрчсөн талаар гомдлыг хүлээн авч шалгах;
- ирсэн гомдол болон бусад асуудлын талаар Стандарт, давуу эрхийн хороонд мэдээлэх.

Комиссар нь хараат бус, шударга ажиллах ба түүнийг Танхимын тогтоолоор нэг удаа 5 жилийн хугацаатай томилно.

Стандарт, давуу эрхийн хороо нь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Комиссарын үйл ажиллагаанд хяналт тавих;
- дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- ашиг сонирхлыг бүртгэх журмын талаар Танхимд зөвлөгөө өгөх;
- Комиссараас мэдээлсэн хэргийг шийдвэрлэх;
- зохих шийтгэлийн талаар Танхимд зөвлөгөө өгөх;
- Комиссарын дүгнэлтийг үл харгалзан өөрөө хянан шалгах.

Тус Байнгын хороо нь сонгуульт 10, орон тооны бус З гишүүний бүрэлдэхүүнтэй. Байнгын хороог сөрөг хүчний парламентын гишүүн даргална. Парламентын гишүүд Байнгын хорооны даргыг сонгоход оролцохгүй. Байнгын хорооны орон тооны бус гишүүд нь парламентын гишүүн биш, салбарын мэргэжилтнүүд байна. Гишүүд намын нөлөөнд автахгүйн тулд Байнгын хорооны бүрэлдэхүүнд эрх баригч болон сөрөг хүчний намуудаас тэгш орно.

Сүүлийн жилүүдэд энэ хоёр институц нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд онцгой анхаарч, гишүүдэд заавар зөвлөгөө өгөх, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах, хувь гишүүдэд нууц зөвлөгөө өгөх зэргээр ажиллаж байна.

### **Гомдол хянан шийдвэрлэх**

Комиссар албан ёсны гомдол (a formal complaint) хүлээн авсны дараа мөрдөн шалгалтыг явуула, хэрэв гомдол мэдүүлэгч нь нэрээ нууцалсан тохиолдолд мөрдөн шалгалт явуулахгүй. Харин Олон нийтийн амьдралын стандартын хороо (Committee on Standards in Public Life) нь Комиссарт хяналт шалгалтыг эхлүүлэх бүрэн эрх олгосон бол өөрийн санаачлагаар мөрдөн шалгалт явуулж болно.

Парламентын гишүүн Комиссарт холбогдох гомдлыг бичгээр гаргах ба парламентын бусад гишүүд хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулан гарын үсэг зурж болно.

Комиссар гомдол хүлээн авсны дараа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эсэхийг шийднэ. Хэрэв гомдолд нь гэмт хэргийн шинжтэй бол Комиссар нь гомдол гаргагчид уг асуудлаа цагдаагийн байгууллагад, эсхүл эрх бүхий байгууллагуудад шилжүүлэхийг зөвлөнө.

Хэрэв гомдлыг цааш хянан шалгах бол Комиссар хэрэг бүртгэл явуулна.

Байнгын хорооны гишүүд гомдол хянан шийдвэрлэхд дараах эрх, үүрэгтэй оролцоно:

- Комиссар хянан шалгах албан ёсны бүрэн эрхгүй ч Байнгын хорооны гишүүд түүнтэй хамтарч ажиллах;
- тухайн асуудалтай холбоотой хүмүүсийг дуудан ирүүлэх, тайлан, бичиг баримт гаргуулан авах;
- хяналт шалгалтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Комиссар хяналт шалгалтын үр дүнг Байнгын хороонд мэдээлсний дараа Байнгын хороо тайланг хэлэлцэж зөрчил гаргасан гишүүнд дараах хариуцлагын аль нэгийг хүлээлгэх тухай санал оруулж хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Үүнд:

- албан ёсоор сануулга өгөх;

- гишүүний цалинг тодорхой хугацаанд хасах;
- гишүүнийг Танхимын ажлаас нь тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх (энэ хугацаанд цалин авахгүй);
- гишүүнээс нь эргүүлэн татах.

## **4.2.ФРАНЦ**

### *Институцийн бүтэц*

2011 онд Францын Үндэсний Ассамблейн гишүүдийн ёс зүйн дүрмийг хүндэтгэн мөрдөхийн тулд анхны бие даасан ёс зүйн Комискар (Déontologue)-аа томилжээ. Үүнийг дараа Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгч, 6 дэд ерөнхийлөгч, 3 квестор (questors), 12 нарийн бичгийн даргаас бүрдсэн Үндэсний Ассамблейн Товчоог байгуулсан.

Комискар нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- парламентын гишүүдийн эд хөрөнгийн мэдүүлгийг цуглуулах, хадгалах;
- ёс зүйн дүрмийн зарчмын талаар гишүүдэд нууц зөвлөгөө өгөх, зөвлөмж өгөх;
- Үндэсний Ассамблейн Товчоонд зөрчлийн талаар сэрэмжлүүлэх;
- ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт Үндэсний Ассамблейд жил бүр тайлагнах;
- ёс зүйн асуудлаар судалгаа хийх;
- нууцлалыг чанд сахиж, хүлээн авсан мэдээллээ задруулахгүй байх.

Томилгоотой холбоотой асуудал шийдвэрлэхэд Товчооны 3/5-ын санал, наад зах нь сөрөг хүчний нэг санал шаардана. Комиссарын бүрэн эрх нь хууль тогтоох байгууллагын тухайн бүрэн эрхийн хугацааг хамаарах бөгөөд цуцлагдах боломжгүй, сэргээгдэхгүй.

### *Гомдол хянан шийдвэрлэх*

Комискар нь Үндэсний Ассамблейн гишүүнийг Ёс зүйн дүрэм зөрчсөн гэж сэжиглэж байгаа бол нэр нь холбогдсон гишүүн, Үндэсний Ассамблейн дарга наарт мэдэгдэж, асуудлыг зохих журмыг эхлүүлнэ. Комискар энэхүү нэхцэл байдлыг арилгах зөвлөмжийг Үндэсний Ассамблейн гишүүнд өгнө.

Үндэсний Ассамблейн Товчооноос Комиссарын хянан шалгасан дүнг хэлэлцээд тухайн гишүүнийг зөрчил гаргасан гэж үзсэн бол дараах сахилгын арга хэмжээний аль нэгийг авах тухай шийдвэр гаргаж болно. Үүнд:

- олон нийтэд мэдээлэх;
- зэмлэх,
- бүрэн эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлэх;
- Парламентын тэтгэмжийг хасах.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Parliamentary Ethics Committees. Transparency International. 25 November 2016.  
[https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary\\_ethics\\_committees\\_2016.pdf](https://www.transparency.org/files/content/corruptionqas/Parliamentary_ethics_committees_2016.pdf)
- <http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EA%B5%AD%ED%9A%8C%EB%B2%95>
- <https://namu.wiki/w/%EC%9C%A4%EB%A6%AC%ED%8A%B9%EB%B3%84%EC%9C%84%EC%9B%90%ED%9A%8C>
- <https://terms.naver.com/entry.nhn?docId=1231717&cid=40942&categoryId=34509>
- <https://www.yna.co.kr/view/MYH20180710015900038>
- <http://www.law.go.kr/lstInfoP.do?lslSeq=204130&efYd=20180717#0000>
- <https://terms.naver.com/entry.nhn?docId=1231717&cid=40942&categoryId=34509>
- <https://moral.na.go.kr:444/moral/statute/statute01.do>
- <https://moral.na.go.kr:444/moral/statute/statute01.do>
- <http://www.law.go.kr/lstInfoP.do?lslSeq=193636&efYd=20170422#0000>
- House of Commons: Code of Conduct.  
<https://publications.parliament.uk/pa/cm201719/cmcodes/1474/1474.pdf>
- Committee on Ethics: Rules.  
<https://ethics.house.gov/sites/ethics.house.gov/files/ADOPTED%20-%20Committee%20Rules%20for%20the%20116th%20Congress.pdf>
- Committee on Ethics: Rules.  
<https://ethics.house.gov/sites/ethics.house.gov/files/ADOPTED%20-%20Committee%20Rules%20for%20the%20116th%20Congress.pdf>

---

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН